



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ЭРДЭМ

ШИНЖИЛГЭЭ

ᠰᠣᠶᠣᠳᠣᠨ
ᠰᠣᠶᠣᠳᠤ
ᠰᠤᠮᠤᠨᠢᠯᠢᠭᠡᠭᠡ



ᠰᠣᠶᠣᠳᠣᠨ
ᠰᠣᠶᠣᠳᠤ
ᠰᠤᠮᠤᠨᠢᠯᠢᠭᠡᠭᠡ

Эрхэлсэн: Э.Итгэл



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ V (№5)

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр хэвлэх, улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар 2023

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

VOLUME V

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(Mongolia)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(Mongolia)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(Mongolia)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(Germany)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(China)
Doctor (Ph.D)	Bold. B	(Japan)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(China)

Edited by: Itgel. E

THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES
Printed with permission of editorial board
A quarterly journal of research

Ulaanbaatar 2023

ISSN: 2791-1446

© *Sodon Soyod Publishing, Mongolia*



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ГАРЧИГ

1. Чулуунбаатар. Л	
<i>Ч.Баудений Монгол-Англи толийн тухай</i>	1
2. Кань Хай Ин	
<i>Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын уламжлал тархалтын тухай (1976-2013)</i>	8
3. Нахиа	
<i>Лао Шө ба М.Хасбаганын соёлт тууж дахь дүр бүтээлтийн харьцуулал</i>	24
4. Хасбаатар. Л	
<i>Эх орныхоо төлөө дусал ус чимх шороо болон амьдрагч</i>	32
5. Аснаа	
<i>Лигдэний “Амьдралын логик” ба Дазай Осамү-ийн “Хүн байх эрхгүй” зохиолуудыг харьцуулах нь</i>	44
6. Пань Вэньчи	
<i>Алунгоо эхийн “хугарсан сумаар хөвүүдээ сургах” хүмүүжлийн аргын судалгаа</i>	53
7. Базаргүр. Б	
<i>Монгол, Англи хэлний хүний бие эд эрхтний нэрээр нэрлэгдсэн өвөрмөц хэлц</i>	60
8. Мөнхцэцэг. А	
<i>Улс төрийн намын үзэл суртлын өнөөгийн агуулгад хийсэн шинжилгээ</i>	70
9. Гао Шя	
<i>Хөлингөр Тучөнзы 1-р булины ханан дахь зургийн шинж чанар</i>	78
10. Ван Рүйбяо	
<i>Хятадын найрал дууны удирдаач Шянь Шинхайн амьдрал, уран бүтээл</i>	94
11. Түвшинбаяр. Ц	
<i>Монгол улс, БНХАУ-ын дээд боловсролын орчны (P.E.S.T.L) харьцуулалт</i>	104
12. Одзаяа. Л	
<i>Бүтээлч сэтгэлгээний зарим асуудалд</i>	114
13. Хань Хуйлин	
<i>Ха Мин-ий “Жэн Тун-ий үеийн монголд хүрсэн тэмдэглэл”-ийн сууринд Мин Инзун хааны монголд суугаа үеийн амьдралын тухай шинжлэх нь</i>	124
14. Жао Хашэнь Гаова	
<i>“Харилцааны соёл”-ын үүднээс Японы сургалтын соёлыг нэвтрүүлэх стратегийн талаар өгүүлэх нь</i>	132



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

CONTENT

1. **Chuluunbaatar. L**
On Mongolian-English dictionary by Charles Bawden.....1
2. **Kan Haiying**
On the dissemination of Mongolian translation in modern Chinese literature (1976-2013)8
3. **Nakhia**
Comparison of characters in cultural novels of Lao She and Khasbagana.M.....24
4. **Qasbaatar. L, Nakhia**
A patriot an intellectual.....32
5. **Asnaa**
Compare the text of Ligden and Osamu Dazai.....44
6. **Pan Wenqi**
Research on Alan Qoa's "teaching children with broken arrows" education method.....53
7. **Bazargur. B**
Mongolian, English languages human body-related idioms.....60
8. **Munkhtsetseg. A**
Analysis of the current content of the Political party's ideology /Programme of the Mongolian People's Party 1992-2004/.....70
9. **Gao Xia**
On the attributes of the mural epitaph in the tomb of Tuchengzi No. 1 in Helingeer.....78
10. **Wang Ruibiao**
The life and works of Xian Xinghai, a famous Chinese composer and conductor.....94
11. **Tuvshinbayar. Ts**
The comparison of higher education systems between Mongolia and the People's Republic of China.....104
12. **Odzaya. L**
Creative thinking some problems.....114
13. **Han Huiling**
Analyzing the life of Ming Yingzun Khan during his stay in Mongolia based on Ha Min's "Records of Zheng Tung's Journey to Mongolia"124
14. **Zhao Hashen Gaowa**
Talking about the culture introduction strategy in Japanese teaching from the "cross-cultural" perspective.....132

Ч.БАУДЕНИЙ МОНГОЛ-АНГЛИ ТОЛИЙН ТУХАЙ

Л.Чулуунбаатар*

Олон улсын монголч эрдэмтэдийн анхдугаар хурлын төлөөлөгч, монгол судлалын гарамгай эрдэмтэн, Английн Хатан хааны академийн хүндэт профессор Чарльз Бауден гуайтай хоёр жил хамт ажиллаж, ярьж хөөрч явсан нь миний амьдралд тохиолдсон нэгэн сайхан завшаант хэрэг хэмээн гүнээ талархаж явдаг юм.

Аугаа хөдөлмөрч энэ хүн 1924 оны 4-р сарын 22-ны өдөр дулаан зөөлөн уур амьсгалт, Английн өмнөт эргийн хот болох Веймоут (Weymouth) хотод Чарльз Роскеллийнхний гэр бүлд хоёр дахь хүү нь болон төржээ. Аав, ээж хоёр нь хоёулаа дунд сургуулийн багш байсан болохоор хоёр хүүгээ эрдэм номтой, хүний дайтай хүн болгон өсгөжээ. Тийм болохоор Ч.Бауден Лондонгийн Их Сургуулийн монгол судлалын гавьяат профессор, Британийн Академийн жинхэнэ гишүүн, дэлхийд нэртэй монгол судлалын эрдэмтэн, ах нь далайн цэргийн нэр хүндтэй офицер, инженер хүн болсон байна. Ч.Бауден дэлхийн II дайны гал ид дүрэлзсэн 1943-1946 оны хооронд 3 жил Британийн усан цэрэгт алба хаажээ.

Дараа нь Кембрижийн Их Сургуульд орж суралцан төгсгөөд, 1955 онд “Алтан товчийн цаг тооллын бичиг” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. 1950-иад оны эхээр монгол бичгийн хэлээр монгол хэл сурсан блохоор 1955 оноос сонгодог монгол бичгийг сонгох хичээл маягаар зааж эхэлжээ. Тэрээр монгол судлалын нэрт эрдэмтэд Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Г.Сэр-Оджав, О.Намнандорж, Ц.Дорж, Я.Цэвэл гуайтай танилцаж, уулзаж хуучилж явжээ. Б.Ринчен багштай 1954 онд анх захидлаар холбоо тогтоосон болохоор миний анхны багш нарын нэг хэмээн хэлдэг байсан. Б.Ринчен багшаас хүлээн авсан 12 захидал болон ил захидал байдаг бөгөөд нэг удаа тэдгээрээ надад авчирч үзүүлсэн билээ. 1967 оны 8 сараас 1968 оны 2-р сар хүртэл Монголд байхад нь Э.Вандуй, Ж.Цолоо нар монгол хэлний багш хийж байжээ. Ж.Цолоог залуухан 20 настай, эхнэртэй хийгээд багш болон хөтөч хийдэг байсан хэмээн хуучилж байсан билээ.

Лондоны Их Сургуульд багшаас эхлэн салбар сургуулийн захирал, проректорын алба хүртэл амьдралынхаа ихэнх хувийг хашиж явсан тэрбээр дэлхийн монгол судлалд нэр алдраа дуурсгасан олон бүтээл хэвлүүлсний

* МУИС-ийн доктор, профессор



THE CULTURAL WAY

дотор монголын эртний уран зохиол, хуучин сурвалж эх бичгээр дагнан ажиллаж:

“Алтан товч” (The Mongol Chronicle Altan Tobci. Wiesbaden: Otto Harrassowitz, 1955),

“Хүрээний Жавзандамба хутагт”(The Jebtsundamba Khutukhtus of Urga; text, translation, and notes. Wiesbaden: O. Harrassowitz, 1961),

“Бигирмижид хаан ба шинэхэн түүх” (1968),

“Монголын шинэ түүх”(The Modern History of Mongolia. New York: Praeger, 1968, 1989),

“Монгол номын католог” (“Catalogue of Mongol books, manuscripts and xylographs”, The Royal library, Copenhagen, 1971)

“Бөө, лам нар болон Евегалистууд” (Shamans, Lamas, and Evangelicals: The English Missionaries in Siberia. London: Routledge & Kegan Paul, 1985),

“Монгол-Англи толь” Mongolian-English dictionary. London: K. Paul International, 1997.

“Өвгөн Жамбалын яриа” (Tales of an old lama, Translated by C.R.Bawden, UK, 1997)

“Монголын уламжлалт утга зохиолын дээжис” (Mongolian Traditional Literature: An Anthology. London: Kegan Paul, 2003) зэрэг ном,

“Монголын Боржгин овгийн түүх” (History of Borjigon clan in Mongolia),

“Монголын эрт ба одоо”(Mongolian past and present, 1959),

“Сүнс дуудах тухай” (“Calling the Soul: A Mongolian Litany”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 25 (1/3): 81–103.1962),

“Ид шидтэй нүүр тулах” (Confronting the Supernatural: Mongolian Traditional Ways and Means. Wiesbaden: Harrassowitz Verlag, 111-42. 1994),

“Кембрижийн Их Сургуулийн номын санд байгаа Монгол гар бичмэл номын тухай” (“A First Description of a Collection of Mongol Manuscripts in the University Library, Cambridge”. Journal of the Royal Asiatic Society 4?: 151–160, 1957),

“Овоо тахихтай холбоотой хоёр монгол бичвэр” (“Two Mongol Texts Concerning Obo-Worship”. Oriens Extremus 5 (1): 23–41. 1958),

“Монголын эдийн засгийн ололт” (“Economic Advance in Mongolia”. The World Today 16 (6): 257–270, 1960),

“Монгол судлалын саяхны бүтээлүүд” (“Some Recent Work in Mongolian Studies”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 23 (3): 530–543, 1960),

“Юан гүрний үеийн адууны тухай бодлогын зарим тэмдэглэл” (“Some Notes on the Horse Policy of the Yuan Dynasty”. Central Asiatic Journal 10 (3-4): 246–268, 1965),



THE CULTURAL WAY

“1919 оны Автономит Монголын Шүүх яаманд өргөсөн хамтын заргын бичиг” (“A Joint Petition of Grievances Submitted to the Ministry of Justice of Autonomous Mongolia in 1919”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 30 (3): 548–563, 1967),

“1756-1757 оны Монголын бослого хөдөлгөөн” (“The Mongol rebellion of 1756–1757”. Journal of Asian History 2 (1): 1–31, 1968),

“Монгол дахь XVIII зууны үеийн аллагын шалтгаан” “A Case of Murder in Eighteenth-Century Mongolia”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 32 (1): 71–90, 1969,

“Монгол дахь XVIII зууны үеийн бүтэлгүйтсэн аллагын шалтгааныг мөшгөсөн нь” “The Investigation of a Case of Attempted Murder in Eighteenth-Century Mongolia”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 32 (3): 571–592, 1969,

“1756 оны Өвөрмонголын бослоготой холбоотой зарим баримт” (“Some Documents Concerning the Rebellion of 1756 in Outer Mongolia”. Bulletin of the Institute of China Border Area Studies, 1, 1-23, 1970),

“Хатуу дарсны хор хөнөөл: XX зууны эхэн үеийн монгол шаштир” (“On the Evils of Strong Drink: A Mongol Tract from the Early Twentieth Century”. Walther Heissig (Wiesbaden: Harrassowitz), 61, 1976),

“Шамбалыг дахин хүсэгч” (“The wish-prayer for Shambhala again”. Monumenta Serica 36: 453–510, 1984-85), зэрэг эрдэм шинжилгээний алдартай өгүүлүүдээ хэвлүүлжээ. Эдгээр бүтээлийн дотроос Монголын олон мянган хэрэглэгчдийн таашаалд нийцсэн “Монгол-Англи толь”-ийн нь тухай ярих гэсэн юм.

1989-1991 оны хооронд Лондонгийн Их Сургуульд зочин багшаар уригдан очоод ажиллаж байх цагт Профессор Чарльз Бауден гуай хэдийгээр тэтгэвэртээ гарсан ч 1963 оноос эхэлж 34 жилийн тэсвэр тэвчээр, мэдлэг оюун, шургуу хөдөлмөр зарсан “Монгол Англи толь”-ио ид хийж байсан билээ. Намайг очиход ерөнхийдөө толио дууссан боловч 1980-аад онд гарсан ил тод байдлын дэвшилтэд нөлөөгөөр монгол ёс заншил сэргэн, монгол хэлний үгсийн санд мартагдах шахсан олон хуучирсан үг шинээр орж ирэн тэр бүхнийг толиндоо нэмж тусган оруулахын тулд зөв ухаарч ойлгох хэрэгтэй болоод байсан хэрэг юм. Бид хоёр, долоо хоногт хоёр удаа 90 минутаар хичээллэдэг байв. Ч.Бауден гуай үгээ авчирч би түүний нь монголоор тайлбарлан, дахин дахин ярилцаж сайн ойлгосны дараа дараагийн үгэндээ ордог байв.

Чарльз Бауден гуайд энэ толио бүтээх санаа Боннын Их Сургуулийн багш Магадбүрэн Халтодыг 1963 онд Лондонгийн Их Сургуулийн Ойрх дорнод болон Африкийн судлалын сургуульд 3 сарын хугацаагаар ажиллахаар ирээд байх үед нь төрсөн байна. “Үг олдож үхэр холдлоо” хэмээн Магадбүрэн гуай их хэлдэг байсан хэмээн хуучилдаг байв. Монгол-Англи толь хийхийн тулд БНМАУ-ын орчин үеийн хэлний үгийг хамтдаа цуглуулахаар ярьж



THE CULTURAL WAY

тохиролцсон байна. ОДАСС (SOAS) кирил үсэгтэй 2 бичгийн машин болон бичгийн хэрэгсэл зэрэг боломжийн хандив дусламжийг үзүүлсэн байдаг. Цуглуулсан үгнүүдээ шуудангаар харилцан илгээж, шалгаж нягтлан нэгтгэж нийлүүлэх бодолтой байжээ. Хоёр тусдаа хол газар ингэж ажиллах нь үнэн хэрэгтээ тэдний бодсоноос ихээхэн бэрхшээлтэй байсан ч үргэлжлүүлсээр байсан гэдэг.

1978 оны 8-р сард Магадбүрэн гуай гэнэт таалал төгссөнөөр хамтран ажиллах бололцоо дуусгавар болжээ. Тэрээр “Би түүний аугаа их судлаачийн байр сууринд хүрэхгүй боловч толио дуусгахыг амьдралын зорилго болгосон” хэмээн хуучилдаг байсан билээ. Энэ тухайгаа ч толийнхоо оршилд дурдсан бөгөөд энэ ажилд хөглөн зоригжуулсан Магадбүрэн гуайд талархал илэрхийлээд, мөн 1963-1964 онд ОДАСС-д нэг жилийг өнгөрөөсөн Цэцэн Жагчид болон хожим 1967-1968 онд Улаанбаатар хотод байхдаа Ж.Цолоо, Э.Вандуй нараас их зүйл сурсан хэмээгээд тэдэнд талархалаа илэрхийлсэн байдаг юм. Мөн “МУИС-иас ОДАСС-д ирж ажиллаж байсан багш Л.Чулуунбаатарт гүн талархлаа илэрхийлэх өртэй бөгөөд бараг 2 жилийн турш өгөөмөр их тус хүргэж, миний асуултад хариулж бэрхшээлийг минь арилгахыг хичээж байсан билээ. Эцэст нь түүний дараа ирсэн Ж.Бат-Ирээдүй багшаас ч бас өгөөмөр их туслалцааг энэ ажилдаа авсан билээ” хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Толийнхоо оршилд дурдаагүй боловч хууч хөөрөхдөө С.Нямсүрэн багш толий минь уншиж засч их тусалж байсан хэмээн дурддаг байсан билээ. Толио бүтээхдээ урьд өмнө гарсан толиудыг шүүрдэж үзэхийн хамт Монгол улсад гарсан сонин сэтгүүл, шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын ном хэвлэлийг уйгагүй шүүрдэн уншиж үгийг карталж тэдгээрийн утгыг тодорхой нарийн харгуулах, дүйцэх үгийг олохын төлөө цаг зав хайрлахгүй маш шургуу, хичээнгүй ажилласны ул мөр болж энэ толийн үйл үгийн оноолт хийгээд монгол англи үгийн оноолт маш сайн болсон байдаг. Түүний тулд л бидний хичээлийн үед нэг үгийн нарийн сайн ойлготлоо дахин дахин асууж тайлбарлуулж яриулдаг байсан билээ.

Энэ толь сайн болсон шалтгаан нь хэдэн зүйлд байгаа юм.

1. Дүйцүүлэх арга буюу Үгийн оноолт ялангуяа үйл үгийн оноолыг маш сайн хийж өргсөн байдаг. Дан гагц би бус олон хүний амнаас энэ үгийг сонссон билээ. Жишээ нь: Лессингийн “Монгол-Англи” тольд овоорох хэмээх үгийг to pile up, to crowd, swarm, Хангиний Гомбожавын тольд to form a pile, to crowd, swarm хэмээсэн бол Ч.Баудений тольд to gather together, to bunch together, to crowd together, to swarm, to pile up хэмээн арай олон утга үйл үгийн хэлбэрээр авсан байдаг.

2. Зарим үндэсний онцлогтой үгийг таацуулан оноохоосоо илүү тайлбарлах аргыг илүүтэйд үзсэн байдаг. Жишээ нь: Лессингийн “Монгол-Англи” тольд эзгий хэмээх үгийг curds, cottage cheese, Хангиний Гомбожавын тольд curds, cottage cheese хэмээн яг адил тайлбарласан бол Ч.Баудений тольд a milk product made by boiling most of the whey from the



THE CULTURAL WAY

curdled milk of sheep, goats or cows and setting the residue to dry on the screen хэмээн тайлбарлан үзүүлсэн байдаг.

3. Тухайн үгтэй холбоотой өвөрмөц хэлц, хэллэгийг олныг оруулж өгсөн байдаг. Жишээ нь: Лессингийн “Монгол-Англи” тольд аав хэмээх үгийг father, grandfather, esp. applied to an old father(endearing), аав зантай behaving like an adult (of a child), Гомбожавын тольд father, papa хэмээсэн бол Ч.Баудений тольд dad, father, буурал аав grandfather, хойт аав stepfather, аавдаа авгай авахыг заах to teach one’s grandmother to suck eggs, аавынд байх to be in gaol, аавын буйд хүнтэй танилцаж, агтын буйд газар үз(аавын бийд уурга барь, ээжийн бийд учиг шингээ) learn to make your way early in life, аавын хүү(аавын хүүхэд)chap, young fellow,аавын цээж show-off, precocious child, аавын цээж болох(аавын цээж гаргах) to teach one’s grandmother to such eggs хэмээн өвөрмөц хэлц, хэлц үг хувилбаруудтай нь хамт оруулан утга дүйх хэлцээр нь орчуулсан байдаг. Мөн дээр дурдсан эзгий хэмээх үгний эзгий буцалгах хэмээх хэлц үгийг to snore like a grampus хэмээн урьд урьдын тольд байхгүй үгийг оруулж монголыг судалдаг гадаадынханд болон монгол заншлаа мартаж байгаа хотынхонд ч чухал тайлбар юм.

4. Монголын зан заншил, шашин суртахуун, дорно дахины ухаан, түүх соёлтой олон үгийг шинээр оруулж өгсөн юм. Жишээлбэл: Дорно дахины 10 ухааны талаарх тайлбар Лессинг болон Гомбожавын тольд байхгүй бол Баудений тольд ухаан хэмээх үгийн олон тайлбараас гадна таван ухаан the five (major) sciences, the five(major) branches of learning (Buddh.), ухааны арван орон the ten sciences, the ten branches of learning, ухааны таван бага орон (бага таван ухаан) the five minor sciences (зурхай astrology, зохист аялгуу (яруу найраг) poetics, ил ёгт өгүүлэхүй (ёгт үг) eloquence, холбоо найруулахуй (холбоо найраг) composition, жүжиглэхүй (бүжиглэхүй) acting, dancing), ухааны таван их орон (их таван ухаан) the five major sciences (дуун ухаан linguistics, учир шалтгааны ухаан logic, тэжээхүй ухаан medicine, урлахуй ухаан mechanical arts, дотоод ухаан theology) хэмээх далгарангүй тайрлан оруулсан байдаг. Мөн энэ тольд ам хэмээх үгийн маш олон холбоо үг, хэлцийн утгыг оруулж өгсөний нэг нь уулын ам mountain valley, valley, уулын суга valleys хэмээх үг бөгөөд урьдах хоёр толь болоод монголчуудын хийсэн тольд ч байхгүй байгаа юм.

5. Гадаадаас орсон үг ямар хэлнээс орсон үг болохыг мөн юуны холбоотой үг болохыг оруулж өгсөн байдаг. Жишээ нь Лессинг болон Гомбожавын тольд галбинга a fabulous bird, female phoenix хэмээн байхад Баудений тольд галбинга 1. The “Indian Cuckoo”, 2. Kalavingka, a fabulous bird (Skr.) хэмээн оруулсан байна. Галай-да хэмээн үг дээрх хоёр тольд байхгүй бөгөөд Бауденд галай-да rank of commander in the watch posts in Manchu times (hist.) хэмээн тайлбалаан оруулсан байгаа болой.

Мөн нөгөөтэйгүүр энэ толийн хийх мэдлэгийн болон хамтын ажиллагааны маш сайн нөхцөлийг бүрдүүлж чадсан байдаг. Үүнд:



THE CULTURAL WAY

1. “Алтан товч” , “Хүрээний Жавзандамба хутагт”, “Өвгөн Жамбалын яриа” зэрэг олон сурвалж бичгийг судалж орчуулсан хийгээд монголын түүхийн ном бичихийн тулд монголын түүх, соёлтой холбоотой олон сурвалж, материал, хэрэглэгдэхүүнийг уншиж ухаанаа цэнэглэж, мэдлэгийн хүрээгээ гүнзгийрүүлсэн байдаг.

2. Урьд өмнийн гарсан бүх толь бичиг тайлбар толиудыг шүүрдэн үзсэн байдаг.

3. Гадаадын монголч эрдэмтэд болох Н.Поппе, Х.Шварц, Хайсиг, О.Латтимор Роберт Рупин нарын олон хүнтэй санал солилцдог байсан.

4. Монгол эрдэмтэн Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Г.Сэр-Оджав, О.Намнандорж, Ц.Дорж, Я.Цэвэл, Магадбүрэн, Цэцэн Жагчид, С.Нямсүрэн, Ж.Цолоо, Э.Вандуй, О.Намнандорж, Эрдэнэпил хамба, Т.Пагва, Чингэлтэй профессор, Инжинаш судлаач Эрдэнэтогтох, Л.Чулуунбаатар, Ж.Бат-Ирээдүй нартай захиагаар харьяаж, асууж лавлаж, үзүүлж засуулж, тайлбарлуулж байсан байдаг.

Ф. Лессингийн “Монгол-англи толь”-ийг 1960 онд хэвлэгдэн гарснаар “...дэлхий дахинаа монгол судлалыг баяжууллаа” хэмээн нэрт монголч эрдэмтэн Ф.В.Кливес (Francis Woodman Cleaves) болон мэргэжил нэгтнүүд нь үнэлсэн байдаг. Тийм болохоор бид Ч.Баудений энэ “Монгол-англи толь”-ийг дэлхий дахинаа монгол судлалыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, урьдах толь зохиогчдын дутууг гүйцээж, дундуурыг дүүргэсэн, энэ цаг үедээ л бидний хэрэгцээг бүрэн хангасан, хэрэглэгч олны таашаал хүлээсэн эрэлт хэрэгцээт толь болсныг цохон тэмдэглэхгүй байхын аргагүй юм.



THE CULTURAL WAY

ABSTRACT

Charles Bawden is a world-famous Mongolist who compiled and translated many books in his lifetime. Among his valuable works, Mongolian-English Dictionary played an important role. He spent 34 years on compiling this dictionary. At the end of 1980's he almost finished his hard work. However, as Mongolia was in the period of glasnost at that time, many old pieces of vocabulary could be restored in the Mongolian language. Bawden did not want to leave those words and worked hard again for another 10 years. Thus, numerous essential words related to Mongolian customs, tradition, history, nomadic life style, Mongolian Buddhism and shamanism were added. Cleaves F.W., when commenting on a famous scholar Lessing F.D who compiled Mongolian-English Dictionary in 1960, said that "Ferdinand D.Lessing has put Mongolian study at the high level all over the world by his excellent and comprehensive dictionary."

We, the Mongolians highly prized Bawden's dictionary, considering it to be an invaluable piece of work for the Mongolian studies. The reason for that is that it included lots of words and expressions that have never been included in previous dictionaries. I would like to mention a simple example. As we look up a compound word 'уулын ам', the translation which follows is: 'mountain valley, valley'.

НОМ ЗҮЙ

1. Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997
2. Ferdinand Lessing, Mongolian-English dictionary, Bloomington, Indiana, 1973
3. Gombojav Hangin, Mongolian-English dictionary, Indiana University, 1986
4. Robert Allen, Consultant editor, The New Penguin English dictionary, Penguin books, 2000
5. www. Charles Bawden - Wikipedia, the free encyclopedia
6. М.И.Гольман. Дэлхийн монгол судлал, УБ., 2005

**ДУНДАД УЛСЫН ОРЧИН ҮЕИЙН УТГА ЗОХИОЛЫН
МОНГОЛ ОРЧУУЛГЫН УЛАМЖЛАН ТАРХАЛТЫН
ТУХАЙ**

(1976-2013)

Кань Хай Ин*

ХУРААНГУЙ

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгыг ихэвчлэн доорх мэт гурван шат үе болгон хувааж болно. 1976 оны 10 сараас 1978 оны 11 сар хүртэлх хугацааг сэргэлтийн цаг үе, манай хэвлэлийн хорооныхон соёлын хувьсгалын хатуу чанга хорио цээрийг эвдэж, хатуу нямбай сонголт хийснээс дундад улсын орчин үеийн утга зохиолын орчуулгыг хэдхэн зүйл хэвлүүлсэн байна. Гэвч тухайн үед хэвлэлийн фронтод зам эрэлхийлж байх шатанд байснаас хэвлүүлсэн зохиол бүтээл нь цөөн тоотой зүйл байж, ихэнх зохиол бүтээл нь голдуу соёлын их хувьсгалаас өмнөх хэвлүүлсэн зохиол бүтээлийн дахин хэвлэл болно. 1978 оны 11 сараас 1989 оны сүүл хүртэл хятад утга зохиолынхны “хилсийг цагаатгах, бурууг зүгшрүүлэх” хөдөлгөөн хийгээд дундад улсын орчин үеийн утга зохиолын хөгжлийн ахицад нэлээд хорио цээртэй байсан зохиол бүтээл аажмаар орчуулгын хууль ёсны чанараа сэргээж, монгол уншигчдын таалалд хүрч, шинэ цаг үеийн хятад утга зохиолын орчуулгын гол урсгал болсон байна. 1990 оноос эдүгээ хүртэл хугацааг зарим судлаачид “хожуу шинэ цаг үе” хэмээж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын шинэ нэгэн хуудсыг бичиглэсэн байна. 1976-2013 оны хооронд дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгыг сэргэлтийн үеийн монгол орчуулга (1976.10-1978.10), өрнөлтийн үеийн монгол орчуулга (1978.11-1989.6), бууралтын үеийн монгол орчуулга (1990-2013) гэсэн гурван шат үе болгон ангилж болох юм.

Түлхүүр үгс: *Шинэ эриний Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга, уламжлан тархалт*

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын шинэ цаг үе нь 1976 оны 10 сар “Дөрвөн хүний бүлэг”-ийг бут ниргэснээр эхлэл болж, өнгөрсөн зууны 80-аад оны сүүл хүртэл хөгжиж, 90-ээд оноос нааш дахин бууралтын шатанд орсон байна. Бидний судалгаа 2013 он хүртэлх орчуулгыг багтаасан юм.

* ӨМИС, МСДС-ийн багш доктор, профессор



THE CULTURAL WAY

Нарийвчлан үзвэл, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгыг ихэвчлэн доорх мэт гурван шат үе болгон хувааж болно. 1976 оны 10 сараас 1978 оны 11 сар хүртэлх хугацааг сэргэлтийн цаг үе, манай хэвлэлийн хорооныхон соёлын хувьсгалын хатуу чанга хорио цээрийг эвдэж, хатуу нямбай сонголт хийснээс дундад улсын орчин үеийн утга зохиолын орчуулгыг хэдхэн зүйл хэвлүүлсэн байна. Гэвч тухайн үед хэвлэлийн фронтод зам эрэлхийлж байх шатанд байснаас хэвлүүлсэн зохиол бүтээл нь цөөн тоотой зүйл байж, ихэнх зохиол бүтээл нь голдуу соёлын их хувьсгалаас өмнөх хэвлүүлсэн зохиол бүтээлийн дахин хэвлэл болно. 1978 оны 11 сараас 1989 оны сүүл хүртэл хятад утга зохиолынхны “хилсийг цагаатгах, бурууг зүгшрүүлэх” хөдөлгөөн хийгээд дундад улсын орчин үеийн утга зохиолын хөгжлийн ахицад нэлээд хорио цээртэй байсан зохиол бүтээл аажмаар орчуулгын хууль ёсны чанараа сэргээж, монгол уншигчдын таалалд хүрч, шинэ цаг үеийн хятад утга зохиолын орчуулгын гол урсгал болсон байна. 1990 оноос эдүгээ хүртэл хугацааг зарим судлаачид “хожуу шинэ цаг үе” хэмээж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын шинэ нэгэн хуудсыг бичиглэсэн байна. 1976-2013 оны хооронд дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгыг сэргэлтийн үеийн монгол орчуулга (1976.10-1978.10), өрнөлтийн үеийн монгол орчуулга (1978.11-1989.6), бууралтын үеийн монгол орчуулга (1990-2013) гэсэн гурван шат үе болгон ангилж болох юм.

Нэг. Сэргэлтийн үеийн монгол орчуулга (1976-1978)

Шинэ эриний монгол үндэстний утга зохиолыг 1978 оны 11 сараас эхэлсэн гэж эрдэмтэд үздэг ч зохиогчийн зүгээс 1976 оны 10 сард соёлын их хувьсгал дуусаж, улс төр аж ахуйн сэргэлтийн цаг үед орсон байна. 1976 оны дараа дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга сэргэлтийн шатандаа орсон хэмээн үзэж байна.

(Нэг) Монгол орчуулгын ерөнхий байдал

Утга зохиол нь улс төр, цаг үеийн нөлөө тусгалаас зайлж чадахгүй нь гарцаагүй, монгол орчуулгын утга зохиолын түүх бичлэгийн явцад, улс төр нь хэзээд омтгойлж болшгүй элемент болдог. Дундад улсын шинэ цаг үеийг цаг хугацааны хувьд хүмүүс 1978 оны 12 сарын 18-ны өдөр 11 дүгээр хугацааны гуравдугаар бүгд хурал нээгдсэнээр эхлэл болгоно хэмээн үзэж байхад, зарим эрдэмтнээс 1978 оны 5 сарын 11-ний өдрөөр эхлэл болгоно хэмээн үзэж байна. Учир нь тэр өдөр “Гоминдан өдрийн сонин”-д үйлдэл бол үнэн ёсыг шалгах цорын ганц шалгуур мөн гэх өгүүлэл нийтлэгдсэн нь манай улсын “хилсийг цагаатгах, бурууг зүгшрүүлэх” хөдөлгөөний эхлэл гэдэг. Бодитжуулбал, 1976 оны 10 сараас монгол орчуулгын түүхийн шинэ шат үеийн хүүрнэлийн эхлэл болсон гэж үзэж болно. “Өвөр монголын өдрийн сонин”-д Лү Шюнь шяньшөний нас нөгчсөн 40 жилийн ойг дурсахын төлөө “Бүгд найрамдах дундад ард улсын Лү Шюнь-ий үзэсгэлэн японы Сиантай хотод нээгдэв” (1976.10.23 т 4)



THE CULTURAL WAY

гэх мэдээ нийтлэгдсэнээр дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын шинэ хуудсыг сөхсөн байна. Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос 1977 оны 8 сард анх хэвийг хийж, 1978 оны 2 сард Лү Шюнь-ий “Булш” гэх шүлэг ба задгай шүлгийн түүврийг анхлан 1-2370 дэвтэр хэвлүүлсэн байна. Энэ нь цаг үеийг заагласан ач холбогдолтой бүтээл болно. 1976 оны 10 сар соёлын их хувьсгал дууссаны дараа дээрх бүтээлүүд залгаа залгаагаар орчуулагдан хэвлэгдсэн байна. Үнэндээ монгол орчуулга энэ үеэс сэргэлтийн цаг үед орсон юм. 1976 оны 10 сар бол дундад улсын шинэ хуучин хоёр цаг үеийн зааг шугам болно. Дөрвөн хүний бүлгийн бут ниргэгдсэн нь 10 жил үргэлжилсэн соёлын их хувьсгал дуусаж, зүүний алдаа үргэлжлэхээ больж, 10 жилийн урваан, ганц хүний эзэрхийлэл, тусгаарлал, бичгийн гай барцад арилсан байна. Үзэл санааны чөлөөт урсгал хаман ирж, хориглогдошгүй урсгал болж халгин цалгив. Тус сэдэвт голдуу сонин сэтгүүл ба бар хэвлэлээр уламжлагдан тархсан дундад улсын орчин үеийн утга зохиолын бар хэвлэлээр эх хэрэглэгдэхүүн болгож, бага дунд сургуулийн хичээлийн сурах бичигт сонгогдон орсон зохиолыг хамруулсангүй.

(Хоёр) Монгол орчуулгын бүтээлийн уламжлан тархалт

Эрдэмтэд шинэ эриний утга зохиолыг 1978 оны 11 сараас эхэлсэн гэж үздэг ч зохиогчоос 1976 оны 10 сараас монгол орчуулгын түүхийн шинэ шат үеийн хүүрнэлийн эхлэл гэх үзлийн суурин дээр 1976.10-1978.10 сарын хооронд бичигдсэн дундад улсын орчин үеийн утга зохиолын орчуулагдан хэвлэгдсэн бодит байдлыг доорх мэт ангилан үзлээ.

1976.10-1978.10 сар хүртэлх орчуулагдан хэвлэгдсэн дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын байдлыг доорх мэт дүр зургаар илтгэж болно. Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын орчуулагдан хэвлэгдсэн ном бүтээлийн байдлыг илтгэсэн хүснэгт: (1976-1978)

Он	1976	1977	1978
Төрөл зүйл (дэвтэр)	2	3	6

Монгол үндэстний дундад улсын орчин үеийн утга зохиолын орчуулгын утга зохиолын түүх судлалын хөгжлийн сэргэлтийн анхан шат (1976-1977), сэргэлтийн хоёр дахь шат (1977-1978) болгон шинжилсэн нь доорх мэт задлалд үндэслэсэн байна.

1, Соёлын их хувьсгалын дараах дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын ерөнхий байдлыг ажиглахад, анхан үеийн бүтээл орчуулагдан хэвлэгдсэний дараа аажмаар өрнөлийн шатанд орсон нь мэдэгдэнэ.



THE CULTURAL WAY

1976-1977 он хүртэл жил бүр 2 буюу 3 номын хурдцаар нэмэгдсэнээсээ дахин өрнөлийн шатанд орсон байна.

2, Шинэ эринээс нааш гурван жилийн турш дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгыг илтгэсэн хүснэгтийг ажиглахад 1976, 1977, 1978 зэрэг оронд тодхон харагдана. Энэ 3 жилд тус бүр олтгойлж болшгүй ач холбогдолтой бүтээл хэвлэгдсэнээрээ монгол орчуулгын утга зохиолын түүхийн дүгнэлтийн шинж онцлог ба эхлэлийн зөн совин зэргээр мэдрэгдэнэ. Эдгээр чухал бүтээл жич эргэн тойрон дахь бүтээлүүдийг авч үзэхэд тухайн монгол орчуулгын утга зохиолын үндсэн онцлог болон ерөнхий хандлагыг олж харна.

1976-1978 оны хугацаанд өнөөгийн монгол орчуулгын утга зохиол сэргэлтийн шатандаа байж, дундад улсын орчин үеийн утга зохиолын бүтээлүүд тийм ч олон орчуулагдаж чадаагүй. Энэ нь тухайн улс төр ба утга зохиолын орчин ахуйтай нягт холбогдох нь гарцаагүй. Бусдач ба биеч талын нөхцөл бололцоог дээр өгүүлсэн учраас энд товчильё. Ийнхүү нөхцөл бололцоо бүрэн гүйцэд байдалд шинэ эриний дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга өрнөлийн шатандаа орсон байна.

Шинэ эринд орчуулагдсан дундад улсын орчин үеийн ууган бүтээл бол “Өвөр монголын өдрийн сонин”-д Лү Шюнь шяньшөн-ий нас нөгчсөн 40 жилийн ойг дурсахын төлөө “Бүгд найрамдах дундад ард улсын Лү Шюнь-ий үзэсгэлэн японы Сиантай хотод нээгдэв” (1976.10.23 т 4) гэх мэдээ нийтлэгдсэнээр дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын шинэ хуудсыг сөхсөн байна. Эдгээр орчуулгын зохиол дотроос өнөөгийн монгол утга зохиолын хөгжилд нөлөө үзүүлсэн зохиол бүтээлийг сонгон танилцуулъя.

(Гурав) Монгол орчуулгын онцлог шинж, үнэ цэнэ ба хязгаарт тал

1. Онцлог шинж

Тус хугацаанд монгол орчуулга сая сэргэлтийн цаг үед орж, илэрхий онцлог гарсан байна.

(1) Хятад утга зохиол, орчуулгын утга зохиолынхон үзэл санааны хүрээн дэх чөлөөжил хийгээд нээлтийн талаар бүх улсын түрүү эгнээнд урагшилсан байна. Соёлын их хувьсгал дууссаны дараа жилд даруй 1977 онд хятад утга зохиолынхон, орчуулгын утга зохиолынхон бүр сэргэж эхэлсэн байна. Тэр үед “үйлдэл бол үнэн ёсыг шалгах цорын ганц баримжаа” гэх асуудал, хос бүхний шугам хараахан дурдагдаагүй. Орчуулгын ажилчид соёлын их хувьсгалын хорио цээрийг эвдэж, дээрх ном бичгийг хэвлүүлсэн нь тэдний хурц гярхай хараа ба зүрх зоригийг олж харна. Гарцаагүй тухайн үеийн хэвлэлийн байгууламж аль хятад утга зохиолын орчуулгыг хэвлүүлэхэд тун



THE CULTURAL WAY

хэрсүү болгоомжтой байдаг. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, ляониний ардын хэвлэлийн хороо, хар мөрний ардын хэвлэлийн хорооноос Лү Шюньий “Булш”, Жу Дэ нарын “Улаан нарны магтаал”, “Хө Жинжы-ийн “Лай Фөний үлгэр”, Жан Тянь И-ийн “Эрдэнийн хулууны нууц”, Е Шэнтао-ийн “Хүүхдийн үлгэрүүд” зэрэг номыг хэвлүүлсэн байна.

(2) Зарим монгол сэтгүүл эхэлж хэвлэсэн ба хэвлэл сэргэв. “Өвөр монголын өдрийн сонин”, “Өнөр цэцэг” зэрэг сонин сэтгүүлд дундад улсын орчин үеийн зохиол бүтээл ба хамаарал бүхий өгүүлэл шүүмж нийтлэгдэж эхэлсэн байна. Лү Шюнь, Гуо Моруо, Сүнь Ли, Зан Көжя, Ду Пөнчөн, Хө Жинжы, Мао Зөдун, Фан Жыминь нарын шүлэг, мэдээ, шүүмж зэрэг хэлбэр төрлийн зохиол орчуулагдан нийтлэгджээ.

2. Үнэ цэнэ, хязгаарт тал

(1) Уран зохиолын сонин сэтгүүлүүд сэргэсэн нь дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын 1978 оны эцэст эхэлж өрнөн хөгжихөд нөхцөл бүрэлдэж өгсөн байна. Орчуулагчдын орчуулгын бүтээлийн халуун сэтгэл нь буураагүй, зохиол бүтээлийн орчуулга нь бүх талыг анхаарахад хичээсэн боловч гээгдүүлж орхигдуулах нь гарцаагүй юм.

(2) Зарим орчуулан хэвлүүлсэн бүтээлийн дотор ихэнх нь бүр соёлын их хувьсгалын өмнөх бүтээлийн дахин хэвлэл учраас уг хэвлэлийн зарим алдаа дутагдал, хэм архаг, үзэл санааны хорио цээр, хязгаарт чанар нь ч үргэлжлэн залгамжлагдаж, дараагийн өрнөлийн хугацааны орчуулгын бүтээлийн чанар чансааг зохих хэмжээнд нөлөөлөх нь ойлгомжтой.

Соёлын их хувьсгал дууссаны дараа, манай улсын үзэл санаа онол ба соёлын хүрээ хэмжээнд бүх талын самуурлыг төвшитгөж, хилсийг цагаатгаж, үзэл санааны чөлөөлөлтийг дагалдан хориот орны цээрийг эвдэж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга дахин хөөр хөгжөөнтэй байдалд орсон байна. Шинэ эринээс нааш дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга ч өндөр түргэн хөгжилд хүрэв. Ерөнхийлөөд хэлбэл, сэргэлтийн үеийн дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга баясам амжилттай мөртөө бас тухайн үеийн хязгаарлалаас болж зарим харамсалтай тал ч илт оршиж байсан. Энэ үеийн утга зохиолын орчуулгын сэргэлтийн шат хэдийгээр богино хугацааг туулсан боловч өрнөлийн шатны орчуулгын хөгжилд бат суурийг тавьж өгсөн байна.

Хоёр. Өрнөлтийн үеийн монгол орчуулга (1978-1989)



THE CULTURAL WAY

Өөрчлөлт нээлтээс нааш монгол үндэстний орчуулга нь 100 жилийн турш хоёр дахь удаагийн уран зохиолын орчуулгын өрнөл үүссэн байна. Энэ удаагийн орчуулгын өрнөл нь хүрээ хэмжээний талаар урьд өмнө гараагүй, орчуулгын эгнээн далайц их, тоо хэмжээ ба төрөл үйл баялаг, шинэ эринээс нааш 10-аад жилийн турш жил болгон шинэ шинэ орчуулгын бүтээлүүдийг хэвлүүлэн гаргасан байна.

(Нэг) Монгол орчуулгын ерөнхий байдал

Шинэ эринд дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын жинхэнэ эхлэл нь хятад утга зохиолын хүрэн дэх “хилсийг цагаатгах, бурууг зүгшрүүлэх” хурал, даруй 1978 оны сарын 13-ны өдрийн “Ардын өдрийн сонин”-д “Намын утга урлагийн төрийн бодлогыг нарийн нямбай тохируулъя” хэмээх зохиол нийтлэгдсэн явдал болно. Энэ зохиол нийтлэгдсэн нь үзэл санаагаа чөлөөлж, үнэнээс бодитойг эрэх, “11.3” бүгд хурлын нээгдэхийн эхний зөн совинг чавхдаад, 1978 оны 11 сарын хятад утга зохиолынхны хилсийг цагаатгаж, бурууг зүгшрүүлэхэд суурь тавьж өгсөн байна.

“11.3” бүгд хурал нээгдэхээс өмнө нэг сар, утга зохиолын орчуулгынхан Гуанжөү-д хуралдаж, 17 жилийн утга урлагийн этгээдийн олсон амжилт ба утга урлагийн шугамыг нотолж, соёлын их хувьсгалын хугацаанд хятад утга зохиолд авсан хязгаарлалын төрийн бодлогыг залруулж, орчуулгын зохиол бүтээлийг дахин дүгнэж шинэ цаг үед зохицсон төрийн бодлого, өнөөгийн утга зохиолын шинэ үр бүтээмж ба шинэ үзэл санааг судлах ба танилцуулах маш чухал үүргийг тогтоосон байна.

Энэ үеийн хятад утга зохиолын монгол орчуулгын бүтээлүүдийг соёлын их хувьсгалын үед бүрмөсөн үгүйсгэж, илээр хэвлэж болохгүй, номын санд хялбар эрж олохгүй, их сургуулийн хичээлийн танхимд хайж болдоггүй. Иймээс тус хугацаанд, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь гарцаагүй чанга хязгаарлалд учирч, зарим онцгой бүтээл нь дотоод хэвлэлээр хэвлэгдсэнээс гадна, орчуулгын утга зохиолын нэг хэсэг хоосон орон зай болсон байна. Залгаад 1978 оны 12 сарын “11.3” бүгд хурал хийгээд 1979 оны 10 сарын 30-ны өдрөөс 11 сарын 16-ны өдөр хүртэл дундад улсын утга зохиол урлагийн 4 дүгээр удаагийн бүх улсын төлөөлөгчдийн их хурал хуралдсан явдал болно. Өмнөх нь үзэл санаагаа чөлөөлөх, үнэнээс зөвийг эрэх, өөрчлөлт хийж чөлөөтэй харилцах чухал зарчим, хойнох нь шинэ цаг үед намын утга урлагийн чиглэлийг тогтоосон байна. Дөн Шяопин-ээс 4 дүгээр удаагийн утга урлагийн хуралдаанд “цэцэг бүхнийг зэргээр дэлгэрүүлэх” зэргийг хэрэгжүүлсэн байна. Үзэл санаагаа чөлөөлөх ба өөрчлөлт хийж чөлөөтэй харилцах шугам харилцан холбогдож, орчуулгын ажил нь төрийн бодлогын зоригжуулал ба баталгаа хүртсэн байна. Энэ нь орчуулагчдын халуун урмыг хөгжөөж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын



THE CULTURAL WAY

ажилд идэвхийлэн оролцож, монгол орчуулгын ажил сэргэн амилсан, өрнөн хөгжсөн шинэ шатанд дэвшин орсон байна.

(Хоёр) Монгол орчуулгын бүтээлийн уламжлан тархалт

Өрнөлийн хугацааны дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь голдуу нэрт зохиолчдын алдартай бүтээлийг орчуулахаар голлож байв. Тус хугацаанд шүлгийн түүвэр 4 дэвтэр, хувьсгалч үлгэрийн ном 2 дэвтэр, ёгт өгүүллийн түүвэр 4 дэвтэр, өгүүллэгийн түүвэр 5 дэвтэр, найрууллын түүвэр 2 дэвтэр, туужис 9 дэвтэр, хүүхдийн үлгэр 5 дэвтэр, дундад улсын орчин үеийн уран зохиолын түүхтэй хамаарал бүхий ном 1 дэвтэр, утга зохиолын онолын ном 2 дэвтэр хэвлэгджээ. Үүнд Бээжингийн үндэстний хэвлэлийн хороо 2 дэвтэр, ӨМАХХ 26 дэвтэр, ӨМСХХХ 13 дэвтэр, хар мөрний хэвлэлийн хороо 4, ляонин-ий ардын хэвлэлийн хороо 1 дэвтэр, хөнань-ий ардын хэвлэлийн хороо 1 дэвтэр, гирын-ий ардын хэвлэлийн хороо 1 дэвтэр хэвлэжээ. Энэ нь өмнөх үетэй харьцуулбал хэлбэр төрөл нь баялагжиж, цаг үеийн хүчит урсгалтай уялдсан байна.

1978.11-1989.6 он хүртэлх өрнөлийн үеийн орчуулагдан хэвлэгдсэн дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын байдлыг доорх мэт зургаар илтгэж болно.

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын орчуулагдан хэвлэгдсэн байдлыг илтгэсэн зураг (1978-1989)

Төрөл	7	6	7	6	2	4	1	3	7	0	3	1
Он	78	79	80	81	82	83	84	85	86	87	88	89

Энэ үеийн орчуулга нь сэргэлтийн үетэй харьцуулбал цаг үеийн урсгалтай айзам нэгдэж, тоо хэмжээ нь илэрхий нэмэгдэж, чанар чансаан талаар мэдэгдэхүйц дээшилсэн байна.

(Гурав) Монгол орчуулгын онцлог шинж, үнэ цэнэ ба хязгаарт тал

1. Онцлог шинж

Тус хугацааны монгол орчуулгад доорх хэдэн талын онцлог илэрсэн байна.

(1) Тусгайлан орчуулгын утга зохиол нийтлэг сэтгүүлийн тоо олширсон байна. 50, 60-аад онд зөвхөн “Өвөр монголын өдрийн сонин”, “Өнөр цэцэг” зэрэг сэтгүүлд нийтэлж байснаас 80-аад оноос нааш “Цолмон”, “Алтан түлхүүр”, “Монгол хэл утга зохиол”, “Өвөр монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл” зэрэг сонин сэтгүүлд нийтлэгдэж эхэлсэн байна. Лү Шюнь, Гуо Моруо, Мао Дунь, Ба Жинь, Ай Чин, Бин Шинь, Тянь Жянь, Жу



THE CULTURAL WAY

Зычин, Жан Тянь И, Фан Жыминь, Мао Зедун зэрэг хувьсгалчдын шүлэг зохиол, шүүмж, дурссан шүлэг, үлгэр, захидал, мэдээ, найруулал, тууж, хамаарал бүхий зохиогч ба зохиол бүтээлийн шүүмж нийтлэгдэж байв.

(2) Олонх хэвлэлийн байгууламж орчуулгын бүтээлийг хэвлүүлж, тусгай орчуулдаг байгууламж байгуулагдсан байна. Тухайн үед хамгийн нөлөөтэй нь ӨМАХХ, ӨМСХХХ, үндэстний хэвлэлийн хороо зэрэг байдаг.

(3) Хэвлэлийн хорооны хэвлүүлсэн нь бүр хуучин хэвийн дахин хэвлэл болно. Соёлын их хувьсгал дуусаад удаагүйн дээр тэр даруйд нь орчуулагчдыг зохион байгуулж орчуулах нь ч бас зохих цаг хэрэгсэх учраас хэвлэлийн хороо хоол ундаар дугааж байв. Лү Шюнь-ий “Хятад нангиадаар айлдсан түүвэр”, Ли Жи-ийн “Ван гүй хийгээд Ли шян шян”, Жөү Либо-ийн “Догшин салхи ширүүн бороо” зэрэг зохиол бүтээл нь хэдийгээр сонгодог бүтээлийн дахин хэвлэл боловч бүх улсын хэмжээнд халуун хүлээллийг олж донслолт гаргажээ. Олонх уншигчид номын дэлгүүрээс булаалдан худалдан авах үзэгдэл буй болжээ.

(4) Дундад улсын орчин үеийн утга зохиолын сонгомол бүтээл нь их хэмжээний системтэйгээр монгол хэлэнд нэлээд олон орчуулагдаж, дундад улсын орчин үеийн утга зохиолын гол урсгал ба гол болгосон байна. Өнгөрсөн зууны 80-аад онд орчуулагдсан монгол орчуулга нь Лү Шюнь-ий “Хоёр сэтгэлийн түүвэр”, “Шүхэр одны түүврийн үргэлжлэл”, Гуо Моруо-ийн “Аварга долгион дуулал”, Ба Жинь-ий “Хавар, “Гэр, “Намар”, Лао Шө-ийн “Тэмээн Шян Зы”, Мао Дүн-ий “Шөнө дөл”, “Хаврын хүр”, Жөү Либо-ийн “Догшин салхи ширүүн бороо”, Вэнь И Дуо-ийн “Хувцас угаагчийн дуулал”, Ли Жи-ийн “Ван гүй болон Ли шян шян” зэрэг ном зохиол орчуулагдан хэвлэгдсэн байна.

(5) Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга аажмаар нэмэгдэх хандлага илэрсэн байна. Хэдийгээр энэ хооронд 1981 оны үзэл санаа онолын фронт дорой буурай, 1983 оны үзэл санааны бохирдлыг арилгах хийгээд 1987 он, 1989 оны хөрөнгөтөн ангийн эрх чөлөөний хөдөлгөөнөөс хүртсэн нөлөө тусгал зэрэг бүх цогцоос үзвэл, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга бүхэлдээ дээшлэх хандлагатай байж, тэр нь шинэ эриний хятад утга зохиолын орчуулгын гол чавхдас болсон байна.

2. Үнэ цэнэ ба хязгаарт тал

(1) Өрнөлийн хугацаанд дундад улсын утга зохиолын хүрээнд үзэл ухамсрын талаар эргэлтийн шатанд оршиж байжээ. Хуучны уран зохиолын орчуулгын бүтээл туурвил нь үзэл санаа, агуулга дээр эсвэл илрүүлэх арга барилын талаар бүр тухайн цаг үе хийгээд уншигчдын шаардлагыг хангаж



THE CULTURAL WAY

чадахгүй байжээ. Уран зохиолын олон ишт систем дотор монгол орчуулгын уран зохиол гэх энэхүү систем нь хоосон зай гарах үед дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгад нөхцөл хангаж өгсөн байна.

(2) Хуучны хоёр ишт онолын загвар нь нэг зүйлийн түүхэн сэтгэхүйн даатгалын чанартай байдаг учраас зарим үед зарим үед зохих хэмжээний нөлөө үзүүлдэг. Энэ нь дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга зохих шилжилтийн цаг үеийн онцлогтой байж, ер бусын цаг үеийг туулж ирсэн гэдгийг харуулж байна. Үүний дагуу хөгжил нь системт чанартай бөгөөд бүх талын чанартай байж, дундад улсын орчин үеийн утга зохиолын хөгжилтэй алхам таарч байдаг. Дээрх тоочлоос үзвэл, ихэнх орчуулгын бүтээл нь анх хэвлэгджээ.

Монгол орчуулгын эгнээ аажмаар бүрэлдэж, орчуулгын чанар чансааг анхаарч эхэлсэн ба орчуулгын хүрээнд 80 гаруй орчуулагчтай болж, дотор нь алдартай орчуулагч, судлаач, зохиогчийг ч багтааж буй. Эдгээр алдартай орчуулагчийн орчуулгын бүтээл нь үнэнч шударга байхыг эрхэмлэж, нэлээд өндөр урлагийн хэр түвшинтэй байж, шүүмжлэгч ба уншигчийн өндөр үнэлэлийг олж, одоо болтол өргөнөөр уламжлагдаж буй. Гэвч өргөн хэмжээний монгол орчуулгын өрнөлийн байдлыг буй болгож чадаагүй нь харамсалтай.

Гурав. Бууралтын үеийн монгол орчуулга (1990-2013)

20 дугаар зууны 90-ээд он өнгөрсний дараа, зах зээлийн аж ахуйн бүх талаар хөгжиж, байгууламжийн талын хууль ёст чанарыг баталсны дараа, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгад шинэ онцлог илэрч, өнгөрсөн зууны 80-аад оны сүүлээр хөгжлөөс аажмаар бууралтын шатанд орж, шинэ зуунаас нааш нэн монгол орчуулгын түүхийн хамгийн доод хэмжээнд хүрсэн байна.

(Нэг) Монгол орчуулгын ерөнхий байдал

Өнгөрсөн зууны 80-аад онд хэдийгээр эдүгээчлэлийн хөгжлийн байдлыг дурдсан боловч тухайн үед төлөвлөгөөт аж ахуйн тогтоцоос зах зээлийн аж ахуйн тогтоцын тохируулалын явцад байснаас дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь төрийн байгууламжтай нягт хатуу харьцаа холбоотой байжээ. 1992 онд Дөн Шяопин-ий “Өмнө орныг тойрон үзсэн яриа”-г нийтэлснээс дундад улсын зах зээлийн аж ахуй нь төлөвлөгөөт аж ахуйг олсны бэлгэ тэмдэг болсон байна. Үүний дүнд нэг талаар, хэвлэлийн байгууламж нь зарчим дээрээ зах зээлд түлхэгдэн орсон байна. Энэ үед орчуулсан зохиол бүтээл нь хэвлэлийн хороонд аж ахуйн ашиг тусыг ч бодохгүй байхын аргагүй болжээ. Нөгөө талаар, булаалдан орчуулах ба бусдын зохиолыг хуулан орчуулах жич дураараа орчуулах зэрэг төв бусын суртал буй болсноос зарим хэвлэлийн байгууламжийн хэвлүүлсэн ном зохиолын чанар чансаа доошилж, тэдгээр ном зохиол нь зах дэлгүүрт тархсан байна. Хэдий



THE CULTURAL WAY

тийм боловч алдартай зохиолчийн нэрт бүтээлийг алдартай орчуулагч орчуулах зэргийг баримталснаас тэд нар орчуулгын зах зээл дээрх гол хүч болсон байна. Үүнд өвөр монголын ардын хэвлэлийн хороо, өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, үндэстний хэвлэлийн хороо зэрэг хэвлэлийн байгууламж цолгорон гарсан байна.

1992 оны 10 сар манай улс “Дэлхийн хэвлэлийн гэрээ”¹-нд оров. Өнгөрсөн зууны 90-ээд оноос нааш манай улсын нийгэм улс төр тогтоод, олон ишт, нээлттэй, ардчилсан нийгэмд орж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын бадрал ба хөгжилд нэлээд сайн нөхцөл хангаж өгсөн байна. Хэвлэсэн ном хэвлэл Лү Шюнь-ий “Хятад нангиадаар айлдсан түүвэр”, “Лао Шө-ийн “Дөрвөн үет том өрх”, “Фан Жыминь-ий “Хайрт дундад улс”, “Шяо Чянь-ий найрууллын сонгомол” зэрэг бүтээл буй.

Өнгөрсөн зууны 90-ээд оноос нааш “Өвөр монголын өдрийн сонин”, “Алшаагийн сонин”, “Баян нуурын өдрийн сонин”, “Шилийн голын өдрийн сонин”, “Хөлөн буйрын өдрийн сонин”, “Жиримийн сонин (Тунляо өдрийн сонин)”, “Ордосын сонин”, “Улаанцавын сонин”, “Хинганы өдрийн сонин”, “Улаанхадын өдрийн сонин”, “Өнөр цэцэг”, “Дэлхийн утга зохиол”, “Алтан түлхүүр”, “Цолмон”, “Хөлөн буйр”, “Шар мөрөн”, “Монгол хэл утга зохиол”, “Цэцэгт цайдам”, “Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан”, “Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл” зэрэг сонин сэтгүүлүүдэд нийтлэгдэж эхэлсэн байна. Лү Шюнь, Мао Дунь, Ба Жинь, Лао Шө, Цао Юй, Ай Чин, Тянь Жянь, Жу Зычин, Зан Көжя, Чюй Чюбай, Бин Шинь, Шяо Чянь, Юй Дафу, Шэнь Цунвэнь, Сүнь Ли, Чинь Мү, Жян Гуандүй, Дуаньмү Хунлян, Дин Лин, Чянь Жуншу, Фан Жыминь, Мао Зөдун, Жу Дө зэрэг хувьсгалчдын шүлэг зохиол, намтар, үлгэр, мэдээ, найруулал, тууж, хамаарал бүхий зохиогч ба зохиол бүтээлийн шүүмж нийтлэгдэж байв.

2003 онд дундад улсын мэдлэгийн эрхийг хамгаалах байгууламж ч улам нэг алхам хөгжиж, “Зохиол бүтээлийн хэвлэлийн эрхийн тухай засаг захиргааны торгуулийг явагдуулах төсөл”² зэргийг баталсан байна. Хэвлэлийн эрхийг хамгаалах ажил тууштай явагдаж, хууль зөрчин хэвлэлийн эрхэнд халдсан явдлыг хатуу шийтгэх зэрэг дэглэм чангарснаас дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга аажмаар буурсан байна. Бас нэг чухал шалтгаан нь 2003 онд дундад улсад сарс (sars) өвчин дэлгэрч, манай улсын бүх фронтод нөлөөлсөн байна. Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгад ч нөлөөлснөөр барахгүй ялангуяа интернет сүлжээ, телевиз, кино урлаг зэрэг соёлын нөхцөл байдлын хурдан хөгжилт зэрэг нь хүмүүсийн

¹ 孙致礼编著：《我国英美文学翻译概论》（1949-2008），译林出版社，2008年，第205页。

² 孙致礼编著：《我国英美文学翻译概论》（1949-2008），译林出版社，2008年，第207页。



THE CULTURAL WAY

хэрэглээний хэлбэрийг улам олон ишт чанартай болгож монгол орчуулгын утга зохиолд түрэлтийг авч ирсэн юм. 2003 оны сүүлээр дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга мөн өдөр ирэхүй буурах хандлагатай болжээ. Үүнээс гадна орчуулгын шүүмжийн ажлыг өрнүүлсэн, орчуулсан бүтээлийн дэмжлэг шагнал, онцгой үр бүтээмжтэй орчуулагчийг шагнах зэрэг нь монгол орчуулгын чанар чансаанд хяналт тавьж, монгол орчуулгын эрүүл хөгжих замд орсныг харуулж байна.

(Хоёр) Монгол орчуулгын бүтээлийн уламжлан тархалт

Бууралтын хугацааны дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь голдуу алдартай зохиолчийн сонгодог бүтээлийг орчуулахаар голлож байв. Тус хугацаанд шүлгийн түүвэр 4, хүүхдийн үлгэр 1, найрууллын түүвэр 2, тууж 2, дундад улсын орчин үеийн уран зохиолын түүхийн хамаарал бүхий ном 5 дэвтэр хэвлэгджээ. Үүнд БҮХХ 2, ӨМАХХ 7, ӨМСХХХ 3, ЛяХХ 1, ӨМИСХХ 1 дэвтэр хэвлэжээ. 1999-2013 он болтол бууралтын үед орчуулагдан хэвлэгдсэн дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын байдлыг доорх мэт зургаар илтгэж байна.

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын орчуулагдан хэвлэгдсэн байдлыг илтгэх хүснэгт (1990-2013)

Төрөл	1	1	1	2	2	1	2	1	2	2	1
Он	1991	1992	1993	1997	1998	2000	2001	2003	2008	2009	2010

Энэ үеийн орчуулга нь өрнөлийн үетэй харьцуулбал, төрөл хэлбэр нь хомстож, чанар чансаан талаар мэдэгдэхүйц дээшилсэн боловч, тоо хэмжээний талаар өмнөх үеийнхээс тун дутуу байж, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын тухай хүмүүсийн анхаарал бууралтын шатанд орсон гэдгийг харуулж байна.

(Гурав) Монгол орчуулгын онцлог шинж, үнэ цэнэ, хязгаарт тал

1. Онцлог шинж

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь шинэ эринээс нааш хамгийн хөгжил дэвшилтэй байдалд орсон гэж хэлж болно. Бүх төрлийн хэлбэр ба хэв маяг бүхий орчуулгын бүтээл хамтдаа оршиж, цэцэг бүхэн зэргээр дэлгэрэх байдал илэрсэн байна. Зохиол бүтээлийн орчуулга ч эрдэм бүхэн чөлөөтэй хэлэлцэх байдалтай болжээ. Энэ нь нөгөө талаас өрнөн хөгжиж бадран дэлгэрсэн байдлыг илтгэнэ. Шинэ эринд ахмад нэг үеийн



THE CULTURAL WAY

орчуулагчид илрэн гарч ирсэн байна. Тэд тасралтгүй шинэ бүтээлээ уншигчдын мэлмийд хүргэж, нэрт зохиолчийн алдартай бүтээлийг орчуулсаар байжээ. Үүний хамт бид баясалтай олж харах нь өөрчлөлт нээлтийн дараах 40 гаруй жилийн турш монгол үндэстний орчуулгын үйлсийн хүрээнд шинээр буй болсон буюу ялгаран гарч ирсэн нэг бүлэг шинэ хүч буй болсон байна. Тэд бат ноттой харь хэлний боловсрол ба хятад монгол хэлний сууриар орчуулгын ажлыг хайрлаж, ажилдаа хариуцлагатай нарийн хянамгай ажиллан, урьдах үеийн хүмүүсээс хол давуу нөхцөлийн суурьтай нэн урагшласан орчуулгын үзэл ойлголттой байж, тэдний аль олон орчуулгын бүтээл нь хэр түвшнээр авч хэлбэл, өмнөх үеийн орчуулагчдын зохиол бүтээлээс нэг хэмжээ дээшилсэн байна.

Хэвлэлийн байгууламжийн талаас үзвэл, шинэ орчуулсан бүтээл нь хуучин орчуулсан бүтээлээс нэн илүү итгэлтэй байдаг. Уран зохиолын орчуулгын талаас авч хэлбэл, ахмад орчуулагчдын бүтээл нь нэн итгэмжтэй шиг санагдана.

Нэг улсын нэг цаг үеийн орчуулгын хэр түвшнээр авч хэлбэл, голдуу тэгшитгэсэн хэр түвшин нь хэдий өндөр гэдгийг үзэх биш, харин шилдэг орчуулгын бүтээл нь ямар хэр түвшинд хүрснээр үзэх хэрэгтэй. Шинэ эринээс нааш 38 жилийн хугацаанд дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга 56 боть бүтээл орчуулагдсан ба өндөр хэр түвшинтэй шилдэг бүтээл ч танилцуулагдсан байна. Өнөөдөр бид шинэ эринээс нааш шилдэг орчуулгын бүтээлийг 19 жилийн үе ба соёлын их хувьсгалын үеийн орчуулгын бүтээлтэй харьцуулбал, шинэ эринээс нааш орчуулгын бүтээл нь уг бүтээлийн суурин дээр орчуулгын үзэл ойлголтын эзэмшил жич хэлний хэрэглэлтийн цаг үеийн төрөгдлийн суурин дээр ил тодорхой урагшлалт ба дээшлэлттэй байдаг.

2. Үнэ цэнэ, хязгаарт тал

(1) “Өвөр монголын өдрийн сонин”, “Алшаагийн сонин”, “Баян нуурын өдрийн сонин”, “Шилийн голын өдрийн сонин”, “Хөлөн буйрын өдрийн сонин”, “Жиримийн сонин (Тунляо өдрийн сонин)”, “Ордосын сонин”, “Улаанцавын сонин”, “Хинганы өдрийн сонин”, “Улаанхадын өдрийн сонин”, “Өнөр цэцэг”, “Дэлхийн утга зохиол”, “Алтан түлхүүр”, “Цолмон”, “Хөлөн буйр”, “Шар мөрөн”, “Монгол хэл утга зохиол”, “Цэцэгт цайдам”, “Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан”, “Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, “Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл” зэрэг сонин сэтгүүлүүдэд нийтлэгдэж эхэлсэн байна. Лү Шюнь, Мао Дунь, Ба Жинь, Лао Шө, Зан Көжя, Бин Шинь, Юй Дафу, Шэнь Цунвэнь, Чянь Жуншу, Фан Жыминь, Мао Зөдун зэрэг хувьсгалчдын шүлэг зохиол, намтар, үлгэр, мэдээ, найруулал, тууж, хамаарал бүхий зохиогч ба зохиол бүтээлийн шүүмж нийтлэгдэж байв.



THE CULTURAL WAY

(2) 1990 оноос 2013 он болтол дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын тоо хэмжээ улмаар багассан нь орны дотно гаднах уншигч ба орчуулагчдын зохиол бүтээлийн халуун урам аажмаар буурсныг харуулж байна. Энэ хугацааны орчуулгын явцад орчуулагдсан зохиол бүтээл нь өвөр монгол орны зохиолчдод чухал нөлөө тусгал үзүүлж, зохион бүтээх сэтгэхүй ба зохион бүтээх арга хэлбэр дээр бүр орон нутгийн зохиолчдын хандлагыг тэлж, хорвоо талаас нэн уужуу байж, шинэ туршилтын зам, шинэ орон зайг нээн өгсөн байна.

Шинэ эринээс нааш монгол орчуулгын эгнээ аажмаар сайжирч, орчуулгын чанар чансаа ч дээшилжээ. Орчуулагчийн хэв маяг хийгээд зохиогчийн хэв маяг, эсвэл орчуулгын бүтээлийн хэв маяг хийгээд уг бүтээлийн хэв маягийн органик нэгдэл бол орчуулгын утга зохиолын гоо зүйн хүслэнт ахуй болно³. Монгол орчуулгын хүрээнд 100 гаруй орчуулагчийн дотор алдартай орчуулагч, судлаач, зохиогчийг ч багтааж буй. Үүнд Н.Сайнцогт, Оргил, Эрдэмбаатар, Пэрэнлэй, Дугарсүрэн, Баяр, Сольфунгаа, Содномравдан, Гэрэлцогт, Гээ, Н.Сундуй, Содбилэг, Жигжид, Ренчинкава, М.Хишигжаргал, М.Асар, Эрдэнэжав, Содном, Гээравжаа, Амгалан, Т.Сайнбаяр, Б.Бат, Жамбал, Дүйнхоржав нар амжилтаар товойм байдаг. Орчуулагчдын орчуулгын бүтээл нь үнэнч шударга байхыг эрхэмлэж, нэлээд өндөр урлагийн хэр түвшинтэй байж, шүүмжлэгч ба уншигчийн өндөр үнэлэлийг олж, одоо болтол өргөнөөр уламжлагдаж буй. Ерөнхийлөн хэлбэл, шинэ эринээс нааших гучин найман жилийн турш дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга баясам амжилттай гэдэг боловч бас харамсалтай тал ч буй. Энэ үеийн орчуулгын бүтээл нь өмнөх үеийнхээс чанар чансаан талаар хол давсан байна.

Соёлын их хувьсгалын дараах хэдэн жилийн хугацаанд ажил ухамсрын хүрээнээ хэдийгээр уран зохиолыг хязгаарлах элемент оршиж байсан боловч өнгөрсөн зууны 80-аад оны эх хүрээд дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга бүх талын өрнөл хөгжлийн шатандаа орсон байна. Орчуулагдсан зохиол бүтээл нь тоо хэмжээ ба чанар чансаан талаар өмнөх үеэс мэдэгдэхүйц хувирал гарсан ч 90-ээд оноос нааш нэлээд хөгжөөнтэй байсан орчуулгын үйлс аажмаар бууралтын шатанд орсон байна. Нэн ялангуяа орчуулагдан хэвлэгдсэн ном зохиолын тоо хэмжээ шинэ зуунаас нааш дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын түүхэн дэх хамгийн доод хэмжээнд хүрсэн байна. Энэ нь манай орчуулгын утга зохиолын хүрээнээ орчуулгын үйлсийг хүндэтгэж, орчуулагчдын нийгэм дэх байр суурь зэрэгт анхаарлаа хандуулж орчуулгын утга зохиол гэх тусгай шинжилгээг тунгаах шаардлагатай болсон гэдгийг хүмүүст сэрэмжлүүлсэн байна. Ерөнхийдөө монгол орчуулгын үйлс муруй хазгай замаар явсан боловч олсон амжилт нь гол

³ 宋学智主编：《翻译文学经典的影响与接受-傅译《约翰克利斯朵夫》》，上海译文出版社，2006年，第240页。



THE CULTURAL WAY

болох бөгөөд нотлуштай юм. Олонх орчуулгын бүтээлүүд нь шинэ эринээс нааш анх удаа хэвлэгджээ.

Соёл алсалсан ба хэл алсалсан харилцаа бол даруй урт удаан хөгжлийн явц дахь тасаршгүй орчуулгын үйлдэл мөн. Харьцуулсан уран зохиолын судалгаа бол ойрын 100 гаруй жилийн турш соёлын мөргөлдөөн солбицлоор суурь болгосон уран зохиолын судалгаа мөн⁴. Солилцоогүй орчуулгын чухал чанар оршихгүй, орчуулга үгүй бол ондоо хэл, ондоо шинж бүхий соёлын солилцоо ч оршихгүй⁵. Соёлын орчин нь утга зохиолыг хүлээн авахад нөхцөл бүрэлдүүлэн өгч, утга зохиолын хүлээнгүй нь соёлын орчинг ахиулан гүнзгийрүүлдэг⁶. Утга зохиолын хүлээн авалт бол оюун санааны үйл ажиллагаа болно⁷. Хүлээн авах судлал бол хүлээн авах түүхэн хэлний орчин соёлын хэлний орчин дахь судлал болно.

Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга монгол зохиолчдын зохион бүтээлтэд агуулга хэлбэр, утга сэдэвлэхүүн, зохиомж байршуулалт, үг хэл зэрэг олон талаар нөлөө тусгал үзүүлжээ. Тэд өөрийн онцгой арга хэлбэрээр өөр бусад үндэстний соёлыг шингээх ба хүлээн авч байв. Алдарт шүлэгч Н.Сайнцогт, Б.Бүрэнбэх, Гэрэлцогт, Ардай, Мэргэн, Батмөнх, А.Одсэр, Лигдэн, Аянга, Сундуй, Ноломсаран, Л.Чулуунбаатар нар өөрийн үндэстнийхээ түүх соёл ба утга зохиолын уламжлалаа гүн судалж гүнзгий ойлгоод, сайтар залгамжилсан суурин дээр орчуулгаар зохион найруулах анхны боловсролоо болгож, өдөр ирэхүй сайжран боловсорсон юм. Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь хятад монгол үндэстний соёлын солилцоонд идэвх нөлөө үйлдэл үзүүлсэн бөгөөд өнөөгийн монгол утга зохиолын хөгжилд шинэ элементийг нэмэрлэсэн байна. Монгол орчуулгын утга зохиолын түүх шинжилгээ нь өнөөгийн монгол утга зохиолын хөгжлийн хандлага жич агуулга хэлбэрийн сонголт ба тэлэлт зэрэг олон талыг судлахад зохих нөлөө үйлдэл үзүүлэхээр барахгүй, монгол утга зохиолын эдүгээч эргэлтийг гүнзгий шинжлэхэд цөм чухал ач холбогдолтой юм.

Шинэ эринээс нааш дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын тухай 40-өөд жилийн судалгааны байдлыг ажиглавал, 70 гаруй өгүүлэл шүүмж нийтлэгдэж, шинэ зуунаас өмнө нэлээд олон байж, ойрын хэдэн жилд хэдхэн өгүүлэл нийтлэгдсэн байна. Голдуу зохиогчийн судалгаа, зохиол бүтээлийн судалгаа, урлаг гоо зүйн судалгаа зэрэгт төвлөрч, Лү Шюнь жич түүний зохиол бүтээлийн судалгааны өгүүлэл шүүмж хамгийн арвин нийтлэгдэж, бусад зохиолчид жич тэдгээрийн зохиол бүтээлийн судалгааны

⁴ 曹顺庆:《跨文明比较文学研究-比较文学学科理论的转折与建构》,《中国比较文学》,2003年第1期,第72页。

⁵ 许钧:《文化「差异」与翻译》,《中国比较文学》,1997年第1期,第74页。

⁶ 董洪川:《文化语境与文学接受》,《外国文学研究》,2001年第4期,第23页。

⁷ 童庆炳著:《文学理论教程》,高等教育出版社,2002年,第286页。



THE CULTURAL WAY

өгүүлэл шүүмж дараагийн байранд орсон байна. Судалгааны өгүүлэл зохиол өмнөх үетэй харьцуулбал, судалгааны хараа тэлж, харьцуулан судлах, тусгайлан судлах жич ширхэгчлэн судлах, хураангуйлан судлах ба хэдэн эмэгтэйчүүдийн уран зохиолын нөхцөл байдлыг судалгаа зэрэг өргөн цар хүрээнд гүнзгийрч байна.

ДҮГНЭЛТ

Соёлын их хувьсгалын дараа дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга нь сэргэлтийн цаг үе “хилсийг цагаатгаж, бурууг зүгшрүүлэх”-ээс бүх талаар хөгжих жич бууралтын шатыг дамжиж, шинэ зуунаас нааш монгол орчуулгын хамгийн доод хэмжээнд хүрсэн байна. Нэгдүгээр шат нь (1976.10 – 1978.11) дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын сэргэлтийн шат, соёлын их хувьсгалын үеийн өөрийн би-гээ үхмэлээр хязгаарлах арга маягаас мултарч, хятад сонгодог зохиол бүтээлийг дахин хэвлэсэн байна. 1978 оны 11 сараас дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын хууль ёст чанарыг баталж, монгол орчуулга бүх талын хөгжлийг олж, өрнөлийн шатанд оров. Өнгөрсөн зууны 90-ээд оноос хойш зах зээлийн аж ахуйн бүх талын хөгжил жич дэлхийн хэвлэлийн гэрээнд элсэн орсны дараа шинэ онцлог илэрсэн байна. Зохих хэмжээнд булаалдан орчуулах, дураараа орчуулах зэрэг төв бус суртал буй болсон ч дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын тоо хэмжээ, чанар чансаа, орчуулгын системт чанар зэрэг нь сэргэлтээ олж, төдий л хөгжиж амжсангүй дахин бууралтын шатанд орсон хөгжлийн үл мөрийг хайн мөшгөж болно. Ойрын жилд монгол утга зохиол ба орчуулгын утга зохиол, интернет цахим сүлжээний утга зохиолын маягаар уншигчдын хараанд орж, өргөн олон уншигчтай нүүр тулах болсноос нэг талаар орчуулгын утга зохиолын шинэ нэгэн хөгжлийн хандлагыг харуулсан төдийгүй нөгөө талаар бичгийн уран зохиолын орчуулгын өрнөлөөс бууралтын шатанд орсон гэдгийг танин мэдэж болно.

ABSTRACT



THE CULTURAL WAY

Mongolian translation of modern Chinese literature can be roughly divided into three stages. During the restoration period from October 1976 to November 1978, only a few translation works of modern Chinese literature were translated and published. However, only a few works were published during this period of exploring the publishing front, and most of them were reprints of works published before the "Cultural Revolution". November 1978 to the end of 1989, for the Chinese literary circle "redress grievances, put things in order" and some taboo works forbidden during the development of modern Chinese literature, gradually regained the legitimacy of translation and were favored by Mongolian readers, and becoming the mainstream of Chinese literature translation in the new era. Since 1990, Mongolian translation of Modern Chinese literature has written a new page. Therefore, the history of Mongolian translation of modern Chinese literature from 1976 to 2013 can be divided into the three stages, like recovery period (1976.10-1978.10) and the climax period (1978. 11-1989. 6) and low tide period (1990-2013).

Keywords: *Modern Chinese literature in the new century, Mongolian translation, dissemination*

НОМ ЗҮЙ

1. 许钧：《文化「差异」与翻译》，《中国比较文学》，1997年
2. 董洪川：《文化语境与文学接受》，《外国文学研究》，2001年
3. 童庆炳著：《文学理论教程》，高等教育出版社，2002年
4. 曹顺庆：《跨文明比较文学研究-比较文学学科理论的转折与建构》，《中国比较文学》，2003年
5. 宋学智主编：《翻译文学经典的影响与接受-傅译《约翰克利斯朵夫》》，上海译文出版社，2006年
6. 孙致礼编著：《我国英美文学翻译概论》（1949-2008），译林出版社，2008年

ЛАО ШӨ ба М.ХАСБАГАНЫН СОЁЛТ ТУУЖ ДАХЬ ДҮР БҮТЭЭЛТИЙН
ХАРЬЦУУЛАЛ

Нахиа*

ХУРААНГУЙ

М.Хасбаганын төлөөлөх чанартай соёлт тууж “Засгийн хутгуур”, “Тэр холын бараа” гэх хоёр роман ба Лао Шө-ийн “Тэмээ шянзы”, “Дөрвөн үет том өрх”, “Хавирган сар” гэх гурван бүтээлийг сонгон тус тусынх нь дүр бүтээлтийн онцлогийг задалсан үндсэн дээр дахин харьцуулан өгүүллээ. Дүр бол тууж бүтээлийн хамгийн чухал элемент мөн. Хятад уран зохиолын тавцанд чухал байр суурьтай ахуйч үзлийн зохиолч Лао Шө-ийн “Тэмээ шянзы”, “Дөрвөн үет том өрх” хоёр романы уран дүрийг задалж, монгол уран зохиолын тавцан дээрх нөлөө ихтэй ахуйч үзлийн зохиолч М.Хасбаганын “Засгийн хутгуур”, “Тэр холын бараа” гэх хоёр романы дүртэй харьцуулан шинжилж, нийгмийн орчин ба соёлын орчин адил бус хоёр зохиолчийн бийр доор бүтээгдсэн дүрийн харьцаа холбоог шинжлэх болно.

Түлхүүр үгс: *М.Хасбагана, Лао Шө, соёлт тууж, дүр бүтээлт, харьцуулсан судлал*

Нэг. Лао Шө-ийн соёлт тууж дахь дүр бүтээлтийн задлалт

Лао Шө-ийн тууж бүтээл дэх дүр бүтээлтийн тухай судлаачид “Лао Шө бусад зохиолчийн маш цөөн бүтээдэг, нийтлэг утга агуулгатай бөгөөд өвөрмөц онцлогтой хотын ядуу ардын дүрийг бүтээв”¹ гэж үнэлэв. Тэмээ шянзы дахь Шянзы, Шяо Фузы нар, Хавирган сар дахь “Би” нь цөм хотын ядуу ардын төлөөлөгч дүр болно. Тэмээ шянзы дахь төлөөлөгч дүр Шянзы, Лю өвгөн, Ху Нью, Шяо Фузы, Э Чянзы сэхээтний дүр Цао овогт ба Ян овогт нар болно. Эдгээр хүмүүсийн дотор Шянзы бол анх эхлэхдээ цэвэр ичимтгий, хэдийгээр мөнгө олохыг хичээдэг боловч өөрийнхөө чадал хэмжээнд төсөөлөхийг бодлогоос биш, илүүц олзонд дурладаггүй, үнэнч цайлган, зүтгэлтэй, цог жавхаатай байснаасаа өөрийнхөө хэвшмэл хөдөөний зан сэтгэхүй хийгээд балар харанхуй нийгмийн шахалт доор алжуу залхуу, хувинцар, биеэ хайрлахыг л мэдэх, хүмүүсийн татаж үлдээсэн тамхины үлдэгдлийг хүртэл түүн татаж өдөр өнгөрөөдөг, бузар муухайн төлөөлөгч болж хувирчээ. Лю өвгөн маш зальтай, олзонд дуртай, үнэнч бус, олзны төлөө төрсөн хүүхнийхээ үрэгдүүлэхээс ч буцахгүй. Ху Нью бол нэгэн хөөрхийлөлтэй дүр юм, гэвч түүний зан араншин нь хүнээр өрөвдүүлэхгүй.

* ӨМИС, МСДС-ийн 2022 оны магистрант. 13337029388, 2100955239@qq.com

Удирдагч багш: Кань Хай Ин

¹ 曾广灿, 吴怀斌: 老舍研究资料(下), 北京知识产权出版社, 2010年版, 679页。



THE CULTURAL WAY

Шянзы-ийн үзэж сонссон зүйл нь түүний өнгөрсөн үеийн Шянзы-тэй бүрмөсөн эсрэг тэсрэг хүн болгов, тэр олон муу дадал сурч, өдөр өнгөрөөх тэрэгчин болжээ. Тэрээр бас сайн сайхан амьдралыг бодож байсан ч түүний өнгөрснөө бодсоор тэр сэтгэл нь хөрчихнө. “Хүчирхэг байгаад яах вэ? өөрөө өнгөрсөндөө бас хүчирхэг байсан биш үү, эцэстээ бас л ийм хэмжээнд хүрсэн биш үү, илүү нэг өдөр бие амар баяртай байхад хүрэхгүй” гэж бодох болов. Хамгийн эцэст, түүний эцсийн найдлага – Шяо Фузы энэ ертөнцөөс салж, бүрмөсөн горь тасарчээ. Нэгэн хөдөөнөөс ирсэн борогжуу, номхон, чихрэг /*чийрэг*/ залуу ингэж доройтоод хүнд өрөвдүүлэх луйварчин болж, хамгийн сүүлд нэг нохой шиг зээл дээр унаж, дахин босож чадахгүй болжээ. Шянзы бол хуучин нийгмийн ядуу зүдүү хөдөлмөрчин ард түмний цомхотгол дүр болно, тэр хуучин нийгмийн ард түмний хүнд хүчир зовлон ба арга мухардлыг тусгав.

Ху Нью их л явдал учрыг төвхнүүлж чадна, Рэнь Хө тэрэгний үйлдвэрийг эмх цэгцтэй хамаарч байдаг. Их арга ухаантай, тэр Шянзы-г мэхлэн түүнтэй хуримлав. Гэвч аав нь түүнийг шууд хаяад тэрэгний үйлдвэрээ худалдан гадагш явна гэж бодож олсонгүй. Эцэстээ тэр алжуу залхуу бөгөөд их иддэгээсээ болж бэрх таргалалтаас болж нас баржээ. Түүний аливаа үр дүн нь бүр өөрөө үүсгэсэн юм.

Лю өвгөн бол Рэнь Хө тэрэгний үйлдвэрээ зориуд Шянзы-д хөлслөгч. Хүн нь шулуун, зан ааш нь эрс хатуу, ерөөс гадны хүний өмнө нүүр барахгүй байхыг хичээдэг. Нэг насных нь хамгийн их харамсал бол ажлаа залгамжлуулах хүү заяасангүй, охин нь хэдийгээр чадвартай боловч яалаа ч гэсэн охин хүн юм. Охин нь насанд хүрээд харьд мордоогүй болохоор тэр охиныхоо өмнө буруу зүйл хийсэн мэт санагдаж, энгийн үедээ ч түүнд найр тавьдаг, гэвч өөрийн үйлээ барж олсон эд хөрөнгөө охинтойгоо хамт Шянзы-д өгөхөөс харамлан охиноосоо харьцаагаа тасалж, хамгийн сүүлд охиныхоо оршуулгыг ч олж мэдсэнгүй. Феодлын үзэл санаа нь түүнийг хайр энэрэлгүй болгожээ, дахиад хожим нь сэхээрэхэд/*ухаарах*/ нэгэнт оройтов. Шянзы түүнийг тэрэгнээсээ хөөн буулгаж, тэр ганцаар удтал тэнд зогсох үед, үнэхээр ганцаардаж, мөнгөнөөс өөр юу ч үгүй болсноо гүн ухаарчээ.

Цао абугай бол Шянзы-ийн хөлслөгч, уламжлалт уран зурагт бахтай /*дуртай*/, нийгэм журмыг шүтдэг болохоор хүнтэй тайван харьцдаг, Шянзы түүнийг “Богд хүн” /*аугаа хүн*/ гэж бодно. Эрх баригчид түүний бичиг заах үзэл санааг сайн гэж хувьсгалт нам гэж үзсэнээс, Шанхайд дуудан аваачиж аюулаас зайлуулж дахин Бээжинд буцаав. Сүүлд нь Шянзы-д тусалж дахин амьдруулсан хүн юм. Нэгэн туйлын энгийн хүн, тэрээр хүн бүрт уужуу тайван, ардчилалын ачаар богд хүн хэмээгдэх болжээ.

Цао абугайтай ил тод харьцуулал болж болох бас нэгэн сэхээтний дүр бүтээгджээ, тэр нь Ян абугай. Ян абугайнхан хүүхэд олонтой, тэрэг хөлслөх нь олон бөгөөд хоёр гэргий нь зарцын зүгээр суух тэнүүчлэн хоол идэхийг нь ч үзэж чаддаггүй, залгаа залгаагаар ажил тохируулж л байдаг. Анх танилцахдаа Шянзы энэ нь зөвхөн түр цаг ажил хөөцөлдсөн төдий гэж бодож байсан нь харин буруудаж, амьдралдаа ч ийм байхаар барахгүй хүч хөдөлмөр мөнгийг нь



THE CULTURAL WAY

өгөх дургүй бөгөөд харааж загнах нь хэцүү, өмнөх Цао аругайнхантай адилтгахын аргагүй билээ. Сүүлдээ Шянзы тэсэхгүй болж Ян аругайн их гэргийтэй нь хэрэлдэн хэдэн өдрийн хөдөлмөрийн хөлсөө авч тэднээс салжээ.

Шяо Фузы бол нэгэн сайн санаатай, өрөвдөлтэй хүн юм. Аав нь түүнийг нэг цэргийн ноёнд худалдаж, цэргийн ноён ажлаас шилжиж явахдаа түүнийг хаяж явсанаас тэр бас төрхөмдөө харьжээ. Тэр үед ээж нь нэгэнт нас барж, аав нь архинд орж, гэрт нь аж ахуй хөтлөлт байхгүй, өлсгөлөн хоёр дүүгээ тэжээхийн төлөө арга бус биеэ худалдах замаар явав. Хамгийн сүүлд Шянзы-д хүсэл тавьж байсан нь цалгардсанаас амьдралдаа бүр ч итгэл алдаж амиа хорлосон байна. Шяо Фузы-ийн нэг нас нь яг тэр цаг үеийн эгэл гаралтай олонх охидуудын заавал өнгөрөх зам байж магад, тэд буруугүй, гэвч тэдний биеийн гарал нь тэдний хувь заяаг тогтоожээ, нэгэнт ийм болсон юм чинь ямар ч ёсгүй, ямар ч эрх тэгш гэж байхгүй, хувь заяа ингэж аливааг шоглоно. Шяо Фузы-ийн амьдрал хүмүүст үлдсэн нь зөвхөн гүн өрөвдөлтэй болон хязгааргүй бодолхийлэл болно. Түүний аав Э Чянзы бол нэгэн биеэ голж гутарсан тэрэгчин, өөрийн охиноо худалдаад тэрэг худалдан авч, нэг хэсэг согтуурч зоосоо дууссаны дараа архи уугаад гэртээ агсам тавьдаг, ингэсээр байгаад эхнэрээ зодож алжээ, эхнэрийнхээ буяныг хийхийн төлөө арга бус тэргээ худалдаад хийх ажил ч үгүй болов. Өдөржин архинд дэвтэж, гэрийн хоёр хүүхдээ ч хамаарахгүй. Охин нь харьж ирсэний дараа бас охиноо элдэвлэж байгаад биеэ худалдах замд тулгаж, үргэлж гэртээ очиж охиноосоо мөнгө авч, мөнгө шал согтуу болтлоо архи ууна. Гэртээ харьвал охиноо харааж аашилна. Хаяа гэнэт сэхээрэн охин, хоёр хүүдээ алдаа хийсэн мэт санадаг, “энэ үед тэр харамсан харамсан бүтэн нэг өдөр унтаж, уйтгар гунигаа зүүдэндээ тушаадаг”².

“Дөрвөн үет том өрх”-д Чы овогт настан бол нэгэн хувиа сахихыг эрхэмлэдэг, хуучин үзэл санааны төлөөлөгч дүр болно. Романы эхэнд “Чы настан юунаас ч айхгүй, зөвхөн наян насны баяраа хийж чадахгүйгээс эмээнэ ... дайн дажин түүнийг айлган сүрдүүлэхгүй, энх тайван түүнийг баярлуулна ... хамгийн дурдууштай нь түүний гэрт хэзээд бүх гэрийн хүмүүсийн гурван сар идэж хүрэх амуу будаа ба дарсан ногоо хадгалж байдаг. Ингэвэл дайн утаа манаран, цэрэг зээл дүүрч байсан ч их хаалгаа дараад, дахин чулуу дүүргэсэн муу гангаар тулгаад тавьчихвал, ямар их гай гамшгийг ч өнгөрүүлж чадна ...”³ хэмээн түүний хувиа сахисан зан араншинг танилцуулав. Чы настны хүү Чы Тяньвү бол нэгэн наймаачин, мөн Чы настан шиг даруу хэрсүү зантай, “Наймаа хийж дадсан болохоор түүний царай дээр хэзээд бүгэм эе найрсгийн оч гялалзаж, хамар дээрээ бараг хэзээд инээдийн атираатай”⁴ байдаг. Чы Тяньвү 3 хүүтэй, том хүү нь Чы Рүйсюнь, гэргий нь Юнь Мэй, хоёрдугаар хүү нь Чы Рүйфэн, гэргий нь Ли Жүйзы, бага хүү нь Чы Рүйчюнь. Хэдийгээр нэг гэрийн адилхан орчинд өссөн боловч зан араншин хийгээд өртгийн сонголт нь харин адил бус байлаа. Чы Рүйсюнь дээд зэргийн сурган хүмүүжил хүртэж, сургуульд

² 老舍:《骆驼祥子》,民主与建设出版社出版,2018年1月版,181页。

³ 老舍:《四世同堂》,中国华侨出版社出版,2019年11月版,第1页,6页。

⁴ 老舍:《四世同堂》,中国华侨出版社出版,2019年11月版,第1页,6页。



THE CULTURAL WAY

бичиг заадаг ажилтай. Номхон шударга, эелдэг зөөлөн зантай, хариуцлагатай, япон эзэрхэг түрэмгийтэн хичээл сургалтын үзэл санааг хязгаарласнаас дургүйцэн ажлаа хаяв. Чы Рүйсюнь-ий эхнэр Юнь Мэй нэг гэрийн хөгшин нялхын амьдралыг додомдож байдаг. Ямар ч учир гэсэн хүнийг дутуу дуугарахыг захиж, амар жимэр амьдрах бол хамгийн чухал гэж үздэг. Арвин ном бичиг сурсангүй ч учир ёсыг сайн мэддэг болохоор тохиромжтой үед зохистой ажил хийж, олонд маш хүндэтгэлтэй байдаг, Чы настан ч гэсэн олон учрыг түүнтэй зөвлөдөг. Юнь Мэй бол өргөн олон эгэл борогжуу бүсгүйчүүдийн төлөөлөл дүр, толгой даран ажиллаж хүмүүс түүний нэр овгийг нь ч сайн мэддэггүй “Шяо Шүнь Э-ийн ээж” гэж л дууддаг. Чы Рүйфэн мөн ном бичиг үзэж явсан боловч жаргаж цэнгэхэд л найзлах дуртай, ханашгүй ховдог шунахай, залхуу архи уух дуртай болохоор үргэлж хүнтэй муудалцаж, газар бүрт хэрэг уршиг тарьж явдаг, баян хүнтэй л найзлах дуртай, өөрийнхөө жаргал цэнгэлийн эхнэртээ туслахгүйгээр япон хүнд үйлчилдэг зальхай болов. Эцэст нь зэргээ хасуулж, эхнэрээ алдаж, толгой ганзагалан гэртээ харьж гэрийн хүмүүсээ мэрг амьдарч байгаад мөн л архи ууж явдаг, нүүр хөрсгүй өөдтэй хүн биш юм. Чы Рүйфэн-ий эхнэр Ли Жүйзы бол түүнтэй нэг төрлийн хүн, хайр найргүй, ичгүүрийг мэдэхгүй, ховдог шунахай, алжуу залхуу, улааныг үзвэл урваж хөхийг үзвэл хөрвөж, эр нөхөр нь тушаалаасаа буумагц Лань Дунян-ийг дагав. Хамгийн сүүлд үр дүн нь гунигтай, бусдад хаягдаж, булаагдан хоосорч, Тяньжинь-ий доройтон янхан болж мөхөв. Чы Рүйчюнь бол том ахтайгаа адил, бичиг соёлтой, үзэл санаа давшингуй сэхээтэн, шинэ цаг үеийн оюутан, хариуцлагатай сэтгэлгээ ба үнэнч шударга улсаа хайрлах сэтгэлтэй. Дайн эхэлмэгц хотоос гарч өмнө фронтод хүрч дайнд оролцов.

Чы настны саахалт айл мөн түүний найз Чянь Моинь настан бол тэр цаг үеийн давшингуй сэхээтэн юм. Архи уух, зураг зурах, цэцэг тарих дуртай байсан өвгөжөөр насны хүн, улс орныхоо мөхөж сөнөх эгзэгтэй үед цээж түрэн босож, өөрийн гэсэн нэг хувь хүчээ нэмэрлэв.

Гуань Шяохө, үндсэн зарчимгүй зөвхөн эрх сүртэй хүнийг хүндэтгэж, бялдууч хуурамч зантай, улс орны их ашиг тусыг хувийн ашгаар сольж, эзэрхэг түрэмгийтэнд үйлчилдэг зальхай болов. Сүүлээр нь япон хүнд амьдаараа чанагдав. Да Дуйбао, Гуань Шяохө-ийн хадагтай, хөзөр тоглох дуртай, мөн жаргал цэнгэлийн төлөө улсаа худалдсан зальт дүр мөн. Жю Тунфан, Гуань Шяохө-ийн хоёрдугаар хадагтай, Гуань овогтын хамгий эхэнд сэхээрсэн хүн, улсаа хамгаалах дайнд хувь нэмрээ үзүүлэв. Гуань Гаоды, Гуань Шяохө-ийн том охин, Гуань овогтын хоёр дахь сэхээрсэн хүн. Гуань Жаоды, Гуань Шяохө-ийн хоёрдугаар охин, өнгө зүс нь сайхан боловч залхуу, амарт ташууран японы тагнуул болж, Рүй Чюань-д алагджээ.

Судлаачдаас: “Дөрвөн үет том өрхөд хүчирхэг их урлагийн ид шид, уран нарийн зураглалаар дундад улсын хүний үнэн бодит оюун санааны дүрс байдлыг, нарийн будлиантай сэтгэцийн дэс давхаргыг, хувирч байгаа сэтгэлгээг өчүүхэн ч нууж далдлалгүйгээр илрүүлэв. Тэр нь яг толь мэт дундад улсын хүний халуун цусаа урсгаж улсаа хайрлах, эрэлхэг баатарлаг юунаас ч айхгүй байдлыг тусгасан бөгөөд зарим хүмүүсийн хүчирхэгийн өмнө буун өгч, биеэ



THE CULTURAL WAY

хуурч бусдыг мэхлэх, улсаа худалдах өнгөц дорой байдлыг ч тусгав. Зохиогчоос улсын гай зовлон, ард түмний соёл ба үндэстний ирээдүйг бодолхийлж, ард түмнийг ташуурдан урагшлуулах хүсэл бодлоо шингээсэн байна”⁵ гэж дүгнэжээ. Улс орон эзэрхэг түрэмгийтний саварт өртсөн түгшүүрт мөчид, зарим хүмүүс сүрдүүлэл ба дарлалын дунд назгайран доройтож, дайсны сүр бараанд автан амь зуух буюу амин хувиа бодож, ноён сууж баяжихын төлөө улсаа худалдсан байна. Романд Лао Шө тэдгээр ардын оюун санаа ба үйл ажиллагаан дээрх сэхээрэлт, идэвхтэй эсэргүүцлийн үндэстний сэхээрэлтэд эрхэм дээд нөлөөтэйг илэрхийлсний хамт түрэмгийлэл ба нэвчилтийн өмнө ичгүүртэй өвдөг ногоорсон зальхай нарыг ширүүн дайрсан байна. Дайсанд эзлэгдсэн оронд илэрсэн зарим зальхай ноёд түшмэдийн муу нөлөөг Лао Шө нэлээд хүч гарган дүрслэн бичжээ. Тэд хэнээс ноён зэрэг олсныг ерөөс бодолхийлэлгүй, ноён зэрэг олсон арга барилын зөв эсэхээ ч бодолхийлэлгүй, тэд зөвхөн ноён зэргийг эрхэмд үзэн чухалчилж, ноён суухаас өөр юу ч хийх дургүй байдаг.

Дээр дурдсан 3 бүтээлийн дүр бүтээлтийг шинжилбэл: “Дөрвөн үет том өрх бол Лао Шө-ийн шинэ зорилго ба дүр байдлаар зохион бүтээсэн, хэвжээ ба үзэл санааны хүчийн аль ч талаар чухал том өөрчлөлттэй бүтээл болно, тэр эзэрхэг түрэмгийтэнд эзлэгдсэн орны хүмүүсийн цочил хэлмэгдэл, хулган амьдрах, хүнд зовуурийг эсэргүүцэх сэтгэлийн өнгөрөлтөөр гар дүрэлтийн чиг болгож, туйлын чанга урлагийн амьжирлын хүчээ илэрхийлсэн юм. Дайны дунд өчүүхэн хүмүүс ч гэсэн сэхээрч, эсэргүүцэн босож, урьд өмнө байгаагүй эрс хатуу зориг зүрхээ илэрхийлж, Хавирган сар, Тэмээ Шянзы дахь хүмүүсийн нэг насандаа хүнд зовуурийн дунд ухаарч сэхээрч чадсангүй зохион бүтээх арга замаа өөрчилсөн байна”⁶ хэмээн задалсан шигээр Тэмээ Шянзы дахь “Шянзы”, Хавирган сар дахь “Би” нийгмийн бодит ахуйн хүчин дор алгуур аажмаар “өөр би”-ээ орхиж, арга бус өөрийн дургүйцдэг замаар явах болсон бол Дөрвөн үет том өрхийн дүрүүд бол бэрхшээлийн өмнө бие бөхийлгүй, өөр би-ээ хичээн биелүүлсэн Чы Рүй Чуань тэргүүтэй баатруудын дүр бүтээгдсэн байна.

Хоёр. М.Хасбаганын соёлт тууж дахь дүр бүтээлт

“Засгийн хутгуур” романд Өлзийжаргал, Лорой зэрэг нутаг усаа хамгаалахын төлөө боссон сайн эрсийн дүр ба Лонтунгаа, Дарьбал, Дарьсоо зэрэг баатарлаг эмэгтэйчүүдийн дүрийг бүтээсэн байна. Зохиогч М.Хасбаганаас номынхоо өмнөх хэсгийн “Засгийн хутгуурыг дахиж хэвлүүлэхийн учир”-т романы тухай тодорхойлсон нь: “Засгийн хутгуурыг 3.26-ны хэрэг хувьсгал үүсгэсэн цаг үеэр зааглан бичсэн нь би Их зуу чуулганд нэлээд нөлөөтэй 3.26-ны хэрэг хувьсгалыг голчлон бичих гэсэн учир биш ээ, харин энэ үймээн шуугиантай цаг үе дэх засгийн хутгуурын бүх давхаргын хүмүүсийн дүрийг бүтээх гэсэн юм” гэв. Тус роман яг зохиогчийн уг санааг гүйцэд бүрэлдүүлж чадсан байна. Б.Гавираагийн өгүүлэлд “М.Хасбагана

⁵ 李淑贤:《四世同堂》人物的亡国奴心态研究,河北大学硕士学位论文,2019年6月。

⁶ Чимэг. Лао Шө-ийн дундад улсын уламжлалт соёл сэтгэцийн тухай эргэцүүлэл. ӨМНШС., 2005 № 3, т 60



THE CULTURAL WAY

туужисдаа монголчуудын гоо сайхны таашаал хийгээд нийгмийн өртгийн хоорондох зөрчлийг тусган үзүүлсний зорилго нь шилдгээ бадруулахын ялдам нийгмийн өртгийн чиглэлийг гярхай ажин ааш зан хийгээд нийгмийн сонголтын огтлолцлын цэгийг зөвөөр хайн олохыг сануулсан хэрэг буюу”⁷ гэж өгүүлсэн байдаг. Романд сайхан хүмүүсийн дүрээс гадна муу санаатай муу хүмүүсийн дүрийг ч амьдлаг бодитой бүтээв. Айлингаа, барзгар Мөнх шиг хөхийг үзвэл хөрвөж, улааныг үзвэл урваж хэзээд хувийн ашгийг л хөөцөлдөж, ямар ч муу үйлийг үйлдэхээс буцахгүй “өчүүхэн хүмүүс” жигшил төрүүлэх боловч толгой шийр нийлэн тогоо дүүрч, сайн муу нийлж ертөнц дүүрдэг жамаар аль ч цаг үе ч гэсэн ашиг хөөцөлдөж ёс суртахууныг умартдаг хүн мундахгүй байх, зохиогчоос сөргөх талын дүрийг ч голчлон бүтээсэн нь уншигчдад нийгмийн сонголт хийхдээ анхаарамж болгохыг зорьсон байна.

“Тэр холын бараа” романд гол баатар Сүмбэрийн дүр бол нэгэн итгэл журмыг эрхэмлэдэг, хүч чадалтай сайн эрийн дүр болно. Тэр Дугарыг авран, хожим нь бас хэдэнтээ түүний хуйхар занд гэндэх шахсан боловч хор бодоогүй, найзын хувиар багтааж явжээ. Дугар бол бие нь намхан, хүч чадлаар буурай, муу санаа муу ухаан муу араншинтай, тогтсон зангүй, урваан хөрвөөнтэй, гэвч Сүмбэрийн удаа дараагийн уужим багтаамжид уяран ухаарсан дүр болно. Энэ нь Сүмбэрийг улам тольдон товойлгох нөлөөтэй. Тараг Цагаанчулуу, Хүнд Батчулуу нар бол мөнхүү хүч дорвитой сайн эрс болно. Романд бас баядын адуунаас таслан хөөх буюу баяд ноёдын хээл хахууль түлхэхээр авч явдаг мөнгийг нь зам тосон дээрэмддэг, ядуучуудад халддаггүй, өөрийнхөө чадлаар эрх тэгш бус явдлыг дэнсэлж явдаг, солир хэдэн төрхтэй “Тэмээ уулын хулгайч”-ын бүлэг буй. Үүнээс гадна, Түлхүүр Лувсан, Зандь багш хоёр бол эрдэмд шамдсан, сэтгэл сайн хүмүүс болно. Эмэгтэйчүүдийн дүр дотор сэцэн сэргэлэн ухаан самбаагаар биеэ хамгаалж явдаг Сувдангэрэл бүсгүй, уламжлалт ёс хийгээд эрхийн дарлалын өмнөөс зоригтой эсэргүүцдэг хэл ам хурц Бодьсоо хүүхэн, Шүрэнхуар хүүхэн, харь орны боловч сэтгэл цайлган, үнэнч хайрын төлөө зүтгэх, зодоонч хүүхэн Дарь буй. Эдгээрээс бусад романд бас ардыг хяхан мөлжих, хээл хахууль идэн эрх тэгш ёс журмыг талхидаж явдаг ноёд, эрх зэрэг эд ашгийн төлөө шиншиж гүйдэг баяд, Зандь багштай эсрэг эрдэм нь нэлээд сайн боловч санаа араншин муутай шид зэрэг харгис балмад баяд ноёд ба завсарын этгээдийн дүр байна.

М.Хасбаганын бийрийн үзүүрт Ордос нутгийн байгалийн үзэмж, аж амьдрал, зан заншил бүр өвөрмөц өнгө төрхтэй тод зураглагдснаас гадна зохиол дахь хүмүүсийнхээ хувь заяа, оюун санаа, дотоод ертөнц, зан чанар, амин сүнснийг нь илэрхийлэхдээ бодит амьдралын шууд мэдрэмж өгөхийг онц хүндэтгэн, өгүүллэгт бичигдсэн хүмүүс нь ахуй амьдрал дундах “энэ нэг” болон уншигчдад танигдаж, мах цустай босоо цогцот дүр болж бүтээгдсэн байна⁸. Засгийн хутгуур романыг уншиж өнгөрсөн хүмүүсийн тархинд Лорой, Арвинцогтын оч гялалзсан том нүдтэй, яралзсан цагаан шүдтэй, дүрслэг өндөр

⁷ Б.Гавьяа. М.Хасбаганын туужис: морал суртахуун, өртгийн үзлийн сүвэгчлэл. Алтан түлхүүр сэт 2004 № 3, т 48

⁸ Хөх-Уул. Ахуйч үзлийн зориг санааны илрэл. Алтан түлхүүр сэт 1985 № 1, т 38



THE CULTURAL WAY

биетэй, сүү шиг цайлган сэтгэлтэй, ухаан самбаатай, зэрлэгшсэн үхр атаршсан адууг аван барин номхруулдаг бие чадалтай сайн эрсийн дүр үлдэх юм. Тэр холын бараа романыг уншвал зодооны эрдэмд шалгарсан, монгол сайн эр Сүмбэр, Тунгалаг тамир дахь Цахиур Төмөртэй хамт чээжинд хоногшино.

Бао Рун-ий өгүүлэлд “М.Хасбаганын туужист эрх баригчдын дарлал ба аж ахуйн хяналд учирсан зол бус орчин тойронд бусдыг гайхуулам цөс зоригоор тэмцэн зүтгэж, өөрийн гэх амьдрал оршихуйн үзлээ эрс баримтлагч эмэгтэйн дүр нэлээд бүтээгджээ”⁹. Үүний нэгэн нийтлэг жишээ бол Лонтунгаа ба Дарьсоо болно. Лонтунгаа хэдийгээр тайж язгууртны гэрт заяасан бөгөөд эх нь муруй Гэрэлсоо ядуу харцыг зөв нүдээр хардаггүй муу араншинтай боловч тэр хар багаасаа цайлган зантай, зөөлөн сэтгэлтэй, царайлаг хүүхэн болж хүмүүжсэн билээ. Түүнийг хялгасан Сүмбэрийн бядуулаг хүү бүтүүрсэнд албадан мордуулах гэсэнд тайж язгуур ба тосонд бялууран торгон дээр бөмбөрөх тансаг амьдралд татагдсангүй, Арвинцогтой оргон зугтааж, хээр хонож хэц дэрлэн явсан билээ. Дарьсоо нялх багаасаа ядуу зүдүүхэн аж төрж явсан боловч дотуур тамиртай ухаан бодол хатуу хүн болон хүмүүжиж, суман зангийн хэлгий ач хүүд даран буулгах гэсэн дарлал шахалтын өмнө Арвинцогтыг даган оргож, түгшүүрт мөчид Арвинцогт ба Лонтунгааг нэхлээс салгахын төлөө биеэрээ нэхэлчдийг дагуулан нэг зүг салав. Хожим нь бас хувьсгалын үйлсэд оролцсон билээ.

Гурав. Хоёр зохиолчийн соёлт туужийн дүр бүтээлтийн харьцуулал

“Тэмээ Шянзы” дахь Шянзы, “Дөрвөн үет том өрх” дэх Чы Рүйсюнь, Чы Рүйчюнь болон “Засгийн хутгуур” дахь Лорой, “Тэр холын бараа” дахь Сүмбэр нар бол мөн чанартаа адил онцлогтой. Шянзы хэдийгээр эцэстээ уруудан доройтсон боловч анх эхлэхдээ бяр чадалтай, энэрэнгүй өрөвчхөн сэтгэлтэй байлаа. Чы Рүйсюнь, Чы Рүйчюнь эх улсынхаа түгшүүрт цаг мөчид эргэлзэлгүй цээж түрэн босож эх орноо хамгаалах дархан үйлсэд оролцсон баатрууд болно. Лорой, Сүмбэр нар бол өндөр соёл боловсрол хүртээгүй боловч өөрийнхөө ухаан самбаа хүч чадалдаа түшиглэн нийгмийн тэгш бустай зоригтой тэмцэлдэж, эх нутгаа хамгаалахад гар бие оролцсон сайн эрс болно.

“Тэмээ Шянзы” дахь Шянзы ба Шяо Фузы, “Хавирган сар” дахь “Би” цөм бодит ахуйн өмнө ялагдаж гунигт төгсгөлд хүрсэн байдаг. Гэтэл М.Хасбаганын “Засгийн хутгуур” дахь Лорой, Арвинцогт, Лонтунгаа, Дарьсоо нар, “Тэр холын бараа” дахь Сүмбэр, Бодьсоо нарын бие дээр мөн гунигт өнгө будаг агуулагдаж, зохиогчоос тухайн цаг төр нийгмийн байдлын ороо бусгаа тэгш бусыг илчлэн заалдах өнгө аяс илхэн боловч Лао Шө-ийн бийрийн доор бүтээгдсэн тэдгээр дүртэй эрс ондоо онцлогтой. М.Хасбаганын романд бүтээгдсэн тэдгээр дүр тэгш бус хувь заяаны өмнөөс ноцон босох орон зайтай, өргөн уудам монгол нутагт аж төрж ирсэн монголчууд байгалийн хүчийг ашиглахдаа чадамгай, үзэл санаа харьцангуй нээгдмэл байдаг. Энэ нь адил бус хоёр орчин хийгээд адил бус сэтгэхүйн илрэл мөн. Хятад орон, Монгол оронтой

⁹ Бао Рун. М.Хасбаганын тууж дахь эмэгтэйчүүдийн дүр. Алтан түлхүүр сэт 2005 № 6, т 36



THE CULTURAL WAY

адилгүй, суурьшин тогтносон нь эрт мөртөө төвлөрөн суудаг, тариалах аж ахуйгаар голлодог тул амьдралын хэв маяг харьцангуй хэвшмэл хязгаарлагдмал онцлогтой байдаг.

ABSTRACT

Character is the most important element of a novel. The characters of the two novels will be compared and analyzed, and the social environment and cultural environment of the two authors will be different. It is manifestation of two different environments and different mindsets. Unlike China and Mongolia, the settlements are concentrated early, and the way of life is relatively limited because it is mainly based on agriculture.

Key words: *Khasbagana. M, Lao She, cultural novels, creative, comparative studies*

НОМ ЗҮЙ

1. Хөх-Уул. Ахуйч үзлийн зориг санааны илрэл. Алтан түлхүүр сэт 1985
2. Б.Гавьяа. М.Хасбаганын туужис: морал суртахуун, өртгийн үзлийн сүвэгчлэл. Алтан түлхүүр сэт 2004
3. Бао Рун. М.Хасбаганын тууж дахь эмэгтэйчүүдийн дүр. Алтан түлхүүр сэт 2005
4. Чимэг. Лао Шө-ийн дундад улсын уламжлалт соёл сэтгэцийн тухай эргэцүүлэл. ӨМНШС., 2005
5. 老舍: 《骆驼祥子》, 民主与建设出版社出版, 2018 年
6. 老舍: 《四世同堂》, 中国华侨出版社出版, 2019 年
7. 老舍: 《四世同堂》, 中国华侨出版社出版, 2019 年
8. 李淑贤: 《四世同堂》人物的亡国奴心态研究, 河北大学硕士学位论文, 2019 年
9. 曾广灿, 吴怀斌: 老舍研究资料(下), 北京知识产权出版社, 2010 年

ЭХ ОРНЫХОО ТӨЛӨӨ ДУСАЛ УС ЧИМХ ШОРОО БОЛОН АМЬДРАГЧ

- *Р.Чойном, Л.Чулуунбаатарын яруу найргийн жишээн дээр**

Л.Хасбаатар*

Нахиа*

ХУРААНГУЙ

Яруу найргийн хэл хэллэг бол тухайн найрагчийн үзэл сэтгэлгээ мөн. Тухайн найрагчаас эх байгаль, ертөнц дэлхийгээ хэрхэн таньж мэдрэн, соён гэгээрсэн явцыг уран яруу шүлгийн хэл хэллэгээс олж мэдэхээр барахгүй, түүний ертөнцийг үзэх үзэл, шүтэлцэх ухаан, зан авиртай маш нягт холбоотой байдаг.

Түлхүүр үгс: *Р.Чойном, Л.Чулуунбаатар, яруу найргийн үг хэл*

Монь уулын өвөр ар талд монголын говь нутаг үргэлжилнэ. Энэ бүс нутгаас улбаалан монголын хээр тал, өндөрлөг, ой шугуй үргэлжлэн холбогддог. Газар орны бүс заагийн ялгаагаар тухайн оронд амьдарч буй монгол ард түмний амьдралын зан заншил, хэл аялгуу, соёл түүх, шашин шүтлэгийн нарийн дүрэм журам нь ч тус тусын онцлогтой байдаг.

Адил бус газар орон гэдэг ч нийт монгол нутаг болох учир тэдний хамтын амьдрах хүсэл эрмэлзэл, зорилго нь ижил байдаг. Тэдний амьдралын тухай үзэл бодол нь ч нэг талаар холбогдож байдаг.

Монгол эх орон, үндэстэн угсаатан, газар нутгийн сэдвээр Р.Чойномын бичсэн зүйл маш олон буй. “Миний монгол”, “Монгол бүсгүй”, “Азийн тухай бардамнал”, “Хорин нэгдүгээр зуун танаа”, “Миний шүтээн”, “Миний ард түмэн”, “Шүлэг бид хоёр”, “Би”, “Хар нүд”, “Уяхан замбуутивийн наран” зэрэг томоохон хэмжээний найрууллуудад монгол нутгийн ширхэг шороо, өвс ногоо, усны дуслас өгсүүлэн эх байгалийн бүхийл ан амьтан, хүн мал, үүл бороо, ус цас, од, сар, нар, солонго зэрэглээ, ургамал хөрс гэхчлэн энэ замбуутивийн амьтай амьгүй дүр бүхнийг гээлгүй тэр бүрчлэн хүүрнэн тоочиж, уянгалан

* 2016-2021 оны Дундад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Суурь Мөнгөний Нийгэмлэгийн Судалгааны Төсөл.

* ӨМИС, МСДС-ийн багш доктор, профессор

* ӨМИС, МСДС-ийн 2021 оны магистрант



THE CULTURAL WAY

дуулж, учирлан шүүжээ. Нэгэн найрагчийн зохиол бүтээлээс ийм уудам том зүйлсийг багтаасан бөгөөд өчүүхэн тоосонцорыг хүртэл барьж адалгүй ажиглан тунгааж байхаас ертөнц дахиныхаа тухай бид ойлгож ухаарах зүйл үнэхээр баялаг байна. Чойномын шүлэг найрагт бодит хүүрнэж буй зүйлсээ амьд хөдөлгөөнт болгохын тулд маш олон дүр зургуудыг босгон амилуулжээ. Энэ дотор түүний нутаг ус, газар эх, тэнгэр эцгийнхээ тухай, энэ ертөнцийн буй бүхий амь ахуйн төлөөний хайр хүндэтгэл гүнээ шингэсэн байна.

Энэ талаар бичсэн түүний олон шүлгүүдийн дотроос өөрийн эрхтнээрээ мэдэрч буй “Зүрхний бичлэг”-ийн нэг хүүрнэлд, эмч, сувилагч, зүрхний бичлэгийн аппаратаар Чойномын зүрхийг үзэж дуусаад өвчтэй хэмээн оношилж, маш хүчтэй эмийн (орос) жор бичиж өгөх гэж байхад нь:

... Энэ чичигнэсэн зураас чинь зэрэглээ татан тал

Эгц өндөр ирмэгүүд чинь миний нутгийн уул

Асралт хайрхан оройтой ахай таван хан хэнтий уул

Ангал жалга, цэнхэр хөндийтэйгөө

Арын мод, ан гөрөөстэйгөө

Агсам цэнхэр гол мөрөнтэйгөө

Аль ч нутагт явахад зүрхэнд минь багтаж явдаг юм

Агшин бүхэнд зүрх минь түүнийг дурсан цохилдог юм

Зүрхийг минь тайвшруулахад волидол хэрэггүй

Зүйтэн төрсөн Балжиннямд хэрэгтэй хэмээн нас барахаасаа нэгхэн сарын өмнө ийнхүү бичиж үлдээжээ.

Нэгэнт бие нь дордоод цааш нь амьд явахын боломжоо алдаж байх үед өөрийгөө мэдэрсэн найрагчаас өчүүхэн ч айж сандралгүй, ирмүүн дайчин зориг золбоотой, уужим тэнгэр багтаамжит бодлоор энэхүү замбуулин хорвоод амьдарч, зовж, шаналж, уйдаж бухимдаж, дарлуулж цовдлуулж, шоронгийн хоригдол, эмнэлгийн өвчтөн болж байснаа нэн ялангуяа амьд ахуй явахынх нь дээдийн мөрөөдөл – яруу найрагчийн нэр алдар, зохиол бүтээлийг нь үнэлэн хэвлэж нийтлүүлэн зон олны хүртээл болгон сайныг нь үнэлж, саарийг нь шүүмжлэн хэлж өгөх ямар ч боломж бололцоо үзүүлдэггүйд нь гомдон эмзэглэж ярьсан нь үгүй билээ. Харин миний биеийн эс эрхтэн бүхэн цөм миний эх орны хаана ч байх уул ус, хайрхан гол мөрнүүд мөн хэмээн алс холыг бараалан аугаа томыг багтаан ярьсан нь байдаг. Энэ дэлхийн хүн амьтан



THE CULTURAL WAY

гэдэг амьд ахуй цагт нь хэн нэгийгээ хайрлан хамгаалах биш, дандаа атаархал жөтөөрхлийн нүдээр нэгийгээ илүүд үзэн нүд үзүүрлэсээр байгаад үхсэнийх нь дараа сая тэр хүн мундаг шүү хэмээн эрхий гозойлгон, худал үнэн нулимс нус гоожуулан өнгөрөх нь харамсал болдог ажгуу. Чойном үнэндээ амьд явахыг, энх тунх сайн сайхан амьдралыг хүсээгүйдээ биш даанч цаг үе, нийгэм ахуй, хүний бэртэгчин чанар, хувь биеэ хичээх өчүүхэн зүйлийн тулд амьдарч байснаас сая олон олон Чойномоо авсалж дөнгөлж өнгөрсөн билээ! Амьдрал гэдэг иймэрхүү арчаагүй жижиг сажиг зүйл дээр тогтох нь даанч утгагүй.

Хүн ардынхаа гэрэл гэгээг олж мэдрэхийн тулд хэчнээн өдөр шөнийг сэтгэлийг эмзэглэл, уйтгар гуниг, ганцаардлын дунд тэлчлэн туулж өнгөрүүлсэн яруу найрагч дэлхийн түүхэнд маш олон ! харин тэдний амьдарч явсан зам мөр даанч муруй сарий мөртөө хэдий чинээ богино ажээ.

Хүн төрөлхтний амьдралын дунд эдгээр олон сайхан найрагч нар минь амьдарч тэмцэж явсан олон мөр нь хойч үеийнхнийг хэчнээн ухааруулан сэхээрүүлж байгаа бол оо !

Яруу найрагчийн эх оронч үзэл сэтгэлгээ, үндэстнээ хайрлах хайр гэдэг мөнхийн сэдэв мөн. Эхийн хайраар төрж, эх оронч хайрыг угжин өсөж, эцэстээ үндэстнийхээ гэгээн саруул хөгжил цэцэглэлтийн төлөө хүмүүс амьдардаг бөгөөд яруу найрагчдын хамгаас илүү сэтгэлдээ тээн бодож явдаг нь яг л энэхүү хайр энэрэл бөгөөд насан туршдаа тэмцэж ухаарах сэтгэлгээ нь ч үүнтэйгээ нягт холбоотой ажгуу.

Өөрийн өсөж төрсөн амьдралын орчин ахуйдаа дасаж соёл боловсрол хүртэж, оюун санаагаа хөгжүүлэх явц дунд Л.Чулуунбаатар бага насны нутаг ус, бригад сумын сургууль суртал, урлагийн сургуулийн хичээл сурлагаас хүн төрөлхтний урьдах уламжлалын баялаг санг сурч ухаарах явц дундаа урлаг, дуу хөгжим, шүлэг зохиолын гэгээлэг нүдээр ертөнцийг таньж олоод энэ аугаа том орчлон дэлхийг өөр шинэ эриний диваажингаар төсөөлөн бодож эрхэс тэнгэр, эх байгаль, уул ус, ургамал навчист өөрийнхөө гүн зузаан хайрыг шингээн өгч, мөн энэ сайхан нутаг дэлхийгээ өнө мөнхийн энх тунх, амар амгалангийн орон болгон байгуулалцах тухай шүлгийн сэтгэлгээгээр уянгалан үлдээсэн бүтээл олон буй. “Би эх орны хүү”, “Номин тэнгэрийн хөвгүүн”, “Хатан голын хар хүү”, “Монгол ээжийн хүү”, “Ээ, миний ордос”, “Гадарид өргөх дуу”, “Зүрх уулын бичлэг”, “Ав хан” зэрэг шүлгүүд нь шүлэгчийн сэрэл бодол дахь өөрийн төрсөн нутаг, газар ус, тив дэлхий, тэнгэр эрхэс бүхнээрээ багтаж байдаг. Энэ дотор бодит газар, төрөлх нутаг нь буй, болох гэж буй шинэ эх хуурай нь буй, бүр цааш нь өөрийн эзэмшил болох эрхэс тэнгэр, одон орон, нар сарны орчлон ч байдаг.



THE CULTURAL WAY

Яруу найрагчийн сэрэл мэдрэмжид илрэн гарч буй шинэ хуучин эх орон гэдэг нь дэлхий ертөнцийн мөнхийн холбоотой үргэлжлэн аялах амь ахуйн эе эвтэй нөхөрсөг журамт, өөрийнхөө жам ёсоор орчин улирах жам хуулийн дагуу хөгжил мөн. Ер нь түүний шүлэгт байгалийн маш олон нарийн зүйлсийн зураглал байх бөгөөд орчлон ертөнц хэмээх аугаа том хорвоогийн амь ахуйн дахин илрэн гардаг. Энэ нь түүний шүлгийн сэрэл мэдрэмж, аугаа ихийг багтаан боддог сэтгэлгээтэй нь холбоотой юм.

Түүний шүлэгт мөн эх дэлхийн амь амьдралын чухал чухал элементийг өөрийн мах цуснаас эрхтэн адил хайрлан бахархсан шүлэг ч нэлээд буй.

Миний зүрх – ноён Гималай

Миний цус – Номхон далай

Зүрх минь

Ноён Гималай шиг дуниартдагаас

Цус минь

Номхон далай шиг долгиолдгоос

Би зүрхэндээ хайртай

Би цусандаа хайртай¹.

Энэ бол найрагчийн маш зоригтой төсөөлөл бөгөөд энэ ертөнцийн хамгийн том зүйл дээр өөрийгөө багтаан шингээж, нэгтгэж чадаж байгаа адилтгал билээ.

Миний уул –

Магма цөгийн хагсгал

Марсгар хад биш л сэн

Мараг жигүүрээ хумин суугаа

Маш том бүргэд билээ

Хүслээ би танина

Хөгслөө би мэдэрнэ

¹ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 111



THE CULTURAL WAY

Миний мөрөн –

Ганга цунхээлийн цутгаал

Гарзын ус биш л сэн

Галав дэлхийг тэтгэн яваа

Галзуу хар хүлэг билээ

Хүлгээ би танина

Хөгслөө би мэдэрнэ²

Амьд биеэс бодит биед шилжиж буй дүрслэгдэхүүн гималай – зүрх, том бүргэд, номхон далай, цус – хар хүлэг, энд тэрбээр өөрийн нэгэн аугаа том дүрийг зураглан бүтээсэн байна. Дэлхийн бөмбөрцөг дээрх хамгийн том уул хайрхан нь найрагчийн зүрх бөгөөд энэхүү зүрх нь яг дүүлэн нисэх гэж буй том бүргэд мөн хэмээжээ. Энэхүү том зүрхтэй бүргэд маань ямар юмыг зорин дүүлэх гэж байгаа асуулт аяндаа тавигдана. Тэгэхээр энэ том бүргэд маань эрх чөлөөг хүсэн дүүлэх гэж байна. Яагаад тэр вэ? үдийн нарыг тэрлэнэ, үүлэн сүүдрийг дэвсэнэ, тэгээд эвшээж байна, суниаж байна. Эрх чөлөөний эрлийн төлөө гарахад бэлэн болсон бүргэд ! мөн дүрслэлийн нэгэн онцгой зураг – гималай уулын гадна үзэмж байц бол эх байгалийн зүрх болж, найрагчийн эх дэлхий, эх орноо хайрлах энэхүү гал халуун зүрх нь яг л мараг жигүүрээ хумин сууж байгаа маш том бүргэдийн дүртэй ив ижил харагдахыг сэтгэж үзээрэй. Гурван төрлийн дүр зураг бол нэгэн зүрхний хөрөг зураг адил гэдгийг авьяаслаг зурж гаргасан буй. Энэ бол хайр – эрх чөлөөний эрлийн төлөө лугшиж буй гайхалтай амьд зүрх байна.

Номхон далай – цус – хар хүлгийн хөгсөл нь нэгэнт өөрийн эрх чөлөөт орон зай – тагнайн одоо угааж байна, тэнгэрийн сарыг тэврэн авч буй. Номхон далайн ойллого цойллоого нь найрагчийн цусаар дамжин хар хүлэгтээ мордоод эрхэс тэнгэрээ эзэгнэн амьдарч байна. энэхүү эрэл хөөцөлдөл дунд энэ замбуулингийн хамгийн жижиг молекул болох тоосонцор биетээс хамгийн том зүйл болох од нар сар бөмбөрцөгт хүртэл бүгдийг багтаан өмчирхсөн байх юм.

Хайрыг бид зөвхөн хувь биеийн сэтгэлгээ хэмээн ойлгож болохгүй. Найрагчийн сэтгэцээс урган гарсан хайр бол хувь биеэс хувь биед, хувьсгалт түмэнд, хорвоо дэлхийд адил цацарч гарсан байх хэрэгтэй. Ингэж байж сая

² Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 111-112



THE CULTURAL WAY

найрагчийн зүрх бол бусад амь ахуйд чиглэсэн гал халуун хайрын элч байх ёстой гэдэг.

Яруу найрагч ингэж сэтгэж чадах хэрэгтэй. Ийнхүү эрэл хүсэл дахин хүрч чадаж байж сая жинхэнэ найрагчийн бүрэлдүүлэх ёстой эрч хүчээ, эрэл сургаа биелүүлж чадаж байна хэмээн үзэж болох мэт.

Найрагчдын үргэлж хэлэх дуртай үг хэллэг нь тэдний зан заншил үзэл сэтгэлгээний өнгийг илэрхийлж байдаг билээ. Цаг үеийн улирах хувьсахыг дагалдан үсгийн сан, үсэг бичгийн илэрхийлэх утга нь тасралтгүй өөрчлөгдөн хувирч байдаг.

20 дугаар зууны 50-80-аад оны үе хүртэл монгол нутгийн яруу найрагчдын хэл хэллэгийг энэ хоёр хүний жишээн дээр товчлон ойлгох боломж бололцоотой.

Үг хэл гэдэг нь хүний бусдад хандаж илэрхийлэх сэтгэл санааны хамгийн нарийн үнэн зүйл байгаа юм. Мөн ч бусдач оршихуйг танин мэдэрч, ойлгож ухаарсан уурга тархин дахь тусгал нь юм. Хэрэв үг хэл үүсээгүй, дохио тэмдгийн ойлголцол байгаагүй бол байгаль ертөнцийн түг түмэн амь ахуй хоорондоо ойлголцож чадахгүй, сүрэлгэн амьдрах буюу амьдралын явцад олон үл ойлголцох согогтой байх нь мэдээж, хүнээс гадна бусад аливаа амь ахуйд цөм өөрийн үг хэл гэж байдаг. Сэтгэлийн хөдөлгөөн хийгээд дуу бүжиг гэж байх учиртай. Тэд зөвхөн өөр хоорондоо ойлголцож, харилцан эв зүйгээ олж чаддаг бөгөөд эв найрсаг, дүрэм журмын дагуу амьдарч иржээ. Өвс ногоо, ус булаг, уул овоо, эрхэс тэнгэр, од гараг зэрэг зүйлс цөм үг хэлтэй, хүн бидний туулж ирсэн үл мөрүүд юуг огоорсон бэ? гэвэл эдгээр эх байгалийн түг түмэн амьтан гөрөөс, ус шороо, нисэх шувууд төрөлтөн бүгд үг хэлтэй, өөрийн оршин тогтнох үргэлжлэн амьдрахын тухай зөв зүйтэй сэтгэхүй ч байх ёстой юм. Гагцхүү хүн хэмээх амьтны төрөлтөн амьдрахын хүсэл шуналд үнэхээр тачаадсаны үр дүнд бусдыг маш их хэмжээнд хохироулан сүйтгэж, энэ аугаа том байгалийн эв түнжин намуун тайван амьдралын жам ёсыг тэрсэлснээс болж ертөнц дэлхийд угаас байгаа ч үгүй маш олон гамшиг зудыг авч иржээ. Ингээд бусдыг хөнөөхөөр барахгүй эцэстээ өөрийгөө ч хохироон сүйтгэсэн нь буй. Шинжлэх ухаан техник технологи өндөр хөгжсөн өнөөдрийн хувьд энэхүү хорлолын аюул улам түргэсэж улам ихсэж бид бөмбөрцөг дээрээ ч тайван амьдарч чадахгүй хэмжээнд хүрэв.

Энэ бол үнэнээс тэрсэлсний шинж, үнэнээс айж байнга худал хуурмаг үйлдэж байсны үр дагавар мөн. Энэ замбуулин хорвоогийн сайн сайхан юун дээр тогтдог вэ?, гагцхүү “үнэн” хэмээх ёс зүйн төлөө орших ажээ. Хүн хэмээх



THE CULTURAL WAY

хар тэргүүтний ихэнх нь үнэнтэй эвлэрэхээс зугтацгааж, үнэн бус үйлдэл хийхийн учир, эцэс сүүлдээ үнэн ёсны шийтгэлийг зайлшгүй хүлээдэг.

Үнэн ёсыг байгаа чигээр нь ухааруулан мэдрүүлэхийн тулд урлаг, уран зохиол, яруу найргийнхан хурц зэвсэг болох үг хэлээрээ гажуу бурууг зад илчилж, хүн төрөлхтөндөө үнэн мөнийг олгохын төлөө амь насаа золиос болгон тэмцэж явсан нь дэлхий нийтийн түүхээс олж харахад төвөгтэй зүйл огт үгүй. Зөвхөн 19 дүгээр зуунд дэлхий дахинд үнэн ёс, эрх чөлөөг дээдлэх эрмэлзлийн төлөө германд Гёте, англид Байрон, орост Пушкин, америкт Хейдман, францад Андре Шене, Рембо, энэтхэгт Тегур, монголд Данзанравжаа нар хурц зэвсэг үнэн үг хэлээр тэмцэж явсан нь буй.

Үг хэл болгон өөрийн онцлог шинжтэй байдаг. Энэ нь тухайн орон газар, цаг үе, хүний үзэл сэтгэлгээ, нийгмийн орчин тойронтой маш нарийн холбоотой бүлгээ. Монгол үг хэлэнд олон мянган жилийн түүхтэй бөгөөд тасралтгүй хөгжсөөр иржээ. Тиймээс хэл судлаачдын зүгээс монгол үг хэлэнд гүн бясалгасан тарнийн увдис хадгалагдан ирсэн бөгөөд үгийн хүч чадал маш их буйг онцолжээ. “Нэг үгийг зуун удаа давтан хэлвэл биелэдэг”, “сайн сайхан ерөөл магтаал дандаа сайн зүйлийг авч ирдэг”, “сайныг ерөө, мууг хараа” хэмээх үг хэлний тухай зуу мянган онож хэлсэн зүйр цэцэн үг, хэлц хэллэг, сургаал үгс буй.

Яруу найрагчдын хэл хэллэг, үргэлж хэрэглэдэг үг яриа нь түүний зан заншил, соёл зүй, үзэл сэтгэлгээтэй нь маш нарийн холбоотой байдаг.

Р.Чойном, Л.Чулуунбаатар хоёрын дандаа хэрэглэх үг хэлэнд:

Аав ээж, өвөө эмээ, монгол бүсгүй, хүүхэд, сургууль соёл, хүлэг морьд, тал нутаг, солонго, монгол хэл, дэлхийн ба монгол нутгийн гол мөрөн, уул сарьдаг, хайрхан овоо, дөрвөн далай, таван тив, монгол, таван хошуу мал, од гараг эрхэс, нар сар бөмбөрцөг, алтан гадас од, долоон бурхан, үүрийн цолмон, гэгээрэх үүр, үдшийн бүрий, тэнгэр газрын савслага, бороо салхи мөндөр, элэг зүрх цөс уураг тархи гэхчлэн таван цул зургаан сав маш олонтоо давтагдан гарна. Энэ бол хоёр найрагчийн бүх насаараа үнэнийг хайх эрлийн төлөө тэмцэн явсан үзэл бодлын илрэл болох яруу шүлгийнх нь хамтын хэл хэллэг мөн бөгөөд эдгээр үсгийн дотор шингэсэн хайр энэрлийн төлөө мятаршгүй тэмцлийн галт зэвсэг нь ч эдгээр үг хэлний илэрхийлэл ажгуу !

Р.Чойномын хэл хэллэгийн талаар миний бичсэн докторантын өгүүлэл “Р.Чойномын яруу найргийн учирлахуй эрдэм”-ийн нэгд “Р.Чойномын хэлний хэв маяг” хэсэгт маш нарийн өгүүлж задалсан нь буй.

Л.Чулуунбаатарын хэлний тухай алдарт яруу найрагч Б.Бүрэнбэх гуай:



THE CULTURAL WAY

“... Л.Чулуунбаатарын шүлэгт Монголын Нууц Товчооны шүлэглэлт мэт үг цөөн, дүр тод, айзам чанга, хийсгэц огцом уламжлалыг залгамжлан бадруулахыг ихэд хичээсэн, монголын эртний бичгийн шүлгийн яруу уламжлалыг хичээн залгамжилсан суурин дээр үгийг хурц, авсаархан, дүрслэг хэрэглэдэг нь түүний зохиолын ой төрхжилд ямар нэгэн дөхөм шатыг тавин өгчээ”³ хэмээн өгүүлжээ.

“Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”-ын өмнөх үг дээр түүний үг сөргүүлж утга илэрхийлэх үг хэлний гайхамшгаар үзэл бодлыг илтгэх, үг хийгээд хөгжмийн нэгдлийн тухай нэгэнт дурдан өнгөрсөн тул энд нуршихгүй !

Юутай ч яруу найрагч үг хэлний зэвсгээр үзэл сэтгэлгээгээ чөлөөтэй илэрхийлж байхын тулд байнга хэрэглэдэг хайртай үг хэллэг нь тэдний ертөнцийг үзэх үзэл, үнэн мөний төлөөх үй ажиллагаа, өөрийгөө ирлэж буй ухаан бодол, энэ насныхаа бэл хөрөнгөө өөр бусдад хүргэж өгөхийн төлөөний тэмцэл хэмээн үзэхэд оновчтой санагдана.

Үнэнийг илэрхийлж, худал хуурмагийг няцаан шүүмжлэхийн төлөө монголын говь нутгийн хоёр хөвгүүний үзэл бодол, тэмцэл зүтгэл нь тэдний яруу тансаг үг хэлний ид шидэнд дүрслэгдэн үлдсэн нь буй.

Мөн яруу найрагчийн үг хэлний дотроос өнгө бодлын сонголт, тооны бэлгэдэл багтдаг бөгөөд энэ хоёрын дээдлэн шүлэглэдэг өнгө нь “солонгын долоон өнгө” ба цэнхэр өнгө юм. Харин тооны бэлгэдэлд монголчууд нийтээр хүндэтгэдэг гурав, долоо, ес, арван гурав, хорин нэг, дөчин нэг, наян нэг зэрэг нь дандаа илрэхээс гадна мянга, түм, сая, живаа, дүнчүүр хэмээх хам тоо олонтоо гардаг.

Нягтлан үзвэл Р.Чойномын шүлэг найрагт нарийн зүйлийн тухай, бодит юмсын ур чанарын тухай маш нарийн зурагладаг онцлог буй. Энэ бол яруу найрагчийн үзэгдэл юмсыг хумх талаас нь маш нарийн дуран хараагаар шинжиж түүнийгээ онцлог шинжээр өгүүлэх гэж буй санал бодлоо гарт баригдаж, нүдэнд үзэгдтэл нь томруун болгож чаддаг ур чадвартай. Л.Чулуунбаатарын шүлэг найрагт бодит дүр зураг байхыг ихэд чухалчилдаг бөгөөд түүний үг хэлэнд байнга яригддаг зүйл нь багаас маш аугаа томд хүрдэг ерөнхий нэгэн үзэгдэлт шинжтэй байдаг. Энэ нь аливаа юмыг холоос, өндрөөс, уужим зайнаас нь ажиглаж, өчүүхэн багыг маш уужим зайд – од, гараг, эрхэс тэнгэрт хүргэдэг, харагч талаас ажиж шинжих ур чадвар илтэд харагдана. Энэ хоёр нарийн ажиглалт, уужим холыг бодон сэтгэх арга барил нь яг сайхан 20

³ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, т 11-12



THE CULTURAL WAY

дугаар зууны монгол яруу найрагчдын хам сэрлийн нэгэн үзэгдэл болж онцлогдоно.

Яг тэр янзаараа 20 дугаар зууны монголын яруу найргийн өргөн чөлөөнд Р.Чойном уран дүрийг зурж гаргасан бөгөөд Л.Чулуунбаатар нь яруу сонсголонтой хөгжим дуугаар хөглөж өгсөн онцгой нэгэн жишээ болох болов уу хэмээн үзэж байна.

ДҮГНЭЛТ

Монголын өнөөгийн шүлэгт найрагт амьд дүрийг амилуулсан яруу найрагч бол Ренчиний Чойном мөн, шүлэг хөгжмийн нэгдлийн төлөө гүнзгий сэтгэж амжилттай бичиж чадсан нэгэн төлөөлөгч бол Л.Чулуунбаатар мөн. 20 дугаар зууны монгол яруу найргийн тавцанд тэр хоёрын нэмж оруулсан хувь нэмэр олон буй. Нэгэн сайн шүлгийг амтархан уншихад амьд хөдөлгөөнт дүр зураг байх мөртөө бас яруу сонсголонтой дуу аялгуу байх нь манай яруу найргийн хөгжин байхын маш чухал тал болой.

НОМ ЗҮЙ

1. Алтангадас. “Монгол ардын аман зохиол хорь гучаад оны монгол улсын шинэ шүлэгт нөлөөлсөн нь”, БХҮнИСЭШС, 1993 №3
2. Асга. “Өвөр Монголын монгол шүлэг бүтээлт дэх монгол улсын нөлөө судлал – Дэлхийн утга зохиол сэтгүүлийн эргэн тойронд”, ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
3. Ч.Эрдэнэ-Баяр. “Монгол улсын орчин үеийн утга зохиол ба зөвлөлт орос улсын утга зохиолыг харьцуулан судлах асуудалд”, ӨМИСЭШС, 2005 №4
4. С.Энхбаяр. “Утга зохиолын онол”, УБ., 2011
5. Ч.Эрдэнэбаяр. “Монголын орчин үеийн эх орон сэдэвт яруу найргийн хөгжлийн товч”, ӨМИСЭШС, 2000 №1
6. Б.Энхтүвшин. “Их Нацагдорж – 20 дугаар зууны монголын соён гэгээрүүлэгч, их зохиолч”, Дундад улсын монгол судлал, 2007 №4
7. Эрхэмбаяр. “С.Буяннэмэх ба түүний зохиол бүтээлийн судлал”, ӨМИСХХ, 2008
8. С.Урсгал. “Монгол утга зохиолын түүх зүйн судлал”, ЛяҮнХХ, 2011
9. Оюунбилэг. “Монгол гэрээр сэдэвлэсэн хоёр шүлгийн харьцуулал”, Алтан түлхүүр, 1985 №6
10. Б.Оюунбилэг. “Шинэ эриний монгол шүлгийн гоо зүй”, ӨМСХХ, 2007
11. Буяндэгжрэх. “БНМАУ-ын орчин үеийн яруу найргийн хөгжлийн товчоон”, ӨМҮнБДСЭШС, 1989 №1



THE CULTURAL WAY

12. Бэй Ган. “Ч.Лодойдамбын Тунгалаг тамир ба М.Хасбаганын Засгийн хутгуур романыг харьцуулах нь”, ӨМҮНИСЭШС, 2004 №4
13. Б.Бүрэнбэх. “Зөн мэдрэхүй шүлэг зүй”, ӨМАХХ, 2001
14. Б.Бүрэнбэх. “Монгол шүлгийн гоо зүйн түүхчилсэн төлөв”, ӨМАХХ, 1991
15. Б.Бүрэнбэх. “Уянгын эрэлчний тэмдэглэл”, ӨМАХХ, 1984
16. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I (Ойн дугараа), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
17. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть II (Зүүдэн цагаан туулиан), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
18. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть III (Хан сасарын үүл), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
19. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть IV (Зүүдэнд минь хоноосой), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
20. Солонгод Л.Хасбаатар. “Р.Чойном, Л.Чулуунбаатар”, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
21. Л.Хасбаатар. “Р.Чойном судлал жич түүний шүлгүүд”, ӨМСХХ, 1996
22. Л.Хасбаатар. “Эмэгтэйчүүдийн чөлөөлөлт ба Р.Чойном”, Алтан гарди, 1996 №4
23. Л.Хасбаатар. “Цагийн жаварт бөхөөгүй зул”, УБ., 2009
24. Ц.Хасбаатар. “Монгол улсын шүүмж судлалын өнөөгийн байдал”, ӨМИС, 2000 №4
25. Хуан Жинь. “Орчин үеийн монгол шүлгийн судлал”, докторын зэрэг хамгаалах өгүүлэл.
26. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх”, I, ӨМАХХ, 1985
27. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, ӨМСХХ, 2004
28. Хайрхан. “Уугал шүлэг зүй”, Улсын бар хэвлэлийн хороо, 2014
29. Хайрхан. “Өнөөгийн монгол шүлгийн ерөнхий судлал”, ӨМСХХХ, 2010
30. С.Хас-Өлзий. “Б.Лхагвасүрэнгийн шүлгийн нууцлал – үйлт уран дүр”, Алтан түлхүүр, 1994 №1
31. Хүүзаяа. “Монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1980-1990)”, ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
32. Л.Хүрэлбаатар. “Дуун утгын яруу зохист”, ӨМСХХ, 2008



THE CULTURAL WAY

33. Монгол судлалын нэвтэрхий толь редакц. “Утга зохиолын боть”, ӨМАХХ, 2002
34. Ван Мандаа. “С.Буяннэмэхийн хоёр жүжгийн гар бичмэл эх ба түүний судлал”, ӨМСХХ, 2004
35. Ван Мандаа. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, ӨМСХХ, 2000
36. Ван Мандаа. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, ӨМСХХ, 1999
37. Б.Мөнхдэлгэр. “Лү Шюнь ба Д.Нацагдоржийн зарим зохиол бүтээлийн харьцуулал”, ЗУМУНБТМСЭШС, 1992 №4
38. Кань Хай Ин. “Диваажингийн элчийн зөн мэдрэхүй”, ӨМИСЭШС, 2020 №1
39. Н.Сайшаалт. “Монгол шүлгийн айзмын судлал”, ӨМАХХ, 1981
40. Сүег. “Монгол шүлгийн ухаан”, ӨМИСХХ, 2000
41. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть I, (Уянгын шүлгүүд), ӨМСХХ, 2014
42. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть II, (Найраглалууд), ӨМСХХ, 2014
43. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть III, (Шүлэглэсэн тууж романууд), ӨМСХХ, 2014
44. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть IV, (Туужсын зохиолууд), ӨМСХХ, 2014
45. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть V, (Дурсамж найрууллууд), ӨМСХХ, 2014
46. О.Дашбалбар. “Гэгээн ертөнц”, боть I, ӨМСДХДШХХ, 2019
47. О.Дашбалбар. “Монгол ертөнц”, боть II, ӨМСДХДШХХ, 2019
48. О.Дашбалбар. “Хүн ертөнц”, боть III IV, ӨМСДХДШХХ, 2019
49. О.Дашбалбар. “Шидэт ертөнц”, боть V VI, ӨМСДХДШХХ, 2019
50. О.Дашбалбар. “Гунигт ертөнц”, боть VII VIII, ӨМСДХДШХХ, 2019
51. Дорнотэнгэр. “Монгол уран зохиолын содон бүтээлийн тайламж”, ӨМИСХХ, 2010
52. Туяа. “Содон шүлэгчийн хэв шинж – Р.Чойном ба Ли Бай-ийг харьцуулан өгүүлэх нь”, ӨМҮНИСЭШС, 2004 №1
53. Ч.Туяасайхан. “Ренчиний Чойном”, Монгол улсын орчин уран зохиолын түүх, 1997
54. Л.Чулуунбаатар. “Ойн дугараа”, ӨМАХХ, 2000
55. Ц.Чойдандар, Жамба. “Монгол улсын орчин үеийн уран зохиол”, ӨМИСХХ, 1998
56. “Р.Чойномын амьдрал уран бүтээл”, Чойномын мэдэлсний 70 жилийг ойг тэмдэглэх эрдэм шинжилгээний хурлын бүтээл, УБ., 2006



THE CULTURAL WAY

57. Д.Цэрэнсодном. “Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал”, ӨМСХХХ, 1983
58. З.Ренчиндорж. “Шинэ эриний монгол уран зохиолын шүүмжлэл”, ӨМҮнХХ, 2007
59. “Р.Чойном”, боть I, Шүлэг, УБ., 2017
60. “Р.Чойном”, боть II, Шүлэг, УБ., 2017
61. “Р.Чойном”, боть III, Найраглал, УБ., 2017
62. “Р.Чойном”, боть IV, Найраглал, УБ., 2017
63. “Р.Чойном”, боть V, Шүлэглэсэн тууж, УБ., 2017
64. “Р.Чойном”, боть VI, Шүлэглэсэн тууж, УБ., 2017
65. “Р.Чойном”, боть VII, Роман, тууж, өгүүллэг, УБ., 2017
66. “Р.Чойном”, боть VIII, Тууж, өгүүллэг, УБ., 2017
67. “Р.Чойном”, боть IX, Орчуулга, УБ., 2017
68. “Р.Чойном”, боть X, Захидал, УБ., 2017
69. “Р.Чойном”, боть XI, Дурсамж, хууч яриа, УБ., 2017
70. “Р.Чойном”, боть XII, Ярилцлага, сурвалжилга, УБ., 2017
71. “Р.Чойном”, боть XIII, Судлал, шинжлэл, УБ., 2017
72. С.Баянжаргал. “Монгол хөгжимдхүйн бүрэн бичиг”, ӨМАХХ, 2017
73. С.Баянжаргал. “Монгол язгуур урлаг – хөгжимдхүй дууны 365 нэрс”, ӨМАХХ, 2017
74. 百度文库：《交响乐乐哭介绍一图文详解》，
<http://wenku.baidu.com/view/2dc72fbf9fc3>
75. 王宁：《管或乐法基础教程》，高等教育出版社，2008年
76. Хайрхан. “Шүлгийн ухааны тайламж”, ӨМИСХХ, 2020

**ЛИГДЭНИЙ “АМЬДРАЛЫН ЛОГИК” БА ДАЗАЙ ОСАМУ-ИЙН “ХҮН БАЙХ
ЭРХГҮЙ” ЗОХИОЛУУДЫГ ХАРЬЦУУЛАХ НЬ**

Аснаа*

ХУРААНГУЙ

Лигдэн ба Дазай Осамү (1909-1948) бол монгол япон үндэстний содон туужсын зохиолчид бөгөөд маш олон шилдэг зохиол бүтээл туурвисан юм. Иймэрхүү адил бус цаг үе, улс гүрэнд мэндэлсэн хоёр зохиолчийн хооронд илэрхий харьцаа холбоо байхгүй боловч “Амьдралын логик” ба “Хүн байх эрхгүй” зохиолуудад адилхан бүр сийрэг мөртөө эмзэг сэтгэлтэй эрэмдэг дүрийг бүтээж, хүний дотоод сэтгэлгээний ертөнцөд гүнзгий задлалт хийсэн мөртөө гүн ухаан ёс суртахууны үүднээс хүн чанарын тухай сүвэгчлэв.

Түлхүүр үгс: *Лигдэн, Дазай Осамү, Амьдралын логик, Хүн байх эрхгүй*

Нэг. Дотоод сэтгэлийн илэрхийлэл

Уран зохиол бол хүний дүр, зан чанар, дотоод сэтгэлийн ертөнцийг илрүүлдэг. Шинэ эриний туужсын зохиол нь зөвхөн нийгмийн амьдралын бодит ахуй ба зохиолын баатрын гадна дүрийг дүрслэхээс биш, харин уран дүрийн дотоод ертөнцийн баялаг шинж, будлиант шинжийг уудлан, нэн гүн ухаанч өөд шинжилсэн байна.

Лигдэн өгүүлэл бичих санаатай хүмүүст: “Амьдралыг аль чадахуйц нарийн бич. Хүнийг аль болохуйц дотроос нь бич”¹, “Өгүүлэгт зохиолын гол баатар буюу дэд баатрын дүрийг зураглахдаа дотроос нь илэрхийлэх, аливаа үйл ажиллагааг нь хүн чанарт нь суурьлан илтгэвэл жинхэнэ хүнд улам ойртоно”² хэмээн сануулав. Эдгээр үгсийн учрыг түүний зохиол бүтээлээс нарийн тайламж олж болно. 1981-1985 он бол Лигдэний тууж бүтээлтийн анхан шат. Тус үе нь яг сайхан монгол туужсын онцлогт эргэлт хувьсалт гарч байсан хугацаа юм. Бодитоор хэлбэл бүх улсад өргөнөөр явагдаж байсан “Дотоод шилжилт” гэх чухад цаг эрин байжээ. Лигдэн “Амьдралын логик”, “Үнсэлт”, “Алтан бөгтөр” зэрэг анхны туужаасаа эхэлж, хүний гадна байдал, галбир

* ӨМИС, МСДС-ийн 2021 оны магистрант

Удирдагч багш: Л.Хасбаатар

¹ Сүег. Лигдэн судлал II, ҮнХХ., 2009 т 123

² Сүег. Лигдэн судлал II, ҮнХХ., 2009 т 111



THE CULTURAL WAY

төрөхийг зураглахыг эрхэмлэх биш, харин дотоод сэтгэл бодлыг илэрхийлэхийг чухалчилж, туужийн үйл явдлаар биш, харин хүмүүсийн сэтгэлийн ажиллагаагаар шижимлэн зохиомжлохыг зорьсон байдаг. Хэрэг учрыг хүмүүс яаж хийж байгаа тухай биш, харин яагаад тэгж хийж байх тухай илүү бичих болжээ. Үүний улмаас тууж дахь үйл явдлын хүүрнэл нь биш, сэтгэлийн дүрслэл, ухамсрын ажиллагааны илэрхийлэл нь чангарсан байна³.

Дотоод сэтгэлийн хөдөлгөөний дүрслэл нь дүрийн баялаг мөртөө будлиантай дотоод сэтгэлийн ертөнцийг илэрхийлж, хүний дүр төрөхийг нэн бүрэн төгөлдөр мөртөө үнэн бодитой болгодог. Амьдралын логикт зохиогч Лигдэнээс хүний сэтгэхүйн эмзэг шинжийг нарийн дүрслэн, зохиолын баатрын зан чанарыг товойлгов. Өндөр том хайлс модыг хараад “...Энэ муу мод бас юундаа тэгж их сүжиглээд үхэхгүй ургаж л байна даа! чи дэлхийд нэгдүгээр зэргийн сайн мод болчихлоо гээд ямар л хэрэг байна даа! хайлсны үйлгэс нь сайхан гээд улсууд авдар хорго хийдэг. Босоо авдар хийвэл зүгээр боловч ямар л хэрэг байна гэж, харин нэг сайн авс хийхийг ч хүрэхгүй – ер нь би маргаашнаас хөрөөдөж аваад эртнээс авсаа хийлгэе !” гэж онгирч бардам аашилж байсан Жаргалбат улайрсан чоныг хараад саяхан авс хийх гэж байсан өнчин хайлснаас үхэн зуурч, амьдралын дутагдал нь түүний санаанд ширхэг төдий ч орохгүй болж, амьдрал бол хамгийн эрхэм чухаг орхиж болшгүй эрдэнэ шиг санагдах болов. Өнгөрсөн үеийн уран зохиолд алдаа осол гаргасан баатраа үг хэл үйл ажиллагааны нөлөөллөөр сурган ятгадаг байсан бол тус зохиолд Жаргалтын засралыг голдуу түүний дотоод сэтгэлийн хурц ширүүн зөрчил мөргөлдөөний үр дүн болгож бичсэн байна.

Дотоод сэтгэлгээний задлалт болон дотоод сэтгэлийн дэлгэлт нь Лигдэний зохиолын өгүүлэмж тоочилтын гол бүрэлдэхүүн болж буй. Үүнийг зохиогчийн сэдэлт оролдлого буюу хөөцөлдлийн нэг тал нь гэж үзэж болно. Тэр зохиолдоо хүмүүсийн дотоод ертөнцөд хайлт хийж, оюун санааны мөр мөшгиж, сүнсний гүн дэх нууцыг илчилж, хүмүүсийн ил далд ухамсрыг илэрхийлэхээр зоригтой дүрслэл хийжээ⁴. Энэ талаар Дазай Осамү ч адилхан юм. “Хүн байх эрхгүй”-д бас “Амьдралын логик”-той адилаар зохиолын баатрын сэтгэлийн цагааварлал ба сэтгэлийн дүрслэлийг уялдуулан, дотоод сэтгэлийн илэрхийллийг чухалчилсан байна. Японы алдарт эрдэмтэн Окүно Такео Хүн байх эрхгүйн талаар “Тус бүтээл бол төрөлх этгээд зан араншинтай, даруу ноомой, сайн сайхан, гуниглангуй мөртөө ариун цэвэр оюун сүнсгүй хүмүүсийн төлөөлөл байж, тэд нарын аврагч мөн. Дазай Осамү бол Хүн байх эрхгүйг зохион бүтээхийн төлөө хорвоод ирсэн зохиолч, тэр мөн энэхүү бүтээлээрээ

³ Сүег. Лигдэний зохиол бүтээлийг ерөнхийлөн өгүүлэх нь. Монгол судлал, 2002 сэт №4

⁴ Мэргэнбилэг. Оюун санааны мөр мөшгиж ахуй амьдралыг энгийн эзэмдэгч. Алтан түлхүүр, 1988 сэт, № 1



THE CULTURAL WAY

хүмүүсийн сэтгэлд мөнхөрнөм”⁵ гэв. Обаёозү ба Жаргалбат хэдийгээр сийрэг мөртөө эмзэг сэтгэлтэй боловч хоёулангийнх нь эх үндэс нь адил бус. Жаргалбат тоост ертөнцийг тууртал харсан гүн ухаантан болохоор аливаа бүхнийг үл тоомсорлон, нийгмийг хажуунаас нь ажигладаг. Гэтэл Обаёозү-д авч хэлбэл хүн төрөлхтөн бол ойлгогдошгүй мөртөө аймшигтай байж, биеэ хамгаалах үүднээс хүний сэтгэлийг ойлгож, нийгэм уусахаар хичээдэг. Обаёозү-ийн “Тэд бие биеэ хуурдаг боловч хоёр этгээдээрээ өчүүхэн ч шархдахгүй нь гайхалтай юм, яг л харилцан мэхэлж байгаага олж мэдээгүй шиг. Иймэрхүү жишээнүүд хүн төрөлхтний амьдрал дунд газар сайгүй буй ... би хичээлийн бичиг дээрх шударга ёс буюу ёс суртахууны тухай өчүүхэн ч хайхрахгүй. Харин хүмүүс харилцан хуурч мэхэлсэн ч үргэлжлэн ариун гэгээн, баяр бахдалтай амьдралыг эдлэх буюу дүүрэн итгэлтэйгээр өдөр хоногийг өнгөрүүлэхэд нь үнэхээр ойлгож ядна. Хүн төрөлхтөн эцсийн эцэстээ надад үүний доторх нарийн нууцыг ойлгуулж чадаагүй. Хэрэв би ойлгосон бол ингэж их хүн төрөлхтөнөөс сүрдэх учиргүй, тэд нарыг бялдуучлах хэрэггүй, нэн хүмүүсийн амьдралтай эсэргүүцэлдэж, шөнө болгон тамын оронд унасан мэт зовлонг амсахын ёсгүй ...” гэх сэтгэлийн цагааварлаас мэдэх нь өвчлөнгүй нийгмийн орчинд хүмүүсийн үнэнч шударга нинжин сэтгэл талхигдан, үнэнийг баримтлан, сайн сайхныг хөөцөлддөг нэг нь харин ондоо этгээд болж, нийгэмтэй уусахуйяа бэрх болдог.

Доройтсон утга зохиолын бүлгийнхэн утга зохиолын хүний мөн чанарыг илрүүлэхийг чангатгаж, дотоод сэтгэлийн үнэн бодит байдлыг чухалчилж, биеч чанарын ба дотоодчилсон “хийсвэр ертөнц”-ийг үүтэн бүтээхийг хөөцөлддөг. Бусдач утгаас авч хэлбэл, тус урсгал бүлгийн уран зохиол нь японы ард иргэдийн дайн байлдаанаас болсон гажигтай сэтгэц ба хүмүүсийн дайны сүрдүүлэл жич дайны дараах нийгэмд дургүйцсэн сэтгэлийг илрүүлж, тухайн үеийн үнэн бодит сэтгэцийн байдлыг харуулахыг зорьдог⁶. Тус бүтээлд Дазай Осамү дамаар хүмүүсийн харгис хэрцгий, өнгөц дорой, худал хуурмаг мөртөө нарийн будлиантай хүн чанарыг үзүүлж, өөрийгөө илчилж, өөрийгөө задлан шинжилсэн хүн нэг бүрийн бодит байдалд ойртсон зохион бичлэгийн арга барил нь тэдгээр минчүүрмэл ба горь тасарсан японы залуучуудад туйлын их нөлөө үзүүлж, уншигчдын гүн бодлогошрол ба цуурайтлыг үүсгэсэн байна.

⁵王秀娟: 《〈人间失格〉在中国的译介综述》, 《齐齐哈尔大学学报》, 2020年第1期。

⁶刘炳范: 《论日本战后[无赖派]文学》, 《齐鲁学刊》, 2000年第2期。



THE CULTURAL WAY

Хоёр. Хоосон энгийн шинж

Лигдэн гуайн “Миний нүдэнд харагддаг, чихэнд сонсогддог, сэрэлд мэдрэгддэг ертөнц бол шогийн ертөнц юм”, “Тиймдээ би хоосон энгийн хэлбэрээр нь ертөнцийг тусгахаар чармайдаг”⁷ гэмээр шог энгийн, хошигнол егөөдөл нь түүний уран зохиолын илтгэх арга барилын чухал хэлбэр болсоор иржээ. Амьдралын логикт Жаргалбатын энгийн үеийн үзэл сэтгэлгээ, үйл явдал болон чононд бүслэгдсэний дараа үхлийн даваан дээр тэлчилж байсан үеийн бодол сэтгэлгээг хооронд нь зөрчилдүүлж, түүний тухайн үеийн үйл явдал ба дотоод сэтгэлийн мөргөлдөөнөөр дамжуулж энгийн шинжийг бүрэлдүүлж чаджээ⁸. Жаргалбат авс хийх гэж бодож байсан хайлснаас зулзаган самж эхийнхээ гуяыг тас тэвэрч байх шиг модны салаанаас тэвэрч наалдсан, амьдралдаа идэвх бус байдалтай байж, амьдрал бол төрөхөөс үхэхийн хоорондох хугацааны идэх өмсөхийн хялбархан ээлжлэл давталт гэж бодож байснаасаа үхлийн өмнө амь тэлчилж аврал гуйж хашхирсан ба амьдралын сайхныг ухаарч, амьдралыг дээдлэх болсон үзэл бодлынх нь зөрчил мөргөлдөөнийг маш энгийн харуулсан байна. Аюулаас мултарсан Жаргалбат эмнэлгийн хороонд Цасанлянхуагаас уучлал гуйх гэж зориг шулуудсан боловч “голсондоо гологдоно гэж дээ ...”, “Цасанлянхуа чинь уулаасаа тэнгэрийн дагина байж шүү дээ, миний нүд сохор байсандаа олж үзсэнгүй, эрдэнийг илжигний баасаар эндүүрээд эсгүүлчихсэн юм чинь, хохино доо”, “илжиг шиг тэнэг нь харин ...” гэж өөрийгөө хошигнов. Ингэж логик бус зөрчил мөргөлдөөнтэй нийгмийн элдэв хачин үйл явдлаас түүний логик чанарыг эрэлхийлэх, шог инээдэм хачин жигтэй үзэгдлээс сайн сайхан ба муу муухайг тодруулан ялгаварлах сэтгэлгээний илрүүлэлтийн арга хэлбэр нь түүний зохиол бүтээлийн энгийн шинжийн бүрэлдэлд чухал үйлдэл /нөлөө/ үзүүлэв⁹.

Уран зохиолын зохион бүтээлтийн арга барилын хувьд өөрийгөө хошигнож, егөөдөх нь Дазай Осамү-ийн утга зохиолын нэгэн онцлог. Түүний зохиол бүтээлд доройтмол амьдрахуйн гүн ухаан ба үгүйсгэх үзлийн зарчмаар дүүрч, ёс суртахуун ба хүмүүсийн хуурмаг багийг урахаар дамжин хүн чанарын дотоод дахь ба махан биеийн сүүдэр талыг илрүүлж, өөрийгөө хошигнож, егөөдөх явц дунд хувийн хүн чанарын чөлөөлөлтийг хөөцөлддөг¹⁰. Дазай Осамү-ийн зохиол бүтээлд уламжлалт ёс суртахууны хүлээслэл ба энгийн утгын талаарх зөв буруугийн баримжаа гэж байхгүй, харин “санаачилгаасаа доройтож”, “дуртайяа доройтох” бол түүний үйл ажиллагааны баримжаа.

⁷ Сүег. Лигдэн судлал II, ҮнХХ., 2009 т 120

⁸ Баяр. Лигдэний өгүүллийн энгийн шинжээс. Алтан түлхүүр, 1988 сэт, № 1

⁹ Сүег. Лигдэний зохиол бүтээлийг ерөнхийлөн өгүүлэх нь. Монгол судлал, 2002 сэт №4

¹⁰任江辉:《论日本无赖派作家太宰治的文学思想》,《西南科技大学学报》,2012年第3期。



THE CULTURAL WAY

Түүнийг багтаасан доройтсон утга зохиолын бүлгийн зохиолчдын ихэнх нь дайны дараах үймээнт он саруудад оюун санааны алмайралд учирсан зориг мөхсөн хүмүүс болохоор, тэд нар урам хугарч, горь тасрахдаа арга бус өөрийгөө элгэлж, өөрийгөө шоглох байдлаар зохион бүтээхийн улмаар цаг үе, нийгмийн хошигнон эсэргүүцэх зорилгодоо хүрдэг¹¹. Иймээс тэд нарын зохиол бүтээлд зохиогчийн хувь хүний бие сүүдэр ба доройтмол амьдралын явц олон харагдана. Обаёозү ба Дазай Осамү бүр том гэр бүлд төрж өссөн бөгөөд уламжлалт ёс суртахуун, эрх сүртэй эсэргүүцэж, бас эхнэр хүнтэй гол харайсан, мэдрэлийн өвчний эмнэлэгт хүргэгдсэн, олон удаа биеэ хорлосон зэрэг адилавар түүхтэй. Хүн байх эрхгүйд зохиогчоос Обаёозү-ийн амаар “Бах мэлхий. Энэ бол даруй би мөн. Ертөнцийн хүмүүс намайг уучлах юм уу, үгүйсгэх юм уу гэх асуудал оршихгүй. Би бол муур, нохойнд ч хүрэхгүй амьтан, зөвхөн бах мэлхий шиг алгуур аажмаар мөлхөж явна” гэж өөрийн гаслант нэг насаа дүгнэв. Дазай Осамү бодит ахуйд дургүйцдэг боловч түүнээ шууд тусгаж илэрхийлдэггүй, харин дандаа зохиол дахь дүрийн ярилцлага, тэд нарын хошигнол, егөөдөл, ёжлолоор дамжуулан японы нийгмийн харанхуй ахуй байдал ба хүмүүсийн жигшүүрт овор байдлыг дам тусган шүүмжилдэг юм. Ерөнхийд нь үзвэл, Амьдралын логикт Лигдэнээс энгийн болон хошигнолыг хавсарган хэрэглэсэн боловч энгийн шинж нь нэн илэрхий байж, Хүн байх эрхгүйд хошигнолын шинж нь нэн мэдэгдэм байдаг.

Гурав. Эрэмдэг дүр

Хорьдугаар зууны 80-аад оны тууж шүүмжлэлд эрэмдэг дүр хэмээх ухагдахуун түрэгдэж нэг бүлэг туужийн уран дүрийг эрэмдэг дүрд бүртгэн шинжилжээ. Энэ бол туужийн урлагийн хүний дүрийн шинэ нээлт бэлгэдэл мөн. Эрэмдэг хэмээх үг хүн амьтны эрхтний илүү дутуу, жирийн бус байдлыг заана. Эрэмдэг дүр гэдэг нь оюун санаа нь эрэмдэг, эрүүл бус өвчтэй сэтгэцийн асуудалтай хүнийг хэлжээ¹². Эрэмдэг дүрийн тухай эрдэмтдээс өөр өөрийнхөө санал бодлыг илэрхийлэх боловч тэдгээр үзлийн дундаж нь бүр дүрийн оюун санааны гажуудал дээр төвлөрч байна.

Монгол үндэстний уламжлалт уран зохиолын дүрд “баатар хүний эрэлхэг үйлсийг баясангуй үзлээр магтан дуулах бол монгол туужийн зохиолд онцлогдсоор ирсэн уламжлалын хэв шинж”¹³, гэвч шинэ эриний уран зохиолд оюун санааны сүйрэлд учирсан, дотоод сэтгэлийн эмзэг хуучтай өчүүхэн жижиг дүрүүд илэрсэн байна. Энэхүү урсгалын эгнээнд зохиолч Лигдэн ч

¹¹ 刘炳范:《论日本战后[无赖派]文学》,《齐鲁学刊》,2000年第2期。

¹² Дорнотэнгэр. Шүүмжлэлийн чадавхи. ӨМАХХ., 2002 т 314

¹³ Намиа. Намиагийн өгүүлэл шүүмжийн түүвэр. ӨМАХХ., 2005 т 222



THE CULTURAL WAY

өөрийн хүч нэмрээ үзүүлэв. “Хамгийн сүүлчийн хөрөнгө”, “Үнсэлт”, “Амьдралын логик” зэрэг зохиолуудад сэтгэлийн эмзэгтэй дүрүүдийг амилуулан босгожээ. Эхэн үеийн Жаргалбат хэдийгээр бие махбод эрүүл саруул боловч оюун сэтгэцийн шарх сорвитой. Тэр амьдрал бол “тэнэг” мулгуу сохор зүтгэлтэн юм уу, биеэ олон хэлбэрээр зовоох ажиллагаа гэж хэлэх бөгөөд ихэнх хүмүүст “тэнэг” гэсэн дүгнэлт өгчээ. Тэгээд тэнэгийг тодруулж чадсан өөрийгөө мэргэн хүн гэж үздэг. Амьдралын үнэн ёсыг таньсан гүн ухаантан гуай тэнгэр дээрх үүл, газар доорх модноос эхэлж өвчтнийг аврах гэж яаравчилж яваа Цасанлянхуаг хүртэл нүдэнд өртсөн бүхнээ үл тоомсорлон, хажуунаас нь хошигнож суудаг. Тэгвэл ертөнцөөс уйдсан Жаргалбат амьдралд хайр найргүй болж, үхлийн өмнө лав тавиад байх ёстой. Гэтэл азарган чонын хүнс болохгүйн төлөө тэр өнчин хайлснаас тас тэвэрч, “...Махан бие нь амьдралаас холдож байгаа ч сэтгэл санаа нь харин амьдралд улам ойртож, амьдралд амь насаа даатгаж авралын гарыг аливаа бүхнээс илүү бачим тулгам мөрөөдөн хүлээнэ”. Жаргалбат бол арван жилийн самуурлын халыг амссан хүн. Тэр соёлын их хувьсгалын үеийн үнэн худал, сайн муу тонгорсон нийгэмд хүсэл аврал хүчлэн урагшлах итгэлээ алдав. Түүний амьдралын гоо сайхныг ажиг нүдэнд нь сүүдэр бүрхсэн байна. Гэтэл тус удаагийн гэнэтийн хэрэг хувьсгалаар дамжин Жаргалбат ертөнцийн хамгийн эрхэм нандин зүйл болох өгөөмөр үнэн чин сэтгэлийн шимийг хүртэж, түүний унтарсан зүрх сэтгэл нь дахин дүрэлзэн ноцож эхэлжээ.

“Хүн байх эрхгүй” бол мөн нийгмийн шилжилтийн үед бичигдсэн зохиол билээ. Зохиолын баатар Обаёозү 2-р дайны дараах нийгмийн эмх дэглэм, ёс суртахуун самуурсан цаг үеийн хүн хар түүрүүтний бие биеэ харилцан мэхлэн, харилцан ашиглан, аливаа юманд зөв буруу, хэв зарчим гэж байхгүй байдалд өнчирч ганцаардсан эрэмдэг дүр. Обаёозү: “... Энэ ертөнцөд би ганцаараа ондоо этгээд шиг санагдана. Би хүмүүстэй харилцахын аргагүй, учир нь юу ярихаа мэдэхгүй байдаг”, “Хүн төрөлхтнөөс би ерөөсөө айж сүрдэх сэтгэлгээ өвөрлөж, өөрийгөө хүн төрөлхтний нэг гишүүн болсны хувьд нэн жаахан ч итгэлгүй. Би ямагт өөрийнхөө бухимдлаа дотроо нууж, уйтгарлангуй мөртөө сэргэг сэтгэлээ хамгаалахын төлөө цэгц цайлган өөдрөг үзэлтний дүрийг гарган, аажмаар өөрийгөө нэгэн шог инээдэм гаргадаг хачин хүн болгосон байна” гэв. Обаёозү өөрийнхөө бусадтай адил бус үзэл бодолд шаналан зовж, уйтгарлан бухимдана. Тэр аажмаар гэрийн хүмүүс, багш нар, зарц шивэгчид зэрэг эргэн тойрны хүмүүстээ шог гаргаж шившгээ үзүүлдэг алиалагч болжээ. Учир нь энэ бол багны доорх ядарч туйлдсан эрэмдэг сүнсээ нуух хамгийн сайн арга болно.

Утга зохиолын урлаг бол урлагчдын зохион бүтээлтийн өнгөн давхаргаас гүнзгийрч нийгэм амьдралын дотоод агуулахууныг илрүүлэхэд буй.



THE CULTURAL WAY

Дайны сүйдэл хийгээд хувьсгаын хөнөөл нь дан ганц улс төр аж ахуйн хохирлоор илрэх биш, ард түмний бие сэтгэл адилхан талхигдалд учирдаг. Жаргалбат ба Обаёозү бүр нийгмийн онцгой нэгэн хувьсалын хугацаанд оршиж, тэд нарын хүний сэтгэл дэх сэжиглэл ба бодит ахуй дахь төрөгдөл нь адил. Иймээс хоёр зохиолчоос зөвхөн зохиолын баатрын үзэл бодол, зан чанарт нарийн гүнзгий задлалт дэлгэлт хийж, сэтгэлийн эмзэгтэй дүрийг бүтээхийн төдий биш, харин хүн чанарын бодлогошрол, цаашлаад бүхийл үндэстний түүхэн амь насны тухай гүн бодлогошрол агуулагдаж байна.

Дөрөв. Хүн чанарын эрэлхийлэл

Амьдралын логик ба Хүн байх эрхгүйд сэтгэлийн гэм архагтай эрэмдэг дүрийг бүтээсэн боловч хоёр зохиолын баатрын эцэс төгсгөл нь харин тэс ондоо. Жаргалбат амьдралын дардан харгуйд замаа олохгүй элий балай, эндүү буруу явж ирсэн боловч эцсийн эцэстээ амьдралыг ухааран, нийгэмд буцав. Үүний эсрэгээр Обаёозү харин нүгэлээс гүн гүвт шавартав. Ер нь гадаадын утга зохиолд илэрч байх уйдангуй өвчлөнгүй, оюун сэтгэцийн гүн архагтай зохиолын баатрыг бодвол Лигдэний бийр доорх дүрүүд нь нэн эрүүл, өөдрөг шинжтэй. Үүний шалтгааныг монгол үндэстний соёл сэтгэц зүйн гүн давхаргаас эрэлхийлэх чухалтай. Монгол туульсын баатрын дүрээс “Ахуйч үзлийн шинэ журмаар цаг үеийн ухамсрыг харуулахдаа мөн л Алмас мэт баатар хүчтэн, Цогт мэтийн дайын гавьяатан, Хатанбаатар мэтийн хамтач үзэлтэн буюу баатар хүний дүрийг бүтээн, магтаал дуугаар зохиол бүтээлийн хөг аясыг өндөрлөсөн байдаг”¹⁴. Иймээс баатар хүний эрэлхэг үйлсийг магтан дуулж, хүмүүсийн дотоод сэтгэлд байгаа гоо сайхны зүйлсийг эрэлхийлэн уудлах бол монгол туужийн зохиолд онцгойрсоор ирсэн уламжлалын хэв маяг болно.

Лигдэн өөрийнхөө өгүүллэг бичих туршлагын тухай ярихдаа: “Өгүүллэгийн үүрэг нь хүн нийгмийг дүр төрхөөр бичиглэн зураглаж үзүүлэхэд буй. Зорилго нь уйлуулах, дуулуулахаар дамжуулан танилтад хүргэх буюу гоо сайхныг сэрүүлэхэд буй”, “Би хүний сайн сайхны төлөө зохиол бичнэ”¹⁵ гэв. Үүнээс мэлдэх нь, Лигдэний өгүүллэгт амьдралын гоо сайхан хийгээд тэрхүү гоо сайхны сэтгэл санааг хүсэн хөөцөлдөж, хүн төрөлхтний амьдрал доторх гоо сайхны зүйлс болон сайн сайхан хэрэг бодисыг амирлуулах хүсэл эрмэлзэл”¹⁶ бол түүний туужийн зохиолынх нь гоо таашаахуйн нэгэн хэлбэр юм. Түүний энэхүү хүсэл зорилт нь Амьдралын логикт бүрэн төгөлдөр илэрч чаджээ. Жаргалбат гуниг гансралд сэтгэл үймэрч, оюун санааны хоосролын дунд

¹⁴ Намиа. Намиагийн өгүүллэг шүүмжийн түүвэр. ӨМАХХ., 2005 т 221

¹⁵ Сүег. Лигдэн судлал II. ҮнХХ., 2009 т 112

¹⁶ Рэгсүрэн. Гоо сайхны хөөцөлдөл. Өнөр цэцэг, сэт 1985, № 1



THE CULTURAL WAY

хойрго явж өнгөрсөн боловч эцэстээ Цасанлянхуагийн нөлөөлөлд “сүнсний үмэн” нь эдгэрч, амьдралын сайхныг мэдэрч, амьдралыг шинээр угтсан байна.

Обаёозү харин Жаргалбат шиг амьдралын нэг цуврал цохилтын дараа дахин өөдлөн босож чадаагүй, хөөрхий тэр нийгмээс улам холдов. Амьдралын логикт Жаргалбат сүнсний сайхан бол аливаа сайхны манлай, амьдралыг амь насаараа хамгаалах ёстой гэх ухааныг таньсан бол Хүн байх эрхгүйд Обаёозү-аас хүн чанар бол бузар булай, аливаа сайн сайхан юм нь оршиж чадахгүй учраас доройтол нь сая эцсийн төгсгөл хэмээх дүгнэлтийг олжээ. Обаёозү багаасаа хүн төрөлхтнөөс сүрдэж, худалдагч, үйлчлэг нартай ч шууд харьцахаасаа айн хэлмэгддэг. Гэвч тэр архины мухлагийн эмэгтэйчүүдийн дэргэд таатай амарч тавтай нойрсож чадна. Учир нь тэдгээр эмэгтэйчүүд ерөөс Обаёозү-ийн бие дээрээс олж алдахыг боддоггүй. Обаёозү ч тэд нарын бие дээрээс ариун эх Мариагийн дүрийг олж харна. Гэхдээ түүний нүдэнд хууль ёсны юм нь нэн аймшигтай, нэн будлиантай санагддаг учраас тэр хууль бус ажиллагаанд оролцож түр зуур ч гэсэн бие сэтгэлийн тааламжтай байхыг хичээнэ. Обаёозү: “Би тамын орон байдагт итгэнэ, гэвч яасан ч тэнгэрийн оронд итгэдэггүй” гэснээс түүний тухайн нийгмийн байдал ба өртгийн үзэлтэд сэжиглэл төрж, ханамжгүй байхыг үзэж чадна. Цагаан цайлган Риүко-ийн худалдаачинд бузарлагдсан явдал нь Обаёозү-ийн сэтгэлийн шархыг улам хөндүүрлүүлж, нийгэм нийтэд нэг мөр итгэл алдав.

Обаёозү-ийн амьдрал хэдийгээр харахад дэмий балай боловч тэр нэг насаараа амь насны үнэн мөнийг эржээ. Амьдралд жинхэнэ зориг мохож, урам хайр алдсан хүн ер нь ялж ялагдахыг хайхарч, баг зүүж бусадтай харьцдаггүй. Иймээс Обаёозү бол цул амьдралаас цөхөрсөн хүн биш, харин амь насны үнэ цэнийг хайж, хүн чанарыг илэрхийлсэн төрөгдлийн дунд тэнэж яваа хөөрхийлөлтэй дүр билээ. Амьдралын логикт амьдрал бол гоо сайхан, хүний төлөө, хүслийн төлөө амьдарвал сая амьдрал амттай сайхан байж чадна гэж хүний оюун санааны гоо сайхныг магтаж дагуулсан бол Хүн байх эрхгүйд Обаёозү өөр би-ийн доройтлоор дагуу ертөнцөд эсэргүүцэл тавьж, өөр би-ийн үгүйсгэлээр хүмүүсийг нүдний өмнөх амьдралын тухай гүнзгий сэтгүүлэв. Даруй зохиогчоос нийгмийн бараан талыг зураглахаар дамжин хуучны өөрийгөө үгүйсгэн эвдэж, шинэ ёс суртахууны ухамсар ба үнэ цэнийн үзлийг дахин байгуулан, хүний сэтгэлийн дотоод дахь сайн сайхан зүйлийг сэрээж, өөр би-ээ дахин цогцлуулахын төлөө юм. Иймээс Хүн байх эрхгүй ба Амьдралын логик бол бүр гүн ухаан ёс суртахууны үүднээс хүн чанарын сүвэгчлэл хийж, хүний оюун сүнсний гоо сайхныг уриалан дууджээ.



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

Амьдралын логик ба Хүн байх эрхгүйд дүр бүтээлтээс агуулга үзэл санаа, урлагийн илэрхийлэх арга хэлбэр зэрэг талаар адилавар шинж оршиж байгаа боловч хоёр зохиогчийн өвөрмөц гоо сайхны үйл ажиллагаа, үндэстний уламжлалт соёл ухамсрын ялгаа зөрөөнөөс болж тэс өөр үр дүнд хүрсэн байна. Лигдэн ба Дазай Осамү нар цаг үеийг туулсан эрүүл бус сэтгэцийг дэлгэн үзүүлж, тэд нарын дотоод ертөнцийг мөшгин, хүн чанарын үнэн мөн байдлыг илчлэхийг хичээв. Хоёр зохиогчийн амьдралын үзэл ба хүн чанарын тухай ойлголт бодол зөрөөтэй байдаг боловч бүр хүмүүсийн дотоод сэтгэлгээний гоо сайхны зүйлсийг амилуулан сэргээхийг зорилгоо болгожээ.

НОМ ЗҮЙ

1. Сүег. Лигдэн судлал II, ҮнХХ., 2009
2. Сүег. Лигдэний зохиол бүтээлийг ерөнхийлөн өгүүлэх нь. Монгол судлал, 2002
3. Мэргэнбилэг. Оюун санааны мөр мөшгиж ахуй амьдралыг энгийн эзэмдэгч. Алтан түлхүүр, 1988
4. Баяр. Лигдэний өгүүллийн энгийн шинжээс. Алтан түлхүүр, сэт 1988
5. Дорнотэнгэр. Шүүмжлэлийн чадавхи. ӨМАХХ., 2002
6. Намиа. Намиагийн өгүүлэл шүүмжийн түүвэр. ӨМАХХ., 2005
7. Рэгсүрэн. Гоо сайхны хөөцөлдөл. Өнөр цэцэг, сэт 1985
8. 王秀娟: 《〈人间失格〉在中国的译介综述》, 《齐齐哈尔大学学报》, 2020 年
9. 刘炳范: 《论日本战后[无赖派]文学》, 《齐鲁学刊》, 2000 年
10. 任江辉: 《论日本无赖派作家太宰治的文学思想》, 《西南科技大学学报》, 2012 年

**АЛУНГОО ЭХИЙН “ХУГАРСАН СУМААР ХӨВҮҮДЭЭ СУРГАХ”
ХҮМҮҮЖЛИЙН АРГЫН СУДАЛГАА**

Пань Вэньчи*

ХУРААНГУЙ

Алунгоо өөрийн нөхөр Добун мэргэнийг нас барсны дараа дахин гурван хүү төрүүлсэн нь өмнөх хоёр хүүгийнх нь хардлагыг төрүүлсэн тул хөвгүүддээ “сумыг хугалах” зарчмаар эв нэгдэлтэй байхыг сургасан билээ. Алунгоог нас барсны дараа таван хүү нь түүний хүслийг биелүүлж, бага дүү Бодончарт эд хөрөнгө хуваарилаагүй ч эцэст нь ах дүүс гар нийлэн хүсэл зорилгоо биелүүлжээ. Чингис хаан ч хөвгүүдийнхээ дунд үүссэн маргааныг шийдвэрлэхдээ “хугарсан сумаар хөвүүдээ сургах” арга барилыг огт ашиглаагүй нь Чингис хааны амьдарч байсан үеийн онцлогтой холбогдох юм.

Түлхүүр үгс: *Алунгоо, хугарсан сум, хөвүүд, эв нэгдэл, Чингис хаан*

Ориул

Алунгоо эхийн судалгааны тухайд өмнөх судалгаа нэлээд үр дүнд хүрэв. Хань Рүлинь “Түрэг, Монголын өвөг дээдсийн домог” өгүүлэлдээ Алунгоо хүү төрүүлсэн нь Фүюй, Сяньби, Уйгурын домогтой холбоотой гэж үзжээ. У Мали-ийн “Улс орнуудын мэлмий хуанли”-д хэвлэгдсэн Хуа Таогийн “Алунгоогийн нурууны тэмдэглэл” өгүүлэлд “Юань гүрний нууц түүх”, “Түүхэн тэмдэглэл”, “Юаний түүх” зэрэгт Алунгоогийн тухай тэмдэглэл бий. Перс түүхийн материалд холбогдох бүртгэлийг ашигласан харьцуулсан судалгаа ч байдаг. Ван Лайши-ийн “Монголын эртний судар дахь үндэсний эв нэгдэл, дэвшлийн үзэл санааны судалгаа” “Монголын нууц товчоон” дахь Алунгоогийн “Хөвүүдээ таван сумаар зааж сургасан” түүхийг жишээ болгон авч үзэх нь” өгүүлэлд Алунгоогийн “Хөвүүдээ хугарсан сумаар сургасан” түүхийг тоймлон, орчин үеийн соён гэгээрлийн нөлөөг онцолсон боловч иш татсан түүхийн материалд нарийн шинжилгээ хийгээгүй байна. Алунгоогийн “Хугарсан сумаар хөвүүдээ сургах” хүмүүжлийн арга нь хөвүүдэд нь нөлөөлсөн, Чингис хаан ч мөн энэ хүмүүжлийн аргыг хожмын үеийн хөвүүдээ сурган хүмүүжүүлсэн эсэх талаар олон судалгаанд дурдаагүй байдаг. Өмнөх эрдэмтдийн судалгаа, холбогдох түүхэн баримтад тулгуурлан энэ асуудлыг шийдвэрлэхийг оролдсон бөгөөд хэрэв зохисгүй бол ахмад эрдэмтэд шүүмжилж, засаж залруулахыг хүслээ.

* Шаогуань Их Сургуулийн багш, МУБИС-ийн докторант



Өгүүллийн ерөнхий бүтэц:

1. Хураангуй
2. Оршил
3. Алунгоо ба түүний нөхөр Добун мэргэн хоёрын ханилсан үйл явц
4. Алунгоогийн “Хөвүүдээ хугарсан сумаар сургах” хүмүүжлийн арга барил
5. Алунгоог нас барсны дараах нөхцөл байдал
6. Чингис хаан ба хугарсан сумаар сургах хүмүүжлийн аргын мөн чанар
7. Дүгнэлт
8. Ном зүй

阿阑豁阿“折箭教子”教育方式研究

潘文琪

摘要：阿阑豁阿在丈夫朵奔篾儿干离世后，又生了三个儿子，这引起了之前两个儿子的猜疑，因此她通过“折箭”的道理来教育她的儿子们团结的重要性。阿阑豁阿离世后，她的五个儿子并未遵照她的意愿，未将财产分给她的幼子孛端察儿，但是最后兄弟们还是携起手来共创了一番事业。成吉思汗在解决儿子们的纷争中，没有用到“折箭教子”的方式，这与成吉思汗所处的时代背景有关。

关键词：阿阑豁阿；折箭；儿子；团结；成吉思汗

引言

关于阿阑豁阿的研究，前人研究成果颇丰。韩儒林在《突厥蒙古之祖先传说》一文中认为阿阑豁阿感光生子与扶余、鲜卑、畏兀儿的传说有关¹。华涛的《乌马里〈眼历诸国行纪〉关于阿阑豁阿“腰”的记载》一文参照了《元朝秘史》《史集》及《元史》中有关阿阑豁阿的记载，并利用阿拉伯文史料的相关记载进行对比研究²。王来喜在《蒙古文古籍中的民族团结进步思想研究——以〈蒙古秘史〉中阿阑豁阿“五箭训子”的故事为例》一文中将阿阑豁阿“折箭教子”的故事作了概述，并指出“折箭教子”对现代的启示作用³，但是未将所引用的史料加以深入分析。诸多研究并未提及阿阑豁阿“折箭教子”这种教育方式对于她的儿子们的影响，以

[基金项目]2017年国家社会科学基金重大项目“13-14世纪波斯文蒙古史史料搜集与研究（17ZDA191）；

2020年国家社科基金青年项目“大一统视野下的元朝汗位继承问题研究”（20CZS026）；

[作者简介]潘文琪（1993-），女，广东新丰人，蒙古国立教育大学（Mongolian State University of Education）博士研究生，韶关学院教师，主要从事高等教育、蒙古教育史的研究工作。

¹韩儒林：《突厥蒙古之祖先传说》，载《穹庐集》，上海：上海人民出版社，1982年，第274-299页。

²华涛：《乌马里〈眼历诸国行纪〉关于阿阑豁阿“腰”的记载》，载《西部蒙古论坛》，第1期，2022年，第10-15页。

³王来喜：《蒙古文古籍中的民族团结进步思想研究——以〈蒙古秘史〉中阿阑豁阿“五箭训子”的故事为例》，载《内蒙古师范大学学报》，第3期，2022年，第5-9页。



及后世成吉思汗是否也用到这一教育方式去教育他的儿子们。本文在前人研究的基础上，参照相关的史料记载，试图解决这一问题，不当之处，还请前辈学者们多多批评指正。

一、阿阑豁阿与丈夫朵奔篾儿干相识的经过

阿阑豁阿与丈夫朵奔篾儿干相识的故事充满着神话色彩。朵奔篾儿干有个名叫都蛙锁豁儿的哥哥，他的额中生有一双眼睛，因此能够看三程之远。一天都蛙锁豁儿同他的弟弟朵奔篾儿干去不儿罕山，都蛙锁豁儿看到了一群百姓，在这群百姓中有一个非常漂亮的女子，并萌生了给他弟弟朵奔篾儿干提亲的想法。朵奔篾儿干看到那个名叫阿阑豁阿的女子果然生得美丽动人，因此便同意了这门婚事。那么阿阑豁阿的父亲豁里刺儿台篾儿干为何同意这门婚事？据《元朝秘史》的两处记载：

史料一：那群百姓是豁里刺儿台篾儿干一家，当初阔勒巴儿忽真地面的主人名巴儿忽歹篾儿干，有一个女儿名巴儿忽真豁阿，嫁与豁里秃马敦部落的官人名豁里刺儿台篾儿干为妻，在阿里黑兀孙地面，生了这阿阑豁阿名字的女儿。⁴

史料二：豁里刺儿台篾儿干起来的缘故，为豁里秃马敦地面貂鼠、青鼠野物被自火里禁约，不得打捕的上头烦恼了，听得不儿罕山野物广有，全家起来，投奔不儿罕山的主人名晒赤伯颜，因此就做了豁里刺儿姓。朵奔篾儿干取了阿阑豁阿为妻的缘故，是这般。⁵

通过这两段史料的记载可以得知，阿阑豁阿的家族成员及其嫁给朵奔篾儿干的原因。其中阿阑豁阿的父亲豁里刺儿台篾儿干是豁里秃马敦部落的官人。据《史集》的记载可知，豁里秃马惕部落位于巴儿忽真-脱窟木地区⁶。因此豁里刺儿台篾儿干娶了阔勒巴儿忽真地面的主人巴儿忽歹篾儿干的女儿巴儿忽真豁阿，并生下了阿阑豁阿。豁里秃马惕部落属于森林部落⁷，主要以捕捉貂鼠、青鼠为生，但是由于这种谋生之路被禁止，豁里刺儿台篾儿干听说在罕山地区野生动物众多，便决定带领全家人迁居到不儿罕山地区，投靠了晒赤伯颜。可见，豁里刺儿台篾儿干一家人是外来移民。而朵奔篾儿干家族在其祖先孛儿帖赤那和豁埃马阑勒之时便迁居到了斡难河和不儿罕山⁸，已经在那里经营数代，有着深厚的根基。笔者推断，豁里刺儿台篾儿干很有可能是考虑到快速地在罕山一带站稳脚跟的问题，因此才会同意将女儿阿阑豁阿嫁给朵奔篾儿干。

二、阿阑豁阿“折箭教子”的教育方式

阿阑豁阿与朵奔篾儿干成婚后，生了两个儿子。但是朵奔篾儿干离世后，阿阑豁阿又“独自”生了三个儿子。先前阿阑豁阿与朵奔篾儿干所生的两个儿子别古讷台与不古讷台背地里对于母亲阿阑豁阿所生的三个儿子表示疑惑，甚至认为这三个儿子是母亲阿阑豁阿与家仆所生。阿阑豁阿得知此事后，便找了一个恰当的时机对儿子们进行说教。据《元朝秘史》记载：

春间一日，他母亲阿阑豁阿煮着腊羊，将五个儿子唤来根前列坐着，每人一只箭箠教折折，各人都折折了。再将五只箭箠束在一处教折折呵，五人轮着都折不折。因那般他母亲阿

⁴ 乌兰校勘：《元朝秘史》，第8节，北京：中华书局，2012年。

⁵ 乌兰校勘：《元朝秘史》，第9节。

⁶ [波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》第一卷 第一分册，北京：商务印书馆，2014年，第202-203页。

⁷ 乌兰校勘：《元朝秘史》，第241节。另见[波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》第一卷 第一分册，第202页。

⁸ 乌兰校勘：《元朝秘史》，第1节。



THE CULTURAL WAY

阿阑豁阿说：“别勒古讷台、不古讷台您两个儿子疑惑我这三个儿子是谁生的？您疑惑的也是。您不知道，每夜有黄白色人，自天窗门额明处入来，将我肚皮摩挲，他的光明透入肚里去时节，随日月的光，恰似黄狗般爬出去了。您休造次说，这般看来，显是天的儿子，不可比做凡人，久后他每做帝王呵，那时才知道也者。”阿阑豁阿就教训着说：“您五个儿子，都是我一个肚皮里生的，如恰才五只箭箠一般，各自一支呵，任谁容易折折。您兄弟但同心呵，便如这五只箭箠，束在一处，他人如何容易折得折？”住间，他母亲阿阑豁阿歿了。⁹

上述史料的记载便是阿阑豁阿“折箭教子”的故事，其中阿阑豁阿将朵奔篋儿干离世后所生的三个儿子用“感光生子”的故事加以神话。根据韩儒林的研究可知，阿阑豁阿感光生子与扶余、鲜卑、畏兀儿的传说有关¹⁰。这可能是阿阑豁阿为后来所生的三子找到合理的解释，亦有可能是成吉思汗及其家族成员在取得丰功伟绩后借助已有传说来神话自己的祖先。事实如何？姑且不论。阿阑豁阿利用蒙古高原上普遍使用的弓箭的箭杆来揭示兄弟团结起来的重要性，这样的教育方式既不是一味地进行说教，又能够生动地将所要讲的道理表示出来，起到了很好的效果。

三、阿阑豁阿离世后发生的事情

随着阿阑豁阿的离世，五个儿子之间由于争夺家产发生了争执。阿阑豁阿的四个儿子别古讷台、不古讷台、不忽合塔吉及不合秃撒将家产分了，见孛端察儿愚弱，就没有将家产分与他。孛端察儿见此情形，离开了家里，独自生活。孛端察儿的哥哥不忽合塔吉应该是良心发现，担心弟弟一个人在外有所差池，因此出去寻找他，后来便找到了孛端察儿并将他接回家去。在回家的路上孛端察儿与他的哥哥不忽合塔吉提起了一件大事。据《元朝秘史》记载：

孛端察儿点着马，随他哥哥行间，说道：“人的身子有头呵，好衣裳有领呵。”说了，他哥哥不答应他。孛端察儿再将前头的言语说了两遍，他哥哥才说：“你两三便的言语，只是这般说呵，意思里如何？孛端察儿回说，恰才统格黎河边那一群百姓，无个头脑管束，大小都一般，容易取有，俺可以掳他。”他哥哥说：“既是这般呵，到家里去，哥哥弟兄每商量着，都来掳他。”到家里兄弟每商量了，教孛端察儿做头哨。孛端察儿哨到那里，将他一个怀孕的妇女拿住，问他：“你是甚么人氏有？”那妇人回道：“我是扎儿赤兀惕阿当罕兀良合真的人氏。”那其余百姓，他兄弟五个都掳将回来了。因这般头口也有，茶饭使唤的都有了。¹¹

从这段史料的记载可以得知，孛端察儿被他的哥哥不忽合塔吉接回家的途中，孛端察儿向不忽合塔吉叙说了统格黎河边那群百姓没有首领的事实，并说可以将他们全部掳走。不忽合塔吉在得知这一情况后便提出回家后集合其他兄弟一起商量后再作决定的想法。之后，孛端察儿做头哨，五个兄弟齐心协力，成功地将这群百姓掳回家中作了奴仆，增加了家族中的劳动力，在那个生产力低下的时代，意义十分重大。这段记载也说明了五兄弟能够齐心协力的办成这件大事离不开阿阑豁阿生前“折箭教子”的教育方式的影响。

四、成吉思汗“折箭教子”的教育方式的真伪

波斯史学家志费尼在《世界征服者史》中记载了成吉思汗“折箭教子”的故事，据《世界征服者史》记载：

⁹ 乌兰校勘：《元朝秘史》，第19-22节。

¹⁰ 韩儒林：《突厥蒙古之祖先传说》，载《穹庐集》，第281页。

¹¹ 乌兰校勘：《元朝秘史》，第33-39节。



THE CULTURAL WAY

有天，他（成吉思汗——引者）把儿子们召来，从箭袋里抽出一支箭，折为两段。接着，他抽出两支箭，也折为两段。他越加越多，最后箭多到大力士都折不断了。然后，他对儿子们说：“你们也这样。一支脆弱的箭，当它成倍地增加，得到别的箭的支援，那怕大力士也折不断它，对它束手无策。因此，只要你们弟兄互相帮助，彼此坚决支援，你们的敌人再强大，也战胜不了你们。”¹²

王来喜将这段史料直接引用到论文中，未作判断¹³。何高济则认为，志费尼很有可能借鉴了《元朝秘史》中阿阑豁阿“折箭教子”的故事¹⁴，因此成吉思汗“折箭教子”的真实性是值得怀疑的。如若研究这一问题，需要借助其他史料的记载加以印证。

事实上在成吉思汗的诸子中也确实发生过争执。这一事件源于成吉思汗派往花刺子模的商人在讹答刺城被其首领哈只儿汗杀害¹⁵，因此成吉思汗要西征花刺子模为他的商队复仇，在出征之时，成吉思汗的妃子也遂提醒他要选定自己的继承者，成吉思汗的次子察合台为了争夺汗位竟然说成吉思汗的长子术赤是蔑儿乞人的后裔，他们甚至到了大打出手的地步。成吉思汗在沉默后也对他的儿子们进行了说教，据《元朝秘史》记载：

太祖（成吉思汗——引者）说：“如何将拙赤那般说？我子中他最长，今后不可如此说。”察阿歹微咲着说：“拙赤的气力技能，也不用争。诸子中我与拙赤最长，愿与父亲并出气力，若有躲避的，就便杀了。斡歌歹敦厚，可奉教训。”于是太祖再问拙赤如何说？拙赤说：“察阿歹已说了，俺二人并出气力，教斡歌歹继承者。”太祖说：“你二人不必并行，天下地面尽阔，教您各守封国，你二人说的言语各要依着，休令人耻笑。如在前阿勒台、忽察儿二人，将自说的言语违了，后如何了来？如今他子孙见在，教随您每以为鉴戒。”¹⁶

根据这段史料的记载可知，成吉思汗是很有威望的，因为他只说了一句话便让察合台服气，但是这一句话也说明了术赤的长子身份是得到成吉思汗认可的¹⁷。察合台表示今后愿与术赤团结起来与父亲成吉思汗共创大业。于是察合台便推举成吉思汗的三儿子窝阔台为汗位继承人，并得到了术赤的认可。在这里，成吉思汗的教育方式与阿阑豁阿有所差别，这是由于当时的形势所决定的。在那时，成吉思汗已经统一了蒙古高原，他的家族已经拥有无限的领地和财富，并积极准备对外扩张，因此成吉思汗打算将长子术赤和次子察合台分封到不同的领地，并列举了他的伯父阿勒台与堂兄忽察儿二人因为违背诺言，最后被杀死的事例¹⁸，借此来劝说术赤和察合台不要违背团结一致的诺言。事实证明，成吉思汗的教育方式为蒙古帝国的稳定发展起到了极大的作用。

¹² [伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册，呼和浩特：内蒙古人民出版社，1981年，第44-45页。

¹³ 王来喜：《蒙古文古籍中的民族团结进步思想研究——以〈蒙古秘史〉中阿阑豁阿“五箭训子”的故事为例》，载《内蒙古师范大学学报》，第3期，第6-7页。

¹⁴ [伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册，第47页。

¹⁵ [伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》上册，第90-92页。

¹⁶ 乌兰校勘：《元朝秘史》，第255节。

¹⁷ 关于术赤的血统问题，见瞿大风：《术赤生平史略考辩》，载《内蒙古社会科学》，第3期，1996年，第58-63页。瞿大风在此文中认为，术赤是成吉思汗的亲生子。

¹⁸ [波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》第一卷 第二分册，第179页。



THE CULTURAL WAY

再者，《元朝秘史》是元朝脱卜赤颜（*tobčiyān*，国史¹⁹）中最重要的部分²⁰，是在成吉思汗的继承者窝阔台时期编纂完成的²¹，窝阔台及其手下的大臣们多数是当时术赤与察合台争执事件的目击证人，因此对于这件事情知之甚详。而《世界征服者史》的作者志费尼是在蒙哥汗时期才到达蒙古本土的²²，成吉思汗时期发生的事情，他只有参照相关史书的记载获得相关的信息，因此他很有可能误以为阿阑豁阿“折箭教子”的故事发生在成吉思汗身上。

结语

阿阑豁阿在丈夫朵奔篾儿干离世后独自抚养五个儿子，并能够通过“折箭教子”的方式教育她的儿子们团结的重要性，这是十分可贵的。在阿阑豁阿离世后，她的四个儿子在短期内由于争夺家产，将愚弱的孛端察儿排除在外，但是到了掠夺那个无领袖的部落之时，五兄弟却能够团结起来取得了成功，使得家族的仆人人数量增加，壮大了他们家族的实力，这也证明了阿阑豁阿“折箭教子”教育方式是成功的。成吉思汗是阿阑豁阿的后裔，他在长子术赤与次子察合台二人因汗位的继承问题发生纷争之时，虽然未必用到阿阑豁阿“折箭教子”的故事来教育二人，但是他通过个人威信使得术赤和察合台屈服，并立下了团结一致誓言。在行动上，成吉思汗又通过蒙古人传统的分封领地的习俗，将术赤和察合台分开，降低了他们之间发生冲突的可能性。并最终将三子窝阔台确定为汗位的继承者。成吉思汗这样做的目的是为了加强蒙古帝国的内部团结。作为一位父亲，成吉思汗教育儿子们加强团结的教育方式也会与身为母亲的阿阑豁阿存在着不同之处。

¹⁹ 亦邻真：《〈元朝秘史〉及其复原》，载《亦邻真蒙古学文集》，呼和浩特：内蒙古人民出版社，2001年，第713页。

²⁰ 亦邻真：《〈元朝秘史〉的流传与价值》，载《亦邻真蒙古学文集》，第695页。

²¹ 乌兰校勘：《元朝秘史》，第281节。

²² 'Ala-ad-Din 'Ata-Malik, Translated by JOHN ANDREW BORLE, Ph.D: *THE HISTORY OF THE WORLD-CONQUEROR*, VOL. I, CAMBRIDGE:HARVARD UNIVERSITY PRESS, 1958, p. xix.



THE CULTURAL WAY

ABSTRACT

Alan Qo'a gave birth to three more sons after the death of her husband, Dobun Mergen, which aroused the suspicion of the previous two sons, so she taught her sons the importance of unity through the principle of "Folding Arrows". After Alan Qo'a's death, her five sons did not share the property with her youngest son, Bodončar, as she wished, but in the end the brothers joined hands and built a business together. The fact that Genghis Khan does not use the story of the "Broken Arrow" to settle his sons' disputes, it has to do with the context of Genghis Khan's time.

Keywords: *Alan Qo'a, Folding Arrows, Sons, Unity, Genghis Khan*

НОМ ЗҮЙ

1. 乌兰校勘：《元朝秘史》，北京：中华书局，2012年。
2. [伊朗]志费尼著，何高济译，翁独健校订：《世界征服者史》，呼和浩特：内蒙古人民出版社，1981年。
3. [波斯]拉施特主编，余大钧、周建奇译：《史集》，北京：商务印书馆，2014年。
4. 'Ala-ad-Din 'Ata-Malik, Translated by JOHN ANDREW BORLE, Ph.D: *THE HISTORY OF THE WORLD-CONQUEROR*, CAMBRIDGE:HARVARD UNIVERSITY PRESS, 1958.
5. 韩儒林：《穹庐集》，上海：上海人民出版社，1982年。
6. 亦邻真：《亦邻真蒙古学文集》，呼和浩特：内蒙古人民出版社，2001年。
7. 瞿大风：《术赤生平史略考辩》，载《内蒙古社会科学》，第3期，1996年。
8. 华涛：《乌马里〈眼历诸国行纪〉关于阿阑豁阿“腰”的记载》，载《西部蒙古论坛》，第1期，2022年。
9. 王来喜：《蒙古文古籍中的民族团结进步思想研究——以〈蒙古秘史〉中阿阑豁阿“五箭训子”的故事为例》，载《内蒙古师范大学学报》，第3期，2022年。

**МОНГОЛ, АНГЛИ ХЭЛНИЙ ХҮНИЙ БИЕ ЭД ЭРХТЭНИЙ НЭРЭЭР
НЭРЛЭГДСЭН ӨВӨРМӨЦ ХЭЛЦ**

Б.Базаргүр*

ХУРААНГУЙ

Монгол хэлний нэгэн өвөрмөц хэсэг болсон зүйл бол яахын аргагүй өвөрмөц хэлц билээ. Өвөрмөц хэлц, хэлц үг, хэвшмэл хэллэг, тогтвортой хэлц гэх мэтчилэн олон янзаар нэрлэн олон янзаар тодорхойлох оролдлогуудыг монголын судлаач эрдэмтэд оролдож ирсэн бөгөөд нэг мөр эцэслэн, өвөрмөц хэлц бол энэ юм үүнийг ингэж авч үзэж болно хэмээн хувааж, ангилж чадаагүй байна.

Аливаа хэл өвөрмөц хэлц, хэллэгээр баян бөгөөд өвөрмөц хэлц нь тухайн хэлнийхээ онцлог, түүх соёл, ард түмний зан заншил, амьдралын хэв маягын илэрхийлэл болдог. Жишээ нь: англи хэлний амьтны нэрээр илэрсэн өвөрмөц хэлцийг аваад үзвэл аж амьдрал ахуйтайгаа ойрхон байдаг нохой, муур, тахиа зэрэг амьтнаар төлөөлүүлэн хүн, амьтан соёлын онцлог бүхий өвөрмөц хэлц их байдаг бол монгол хэлний хувьд нохой, таван хошуу мал-аар илэрсэн өвөрмөц хэлц илүү их тоогоор байдаг, мөн монголчуудын аж амьдралд муур гэсэн толгой үгээр илэрсэн өвөрмөц хэлц цөөхөн байдаг.

Үүнээс бид өвөрмөц хэлц бол бидний аж ахуй, соёл, түүхтэй улбаалан бий болдог зүйл гэж хэлж болно. Энэ үр дүнгээс харахад англичад ч хүн байна, монголд ч хүн байна, англи хэл болон монгол хэлний хүний бие эд эрхтэний нэрээр илэрсэн өвөрмөц хэлц нь хэрхэн яаж илэрхийлэгдсэн байна, соёл, аж ахуй, зан заншлын хувьд эдгээр өвөрмөц хэлц нь адил тал ажиглагдаж байгаа эсэх, өөр бол ямар утгыг илэрхийлж байгаа эсэхийг энэхүү өгүүллээр судлах зорилгыг тавьсан болно.

Түлхүүр үгс: *Өвөрмөц хэлц, хэлц үг, гар, хэлц, хэллэг, идиом, толь бичиг*

* ӨМИС-ийн докторант. 99131783, bazargur0804@gmail.com



THE CULTURAL WAY

Өвөрмөц хэлцийн тухай

Өвөрмөц хэлц нь нэг үгийг эсвэл нэг утгыг гаргахдаа тухайн хэлний онцлогоос шалтгаалан тухайн хэлэх гэсэн санаанаас өөр утга бүхий нэг үг, хэд хэдэн үгс, холбоо үгс, тэр ч байтугай өгүүлбэрээр илэрхийлэн гаргадаг бөгөөд энэ нь яагаад заавал тухайн үг, нэгжийг ашигладаг нь хэрхэн хэзээ ямар тохиолдолд хэрэглэж байгаагаар нь тухайн хэлний онцлог, ард түмний соёл, түүх, аж ахуй, түүхэн цаг хугацааны онцлогыг агуулж байдаг.

Б.Ринчен 1950 онд нийтлүүлсэн Үгийн утга учир өгүүллийнхээ Идиом гэдэг холбоо үгийн учир хэмээх наймдугаар хэсэгтээ “Хэд хэдэн үг нийлэн, нэг утга ухагдахуун бүхий бүрэн иж болдог ёс хэл, хэл бүхэнд байдаг учир, тусгай нэртэй байдаг юм. Хэлний шинжлэлд үүнийг “идиом” гэж нэрлэдэг. Идиомын зүйлд утга санаа нь бүтэн идиоомоос гарахаас биш, идиомын доторх үг тус бүрт байдаггүй. Тийм учраас идиомын зүйлийг үг дагуу махчлан орчуулбал утга нь нэвтэрдэггүй гээгддэг юм. Жишээг хэлбэл, хоёр хүн, олон хүнд задруулахгүй аминчлан хэлэлцэхийг “эндээ гэж хэлэхэдл” гэж монголоор ярьдгийг орос бол “нүднээс нүдэн дээр” гэдэг. Англи хүн бол “нүүр нүүртээ” гэдэг. Герман бол “дөрвөн нүдний дор” гэдэг. Үүнд Монгол Орос, Англи, Германд энэ дөрвөн өөр идиом үгээр яг нэг санааг илэрхийлжээ” /1950:48/ хэмээн тэмдэглэсэн байна. Чой.Лувсанжав, “Өвөрмөц хэллэг гэдэг Энэтхэг Европ хэлний idiom хэмээх үгээс хуулан орчуулж монголчилсон нэр юм. Мөн англи хэлний idiomatic expression, idiomatic phrases зэрэг үгтэй ч утга тэнцэнэ.миний үгсийн сангийн утгазүйн онцлогийг харгалзан өвөрмөц хэллэг, бүтэн өвөрмөц хэллэг гэж хоёр хуваав” хэмээн тайлбарлажээ.

Судлаач Г.Аким “Өвөрмөц хэлц гэдэг бол гагцхүү тухайн үндэстний хэлэн дэх бүрэлдүүлсэн үгийн утга алдагдаад нэгэн нэгдмэл утга гаргах болсон тогтвортой нийлэмж үг юм”, эрдэмтэн М.Базаррагчаа, “Хоёр буюу түүнээс дээш үгс нийлж өвөрмөц утга илтгэнэ. Тогтвортой, чөлөөт бус үг, холбоо үг, өгүүлбэрийг өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэг гэж нэрлэсээр ирсэн ба хэлц үг, хэлц хэллэг ч гэх нь бий”, гэсэн бол профессор Ж.Баянсан, “.... идиом үүсэхдээ хэлний үгийн сангийн бэлэн нэгж, түүнийг холбож, нийлмэл дохио үүсгэх хэлзүйн бэлэн загварыг ашигладаг ч гэсэн дүр дүрслэлийг сэдэлийн үндэс болгодгоороо өвөрмөц ажээ.” гэж бичжээ.

Монгол хэлний хэлц үг хэллэгийг Чой.Лувсанжав, М.Базаррагчаа нар бүтэц, утга, хэлбэрийн талаас: Д.Бадамдорж, Д.Баттогтох, Ж.Баянсан, Л.Ганчимэг, Б.Пүрэв-Очир нар бодит хэрэглээ, утга агуулгын талаас: Г.Аким, Бүрэнтөгс, Ц.Дашдондов, Л.Дашням, Ж.Бат-Ирээдүй, Л.Чулуунбаатар, Г.Эрдэнэ-Очир, С.Энхжаргал нар зүйлчлэн ангилах, толилох талаас нь түлхүү судалжээ. Монгол хэлний хэлц үг хэллэгийг орчин үеийн хэл шинжлэлийн онолын үүднээс нарийвчлан судалж ангилсан томоохон суурь судалгаа өнөө хэр хараахан гараагүй байна. Хэдий тийм боловч монгол хэлний хэлц үг



THE CULTURAL WAY

хэллэгийг орос, англи, франц, япон хэлний хэлц үг хэллэгийн зохих хувилбартай дүйлгэн орчуулсан, мөн орос англи хэлний хэлц үг хэллэгийг монгол хэлээр орчуулсан бүтээлүүд хэвлэгдэн гараад байна.

Монгол хэлний хэлцийг утгаар нь ангилахдаа:

Монгол хэлний хэлцийг судлагч нар хэд хэдэн янзаар ангилж ирсэн. Гэвч нэг мөр болгож тогтсон зүйл алга байна. Хэлц утгыг ангилах нь их төвөгтэй асуудал. Үүний учир нь утгатаа байгаа юм. Чухам утгын ангилал хийхээс хэлбэрийн ангилал хийж болохгүй тул төвөгтэй байдаг.

Судлаач Н.Нансалмаа үгийн сан судлал зохиолдоо тодорхойлохдоо

1. Өвөрмөц хэлц бүр хэлбэрийн хувьд бие даасан хэд хэдэн үгээс тогтсон
2. Өвөрмөц хэлцийн бүрэлдэхүүнд орж байгаа нэгжүүдийн утгын нийлбэр нь өвөрмөц хэлцийн утга болохгүй
3. Өвөрмөц хэлцийн бүтэц, бүрдүүлбэрүүд нь байнгын тогтвортой байна.
4. Өвөрмөц хэлцийн бүр хэлзүйн хувьд хэлбэржин бэхэжсэн байдаг.
5. Ихэнх өвөрмөц хэлц үүргийн хувьд нэг үгтэй тэнцэж, өгүүлбэрийн нэг гишүүн болно
6. Өвөрмөц хэлц нь хэлний бэлэн нэгж юм. Бүтэц, бүрдүүлбэрүүд нь байнгын тогтвортой байж өвөрмөц хэлц бүхэлдээ нэг утга илэрхийлдэг нь үүний үндэслэл болж тухайн хэллэгийн ахин дахин хэрэглэх боломж олгодог.¹

Дээрх тодорхойлолт шинж чанарыг нь аваад үзвэл өвөрмөц хэлц гэдэг нь:

1. Бүх хэлэнд байдаг хэлний үгсийн сангийн нэг тогтвортой нэгж болдог
2. Тухайн хэлний өвөрмөц онцлогийг дотроо агуулдаг
3. Хоёр ба түүнээс дээш үгээс бүтдэг хирнээ бүтээсэн үгийнхээ утгыг авдаггүй
4. Өвөрмөц хэлц нь хэлнийхээ онцлогыг дотроо агуулж байдаг: түүх соёл, зан заншил, амьдрал ахуй, ертөнцийг үзэх үзэл
5. Өвөрмөц хэлц нь нэгдсэн байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн аливаа тодорхойлолтоос ангид байдаг. Жишээ нь: монгол хэлний өвөрмөц хэлцэд зүйр үг, цэцэн үг, хэвшмэл хэллэг, оньсого, зүйр үг, ёгт үг, зугаа үг, дүрслэл үг, бэлгэ дэмбэрлийн үг, хошин шог үг² зэрэг нь зарим тохиолдолд бүрдүүлэгч нь өвөрмөц хэлц болдог ч зарим тохиолдолд өөр өөр онцлогыг авч байдаг.
6. Өвөрмөц хэлц нь тогтвортой бэхэжсэн хэлний нэгж ямар нэг байдлаар шинээр өвөрмөц хэлцийг бүрдүүлэгч үгсийн аль нэгийг сольсон тохиолдолд өөрийн утгыг алддаг.

¹ Н.Нансалмаа үгийн сан судлал Улаанбаатар 2015

² Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь М.Базаррагчаа, Ч.Зээнямбуу Улаанбаатар 2014 он



THE CULTURAL WAY

- Монгол улсын их сургуулиас гаргасан Монгол хэл судлалын 15 боть номны 10-р боть үгийн сан, утга зүй номонд өвөрмөц хэлцийн тухай бичихдээ

Бүрдүүлж буй үгсийн утга нь бүгд юм уу, аль нэг үгийн утга нь шилжиж, шууд бус нэрлэлтийг үүсгэсэн тогтвортой холбоо үгсийг өвөрмөц хэлц гэнэ. Монгол хэлний өвөрмөц хэлцэд дараах шинж бий. Үүнд:

1. Бүрдүүлж буй үгсийн утга бүрэн юм уу аль нэг үгийн утга нь шилжсэн байна. Жишээ нь: амаа барих “харамсах” гэж хэлэхэд хоёр үгийн утга бүрэн шилжсэн бол, хурга дарга “бага тушаалтан” гэж хэлэхэд хурга гэх үгийн утга нь шилжжээ. Монгол соёлоор хург бол төл амьтан учир жижиг гэсэн утга илэрхийлжээ.
2. Бүрдүүлж буй үгс нь утга дүрслэл болон өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн нэмэлт утга(сonnotation)-тай байдаг. Жишээ нь, амаа барих гэж хэлэхэд зөвхөн “харамсах” утга төдий бус, хүн харамсах үедээ амаа гараараа хааж шогшрох байдлыг дүрсэлсэн төдийгүй, ихэд харамсах байдлыг давхар илэрхийлсэн нэмэлт утгатай байдаг юм.
3. Өвөрмөц хэлцэд хүн уг юм, үйл явдлыг ямар нэг хэмжээгээр мэдэрч ойлгосон зөн билиг туссан байна. Жишээ нь, хөл газар хүрэхгүй байх “ихэд баярлах” хэмээн хэлэхэд хүний алхаа гишгээ хурдан хөнгөн болдог төдийгүй, хүүхэд багачууд, тэр байтугай амьтны үр төл, бидний хайртай нохой дэгдэх шахам гүйдэг байна.
4. Өвөрмөц хэлцийн үгийг дураар сольж болохгүй. Жишээ нь, амаа барих “харамсах” гэхэ өвөрмөц хэлцийн үгийг сольж “морь барих” гэж хэлбэл өөр утгатай болно
5. Өвөрмөц хэлц нь үг шиг хэлний бэлэн нэгж байна. Жишээ нь монгол хүн уг юм байх ёстой хэмжээнээсээ хэтэрчээ гэх санааг илэрхийлэхдээ “Зуун ямаанд жаран ухна” гэж хэлдэг нь хэлний бэлэн нэгж болсонтой холбоотой байна. Учир нь монголчуудын мэдлэг, соёлоор бол зуун ямаанд тав зургаан ухна байх нв сүргийн бүтцийн зөв харьцаа болдог.
6. Өвөрмөц хэлц нь хүнд өгүүлбэрийн тодорхой нэг гишүүн, эсвэл бүхэл агуулгыг илэрхийлсэн өгүүлбэр мэтээр хүнд сэтгэгдэнэ. Жишээ нь амаа барих “харамсах” гэж хэлбэл үйл өгүүлэхүүн гишүүн мэтээр, “зуун ямаанд жаран ухна” гэж хэлбэл, уг юм хэвийн хэмжээнээсээ хэтэрчээ гэсэн бүхэл агуулгыг илэрхийлсэн өгүүлбэр мэтээр бидний ой ухаанд буудаг.
7. Өвөрмөц хэлц нь тухайн ард түмний аж ахуй, шашин шүтлэг соёл боловсрол , газар нутгийн онцлог, оюуны мэдлэгийн тусгал байна. Монгол хүн судас барих “арга эвийг нь мэдэх” гэж хэлдэг нь өвчтэй хүний судсыг барьж онош тогтоон эмчилж ирсэн анагаах ухааны уламжлалт мэдлэгтэй нь холбогддог байна.



THE CULTURAL WAY

8. Өвөрмөц хэлц нь ард түмний мэдлэг, соёлын тусгал учир өөр хэлэнд үгчлэн орчуулж болдоггүй.

Монгол, англи хэлний хүний биеийн эд эрхтний нэрээр нэрлэгдсэн өвөрмөц хэлцийн харьцуулсан судалгаа

- Энэхүү судалгааг хийхийн тулд монгол хэлний өвөрмөц хэлцийн толь бичгүүдээс давхардсан тоогоор 150000 гаруй үг, Англи хэлний 130000 үгнээс ялгалт хийсэн болно.
- Хоёр хэлэнд хүний биеийн эд, эрхтний нэрээр нэрлэсэн өвөрмөц хэлцийн нийт тоо 14583
- Үүнээс англи хэлэнд 66 төрлийн 7891 ширхэг байсан монгол хэлэнд 95 төрлийн 6488 байна.
- Англи хэлэнд байгаа хүний биеийн эд, эрхтний нэрээр нэрлэгдсэн өвөрмөц хэлцийг аваад үзвэл Толгой-908, Нуруу-600, Гар-554, нүүр-477, царай-477, нүд-475, зүрх-458, чих-309, хамар-279, бөгс-251, ам-212, шүд-201, цус-199 гэх мэтээр илрэн гарсан байна.
- Монгол хэлэнд байгаа хүний биеийн эд, эрхтний нэрээр нэрлэгдсэн өвөрмөц хэлцийг аваад үзвэл ам-1003, нүд-694, хөл-434, гар-408, толгой-394, зүрх-328, нүүр-290, хэл-257, чих-250, яс-126 гэх мэтээр илрэн гарсан байна.
- Хоёр хэлэнд байгаа хамгийн их тоотой өвөрмөц хэлцийг харьцуулан харвал Англи хэлэнд “Толгой” Монгол хэлэнд “Ам” гэсэн үг оролцсон өвөрмөц хэлц хамгийн олон тоотой байв.
- Монгол хэлний хувьд нийт 95 төрлийн биеийн эд, эрхтэн орсон өвөрмөц хэлц байсан бол Англи хэлэнд 66 төрлийн өвөрмөц хэлц байна.
- Хоёр хэлний өвөрмөц хэлцийг тоо ширхэгээр харьцуулбал:

№	Биеийн эд, эрхтний нэр	Англи хэлний өвөрмөц хэлцийн тоо	Монгол хэлний өвөрмөц хэлцийн тоо
1	Алга	31	78
2	Ам	212	1003
3	Араа	0	19
4	Арьс	60	35
5	Атга	31	7
6	Аюулхай	0	1
7	Багалзуур	0	7
8	Борви	4	34
9	Бөгс	251	85



THE CULTURAL WAY

10	Бөөр	3	37
11	Буйл	0	2
12	Буллуу	0	2
13	Булчин	23	1
14	Булчирхай	0	3
15	Бүсэлхий	3	1
16	Гавал	14	3
17	Гар	554	408
18	Гол	0	16
19	Гуя	4	16
20	Гүзээ	31	27
21	Гэдэс	71	101
22	Давсаг	0	5
23	Дал	2	11
24	Дух	0	13
25	Дэлүү	0	5
26	Зулай	0	9
27	Зүрх	458	328
28	Магнай	0	35
29	Мах	52	107
30	Мөр	113	83
31	Мэнгэ	2	5
32	Нармай	1	5
33	Нугас	0	4
34	Нулимс	55	5
35	Нуруу	600	72
36	Нус	0	9
37	Нуух	0	2
38	Нүд	475	694
39	Нүүр	477	290
40	Өвдөг	78	17
41	Өвчүү	30	10
42	Өр	0	1
43	Өрц	0	2
44	Сав	19	5



THE CULTURAL WAY

45	Сахал	10	5
46	Сормуус	10	5
47	Суга	8	7
48	Судас	0	4
49	Сүүж	0	5
50	Сүүл	133	72
51	Сээр	23	4
52	Тавхай	56	3
53	Тагнай	2	2
54	Тархи	14	52
55	Толгой	908	394
56	Ул	130	12
57	Уруул	108	22
58	Ууц	28	1
59	Уушги	8	21
60	Үе	0	6
61	Үс	150	87
62	Хаа	0	4
63	Хавирга	9	26
64	Хамар	279	106
65	Ходоод	73	36
66	хоншоор	0	36
67	хоолой	54	18
68	Хошуу	1	41
69	Хөл	135	434
70	Хөлс	0	10
71	Шүлс	0	7
72	Хөмсөг	14	10
73	Хөх	24	46
74	Хумс	115	40
75	Хуруу	186	86
76	Хүзүү	159	105
77	Хэл	151	257
78	Царай	477	99
79	Цөс	2	38



THE CULTURAL WAY

80	Цус	199	60
81	Цээж	30	86
82	Чих	309	250
83	Чөмөг	0	15
84	Шанаа	30	3
85	Шил	2	2
86	Шөрмөс	0	16
87	Шүд	201	51
88	Эр бэлэг эрхтэн	41	0
89	Эгэм	0	2
90	Элэг	10	120
91	Энгэр	0	8
92	Харцага	0	3
93	Эрүү	36	42
94	Яс	112	126

Дээрх хүснэгтээс харахад монгол хэлний хувьд алга, ам араа, борви, бөөр, буйл булуу, гол гуяа, гэдэс давсаг дал дух, дэлү зулай, магнай мах, мэнгэ, нармай нугас нүд гэсэн эрхтнүүдийн хувьд англи хэлний өвөрмөц хэлцээс тооны хувьд илүү байгаа нь харагдаж байна. Бусад эрхтний хувьд тоогоор бага илэрсэн байна.

ДҮГНЭЛТ

Хоёр хэлний хүний биеийн эд эрхтнээр нэрлэгдсэн өвөрмөц хэлцүүдийг харьцуулан харахад дээрх ялгаа болон ижил талууд илэрч байна. Ижил утгатай өвөрмөц хэлцүүдээс дурдвал:

1. Be head and shoulder above-толгой илүү
2. Head over heels-хөл толгойгүй-Анх 1350 онд англи хэлэнд орж ирсэн бөгөөд эмэгтэй хүнээс болоод амьдарлаа сүйтгэсэн гэсэн утгаар анх хэрэглэж
3. Beef-head-Барын сүүл байснаас батганы толгой байсан нь дээр
4. Eyes in the back head-ардаа нүдтэй
5. From head to foot-толгойноос хөл хүртэл
6. Nose is always in the air-хамартаа баас түрхсэн
7. Long hair, don't care-үс нь урт ухаан нь богино
8. On your hands and knees-өвдөг шороодох



THE CULTURAL WAY

9. Arm to the teeth-шүдээ хүртэл зэвсэглэсэн
10. Kings have long arms-урт гартай
11. By an eyelash-нүд ирмэх төдийд
12. Eye for an eye-нүдийг нүдээр шүдийг шүдээр гэх мэтчилэн тодорхой тооны өвөрмөц хэлцүүд монгол хэлэнд ч англи хэлэнд ч адил утгаар хэрэглэгддэг байна.

Мөн монгол хэлэнд байдгүй ч Англи хэлэнд байдаг утгууд илэрч байна. Жишээ нь: хар тамхи татах, эр бэлэг эрхтний доромж хэллэг, далайн устай холбоотой, далайчинтай холбоотой өвөрмөц хэлцүүд тохиолдож байв. Мөн соёлын ялгаа ч тод харагдаж байв.

Жишээ нь: Англичууд гэрлэх санал тавихдаа эрэгтэй нь өвдөг сөхрөн гэрлэх гуйлт гуйдаг нь анх 1470 онд Виктория хатанд Алберт хунтайж гэрлэх саналыг ингэж тавьсан бөгөөд энэ нь down on one knee буюу нэг хөл дээрээ сөхрөх гэсэн хэллэг үүнээс хойш хэрэглэгдэж соёлын салшгүй нэг хэсэг болсон нь бүх дэлхий даяар тархан хэрэглэгдэх болсон байна. Монголчуудын хувьд гэрлэх саналыг “багалзуур идье” гэж хэлдэг нь Монголын нууц товчооноо бичигдэн үлдсэн байдаг байна.

Хүний биеийн эд, эрхтний нэрээр нэрлэгдсэн өвөрмөц хэлцийн хувьд өвөрмөц хэлц дотроо томоохон тоогоор илэрч байгаа нь харагдаж байна. Ажиглалтын хүрээнд дунджаар 10 үг дутмын нэг нь ямар нэг байдлаар эд эрхтний нэр орсон байна.

Монгол хэлний өвөрмөц хэлцээр илэрсэн ч Англи хэлэнд байдгүй эрхтний тоо нь нийт 29 байна. Эдгээрээс аюулхай, буйл, булуу, булчирхай, дэлүү, өрц, хоншоор, чөмөг, хаа зэрэг эрхтэн нь монголчуудын мал аж ахуйтай холбоотойгоор хэрэглэгдэж буй нь ажиглагдав.

ABSTRACT

Any language has an idiom. Idioms represented human life, tradition, culture, chronicle time events, etc. a lot of researcher study this field and are trying to find their origin in, history, lexical meaning, and semantic structure and try to classify idioms. This study tries to find and compare idioms related to 'hand' in the Mongolian language and English language. In Mongolia idioms with 'Human body related are 6488 on the other hand in English has 7891 words. Those two languages' comparative study with idioms is not enough to study and this study is a too interesting field of comparative linguistics.



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Чой.Лувсанжав. Орос-Монгол өвөрмөц хэллэгийн толь. УБ.,1970
2. Н.Нансалмаа. Хэлшинжлэлийн судалгааны аргазүй. УБ.,2014
3. С.Энхжаргал. Монгол хэлцийн тайлбар толь. УБ.,2019
4. Д.Төмөрсүх, Н.Цэвэгсүрэн. Д.Чогсамба Өвөрмөц хэлцийн тайлбар. УБ.,2015
5. Монгол хэл судлалын түүх, Монгол хэлний үгийн сан, найруулга судлал 3-р боть. УБ.,2020
6. Монгол хэл судлалын түүх Монгол хэлний үг зүй, өгүүлбэр судлал 2-р боть. УБ.,2020
7. О.Шинэбаяр, Б.Золжаргал. Адилтгалын аргаар бүтсэн Монгол нэр томъёо. УБ.,2020
8. Ж.Бат-Ирээдүй Монгол хэлний хэвшмэл хэллэг дэх хэлц үгийн утга. УБ.,2007
9. Чой.Лувсанжав. Монгол хэлний өвөрмиц хэллэг. УБ.,2006
10. Н.Баяртогтох. Оюун билгийн сан хөмрөг. УБ.,2017
11. Н.Нансалмаа. Үгийн сан судлал. УБ.,2015
12. М.Базаррагчаа, Ч.Зэгиймаа. Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь. УБ.,2014
13. Ш.Нарантуяа. Монгол хэлц үгийн тайлбар толь. УБ.,2017
14. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,2013
15. Н.Нансалмаа. Нийгэм хэл шинжлэл. УБ.,2019
16. Ч.Чимэгбаатар. Монгол хэлний яруу найруулга. УБ.,2012
17. Ж.Бат-Ирээдүй, Б.Номинзул. Монгол-Англи хэлц үг хэвшмэл хэллэгийн дүймэн. УБ.,2007
18. Г.Аким Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь. УБ.,2012
19. Ш.Сэрчмаа Ярианы хэлэнд түгээмэл хэрэглэгддэг Англи хэлний өвөрмөц хэлц. УБ.,2017

УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЗЭЛ СУРТЛЫН ӨНӨӨГИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

/МАН-ын 1992-2004 оны мөрийн хөтөлбөр/

А.Мөнхцэцэг*

ХУРААНГУЙ

Манай Үндсэн хуульд улс орон, ард түмний зорилго, хүсэл эрмэлзлийг “Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэж үзэж, эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”¹ гэж нэгтгэн томъёолсон байна. Үндсэн хуулийн энэ заалт, үзэл санаа нь манай улс төрийн үйл ажиллагааны стратегийн зорилго, бодлогын агуулгыг илэрхийлж байгаа юм. Гэхдээ намуудын улс төрийн үйл ажиллагааны зорилго нэг нэгдмэл байх нь түүндээ хүрэх арга зам, боломж нам тус бүрийн хувьд харилцан адилгүй, өвөрмөц онцлогтой байхыг үгүйсгэдэггүй. Үнэхээр ч намуудын улс төрийн баримт бичигт тусгагдсан үзэл санаа, тэдгээрийн үйл ажиллагааны шинж байдлаас үзэхэд улс төрийн нийтлэг зорилгодоо хүрэх арга зам, шийдэл нь нам бүрийн хувьд харилцан адилгүй болох нь тодорхой байна.

Түлхүүр үгс: *Улс төрийн нам, улс төрийн намын тухай хууль, үзэл суртал, мөрийн хөтөлбөр*

Үндсэн хэсэг

Монголын улс төрийн намуудын нэг хэсэг нь нийтлэг зорилгоо хэрэгжүүлэхдээ бүх бодлогынхоо төвд хүнийг тавьж, хүний эрх, эрх чөлөө, хувийн овсгоо самбаа, санаачилга идэвхийг хөхүүлэн дэмжиж, нийгэмд хөрөнгөлөг чинээлэг давхарга, жижиг өмчтөнүүдийг олноор төрүүлэх замаар хувийн өмч, хувийн хэвшлийг Монгол орны эдийн засагт зонхилох чиглэлтэй болгохыг зорьж байхад нөгөө хэсэг нь нийгмийн амьдралын бүх талыг ардчилах, нийгэм, хүмүүсийн эрх, эрх чөлөө, эв нэгдэл, шударга ёсыг амьдралын бодит хэм хэмжээ болгон төлөвшүүлэх, эх болсон байгаль дэлхийгээ хамгаалах асуудлыг төрийн бодлогын төвд тавьж, хүмүүсийг

* ДХИС, ЭЗНУС-ийн багш, цагдаагийн дэслэгч

¹ Монгол Улсын Үндсэн хууль.УБ., 1992. 3 дахь тал



THE CULTURAL WAY

экологийн цэвэр сайхан орчинд амьдарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг баталгаажуулахыг сонирхож байдаг. Гэтэл гурав дахь хэсэг нь улс орныхоо үндэсний онцлог, аж төрөх арга ухаан, нүүдлийн иргэншлийн өвөрмөц үнэт зүйлсийг орчин үеийн хүн төрөлхтний соёл иргэншлийн ололттой хослуулан сэргээж, улс орныхоо тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлийг онцлон үзэж байна. Ингэж нийтлэг зорилгодоо хүрэх арга зам нь нам тус бүрийн хувьд харилцан адилгүй байна.

² Үүнд:

1. Улс төрийн намууд нийгэмд бодитой илэрч байгаа харилцан адилгүй олон янзын эрх ашиг, сонирхлын өвөрмөц тусгал болж байна;
2. Нам бүхэн амьдралын алив асуудлыг үнэлэн цэгнэх онол баримтлал, чиг бодлогын өөрийн гэсэн онцлогтой, улс төрийн үзэл бодлын үнэ цэнтэй зүйлст тулгуурлаж байна;
3. Нийгмийн оюун санааны амьдралын олон ургалч шинж байдал, түүний зохистой тэнцвэрийг хангагч гол хүчин зүйл мөнхийн хувьд намууд нь нийгмийн хөгжлийн бодит явцаар дэвшигдсэн аливаа асуудлыг шийдвэрлэхдээ өөрийн гэсэн өвөрмөц байр суурь, үзэл бодлын үүднээс хандаж байдагтай холбоотой юм.

Ардчилсан төрийн тогтолцоонд нам нь бусдаас ялгарах өөрийн гэсэн үзэл сурталтай байдаг. Энэ нь намын үйл ажиллагааны зорилгын үнэт зүйлсийн гол тулгуур, үндэс нь болдог. 2004 оны сонгуульд МАН ялалт байгуулж, УИХ-д 70 суудлыг авчээ. 1996 онд Монголын Ардчилсан Холбоо, ардчилсан намуудын эвсэл тус улсын эдийн засаг ба улс төрд шинэчлэлт, өөрчлөлтийг гүйцэтгэх шинэ хөтөлбөр боловсруулж оролцсоны дүнд сонгуульд онцгой ялалт байгуулсан. Энэ санал хураалтаар Улсын Их Хурлын 76 суудлын 50-ийг нь Ардчилсан Холбоо эвсэл, 25 суудлыг МАН авсан байна. 2000 оны сонгуулиар МАН 72, бусад нам эвсэл (АН, МАШСН, МИЗН) 4 суудал авсан юм. Мөн 1992-1996 оны мөрийн хөтөлбөрийн гол агуулга нь “Эх орон, ард түмний төлөө” гэсэн зорилго дэвшүүлсэн. Энэ үед МАН нь төв ёсны үзэл суртлыг чиг баримжаа болгож байсан.³

Арга билгийн хувьд, Эзэн хичээвэл заяа хичээнэ. Харин эрмэлзлэлийн хувьд, Бүтээлч хөдөлмөр, ардчилал, шударга ёс, сахилга зохион байгуулалттай байхыг тусгасан байв. Эдийн засгийн хувьд, Үйлдвэрлэлийн уналтыг зогсоох, санхүү мөнгөний зохицуулалт хийх бодлогыг чухалчилж байсан. Оюун санааны хувьд, Олон талт үйл явц буюу Боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, хэвлэл мэдээлэл, ёссуртахуун, шашны асуудлуудыг чухалчилж байсан.

Хүн амын нийгмийн баталгааны хувьд, Хөдөлмөр эрхлэлт, цалин орлого, хүн ам зүй, эрүүл мэнд, орон сууц, хүүхэд залуучууд, ахмад үе гэх мэт нийгмийн хүрээрүү чиглэсэн бодлогыг чухалчилж байв. Жишээ нь: Ядуу

² Болд-Эрдэнэ. Д “Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил”, УБ.,2008. т 18

³ “Мөрийн хөтөлбөр”, 1992-1996 он.



THE CULTURAL WAY

амьдралтай хүмүүс, өнчин тахир дутуу иргэдийн нийгмийн баталгааг хангахад түлхүү чиглэсэн байна.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр нийгэм нь байгалиа түшиж хөгжих үзэл санааг төрийн бодлогын үндэс болгоход анхаарлаа хандуулсан байна.

Улс төрийн бүрэн эрхт байдал, төрийн тогтолцооны хувьд, ардчилсан төрт ёс, төрийн гадаад бодлогыг нэн тэргүүнд тавьж байв. Энэ үед хийгдсэн улс төрийн шийдвэрүүдээс авч үзэхэд:

Энэ парламентын үед зах зээлийн эдийн засгийн харилцааны тулгуур хуулиудыг баталсан. Тухайлбал, Улсын төсвийн тухайг НББ, Татварын багц хууль, Онцгой албан татвар, Гадаад хөрөнгө оруулалтын тухай хуулиудыг дурьдах нь зүйтэй юм. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хийх өмч хувьчлал дуусч, үнэт цаасны хоёр дах зах зээлийг нээсэн нь шинэ нийгмийн эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэхэд чухал алхам болсон юм.

Мөн 1996-2000 оны мөрийн хөтөлбөрийн гол агуулга нь: Эрх орон ард түмний төлөө буюу ард түмэнтэйгээ хамт байна гэсэн утга бүхий зорилго дэвшүүлсэн.⁴ Энэ үед социалист үзэл суртлыг чиг баримжаа болгож байв. Хүн-хөдөлмөр-хөгжил гэсэн эрмэлзлэлтэй байв. Хүний төлөө төрийн бодлогын хувьд: XXI зууны мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухаан-технологи-хөгжлийн хурдасгуур, Соёл урлагийг ивээн хөгжүүлэх, Мэдээллийг хүн амд шуурхай хүргэх, Эрүүл мэнд нийгмийн баялаг, Биеийн тамир, спорт-эрүүл байхын үндэс, Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх, Ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах, Ахмадаа онцгойлон халамжлах, Эмэгтэйчүүдийн аж байдал, хүүхдийн хөгжилд бодитой туслах, Залуучуудаа тал бүрээр дэмжих, Хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж тодорхой алхам хийх, Орон сууцыг хөнгөлөлттэй нөхцлөөр эзэмшидэд нь хувьчлах, гэр хороололд үйлчилгээг хүргэхэд чиглэсэн байна.

Эдийн засгийн тогтвортой өсөлт- ард түмний сайн сайхан амьдралын баталгааны хувьд, Хот хөдөөг эрчим хүчээр хангах, Зам харилцааг дэлхийн сүлжээтэй холбох, Хөнгөн үйлдвэрүүдийг тогтвортой хөгжүүлэх, Мал аж ахуйг анхаарлын төвд байлгах, Газар тариалангийн уналтыг зогсоох, Нутаг дэвсгэрээр бүсчлэн хөгжүүлэх, Аялал жуулчлалыг бие даасан салбар болгон хөгжүүлэх, Өмч хувьчлалын өгөөжийг дээшлүүлэх, Хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх, Татварын тогтолцоог төгөлдөржүүлэх, Засгийн Газрын хөгжлийн банк байгуулах, Инфляцийн түвшинг тууштай бууруулах, Байгаль орчноо хамгаалахад чиглэсэн байна.

Эрх зүйт төрийн бэхжилт-иргэдийн амгалан аж төрөх баталгааны хувьд, Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, Удирдлагын цомхон, чадварлаг алба бий болгох, Орон нутгийн удирдлагыг бэхжүүлэх, Хуулийг дээдэлж, шударга ёсны төлөө тууштай тэмцэх, Иргэдийн, амгалан аюулгүй аж төрөх баталгаа хангахын төлөө байна. Цаашлаад Батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн байна.

⁴ “Мөрийн хөтөлбөр”, 1996-2000 он.



THE CULTURAL WAY

Нээлтэй гадаад бодлогын хувьд, Улс орнуудтай харилцаагаа өргөтгөн хөгжүүлэх, Олон улсын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллахад чиглэсэн байна.

2000 оны мөрийн хөтөлбөрийн агуулга: Төрөө хямралаас гаргая, түмнээ ядуурлаас аваръя зорилго дэвшүүлсэн байна.

Нийгмийн бодлого –хүний хөгжил, амьдралын баталгааны хувьд, Хүн амын боловсролын хэрэгцээг жигд хангах орчин бүрдүүлж бүх нийтээр бүрэн дунд боловсрол эзэмших, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, орчин үеийн мэдлэг олгох системийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн үйлчилгээ урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэж, хүн амыг эрүүлжүүлэх замаар хүн амын өсөлтийн урамшуулах, дундаж наслалтыг уртасгах зорилтыг хэрэгжүүлнэ. Монгол Улсын үндэсний соёл урлагийг хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг жам, дорнын соёлын өвөрмөц өнгө аястай уядуулан, эрчимтэй хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадамжийг дээшлүүлэн хөгжлийн харьцангуй шинэ давуу тал олж авах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судлаачдын бүтээлийн үнэлэмжийг өсгөх зорилтыг хэрэгжүүлнэ. Нийгмийн баялаг, орлогын хуваарилалтыг оновчтой болгож ард иргэдийн амьжиргааны түвшний уналтыг зогсоож, нийгмийн доторх орлогын ялгааг багасгаж туйлын ядуурлыг арилгах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Эдийн засгийн хувьд, Үндэсний үйлдвэрлэл тогтвортой өсөлтийг хангах бодлогыг чухалчилсан байна. Тухайлбал, Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, экспортыг бүх талаар дэмжих бодлого явуулна. Аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэлийн нэг болгон хөгжүүлнэ. Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн хөшүүрэг, механизмыг боловсруулж хэрэгжүүлнэ. Бүс нутаг, хөдөөгийн бодлого-бүс нутаг жигд хөгжил: Бүсүүдэд дэд бүтэц бүрэлдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөхөд чиглэсэн байна.

Байгаль орчны хувьд, Унаган байгаль ухаалаг ашиглалт: Байгалийн баялгийг түүний даац чадавхад нь нийцүүлэн зохистой ашиглах, нөхөн сэргээн замаар экологийн баримжаатай эдийн засгийн хөгжлийн хангах, орон нутгийнхаа байгалийн баялгийг ашиглах, байгаль орчныг ард иргэд өөрсдөө хамгаалах механизмыг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталсан байна.

Батлан хамгаалах гадаад бодлогын хувьд, Монгол улсын батлан хамгаалах тогтолцоо, цэргийн шинэчлэлийн бодлогыг “Төрийн цэргийн бодлогын үндэс”-ийн дагуу тууштай хэрэгжүүлж энэ салбарт сүүлийн жилүүдэд гаргасан гажуудал, бэрхшээлийг арилгах арга хэмжээ авах, Зэвсэгт хүчин, тагнуул, цагдаа, хууль хяналтын байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын дагуу улс төр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогодоо тусган хэрэгжүүлэх, Монголын улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлийг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалд



THE CULTURAL WAY

тохируулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн олон тулгуурт нээлттэй бие даасан санаачилгатай гадаад бодлого явуулна гэсэн бодлого баримталсан байна.

Засаглалын хямралыг арилгах дэг журмыг бэхжүүлэх бодлогын хувьд, Шударга ёсыг хэвшүүлэх сайн засаглалыг бүрдүүлэхийг зорино. Төрийн албаны хариуцлагын тогтолцоог сайжруулан, нэр хүндийг өргөж чадавхжуулна. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлнэ. Авлига гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэхэд чиглэсэн бодлого баримталсан байна.

Мөн 2004 оны мөрийн хөтөлбөрийн агуулга:⁵ Таны төлөө тантай хамт буюу ард түмэнтэйгээ хамт байна гэсэн уриан дор бичигдсэн.

Нийгмийн бодлогын хувьд, Ажлын байр нийгмийн баталгаа гэж үзэж, Боловсролын чанарыг дээшлүүлэх стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй, бодит чадвартай, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд чиглэсэн хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ. Иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурласан, өвчнөөс урьдчилан сэргийлэх, чиглэлийг эрхэм болгосон эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэн хөгжүүлнэ. Цаашлаад Ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлнэ. Нийгмийн эмзэг хэсэгт зориулан төрөөс олгож байгаа хөрөнгийн үр шимийг дээшлүүлэх, орлого зарчмыг тууштай хэрэгжүүлнэ. багатай өрхийн амьжиргааг дэмжиж, хөгжүүлэх, Соёл урлагийн салбарыг бие даасан салбар болгон хөгжүүлнэ. Шинжлэх ухаан, технологийн салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байсан.

Эдийн засгийн хувьд, Эрчимтэй хөгжил итгэлтэй ирээдүй уриа дэвшүүлсэн байна. Эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэн өндөр өсөлтийг хангаж ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг 7-оос доошгүй хувьд хүргэнэ. Эдийн засгийн гол салбаруудын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Төсөв, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ. Татварын иж бүрэн шинэчлэл хийж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, шинээр ажлын байр бий болгохыг татварын бодлогоор дэмжихэд чиглэсэн бодлого баримталж байв.

Дэд бүтэц, хөдөөгийн бодлого-бүсчлэлийн бодлого- хөдөөгийн хөгжлийн хувьд, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг гүнзгүүлж бүс нутгуудын эдийн засгийг өсөлтийг түргэсгэж, хот, хөдөөгийн хүн амын, нийгэм, соёлын харилцан уялдаасан цогцолбор хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлнэ. Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ. Мэдээлэл холбооны суурь сүлжээний багтаамж ашиглалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлж, өрсөлдөөн бий болгоно. Үнэ, тарифыг хямдруулах арга хэмжээ авч үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ. Бүс нутаг дэд бүтцийг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байв.

Байгаль орчны бодлого-байгаль орчин, тогтвортой хөгжлийн үүднээс аваад үзэхэд, Байгаль орчны бодлого, арга хэмжээг бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдуулж улс орны төрийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлнэ.

⁵ “Мөрийн хөтөлбөр”, 2004 он.



THE CULTURAL WAY

Төрийн байгуулалтын бодлого-сайн засаглал- шударга нийгмийн үүднээс аваад үзэхэд, Хүний хөгжлийн төлөө ардчилсан, сайн засаглалыг төлөвшүүлнэ. Төрийн байгуулалтын тогтолцоо боловсронгуй болгож үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ. ийгмийн дэг журам, сахилга, хариуцлагыг дээшлүүлж, шүүх эрх мэдэл, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрс сайжруулна

Батлан хамгаалах гадаад бодлого- идэвхтэй харилцаа- итгэлтэй түншлэлийн үүднээс аваад үзэхэд , Батлан хамгаалах тогтолцоог аюулгүй байдал шинэ орчин нөхцөл, улс орны бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжүүлж, зэвсэгт хүчнийг цомхон чадварлаг мэргэжлийн чиг баримжаатай болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Монгол улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгална. Үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн Монгол Улсын аюулгүй байдал тогтвортой хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэхэд чиглэсэн олон талт нээлтэй биеэ даасан гадаад бодлого явуулахад чиглэсэн бодлого баримталж байв.

Мөн 2004 онд 36 суудалтай МАН, 34 суудалтай “Эх орон- Ардчилал”эвслүүд хавсран засгийн газар байгуулж ажилласан ч, Эх орон- Ардчилал эвслийг бүрдүүлж байсан. АН, Эх орон МАШСН, ИЗ-БНН намууд задарсан. Харин гурван нам /МАН,АН, ИЗ-БНН/- ын засгийн газар ажиллаж, хүчтэй сөрөг хүчингүй нам парламент болсон. Хэдий парламентад хоёр нам /Эх орон нам, БНН/-ууд болон бие даан нэр дэвшигчид буй ч бодлогын түвшинд үйл ажиллагаа хянах, нөлөөлөх боломж байхгүй байна. МАН ноёрхогч нам болох нь ардчилсан бус коммунист тогтолцооны үед дангаар засаглаж байсан МАН, өнөөгийн олон намтай, чөлөөт сонгуультай, ардчилсан нийгэмд ч бас ноёрхож байна.

Улс төрийн сонгодог үзэл суртлууд нь өөр хоорондоо өвөрмөц ялгаатай боловч нийтлэг олон шинжүүдээрээ бие биетэйгээ харилцан нөхцөлдөхийн зэрэгцээ, харилцан бие биенээ нөхөн сэлбэж баяжуулж байдаг. Тиймээс ч үзэл суртлын янз бүрийн чиглэл бүхий намууд ардчилсан нийгэмд зэрэгцэн оршиж, хамтран ажиллаж гол асуудлаар нэгдмэл шийдэл, зөвшил, тохиролцоонд хүрэх бүрэн бололцоотой юм. Улс төрийн либерал, социал-демократ буюу ардчилсан социалист консерватив улс төрийн үзэл номлолууд нь эцсийн дүндээ тогтвортой хөгжлийн талаарх үзлийн өвөрмөц хувилбарууд болж байдаг. Харин тогтвортой хөгжлийн талаарх олон хувилбарт ппюраль үзэл хандлагын хүрээн дэх бие даасан тэрхүү өвөрмөц улс төрийн үзлийн чиглэмжүүд нь хөгжлийн нэг нэгдмэл бүхэл бүтэн цэгцтэй үзэл суртлыг боловсруулан томъёолж, хэрэгжүүлэх чөлөөт сонголтын өргөн боломжоор хангаж байгаа юм.

ДҮГНЭЛТ

Үүнээс үзэхэд Судлаачид Улс төрийн намыг тодорхойлохдоо үзэл санаа нэгтнүүд чөлөөтэй эвлэлдэн нэгдсэн нийгмийн холбоо юм гэж үзсэн байдаг. Энэ нь намууд гол төлөв мөрийн хөтөлбөртөө тодорхойлсон бодлогоо амьдралд хэрэгжүүлэх эрмэлзлэлтэй, иргэдийн холбоо учир намуудын зохион



THE CULTURAL WAY

байгуулалтын хэлбэр тодорхой хэмжээгээр үзэл суртлаар тодорхойлогддог билээ.

Намууд төрийн бодлого боловсруулж тодорхойлох гол институт болохынхоо хувьд үзэл сурталтай байдаг. Үзэл суртал нь намыг дэмжсэн бүлгүүдийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалдаг үнэт зүйлсийн систем юм.

Үзэл суртал улс төрд чухал үүрэгтэйгээс гадна хүмүүсийн учир шалтгааныг тодорхойлох шинжтэй байдаг. Иймд намуудын үзэл баримтлалаар дамжуулж олон нийтийг нэгтгэх, нягтруулах, дайчлах хэрэгцээ их өсч байна. Нам үзэл суртлаа сайн боловсруулна гэдэг бол онолын, оюуны өндөр мэдлэг, соёл, туршлага шаарддаг нарийн чимхлүүр ажил байдаг.

Сүүлийн үед үзэл суртлууд интеграчилагдаж байгаатай холбоотойгоор намууд ижилсэх, ойртох хандлагатай болж, бас үзэл суртлууд бие биесээ нөхөн сэлбэж, зэрэгцэн оршиж, үнэт зүйлсээрээ баяжиж байна.

Санал:

- Монголын намуудын үзэл суртал өвөрмөц ялгаатай байна гэдэг нь тэдний хувьд улс орноо хөгжүүлэх нийтлэг чиглэмжийн суурьүндэс байхгүй болно гэсэн үг хараахан биш юм. Харин ч улс төрийн олон ургалч үзэл хандлагын өвөрмөц хувилбарууд нь улс орны ирээдүйн төлөв байдлын төвөгтэй олон асуудлыг янз бүрийн бодитой шийдвэрлэх найдвартай үндэс, хөгжлийн талаарх нэгдмэл бүхэл бүтэн үзэл суртлын олон тулгуур болох юм.
- Улс төрийн намууд үзэл суртлынхаа хувьд баруун, зүүн, төвийнх гэж нэрлэдэг ч бодлогын концепциос эхлээд улс төрчид нь хэрэгжүүлэх хэрэгтэй байна;

ABSTRACT

Comparative study by analyzing the ideology of Mongolian political parties and the contents of some platforms;

Keywords: *Political party, Political party law, ideology, platform;*



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

Хууль дүрэм, албан бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын намын тухай хууль 2005 он
3. МАН-ын үндсэн дүрэм
4. МАН-ын мөрийн хөтөлбөр 1992он
5. МАН-ын мөрийн хөтөлбөр 1996 он
6. МАН-ын мөрийн хөтөлбөр 2000 он
7. МАН-ын мөрийн хөтөлбөр 2004 он

Ном бүтээл

1. Д.Болд-Эрдэнэ. “Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил, УБ.,2008.
2. Э.Гэрэлт-Од. Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн шинжлэх ухааны докторын диссертаци. УБ., 2009
3. М.Энхсайхан. “Орчин үеийн улс төрийн намууд”, УБ., 1996.
4. G.Sartori. Parties and Party systems.London, 1976.
5. Duverger M. Political Parties. London., 1970.
6. МУИС “Улс төрийн шинжлэх ухаан”,УБ.,2010.
7. Улс төрийн боловсролын академи “Улс төр судлал”УБ.,1996
8. Сонгуулийн Ерөнхий Хороо <http://www.gec.gov.mn/>

**ХӨЛИНГӨР ТУЧӨНЗЫ 1-Р БУЛШНЫ ХАНАН ДАХЬ ЗУРГИЙН ШИНЖ
ЧАНАР**

Гао Шя*

ХУРААНГУЙ

Хөлингөр Тучөнзы 1-р булш нь булшны эзний хувийн амьдрал, оршин суугаа газрынхаа дагуу уран сайхны амт, оюун санааны эрэл хайгуулаар дүүрэн газар доорх ордон бүтээжээ. Булшны эзэн сургуулийн дэслэгч шёгуны булшны бүтэцтэй чадварлаг хослуулж, ханын зураг хэлбэрээр өөрийн намтрыг бичсэн байхаас гадна: Хувийн сургуульд уншсан – Жү - Ланг - Шихө Чанши - Шиншан хошууны ахмад - одон. Фаньян—Ухуаны алдар суут амьдралыг хамгаалах элч Чижи. Ханын зургууд нь морь, морьтой аялах, хот суурин газар, хүндэтгэл үзүүлэх, Байши, Янжү, мэргэд, хүүгийн сүсэг бишрэл, өргөө зэрэг баялаг сэдвийг сонгосон бөгөөд эдгээр нь цөм чимэглэл, дүрслэл болох юм. Булшны ханын зургийн агуулгыг задлан шинжилснээр уг нийтлэлд нэр, овог, амьдралын түүх, шүлгийн магтаал гэсэн дөрвөн чиглэлээр жишиг чулуун бичээстэй харьцуулсан судалгаа хийсэн болно. Ханын зургийн зохион байгуулалтын дагуу дүрслэл нь булшны эзний амьдралын оргил үеэс эхэлж, Зүүн Хань гүрний сүүл үеийн элч Ухуан Сяовэйгийн амьдралыг гэрэл гэгээтэй байдлаар дүрсэлжээ. Эндээс үзэхэд булшны ханын зураг нь булшны эзний гараар дүрслэгдсэн хөшөө мөн гэж дүгнэж болно.

Түлхүүр үгс: *Хөлингөр Тучөнзы 1-р булш, ханын зураг, булшны бичээс*

试论和林格尔土城子1号墓壁画墓志铭属性

张家口市文物考古研究所 馆员高霞

内容摘要：和林格尔土城子1号墓按照个人生平和生前府邸为墓主人打造了一个满载艺术气息和精神追求的地下殿堂。墓主人将生前的校尉幕府与墓室结构进行了巧妙结合，以壁画的形式为己作传，描述了：私塾读书——举——郎——西河长史——行上郡属国都尉——繁阳令——使持节护乌桓校尉的荣耀一生。壁画选取了车马出行、城池、拜谒、百戏、燕居、圣贤孝勇、庄园等丰富题材，即是装饰，又为记述。文章通过对该墓葬壁画内容的分析，与标准墓志铭在姓名、家世、生平事迹和韵语颂辞四方面作了对比研究。

* Жанжякөү хотын Соёлын дурсгал, археологийн хүрээлэнгийн номын санч
Судлагааны чиглэл: Булшны ханын зураг, 15031348604, 15031348604@163.com



按照壁画的设计安排从墓主人人生巅峰开始描述，以倒叙方式描述了东汉后期一位使持节护乌桓校尉的生平。以此得出结论，该墓壁画是墓主人的手绘墓志铭。

关键词：和林格尔土城子 1 号墓 壁画 墓志铭

和林格尔土城子 1 号墓（以下简称 M1）是“目前已发现壁画分布面积最大、榜题数量最多、构图形式最为复杂的汉代墓室壁画。”^[1]这座东汉壁画墓是继马王堆汉墓、满城汉墓之后又一重大发现。最引人瞩目的就是墓室内满布的壁画，画面艳丽，内容色彩丰富写实，成为研究汉代社会不可多得的图像资料。M1 的墓主人的姓名无从考证^[2]，其生活年代为东汉后期永和五年到二世纪六十到七十年代^[3]，官至使持节护乌桓校尉。笔者通过对墓室写实壁画的研究发现，壁画是对墓主人一生的回顾和自评，是其个人画传，是墓主人的手绘墓志铭。

一、墓志铭的源流

墓志铭的起源在学界一直说法众多^[4]，原因在于各家对墓志铭的认定和形制有着不同的理解。如果说只有墓室之中有墓志完整的石刻碑才能称为墓志铭，本文比较认同东汉起源说。M1 以壁画形式展示出了墓主人波澜壮阔的一生，凸显了其墓志铭的属性，并成为东汉末叶的百科全书。它是石刻铭文墓志铭的前期和过渡形态，也是墓志铭东汉起源说的一个有力证据。

二、与标准墓志铭的对比研究

标准化的墓志铭主要由姓名、家世、生平事迹和韵语颂辞四部分组成，其中生平为核心内容。M1 墓主人生平写实彩绘壁画手绘墓志铭从构成来讲，其核心部分完备：

标准墓志铭与 M1 壁画的属性对比表

项目	标准墓志铭	M1	M1 表达方式
姓名	√	√	墓碑+墓主人像榜题
家世	√	√	从举孝廉推断为贵族
生平事迹（核心）	√	√	连贯叙事壁画叙述官场生涯
韵语颂辞	√	○	精取的象征属性图像元素抒发个人情感

（一）姓名

按照东汉墓葬的基本模式，墓葬由地上的墓碑、祠堂、墓阙、封土和地下的墓室构成。姓名一般被镌刻在墓碑之上，墓碑“上刻碑文，记载死者的姓名、年龄、生平事迹等……东汉立碑风盛行，有多种文体，有铭，亦有序。”^[5]“自后汉以来，门生故吏更多相与立碑颂德矣。”^[6]可见东汉墓碑是墓葬的标配。



由于墓碑遗失、男主人壁画榜题字迹脱落，墓主人的姓名成了迷一样的存在。黄盛璋^[7]、安其乐^[8]等人都在论文中做过考证，未能得出具体结论。笔者以“孝廉”为关键词对电子版二十四史做了一个检索，也没有找到与墓主人经历相同的孝廉。但肯定的是 M1 墓主人的姓名由墓碑和榜题体现。

(二) 家世

墓主人家族世系没有在壁画中得以表现，但可推断出他出身贵族，家世显赫。

1、M1 墓葬的豪华非贵族无法负担。按照常理贫苦出身的孝廉仅凭几年间比二千石的高俸禄，没有殷实家底的支撑恐难以完成。

2、孝廉身份。孝廉多为显贵名门之后。举孝廉是秦汉仕进制度的重要环节，在人数上有着严格的规定。按照“永元新规”：“其令缘边郡口十万以上，岁举孝廉一人；不满十万，二岁举一人；五万以下，三岁举一人。”^[9]墓主人祖籍在定襄郡，人口为 13571^[10]，故该地举孝廉比例为 1/13571，且三年一次。汉代以孝治天下，孝廉是入仕的重要途径，受世家大族重视。世家比平民更容易受到作为举主的州郡长官垂青。且东汉时，常有贿选发生，故有“察孝廉，父别居”^[11]一说。从世家重视孝廉，较之平民被推举的几率大，有力贿选举主的三点原因出发，可知东汉后期的孝廉，家世非富即贵。

(三) 生平事迹 (核心)

根据 M1 榜题和壁画的排列顺序可以归纳出墓主人“举孝廉——郎——西河长史——行上郡属国都尉——繁阳令——使持节护乌桓校尉”的升迁过程。

汉画有连续叙事的传统^[12]。M1 壁画是汉画极具写实意味的典型例证。M1 将建筑与壁画相结合模拟了生前的校尉幕府，墓室既是幕府的缩影。壁画从墓主人引以为傲的校尉官邸和代天子受贡绘起，将其他重要官职以时间顺序进行插叙处理：

1、使持节护乌桓校尉要事：

护乌桓校尉是汉魏晋王朝统辖北部境内游牧民族乌桓、鲜卑诸部事务的官属机构：“……使匈奴中郎将一人，比二千石。……置从事二人，有事随事增之，掾随事为员。护羌、乌桓校尉所置亦然。护乌桓校尉一人，比二千石。本注曰：主乌桓胡”^[13]“《续志注》引应劭《汉官》曰：‘并领鲜卑’。”^[14]这是墓主人的最后一任官职，也是等级最高的一任官职，而且是“长期持节官”^[15]，代表国家在边陲行使权力，是皇帝意识的执行者，是有生杀予夺的封疆大吏，是其仕途的巅峰时刻。与 M1 其他壁画相比，关于乌桓校尉的画面都是大幅的、气势磅礴的画面，包括整个墓室的设置都是与乌桓校尉的幕府形制统一。^[16]

M1 使持节护乌桓校尉及校尉幕府相关壁画情况一览表^[17]

发掘报告示意图编号	《和林格尔汉墓壁画孝子传图摹写图辑录整理》页码	画面名称	位置	画面主要元素



37	116-117	宁城前卫	中室东壁	建筑、建鼓、蓝袴、矛、戈、人物 (戴盔着甲执矛列队士兵、鼓吏、 献降乌桓人)
36	118-119	宁城图	前室至中室甬道北壁	大型城池、建筑、墙体、人物(墓 主人、属官、武士、献降乌桓人)、
6	42	门卫	墓门甬道北壁	建筑、献降乌桓人、
47	43-44	幕府大廊	前室东壁甬道门北侧至 北壁甬道门东侧	建筑、人物(曹官、乌桓人)
5	41	门卫	墓门甬道南壁	蓝袴、建鼓、人物(甲士、持剑武 官、)
7	56-60	幕府东门	前室东壁甬道门南侧至 南壁甬道门东侧	东门建筑、人物(曹官)
8	57	兵弩库	前室东壁甬道门南侧	建筑、人物(曹官)
7	56	诸曹	前室南壁甬道门东侧	建筑、人物(曹官)
40	50-52	护乌桓校尉 幕府谷仓	前室西壁甬道门西侧	谷仓
4	78-80	使持节乌桓 校尉出行	前室北壁甬道门上方	大型仪仗车马人
38	110	使君从繁阳 迁渡关时	中室东壁甬道门上方	车、马、人
35之上	120	迎迓	中室北壁	人物、赤节

(1) 代天子接受乌桓人及渠帅献降献贡

在东汉末叶的某一天，内附的乌桓人在其首领大人、渠帅的带领下沿着宁城前卫(图4)——宁城南门——幕府南门——幕府内府广场的顺序进入宁城的校尉幕府中。来人众多，他们皆髡首颌首塌腰鍪衣，鱼贯而入。作为刚刚臣服于汉的内附少数民族，他们对汉更多的是惧怕，姿态很低，与周围笔直站立的武官和甲士形成了鲜明的对比。络绎不绝前来献贡的乌桓人，一直持续到幕府的内府广场中。作为护乌桓校尉的墓主人端坐于幕府大堂(见图2、图3)，身边陪坐着他下属的高级官员，皆着红衣，其身后为执勤武官着黄绿色裤褶。门前站立着侍卫，正堂阶下跪着的有可能是乌桓、鲜卑大人、渠帅。此时正堂外广场中央正有百戏表演。倒立、跳舞、弄丸、击鼓等十四人展示了他们娴熟的技巧，立于中央的建鼓既是作为发号施令的工具和迎接宾客^[18]的礼节，仪式隆重。同时，也反映了墓主人对升仙之路的向往。^[19]此百戏建鼓一方面是娱乐之意，更重要的一方面是仪式。在演员的周围站立着身着红衣的武官，和顶盔带甲，手执红缨矛的武士。整个画面在活泼而严肃，紧张和轻松中记录了墓主人最巅峰的一天。



THE CULTURAL WAY



图 1 宁城前卫 (临墓) [20] (第 173 页)



图 2 宁城图 (临墓) (第 173 页)



图3 宁城图(局部)(临摹)

连续几幅画面的叙述一直从墓门开始，经前室延续到中室。周边设置的是其他题材画面。这种布局与墓内祭祀有关。“约在西汉后期开始，汉代人还流行墓内设奠祭祀，比较注重墓内的祭祀空间。”^[21]墓室在修好后，或启用前的某个时刻，会向参加祭奠仪式的受众开放，展示墓室内部的陈设。

(2) 校尉行部

“按汉制各级官吏在所辖或所察地区巡行成为行部。”^[22]前室北壁中层上的画面就是墓主人巡行图。校尉大人坐在赤节飘动的三马主车上，逆风出行，前方的目的地是乌桓或鲜卑的部落，浩浩荡荡的队伍从崇山密林中穿过，远方是众多矮小的树木。所到之处，都被校尉的车马的仪仗，剑、戟和风侯所震撼，威慑边防。

总观巡行队伍，由墓主人的1乘三马主车、副将的2乘两马从事车、随从的10乘辎车、1乘三马战车和“129乘从骑”^[23]组成。这与“二千石以上至万石丞相、王公贵族，可用二至四马。”^[24]的规制相吻合。汉代对天子、后妃、官员、百姓的车马服饰有着极为严格的要求：“自天子而至诸王，下及百官，各有等差，不得僭越。”^[25]文献和画面的一致体现了汉画语图关系互补^[26]的现象，也是本文论证观点的基础依据。汉画是汉代文献、实际生活的真实体现，汉代壁画墓是珍贵的历史资料，汉代文献是汉代知识分子对汉代社会的直接写照。汉画和汉代文献存在描写场面和描写状态的互补关系。根据王国维的“二重证据法”可以根据汉画等考古成果观察和研究汉代社会的社会状态和社会风骨。

(3) 就职

壁画中用了《过居庸关》和《迎迓图》两幅图来表现墓主人从繁阳令到护乌桓校尉的到任情况。居庸关“始设关城应源于东汉”^[27]是从繁阳到护乌桓校尉的治所宁城的必经之地。上任途中仪仗队经过居庸关大桥，桥上身着红衣的墓主人正行至桥中央，四周是随行的辎车和从骑。这些着黑衣的下属官员没有携带任何兵器，表明此时墓主人使用的依然是繁阳令的仪仗。



THE CULTURAL WAY

迎迓图被安排在百戏图之上，横舍之下。主题要素是赤节、使持节护乌桓校尉和众仗剑列队前行武官组成的迎接仪仗。此时赤节在墓主人左手边红衣官员之后的位置，据此判断另一红衣官员是上一任的乌桓校尉，二人在进行交接，整个方阵排列有序，仪式感很强，行进的方向直指中室东壁的宁城图。

2、繁阳令

(郡国)“属官，每县、邑、道，大者置令一人，千石”^[28]，繁阳令是已经跻身到俸禄千石的高级官员，东汉孝廉中有一位陈球与墓主人一样做过“(稍迁)繁阳令”^[29]。

M1 壁画繁阳令相关壁画情况一览表

发掘报告示意图编号	《和林格尔汉墓壁画孝子传图摹写图辑录整理》页码	画面名称	位置	画面主要元素
14	53	繁阳县仓	前室西壁甬道门南侧	县仓建筑、官吏、独轮车、屋脊对称位置黑色鸟雀(孝乌乌鸦)
3	74、85	繁阳令出行	前室东壁甬道门上方	车、马、人
15	108-109	繁阳令被玺 □时	前室至中室甬道南壁	大量列队人物，建筑单体，
16	107	繁阳县城图	中室南壁	县城俯瞰图，有城，有郭，有着汉家衣服的人物，有二层或单层的独体建筑。县仓双层建筑可能被绘其中。

繁阳令是墓主人在任校尉之前的又一重要官职，正是因为繁阳令期间的功绩才让他跻身为封疆大吏。无从得知功绩因何而起，却在壁画中看到了，墓主人受封赏时的壮观景象：

(1) 繁阳令被玺书时

这一天繁阳县县寺紧张而喜庆，正堂的庑殿顶建筑被装饰了红色幔帐，建筑中依稀见得一位黑袍官吏和几位侍者。建筑外左右是两边空间很大的场院，院内站有超过半百的官员、随从人员，都是手中没有持剑，没有披甲戴盔的文官和文吏。院中偏右位置立有一座红色的建鼓，左下方站有一牵索人。针对繁阳令的“被玺书”仪式正在间鼓声中按步骤进行。按照玺书的严格的格式，墓主人得到的玺书应该这样开头“皇帝敬向繁阳令某”中间部分阐述其功绩诸如“兵马精强，仓库有蓄，民庶殷富，百姓蒙福”一类，在文末的固定格式：“今以……赐贵县，便宜辄言。”结束全文。具体的赏赐原因，在榜题中没有体现。



建鼓之右有一特写官吏,着黑衣白领、束带、白裤,手中持木制金吾^[30],手捧红黄相间团服饰类物品,略做弯腰状,并且细致描绘了其五官。由此推断该官吏为刚受玺书的墓主人。在其身边立有多位侍者。此形象是对“被玺书”时墓主人的一个特写。这就是由列队文官、单体单层庑殿顶建筑、建鼓构成的一丝不苟的“被玺书”时的大场面。

图 4 繁阳令被玺书时 (见第 108-109 页)

“被玺书”壁画中榜题有失,但根据史书同类事件记载可以判断“繁阳令被玺书时”(图 4)遗失的字是“书”。三国时魏的管宁曾“奉今年二月被州郡所下三年十二月辛酉诏书,重赐安车、衣服,别驾从事与郡功曹以礼发遣,又特被玺书,以臣为光禄勋,躬秉劳谦,引喻周、秦,损上益下。”^[31]玺书“为古代君王用空以封的告渝、答报或奖劳责让臣僚的下行公文文体。”^[32]管宁“被玺书”是因皇帝赐玺封官,这是在古代社会是至高无上的荣宠。

(2) 繁阳令出行

繁阳令出行的仪仗包括了“1 乘主车、10 乘辎车,10 余乘从骑”^[33]其中一车为导斧车,“县令以上,加导斧车。”^[34]导斧车是权利的象征,符合礼制。四川省博物馆收藏,1959 年四川彭县太平乡出土的一块汉代画像石上就刻有导斧车,结构清晰中立一斧,立两人。^[35]

M1 前室四个墙面的壁画皆分为三层,中间一层均为墓主人出行图,画面首尾相连,突出了视觉上的震撼之感,也开门见山地将历任官职依次展现。



3、举孝廉

墓主人在家族的支持下以举孝廉的方式入仕，担负起光耀门楣和增强家族势力的责任。“两汉之世，……共举孝廉约七万四千余人。……今可考见的两汉孝廉仅约三百余人，约占孝廉总数的二百四十分之一。”^[36]这些孝廉中高官后代高达 69.6%，富豪 6%，平民 15.7%，贫民只有 8.7%^[37]。



图 5 举孝廉、郎、西河长史出行（局部）（第 63—64 页）

“举孝廉”以车马出行为主题出现，以车马数量的配备和随行人员的多寡来体现墓主人当时的身份地位。身为孝廉的墓主人拥有 7 乘车马规模的仪仗，包括 1 乘主车、5 乘从骑、1 乘服车。主车以“二百石以下白布盖”^[38]装饰。

4、郎

“汉法，孝廉试经者拜为郎。”^[39]东汉郎官主要由孝廉拜授而来。正式官员大多会从郎官中选取。郎一般为文官^[40]。壁画中“郎”的车马配置是“1 乘主车，6 乘辎车，1 乘随骑”^[41]郎官已经是正式的官员，车马的档次也在升级，按照郎一般三百石的俸禄“三百石以上皂布盖”，^[42]与壁画中（图 5）黑色的顶盖是一致的。

5、西河长史

《后汉书·郡国志》载：“西河郡，武帝置。”^[43]东汉和帝永元二年（90 年），汉军大败北匈奴，为安置归降的北匈奴人，“已亥，复置西河、上郡属国都尉官”。西河郡主要处理的是少数民族问题。

“每郡置太守一人，二千石，丞一人。郡当边戍者，丞为长史。”^[44]西河长史是西河郡编制体系下的官员，武将，是郡国丞的角色，应在边郡故称为长史，以明身份。

壁画中（图 5）所示“西河长史”的车马配置：“1 乘主车，2 乘辎车，70 余乘从骑”^[45]按照史籍记载西河长史食千石，“其千石、六百石，朱左轹……千石以上皂缯覆盖”作为西河长史的墓主人的主车是黑色的车顶但是是“皂布”还是“皂缯”的确但从图上无从考证，但从外形上看的确更华丽了。



在中室南壁右下部有榜题为“西河长史所治离石城府舍”的离石城府舍图面积为 59cm*38cm^[46]。就壁画整体分析，此图与行上郡属国都尉时的土军城府舍图作用相同，与《宁城图》相比，为略写仅为展示墓主人的“势力范围”。

6、行上郡属国都尉

“每属国置都尉一人，比二千石，丞一人。……又置属国都尉，主蛮夷降者。”^[47]“郡尉，秦官，掌佐守典武职甲卒，秩比二千石。有丞，秩皆六百石。……属国都尉，皆武帝初置。”^[48]行上郡属国都尉表明其为代长官。行某官在汉代职官史上是常态，如王尊曾“守京辅都尉，行京兆尹事。”^[49]

在壁画中出行图车马的阵仗：1 乘主车、10 乘辎车、10 余乘从骑，与俸禄比二千石的属国都尉的一马拉车相匹配。朱锡禄先生认为，二千石以下的官吏，只能用一马拉车。^[50]

在中室南壁右下部有榜题为“行属国都尉时治土军城府舍”的土军城府舍图面积为 50cm*54cm^[51]。画面与西河长史相连。按照地理学家黄盛璋的判断墓主人由西河长史任上，在上郡属国都尉和军司马被杀情况下，临危受命接手上郡属国南匈奴之事，^[52]又有一个“行”字在其中是否可以判断，墓主人的行上郡属国都尉时有西河长史兼任，而不是连续任职。所以将两处画面相连，且离石城舍人物数量比高一级的土军城府舍人数要多，可能是墓主人常用的办公府衙依然在离石城。再者前室南壁甬道门西侧一副 128cm*67cm^[53]的榜题为“上郡属国都尉及西河长史厉兵马皆食太仓”的壁画，意思表达得比较明确。两种职责的官员所用的粮仓绘在一处，用清晰的三层画面表示粮仓的职能和墓主人主持工作时的状态，显示出对此阶段履历的重视，并可以推断出兼任的可能。汉代礼制完善，等级森严，代长官肯定会有很多约束。这种判断逻辑上行得通。

(四) 韵语颂辞

图像作为一种符号，与线性特点的语言符号^[54]不同，它的特点是“面性”，色块与线条将不同的信息同步放置于同一视框之中，更直接的将能指和所指体现出来。M1 壁画的图像符号利用自身特点向受众表达出墓主人的所指，也就是他信仰和追求的价值。

1、维护皇权和礼乐：

墓主人的身份是使持节护乌桓校尉，护乌桓校尉表明了墓主人的官职，使持节更重要的意义在于表明了他的地位和代表的权势，墓主人是效力边陲的“长期持节官”^[55]，代表国家在边疆地区行使权力，更是皇帝意识的执行者，是帝王的代言人，是有生杀予夺的封疆大吏，也是其仕途的巅峰时刻。在壁画中无论是出行的仪仗，宁城图献降的场面，还是建鼓的摆放和应用都显示着皇权的不容置疑和威严。由于篇幅所限仅列举几种典型礼仪：

(1) 出行礼仪

最凸显墓主人气势的出行图被集中安排在前室四壁的中层位置，按照墓主人当时的官职安排相应的仪仗，车马的数量、品类、从骑的人数、从骑士兵持械的种类和规模都体现了其对出行礼仪的重视。



(2) 饮食礼仪

庖厨图在壁画中多个位置都有体现，在显示墓主人财富地位的同时，也是对饮食礼仪的一种重视。

(3) 乐礼

在壁画中出现了 13 副建鼓图，这些建鼓在有音乐场景的宁城百戏图（图 6）、燕居图中出现，在没有音乐场景的校尉出行、幕府门、后室建鼓（图 7）等画面中出现，体现的除了建鼓本义上的作用外，更重的就是“礼用价值”^[56]。



图 6 百戏建鼓图（临摹） 图 7 后室建鼓图（临摹）

（第 117 页）

（第 114 页）

(4) 射礼

射礼是古代六艺之一，“六艺之中，礼乐为急，射即次之……”^[57]依据《仪礼》射礼分为大射礼和乡射礼，前者适用于诸侯王族，后者适用于卿大夫。M1 中后室北壁的《立官桂树》（图 8）中就有射礼的画面，两人仰面立于桂树之下，一人持弓，另一做持弓动作。这与初射仪中对“每两人一组即‘耦’，共‘三耦’……‘三耦’的射手依次弓射。”^[58]的描述是吻合的。



图 8 立官桂树 (临摹)



图 9 拥慧立门 (临摹) (第 154 页)

(第 10 页)

(5) 迎宾礼

拥慧立门“描述的就是一种汉代礼节，……是一种礼贤下士、敬重长者、传为头谈的古风”^[59]在《宁城前街图》中画面最左下位置和对称的左上位置的两名黑袍，红冠，束带的门吏，手中执的就是慧（扫帚）（图 9）。从壁画中可以看出拥慧立门，并非临门而立，而是在门外不远处，左右分立。

2、崇尚儒学

集中在中室的孝子传图、列女传图、列士图、孔子弟子图是对墓主人崇尚儒学的最有利的证明，而且该系列图成为研究汉代儒家文化不可多得资料，为此内蒙古自治区文物考古研究所、内蒙古博物院、日本幼学会共同编辑出版了《和林格尔汉墓壁画孝子传图摹写图辑录》将壁画图像重新进行摹写和归类，成为留给后世的文化财富。



图 10 三老、仁姑

(第 10 页)



本文从姓名、家世、生平、韵语颂辞四个方面对照标准的墓志铭对 M1 的壁画做了对应分析。这座用彩绘写实壁画装饰的墓葬，既是墓主人赶厚葬风潮的时髦，又是对己一生的回顾和自评，极高地体现着个人意志。整个墓室的画面是一个完整的体系。整部壁画连接起来是用不同的母题和个题展现的视觉文本，如果给这个文本一个命题，那就是墓志铭。墓主人的手绘壁画墓在特点方面与文字墓志铭异曲同工，作为绘画作品具有艺术性；作为画传，具有真实性和史传性质；作为实用画作，即突出个性又未远离母题，呈现出固定模式。M1 的壁画作为一个整体观察是墓主人护乌桓校尉的手绘版墓志铭，是墓志铭的一种特殊的存在形式，同时，可以成为墓志铭东汉起源说的一个重要证据。

附：使持节护乌桓校尉某君墓志铭^[60]

使君□□□，字□□。定襄郡人，君□□之玄，□□之曾，□□之孙，□□之元子也。君察孝，除郎中，迁西河长史，后迁行上郡属国都尉，后拜繁阳令，因□□受圣恩，被玺书，民颂其慧，吏怀其威。帝咨君谋，终使持节以护乌桓校尉，监视乌桓，君执威权，令其后伏。文则作颂，武襄乌桓。有助力于汉室。夫人讳□，字□，□郡人也。年有□□，始适□氏。夫人礼性纯淑，忠贞智慧。祇奉姑舅，接事夫主，整修中匮，仆御肃然。子孙贤孝，门楣光耀。子孙□□。

使君终年□□有□，□□年□□月□□日故。□□不胜感墓罔极之哀，财立墓碑，略记遗烈。

其辞曰，皇灵诞育，□□□□，□□夫人，秉德淑清。聪朗内识，接物以诚。□□□□，□□□□，千秋万岁，何时复形。呜呼哀哉！

ABSTRACT

Helingeer Tuchengzi No.1 Tomb creates an underground dwelling full of artistic atmosphere and spiritual pursuit for the tomb owner according to his personal life and residence. The owner of the tomb merged the structure of the former official government with that of the tomb to write his personal autobiography in the form of murals. The order he describes is: Study under a tutor ——enter politics via "xiaolian" ——do the official post of "lang" —— Xihe "zhangshi" -- do the official name of "xingshangjunshuguoduwei" ——The governor of Fanyang County Be a General Wuhuan with a "jie" as a representative ambassador. It was a life that honored him. The murals select a variety of themes, such as carriage travel, city, greeting and meeting officials, various "zaji" performances, living, wise and obedient people, large estates, etc., which is not only a decoration, but also a way of narration. Through the analysis of the content of the tomb mural, the paper compares with the standard epitaph in four aspects: name, family, life story and rhymes. According to the design arrangement of the mural, it starts from the peak of the tomb owner's life, and describes the life of a general Wuhuan in the late Eastern Han Dynasty in a flashback way. It is concluded that the tomb mural is a hand-painted epitaph of the tomb owner.

Key words: *Tomb 1 of Tuchengzi, Helingeer, Mural painting, epitaph*



注释：

- [1]陈红军,《汉代墓室壁画图像语言研究》,福建师范大学硕士学位论文,第4页。
- [2]“所以我们认为这个曾任护乌桓校尉的墓主是为史籍所未记的。”黄盛璋,《和林格尔汉墓壁画与历史地理问题》,《文物》,1974年01期,第44页
- [3]内蒙古自治区文物考古研究所,《和林格尔汉墓壁画》,北京:文物出版社,2007年,第10页。
- [4]王欢在硕士学位论文《汉魏六朝墓志铭研究》中做了墓志铭起源研究综述,认为有“先秦说、秦代说、西汉说、东汉说、魏晋说、南朝说”。
- [5]张茂华、元宏昌主编:《中华传统文化粹典》山东:山东人民出版社,1996年4月,第333页。
- [6](宋)欧阳修《集古录跋尾》卷四,跋《宋文帝神道碑》(四部丛刊全集本四部备要集部本,1936年,第543页
- [7]黄盛璋,《和林格尔汉墓壁画与历史地理问题》,《文物》,1974年01期,第44页
- [8]安其乐,《论和林格尔壁画墓中的建鼓》,硕士学位论文。
- [9](宋)范华撰;(唐)李贤等注,《后汉书(卷四)孝和孝殇帝纪第四》,北京:中华书局,1965年,第189页。
- [10]“定襄郡高帝置。五城,户三千一百五十三,口万三千五百七十一。”《后汉书·志》第二十三 郡国五,北京:中华书局,1965年,第3525页。
- [11]桓灵时的童谣“举秀才,不知书;察孝廉,父别居。”原载东晋葛洪《抱朴子》。
- [12]著名学者巫鸿针对长沙马王堆一号汉墓的帛画提出画面不同主题“相关性的”观点。见巫鸿,礼仪中的美术马王堆再思考,见《礼仪中的美术——中国古代美术史文编》,郑岩等译,北京:生活·读书·新知三联书店,2005年第一版,第110页
- [13](宋)范华撰;(唐)李贤等注,《后汉书·志第二十八·百官五》,北京:中华书局,1965年,第3626页。
- [14]吕思勉,《秦汉史》,南京:译林出版社,2016年6月第1版,第486页。
- [15]张鹤泉:《东汉持节问题探讨》,《史学月刊》,2003年第2期,第17页。
- [16]崔雪冬,《图像与空间——和林格尔东汉墓壁画与建筑关系研究》,沈阳:辽宁美术出版社,2017年7月第一版,第85页
- [17]该图表根据M1发掘报告、《和林格尔汉墓壁画》、《和林格尔汉墓壁画孝子传图摹写图辑录整理》。
- [18]马玉香,《论建鼓的特殊功能》,《长春教育学院学报》,2013年第16期,第53页。
- [19]“河南汉画像砖中的建鼓图多位于墓葬门楣或墓门之上,且以一种独特的呈现方式,即多与车骑出行、乐舞百戏、捞鼎图和西王母图像系统相配合出现,共同指向求仙道的礼仪功能。”刘乐乐,《河南汉画中建鼓图的礼仪功能探析》,《文化遗产》,2017年第3期,第117页。
- [20]本文所采用图片均见内蒙古自治区文物考古研究所、内蒙古博物院、日本幼学会,《和林格尔汉墓壁画孝子传图摹写图辑录》北京:文物出版社,2015年9月。
- [21]马新,《试论汉代的墓祀制度》,山东大学学报(哲学社会科学版),2014年第1期,第23页。



- [22] 宋治民,《<和林格尔汉墓壁画>的几点我见》,《四川大学学报(哲学社会科学版)》,1980年3月,第104页。
- [23] 崔雪冬,《图像与空间——和林格尔东汉墓壁画与建筑关系研究》,沈阳:辽宁美术出版社,2017年7月第一版,第26页
- [24] 朱锡禄,《武氏祠汉画像石》,济南:山东美术出版社 1986年12月,第7页。
- [25] 林剑鸣,《余华青等·秦汉社会文明》,西安:西北大学出版社,1985年,第258页。
- [26] 赵宪章先生在《文学和图像关系研究中的若干问题》中提到的汉代处于语图关系中“语图分体”阶段的论述。(赵宪章,《文学和图像关系研究中的若干问题》,《江海学刊》,2010年第1期,第187页。)他的学生李彦锋以此为方向的博士毕业论文《中国绘画史中的语图关系研究》(李彦锋,《中国绘画史中的语图关系研究》,硕士学位论文)中也明确指出汉代绘画是“经史故事的图像化”过程中的产物。汉画和文献紧密相关,互相印证。笔者认为汉代绘画的语图关系可以描述为“语图互补”。
- [27] 刘珊珊、陈晓宇,《居庸关历史演变特征研究》,《建筑学报》2012年第8期,第59页。
- [28] 《后汉书·志第二十八·百官五》,北京:中华书局,1965年,第3622页。
- [29] “球少涉儒学,善律令。阳嘉中,举孝廉,稍迁繁阳令。”见(宋)范华撰;(唐)李贤等注,《后汉书·卷五十六》(列传·赵尹韩张两王传第四十六),北京:中华书局,1965年05版,第1831页。
- [30] “汉朝执金吾,金吾亦棒也,以铜为之,黄金涂两末,谓为金吾。御史大夫、司隶校尉,亦得执焉。御史、校尉、郡守、都尉、县长之类,皆以木为吾焉”见[晋]崔豹,《古今注》,《百子全书》,杭州:浙江古出版社,1998:1图页,转引自黄剑华,《汉代代画像中的门吏与持械人物探讨》,《中原文物》,2012年第1期,第56页。
- [31] 《三国志·卷十一·魏书十一·袁张凉国田王邴管传》北京:中华书局,第357页。
- [32] 山河、李耀臻、李淑先,《中国历代应用文章名篇赏析》,青岛:青岛海洋大学出版社,1998年12月第1版,第115页
- [33] 崔雪冬,《图像与空间——和林格尔东汉墓壁画与建筑关系研究》,沈阳:辽宁美术出版社,2017年7月第一版,第26页
- [34] (宋)范华撰;(唐)李贤等注,《后汉书·志第二十九·舆服上》,北京:中华书局,1965年,第3651页。
- [35] 形昊,《<后汉书·舆服志>车舆类名物词研究》,硕士学位论文,第21页
- [36] 黄留珠,《秦汉仕进制度,西北大学出版社》,1985年07月第1版,第106页
- [37] 黄留珠,《秦汉仕进制度,西北大学出版社》,1985年07月第1版,第142页
- [38] (宋)范华撰;(唐)李贤等注,《后汉书·志第二十九·舆服上》,北京:中华书局,1965年,第3648页。
- [39] 田瑞文,《东汉郎官辩考》,《兰台世界》,2012年第01期
- [40] “乃者以缚马书遍视丞相、御史、二千石、诸大夫、郎、为文学者。”见《资治通鉴·汉纪·汉纪十四》
- [41] 崔雪冬,《图像与空间——和林格尔东汉墓壁画与建筑关系研究》,沈阳:辽宁美术出版社,2017年7月第一版,第26页



- [42] (宋)范华撰；(唐)李贤等注，《后汉书·志第二十九·舆服上》，北京：中华书局，1965年，第3648页。
- [43] (宋)范华撰；(唐)李贤等注，《后汉书·郡国志第二十三·郡国五》，北京：中华书局，1965年，第3524页。
- [44] (宋)范华撰；(唐)李贤等注，《后汉书·志第二十八·百官五》，北京：中华书局，1965年，第3621页。
- [45] 崔雪冬，《图像与空间——和林格尔东汉墓壁画与建筑关系研究》，沈阳：辽宁美术出版社，2017年7月第一版，第26页
- [46] 内蒙古自治区文物考古研究所，《和林格尔墓壁画》，文物出版社，2007年第2版，第33页
- [47] (宋)范华撰；(唐)李贤等注，《后汉书·志第二十八·百官五》，北京：中华书局，1965年，第3621页。
- [48] 《汉书·百官公卿表第七》，北京：中华书局，第742页。
- [49] (宋)范华撰；(唐)李贤等注，《后汉书》(列传·赵尹韩张两王传第四十六)，北京：中华书局，1965年05版，第1819页。
- [50] 朱锡禄，《武氏祠汉画像石》，济南：山东美术出版社，1986年12月版，第7页。
- [51] 内蒙古自治区文物考古研究所，《和林格尔墓壁画》，文物出版社，2007年第2版，第33页
- [52] 黄盛璋，《和林格尔汉墓壁画与历史地理问题》，《文物》，1974年01期，第40页
- [53] 内蒙古自治区文物考古研究所，《和林格尔墓壁画》，文物出版社，2007年第2版，第32页
- [54] 庄孔韶，《人类学通论》，陕西教育出版社，2009年7月第一版，第172页“语言符号的另一个重要特点就是线性。”
- [55] 张鹤泉，《东汉持节问题探讨》，《史学月刊》，2003年第02期，第17页
- [56] 安其乐，《论和林格尔壁画墓中的建鼓》，硕士论文，第25页。
- [57] 刘博骥，《六艺通论》，台北：台湾中华书局，1977年9月，第126页
- [58] 王海燕，《古代日本的都城空间与礼仪》杭州：浙江大学出版社，2006年08出版，第132页。
- [59] 黄剑华，《汉代画像中的门吏与持械人物探讨》，《中原文物》，2012年第1期，第57页。
- [60] 笔者据壁画内容拟撰。

**ХЯТАДЫН НАЙРАЛ ДУУНЫ УДИРДААЧ ШЯНЬ ШИНХАЙН
АМЬДРАЛ, УРАН БҮТЭЭЛ (1905-1945)**

Ван Рүйбяо*

ХУРААНГУЙ

Монгол, Хятадын хөгжмийн соёл өнө эртний түүхтэй бөгөөд Монголын хөгжимчид Хятадад зочилж, Хятадын хөгжимчид Монголд айлчлан, харилцан суралцаж, туршлагаа хуваалцаж байсан олон сайхан жишээ түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Хятадын “Буурал үст бүсгүй” хөгжимт жүжгийг Улаанбаатарт тавьж, монголын “Учиртай гурван толгой” үндэсний алдарт дуурийг Бээжинд тавьж байсан нь саяхны буюу XX зууны 50-иад оны явдал билээ. Харин XX зууны 40-өөд онд Улаанбаатар хотод хятадын орчин цагийн хөгжмийн нэрт зохиолч Шянь Шинхай хэсэг хугацаанд амьдарч, өөрийн алдарт бүтээлээ сонсгож, монголын хөгжмийн ертөнцийнхөнтэй хамтран ажиллаж байсан сонин баримтыг, түүний амьдрал, уран бүтээлтээр дамжуулан танилцуулахыг тус өгүүлэлд зорив.

Түлхүүр үгс: *Хөгжмийн зохиолч, Шар мөрний кантата, Хатан голын магтуу, Шийяанз, симфони*

Удиртгал

Аливаа урлаг, уран сайхан гэдэг бол тухайн улс үндэстний түүх цадиг, хөгжил дэвшил, алдаа оноо, ахуй соёлыг өөртөө шингээж, үеэс үед уламжлан дамжуулж байдаг онцгой нэгэн зүйл билээ. Иймд хятадын хөгжмийн нэрт зохиолч Шянь Шинхайн амьдрал, уран бүтээлээр дамжуулан, хятадын шинэ цагийн нийтийн дууны өвөрмөц, шинэлэг, дайчин хэлбэрийг цоо шинээр бий болгож, японы эзэрхэн түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн хятадын ард түмний тэмцлийн дайчин уриа, цэрэг, ард түмний эв нэгдлийн дуулал болсон түүхэн үзэгдлийг тайлбарлахаар зорьсон болно. Мөн Шянь Шинхайн алдарт хөгжмийн бүтээлүүдийн төрсөн түүх, урлаг судлаачдын тэдгээр бүтээлд өгсөн үнэлгээ дүгнэлт



* Монгол Улсын Сити Их Сургуулийн докторант.



THE CULTURAL WAY

зэргийг түүний тухай дурсамж яриа, намтар түүхээс тодруулахыг хичээв.

Шянь Шинхайн намтар

“БНХАУ-ын хөгжмийн найрал дууны удирдаач Шянь Шинхай (洗星海,)¹ нь 1905 оны 6-р сарын 13-нд Макаогийн далайн эрэг дээр загасчны онгоцон дээр мэндэлжээ. 1926 онд Бээжингийн Их Сургуулийн хөгжмийн салбар, Улсын Соёл Урлагийн Их Сургуулийн хийлийн сонгон сургалтын ангид дэвшин суралцжээ. 1928 онд Шанхайн Хөгжмийн Их Сургуулийн хийл, төгөлдөр хуурын ангид суралцсан бөгөөд суралцаж байх хугацаандаа “*Нийтлэг ая*” хэмээх нийтлэлээ бичиж хэвлүүлжээ². 1929 онд оюутны хөдөлгөөнд оролцсон шалтгаанаар сургуулиасаа гарч, 1929 онд Францад суралцахаар оджээ. Улмаар Парисын Хөгжмийн Их Сургуульд элсэн орж, хийлээр В.Д’Энди, хөгжмийн онол, зохиомжоор Пол Дюка нарын гарын шавь болжээ. 1935 онд Парис дахь сургуулиа дүүргээд Шянь Шинхай эх орондоо буцаж ирэхдээ, хэдийнээ олонд танигдсан нэр алдартай хүн болсон байжээ. Иймээс Гэмин намынхан, нэртэй баячууд бүгд өөрсдийн эрх ашгийн төлөө түүнд мөнгө амлан, зохиол бүтээл туурвиулах гэж ятгаж, өмнө нь хуурамчаар бөхөлзөн саймширч байжээ.

Шянь Шинхай бол мятрашгүй, шинийг эрэлхийлэгч, их бүтээлч, дуу хөгжмийн авьяас төгөлдөр зохиолч, нэрт хөгжимчин байсан бөгөөд түүний очсон газар бүрд японы түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн хятадын ард түмний тэмцлийн дуу хөгжим цуурайтан, цэрэг, ард түмнийг зоригжуулдаг байжээ.

Энэ үед орон даяар болж байсан партизаны тэмцэл Хуа Бэйд партизаны зохион байгуулалттай хөдөлгөөн болон өрнөж, дайны хэлбэрт шилжсэн байв. Үүнд Шянь Шинхай тэр даруй шинэ бүтээлээрээ оролцож “*Партизанууд дайсны ар талд гарсан нь*” зэрэг сод бүтээлээ туурвижээ. Тэр бээр Японы түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд Хятадын коммунист намын баримталж буй бодлого, үйл ажиллагааг ихэд дэмжин, хүлээн зөвшөөрч байсан бөгөөд харин Гэминдан намын хоёр нүүртэй үйл ажиллагааг шүүмжлэн, сэтгэл дундуур байжээ.

1938 оны 9-р сард 8-р армийн удирдлага түүнд урилга ирүүлж, Яньан дахь Лу Синий нэрэмжит урлагийн академийн хөгжмийн салбарын эрхлэгчээр ажиллахыг санал болгожээ. Шянь Шинхай энэ урилга, саналыг дуртай хүлээн авч, тэр даруй Яньанд очжээ.

1938 оны 10-р сард түүний гэргий Чжэнь Юн Лин Яньанд ирсэн бөгөөд Шянь Шинхайн гэр бүлийнхний аюулгүй байдлыг сахих зорилгоор Яньан дахь 8-р армийн штабын байранд амьдруулж байлаа. Тухайн цагийн түгшүүрт байдлаас шалтгаалан Яньан руу явах нь аюултай, очих хэрэггүй гэж нөхөд нь хориглож байсан хэдий ч Шянь Шинхай ажлынхаа төлөө сэтгэл нь зовж, европ

¹ <https://www.sin80.com/en/artist/xian-xinghai>

² 何乃强 (1 September 2013). [洗星海在新加坡十年 1911-1921：历史补遗 谬误纠正](#).



THE CULTURAL WAY

маягаар хувцаслан худалдаачны дүрд хувиран Гуандун аялгаар ярьж, бусдын анхааралд аль болох өртөлгүй хувьсгалын өлгий нутаг Яньанд хүрч чаджээ. Тэр бээр Яньанд чин сэтгэлээсээ ажиллаж, хөгжмийн уран бүтээл, багшлах ажилдаа сэтгэл хангалуун байв.

1935–1938 онд бүтээл туурвилаа идэвхтэй үргэлжлүүлж, “*Аврагч армийн дуу*”, “*Партизаны дуулал*”, “*Замыг бид нээнэ*”, “*Хатан мөрний хайр*”, “*Эх орны хүүхдүүд*”, “*Дайсны ар тал руу*”, “*Тайхан ууланд*” зэрэг төрөл бүрийн сэдвээр олон тооны бүтээл туурвижээ³. 1938 онд Яньанд Лу Синий нэрэмжит Соёл Урлагийн Академийн Хөгжмийн салбарын эрхлэгчээр ажиллахын зэрэгцээ Эмэгтэйчүүдийн Их Сургуульд хичээл зааж, давхар үүрэг гүйцэтгэж байжээ. Мөн энэ хугацаанд алдарт “*Хатан голын магтаал*”-ынхаа эх зохиолыг боловсруулж, хөгжмийг нь бичиж, “*Магтуу төрөх нь*” хэмээх алдарт бүтээлээ бичжээ⁴.

1940 оны 5-р сард Шянь Шинхай ЗХУ-д очиж, Яньан болон 8-р армийн тухай киноны хөгжмийг зохиохоор гарахын өмнөхөн Мао Зе Дун дарга зоогонд урьж, зардлыг нь даажээ. Гэвч зөвлөлт, германы дайн удалгүй дэгдэж, уг киноны ажил тасалджээ.

1940 оны 9 сард Шянь Шинхай Улаанбаатарт ирж, Нийслэл дэх хятад ажилчдын клубт гуталчин, цагийн багшаар ажиллахын хамт мэргэжил нэгт монгол анд, найз нөхөдтэй болж, өөрийн нэрийг нууцлан “Нөхөр” хэмээн нэрлэх болж, мэргэжлийн хөгжмийн соёлыг түгээсээр байжээ. Мөн алдарт “*Хатан голын магтуу*”-аа хятад ажилчдын клубийн дэмжлэгтэйгээр олны хүртээл болгож, монголын ард түмэнд тоглолт болон радио нэвтрүүлгээр сонсгожээ.

1940-өөд оны тэр бүтээлд гар бие оролцсон болон үзэж сонсож байсан ахмад буурлууд өдгөө ч Улаанбаатар хотод амьдарч, тэр их хүнийг дурсаж байдаг нь монгол, хятад хоёр ард түмний уламжлалт найрамдлын биет баримт болж байна.

1941 оны 12-р сарын 30-аас Шянь Шинхайн архаг өвчин хөдлөн, хүндэрч эхэлжээ. Гэвч тэр бээр маш тэвчээртэй, шаргуу хөдөлмөрч, зорьсондоо хүрэх хатан зоригтон байсан тул өвчин нь хүндэрснийг үл ажран 1945 оны 1-р сарын 27-оос 2-р сарын 15-ныг хүртэлх 10 гаруйхан хоногийн дотор төгөлдөр хуурт зориулсан “*Жунгуо ван шан чү*” бүтээлээ бичиж дуусгажээ.

Хөгжмийн аугаа их зохиолч Шянь Шинхайн дурсгалд зориулж Яньаны ард иргэд цэргийн гашуудлын цуглаан зарлаж, Мао Зе Дун дарга “*Хятадын ард түмэн хөгжмийн аугаа их зохиолч Шянь Шинхайн төлөө гашуудаж байна*” хэмээн өөрийн мутраар бичиж дээд хэмжээний эмгэнэл илэрхийлжээ. 1999 онд Казахстаны Алма – Ата хотын нэгэн төв гудамжийг Шянь Шинхайн нэрэмжит

³ Smith, Nicholas (20 September 2003). "[Conductor's Notes: Xian Xinghai Yellow River Cantata](#)". *Beijing International Festival Chorus program 20 September 2003*. Beijing International Festival Chorus. Retrieved 27 August 2010.

⁴ <https://www.sin80.com/en/work/yellow-river-cantata>



THE CULTURAL WAY

болгож, Жан Зэ Мин дарга Казахстанд хожим айлчлах үеэрээ “Хятадын ард түмэн хөгжмийн энэхүү зохиолчийг үүрд дурсаж байх болно” хэмээн тэмдэглэжээ.

Шянь Шинхайн уран бүтээл

Шянь Шинхай асар богино амьдралдаа хэдэн зуун дуу, нийтлэл бичсэн бөгөөд голлох бүтээлээс нь дурдвал: “Үндэсний чөлөөлөлт (Үндэсний эрх чөлөө)”⁵, “Ариун дайн”⁶ зэрэг 4 симфони, дуулалт жүжиг 2, харилцаа дуу 2, нийтийн дуу 300 гаруй, “Хятадын шинэ үеийн дууг үндэслэгч”, “Хятадын дуу хөгжмийн үндэсний хэв маяг” зэрэг 30 гаруй нийтлэл бичжээ⁷.

Яньанд ажиллаж байсан хүнд хэцүү цагт Жү Дэ командлагч 5, Лү Ин туслах 5, багш нар 12 юанийн нэмэгдэл авдаг байхад Намын Төв Хороо Шянь Шинхайд 15 юанийн нэмэгдэл өгч байсан бөгөөд 7 хоногт 2 удаа мах, 2 удаа будаа идэж, хоол болгондоо 1 шөл нэмүүлдэг байсан нь Нам түүнд онцгой хүндэтгэл үзүүлж байсны нэгэн хэлбэр байжээ.

Дээр бичсэнчлэн түүний бүтээлүүдээс гадна хамгийн олон, хамгийн их нөлөөтэй, сэдэв өргөнтэй нь нийтийг хамарсан найрал дуу болой. Эдгээрээс цохон тэмдэглүүштэй нь: Хятадын ард түмэн дайныг эсэргүүцсэн, тэмцэлд уриалан дуудсан, дайны уршгийн сэдэвтэй “Эх орны цэрэг”, “Залуучуудын уриа”, “Дайсны ар талд” мөн дайны дүр зураг, уянгын болон айдас түгшүүр,



дүрслэлийн ерөнхий шинжүүдийг багтаасан: “Явган цэрэг”, “Сөрөг довтолгоо”, хөдөлмөрчин олны аж амьдралыг илэрхийлсэн: “Оргил дээр”, “Замыг бид нээнэ”, дайны үеийн хүүхэд, эмэгтэйчүүдийн тухай үгүүлсэн: “Эх орны хүүхдүүд”, “Мартын 8”⁸ зэрэг олон дуу бий.

Энэ дуунууд өөр хоорондоо адилгүй өнгө аяс, агуулга хэлбрийг илэрхийлсэн, хувьсгалын үеийн ард түмний сэтгэлийн дотоод ертөнцийг нээн харуулж чадсан байдгаараа онцлог юм.

Зохиолч Гуан Мүран (光未然; *Guāng Wèirán*)⁹ 1938 оны 10-р сард Шар мөрнийг завиар гаталж явахдаа мөрөнгийн эрэг хавийн байгалийн сайхныг алмайран биширч байтал тэртээх уулын ойд өсвөрийн пионерууд дайсныг эсэргүүцсэн дууг сүр жавхаатай дуулж буй тэдний зоригт дуу хоолой зохиолчийн сэтгэлийг бүр ч ихээр хөдөлгөсөн гэдэг. Энэ явдлаас хойш удалгүй Гуан Мүран шархдаж Яньаны эмнэлэгт хэвтэж эмчлүүлжээ. Шянь Шинхай

⁵ Symphony No. 1 "Liberation of the Nation" Op. 5 (1935/1941)

⁶ Symphony No. 2 "Holy War" Op. 17 (1943)

⁷ "Xian Xinghai". icm.gov.mo. Retrieved 17 March 2019.

⁸ Appiah (ed), Kwame Anthony; Henry Louis Gates, Jr. (1997). *The Dictionary of Global Culture*. New York, NY: Alfred A. Knopf. pp. 703.

⁹ https://en.wikipedia.org/wiki/Guang_Weiran



THE CULTURAL WAY

түүнийг эргэж ирэхэд нь зохиолч өөрт төрсөн сэтгэгдлээ ярьжээ. Шянь Шинхай түүний ярьсныг тун анхааралтай сонсоод, таатай хүлээн авч, энэ санаагаа дууны үг болгохыг хүссэн гэдэг. Гуан Мүран зохиолч Шянь Шинхайн дэмжлэгтэйгээр 400 гаруй мөртэй уртхан шүлэг бичсэн нь хожим “Хатан голын магтуу” (黄河协奏曲; *Huáng Hé xiézuǒqǔ*)¹⁰ хэмээх алдарт найрал дууны үг болох хувь тавилантай байжээ.

1939 оны хавар чөлөөлөх армийн жүжгийн багийнхны нэгэн хүлээн авалт дээр Гуан Мүран өөрийн анд Шянь Шинхайтай тааралдаж, бэлэн болсон шүлгээ өгөхөд Шянь Шинхай ихэд догдлон “Энэ чинь Хятад үндэстний түүхэн дуулал байна. Би үүнийг манай ард түмний агуу хүч чадлыг илтгэсэн найрал дуу болгоно оо, энэ бол хятадын шинэ маягийн найрал дуу байх болно. Би та бүхэнд цаг алдалгүй гаргаж өгнө”¹¹ хэмээн сэтгэлийн хөдлөлөө барьж дийлэлгүй хэлсэн тухай тэмдэглэгдэн үлджээ.

Энэ нь зохиогч олны өмнө өгсөн амлалтаа хугацаандаа, бүр түүнээс ч өмнө биелүүлэх арга зам нь болж өгчээ. Шянь Шинхай магтуугаа бичиж дуусгаад 1939 оны 4-р сарын 13-нд чөлөөлөх армийн жүжгийн багийнхнаар анх удаа дуулуулж, улмаар 4-р сарын 25-наас эхлэн Шянь Шинхай өөрөө удирдан даруй 10 гаруй дараалан тоглуулж, сонсогчдоос хамгийн халуун талархал хүлээн авч, Лу Синий нэрэмжит Соёл Урлагийн Академийн 1 жилийн ойд зориулсан хүлээн авалтын үеэр тус сургуулийн оюутан сурагчдаас бүрдсэн 100 орчим хүнтэй найрал дуучид Шянь Шинхайн удирдснаар “Хатан мөрний магтуу”-г дуулж сонсоход Мао Зе Дун дарга болон төр, засгийн удирдагчид, олон нийтийн төлөөлөгчид суудлаасаа босон удтал алга нижигнүүлэн, догдлон баярлаж талархсан сэтгэлээ илэрхийлжээ¹². Үүнээс хойшид чухал бөгөөд том хүлээн авалт, хурал цуглааны үеэр “Хатан голын магтуу” тоглолтын хөтөлбөрт заавал дуулагдах уламжлалтай¹³ байжээ.

1955 онд Москвад П.Чайковскийн нэрэмжит концертийн их танхимд Шянь Шинхайн нас нөгчсөний 10 жилийн ойг хүндэтгэн зохион байгуулсан концертод Москвагийн алдарт тайзнаа “Хатан голын магтуу”-г орос хэлээр амжилттай тоглогдсоны гадна яруу найраг, хөгжмийн зохиомжийн төгс илэрхийлэл, дууны өвөрмөц зохиомж, хөгжмийн зохиолдоо бүгд яруу цогцолсон хятадын хөгжмийн түүхэнд баларшгүй мөрөө үлдээж, дэлхий хөгжмийн түүхэнд ч хүндтэйгээр тэмдэглэгдэх бүтээл болсныг нотлон харуулсан онцлог явдал болжээ.

“Хатан голын магтуу” буюу “Шар мөрний тухай кантат”
хөгжмийн зохиолын товч танилцуулга

¹⁰ https://en.wikipedia.org/wiki/Yellow_River_Cantata

¹¹ Шянь Шинхайн өдрийн тэмдэглэл 1978 он.

¹² Мао Дун. Зохиолын эмхтгэл. 12-р боть. Ардын утга зохиолын хэвлэх хороо. Бээжин, 1986 он.

¹³ https://en.chncpa.org/production/productions/repertoire/JM/202112/t20211207_238766.shtml



THE CULTURAL WAY



Энэхүү магтуу нь зохиомжийн хувьд тухайн цаг үед зонхилох ач холбогдолтой байсан дайчин эрэмгий маршийн хэлбэрийг сонгосон нь японы эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд өргөн олныг нэгтгэж, эх орноо илүү их хайрлан хүндлэх үзэл санаагаар зоригжуулах зорилго агуулжээ. Энд зохиогчийн сэтгэл хөдлөн хэлсэн ... *энэ бол хятадын шинэ маягийн найрал дуу байх болно оо* ... гэсэн үгийг эш татахад хангалттай юм. Чухам ийм дуу л хятадын ард түмний агуу их хүчийг илэрхийлж чадах байлаа, тэгээд ч бүхний сэтгэлийг эзэмдсэн агуу дуу болсон билээ.

16 такт хөгжмийн эхлэл нь C dur – т бичигдсэн бөгөөд I анги мөн энэ хөг эгшиглэгээгээр шууд үргэлжлэн гоцлоочид эхний 30 такт үндсэн сэдвийг дуулж, их найрал дуу залган I ангийн дэд хэсгийг өрнүүлэн 54 такт дуулна. 55-р тактаас F dur – т хөгжмийн цоглог аялгуугаар холбоос залган 24 такт яваад хөг эгшиглэгээ дээшлэн Es dur-ын залгаа II ангийг эхлүүлэн 16 такт хөгжимдөөд найрал дуу 141 дэх тактаас баатарлаг дуулал эхлэн сүрлэг төгсгөлтэйгөөр өндөрлөнө¹⁴.

Шянь Шинхай 1939 оны 3-р сарын 26-аас 31-нийг хүртэл ердөө 6 хоногийн дотор “Хатан голын магтуу”-ны 8 бадаг бүхий хөгжмийг зохиож дуусгасан бөгөөд анхны гар бичмэлээрээ сайн зохиол болох нь танигдаж, цаашид амжилт олох үндэс суурь нь тавигджээ. Үүгээр Шянь Шинхай ая дууны агуу их мастер гэдгээ харуулжээ. Шянь Шинхай энэ бүтээлдээ нягт нямбай хандаж, дуулуулахаасаа өмнө гурван удаа өөрийн сэтгэлд хүрээгүй хэсгүүдийг засаж бичсээр байжээ¹⁵.

“Хатан голын магтуу”-ны шүлэг, хөгжим нь гайхамшигтай тохирч, чанд уялдсан, утга агуулга, цаг үеийн үзэл санааг хамгийн яруу гаргаж чадсан алдартай зохиол учраас анхны тоглолтыг үзсэн их удирдагч Мао Зе Дун “Сайн, сайн”¹⁶ хэмээн хэдэнтээ сайшаан дэмжиж чин сэтгэлээ илэрхийлж байжээ.

1940-өөд оны дунд үед Шянь Шинхай Москвад байхдаа “Хатан голын магтуу”-ныхаа дарамж - (клавир) – ийг нягтлан бэлтгэж, мөн бүхэл бүтэн удиртгал хөгжим нэмэн зохиож, симфони найрал хөгжимтэй, их найрал дуу дуулна хэмээн тодорхойлжээ.

¹⁴ http://www.jameschingmusicnotes.co.uk/html/xian_xinghai_yellow_river_pian.html

¹⁵ 毕星星: 音乐大师洗星海的查民身份 评论频道 凤凰网". news.ifeng.com. Retrieved 26 March 2018.

¹⁶ Нэрт хүмүүсийн хэлсэн үг. Шанхайн хэвлэлийн хороо, 1985 он.



THE CULTURAL WAY

Шянь Шинхай Монголд

1940 оны 9-р сард Шянь Шинхай аргагүй нөхцөл байдлаас шалтгаалан Улаанбаатарт ирж хэсэг хугацаагаар амьдарсан байдаг. 1940-өөд оны эхээр нутгаа зорин Москвагаас гарсан боловч адал явдал мэт ээдрээт замын эрхээр Монгол орныг дайрч гарах нөхцөл тулгарчээ. Улаанбаатарт хүргэгдэн ирэхэд нь Шянь Шинхайг нийслэл дэх хятад ажилчны клубт гутлын засварчнаар ажиллахыг зөвшөөрчээ. Монгол анд нөхөд нь түүнийг халуун дотно хүлээн авч, тэр бээр мэргэжил нэгт олон нөхөдтэй болж, улмаар ажлын бус чөлөө цагаар өөрийн дуртай хөгжмийн ажлаа хийж, зарим бололцоотой цагаар нөхдийнхөө хүсэлтээр багшлах болжээ¹⁷. Ийнхүү тэр бээр анд найз, нөхөд, түүгээр үл барам монгол шавь нартай байлаа.

Монголчууд түүнээс нэрийг нь асуухад тэр бээр даруухан инээмсэглэж “Намайг найз нөхөр гэхэд болно” хэмээснээс үүдэн нөхөд нь түүнийг “Найз, Нөхөр” хэмээн хүндэтгэдэг байжээ. Шянь Шинхай Монголд байхдаа Монгол дахь хятад цагаачдын холбоог зохион байгуулалцаж, тэднийхээ хүчээр “*Хатан голын магтуу*”-аа тайзнаа дуулуулж, хятад нөхдөдөө их нөлөө үзүүлжээ.

Энэ алдарт хөгжмөөрөө Шянь Шинхай зөвлөлтийн арми, монгол цэрэг, ард түмний ариун тэмцэл, эв нэгдлийг хөгжмийн хэлээр илэрхийлэхэд хувь нэмрээ оруулсан юм.

Монголын орчин үеийн хөгжмийн нэрт зүтгэлтэн,
хөгжмийн ахмад зохиолч, удирдаач П.Хаянхярваагийн дурсамж

Улаанбаатар хотод Гандангийн дэнжийн зүүн доор 1929–1955 онд хятад ажилчдын клуб үйл ажиллагаагаа явуулдаг байлаа. Монголчууд тэр клубийг Шийяанз гэж нэрлэдэг, хятадууд Шийяанзад очих их дуртай байсан.

Шийяанз гол төлөв “*Бээжин дуурь*”, хятад үндэсний жүжгүүд мөн монгол драм тоглодог, хятадын тулааны урлаг, орчин үеийн биеийн тамир, спортын дугуйлан, ардын болон орчин үеийн хөгжмийн чадварлаг томоохон хамтлаг, сайн дуучидтай, их авьяаслаг жүжигчид, бүжигчидтэй, үсчин, гэрэл зурагчин, халуун ус, ресторан хэлбэрийн том гуанзтай, өөрөөр хэлбэл цогцолбор үйлчилгээтэй, хятад ханзаар сонин (Хятад ажилчны зам) хэвлэн гаргадаг Улаанбаатар хотын баруун хагасыг соёлоор үйлчилдэг байсныг би сайн мэдэх юм. Маршал Х.Чойбалсан гуай Шийяанзад очиж ший жүжиг үздэг, БНХАУ-ыг тунхагласны 1 жилийн ойгоор маршал шийяанзад очиж байсан, тэндхийн дарга, багш нартай дотно ярилцдаг байсныг мэдэх юм. Би ч 12 настайгаасаа эхлэн Шийяанзаар бишгүй нэг орж гарч явлаа. Шийяанзад Күн Юү /би Фүн Юү гэж буруу сонссон юм билээ/ гэдэг алдар хүндтэй хөгжмийн зохиолч байдаг гэж анх ааваасаа сонссон юм.

¹⁷ Шянь Шинхайн өдрийн тэмдэглэл, Бээжин, 1978 он.



THE CULTURAL WAY

Миний аав дэд хурандаа Б.Пүрэвжав Монголын цэргийн хөгжмийн ерөнхий удирдаач хүн, олон түмэнд их нэр хүндтэй, алдартай олон хөгжимчдийн багш, ахмад удирдаач байсан. Би хар бага наснаасаа хөгжимд дуртай, радио нэвтрүүлгээс чихээ салгадаггүй хүүхэд байсан учир тэр их хүний тухай ааваасаа мэдэж аваад улмаар 1942-1943 онд монголын радиогоор өдөр болгон шахам нэвтрүүлдэг асан Шянь Шинхайн зохиол “*Шар мөрний тухай кантат*”-ын аялгууг амтархан сонсож, хөгжмийг нь өөрөө цээжлээд аялж явдаг 10 нас ч хүрээгүй жаахан хүү дэгдэж явлаа. Тэр үед монголын радиогийн нэвтрүүлэгт нийслэл хотын бүх клубүүд ээлжлэн тогтмол оролцдог, хятад шийяанзныхан бүр ч олон оролцдог, тэр бүрдээ хэний зохиол гэдгийг нь зарлахгүйгээр “Шар мөрний тухай кантат”-ыг заавал дуулдаг байсан юм. Түүнээс хойш 15 жилийн дараа би Москвагийн консерваторт суралцаж, орос хэлийг сайн эзэмшээд, Си Синь Хай-гийн (орос галигаар) тухай арай илүү мэдэх болсон. 1972 онд би аавынхаа хааж асан албан тушаалд очиж, Ардын армийн хөгжмийн албаны дарга болоод, өмнө нь энэ албыг хашиж асан БНМАУ-ын урлагийн гавьяат зүтгэлтэн, хурандаа Н.Цэрэнпилээс Шянь Шинхайн тухай зарим сонирхолтой мэдээ сонсож билээ. Н.Цэрэнпил гуай 1960 онд монголын цэргийн үлээвэр хөгжмийн иж бүрэн урын сан /репертуар/-г анх удаа Бээжинд хэвлүүлж, Бээжингийн цэргийн хөгжмийн хороогоор хөгжимдүүлэн 10 ширхэг пянзыг нь бичүүлж байсан гавьяатай хүн. Тэр хэвлэлийг П.Хаянхярваа би редакторласан билээ. Н.Цэрэнпил гуай надад 1973 онд ярихдаа: *Би уг нь хөгжмийн тусгай боловсролгүй хүн, харин гармонийг бол Кун Юү багшаар заалгаж байлаа. Иймд намайг тэр их хүний шавь гэж болно гэж билээ.*

Хөгжим сурах хорхойтой нэг үеийн залуус Л.Мөрдорж, Т.Чимэддорж, Лха.Дорж, Б.Дамдинсүрэн, Н.Дагва-Осор бид нар хятад шийяанзаар их “гүйдэлтэй” байлаа. Тэр үед цаг хатуу, юм нарийн учир Кун Юү багшийн жинхэнэ нэрийг мэдэхгүй, мэдэх ч арга байхгүй. Багш маань их энгүүн даруу, маш нямбай, их ажилсаг, шөнө дөл хүртэл сууж ажилладаг, хөгжим байнга бичиж байдаг хүн байсан. Түүнийг гадаадад хөгжмийн сургууль төгсгөсөн тухай хүнээс дам мэдсэн боловч багш өөрөө энэ талаар юу ч хэлээгүй, бид ч хэрэгт дурлан асуух ухаан байсангүй. Кун Юү багш гармонийн хичээлийг тоон нотоор тэмдэглэх аргаар заадаг байсан учир би зарим нарийн юмыг нь сайн ойлгохгүй гэвддэг сэн. Багш бидэнд юм мэдүүлж, ойлгуулахыг их л чармайсан даа. Тэр үед сурсан юм одоо марш, хөгжим бичихэд маань хэрэг болж байна. Кун Юү багшийн тэр үеийн шавь нараас гадаадад явж сураагүй нь Н.Дагва-Осор бид хоёр л юм даа” хэмээн дурсаж билээ. Хурандаа Н.Цэрэнпил гуай авьяас билигтэй хүн учир монгол цэргийн хөгжмийн урын санг цоо шинээр үндэслэж, ялангуяа цэргийн марш 112-ыг зохион хөгжимдүүлж ард түмэндээ “маршийн хаан” гэж хүндлэгдсэн уран бүтээлч хүн байсан юм.

Шянь Шинхайн монгол шавь Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн нар Москва, Ленинграддад сурсан, Б.Дамдинсүрэн хожим Бээжингийн консерваторт



THE CULTURAL WAY

суралцсан, хоёулаа БНМАУ-ын Төрийн хошой шагналтан, Ардын жүжигчин, монголын орчин үеийн хөгжмийн урлагийг үндэслэгчид. Лха.Дорж, Т.Чимэддорж нар Шанхайн консерватор төгсгөсөн, нэрт зохиолчид байсан. Т.Чимэддорж БНМАУ-ын гавьяат зүтгэлтэн цолтой, Монголын радиогийн хөгжмийн ерөнхий редактор байсан хүн хэмээн П.Хаянхярваа багш дурсаж, Шянь Шинхай бол монгол, хятадын ард түмний хөгжмийн соёлын харилцааг өргөжүүлж, алдарт бүтээл “*Шар мөрний тухай кантат*” – аараа монголын ард түмэнд танил болж, зүрх сэтгэлд нь мөнхөрсөн гавьяатай хүн мөн¹⁸ гэж дүгнэсэн билээ.

ДҮГНЭЛТ

Хятадын хөгжмийн нэрт зохиолч Шянь Шинхай бол ХХ зууны эхний хагасын хөгжмийн урлагт тодорхой ул мөрөө үлдээсэн, шинэ үеийн өндөр боловсрол, мэдлэгтэй сэхээтэн бөгөөд өөрийн ухамсарт амьдрал, уран бүтээлээ хятадын нийгмийг шинэчлэх зорилго, японы эзэрхэн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэх ард түмэн, ХКН-ын ариун шудрага үйл хэрэгт тууштай зориулсан, үүгээрээ хятадын ард түмэнд хайрлагдан хүндлэгдсэн эрхэм уран бүтээлч мөн.

Шянь Шинхайн уран бүтээлд голлох байрыг эзэлсэн бүтээл бол “Хатан голын магтуу” буюу “Шар мөрний кантат” бөгөөд хөгжмийн ертөнцөд арилшгүй мөрөө үлдээжээ.

Шянь Шинхай Монголд ажиллаж, амьдарч байх хугацаандаа хятад улсын хөгжмийн соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг нэлээд хийсний үр дүн өнөө хэр дурсагдсаар байгаа нь түүнийг үнэ цэнтэй амьдарч байсныг нь гэрчилж байна.

ABSTRACT

Xianxinghai (1905-1945) Chinese composers. Huang Xun had names, hole Yu, Guangdong Panyu, was born in Macau, the family of seafarers. Lingnan University Foundation has, Beijing Art school music specialist, Shanghai and Paris National Conservatory of Music to study music. 1935 returned to participate in the anti-Japanese national salvation music. 1938 Yan'an, the following year appointed Head of the Department of Lu Xun Art Institute of Music and joined the Chinese Communist Party. (Lsjt.org) 1940, he went to Yanan Soviet Union for shooting video in the "Yan'an and the Eighth Route Army" soundtrack. In the same year in Mongolia Mongolian musicians with many learning and life, Mongolia and China and Mongolia International Friendship music play a very important role as a bridge, 1945 Died in Moscow.

Works with "Yellow River Cantata", "production of large sets to sing" and four, the song "Song of Salvation", "To go behind enemy lines", "guerrilla war song," "In the Taihang Mountains" and other five hundred or so (the existing two hundred fifty more than the first), Symphony "national liberation" and "Holy war", Symphonic

¹⁸ <http://www.analiz.mn/postview/5055>



THE CULTURAL WAY

Suite "Azolla" and four, orchestral "Chinese Rhapsody", and solo music, solo and other dozens of first. Following NieEr, after he, to a wider range of topics, genres and more rich artistic performance of the Chinese people's liberation struggle, the country encouraged anti-Japanese army played a role in his masterpiece "The Yellow River Cantata" is particularly wide impact.

Keywords: *Great, Yellow River, Cantata excellent, artistic, characteristics of creative motivation*

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх ном сэтгүүл

1. Мао Дун. Зохиолын эмхтгэл. 12-р боть. Ардын утга зохиолын хэвлэх хороо, Бээжин, 1986 он.
2. Нэрт хүмүүсийн хэлсэн үг, Шанхайн хэвлэлийн хороо, 1985 он.
3. Шянь Шинхайн өдрийн тэмдэглэл, Бээжин, 1978 он.

Хятад хэлээрх ном сэтгүүл

1. 何乃强 (1 September 2013). [洗星海在新加坡十年 1911-1921: 历史补遗 谬误纠正](#).
2. [毕星星: 音乐大师洗星海的登民身份 评论频道 凤凰网](#). *news.ifeng.com*. Retrieved 26 March 2018.

Англи хэлээрх ном сэтгүүл

1. [Appiah \(ed\), Kwame Anthony](#); Henry Louis Gates, Jr. (1997). [The Dictionary of Global Culture](#). New York, NY: Alfred A. Knopf. pp. 703
2. Symphony No. 1 "Liberation of the Nation" Op. 5 (1935/1941)
3. Symphony No. 2 "Holy War" Op. 17 (1943)
4. Smith, Nicholas (20 September 2003). ["Conductor's Notes: Xian Xinghai Yellow River Cantata"](#). *Beijing International Festival Chorus program 20 September 2003*. Beijing International Festival Chorus. Retrieved 27 August 2010.
5. ["Xian Xinghai"](#). *icm.gov.mo*. Retrieved 17 March 2019.

Цахим холбоос

1. <https://www.sin80.com/en/work/yellow-river-cantata>
2. <https://www.sin80.com/en/artist/xian-xinghai>
3. https://en.wikipedia.org/wiki/Guang_Weiran
4. https://en.wikipedia.org/wiki/Yellow_River_Cantata
5. <http://www.analiz.mn/postview/5055>
6. https://en.chncpa.org/production/productions/repertoire/JM/202112/t20211207_238766.shtml
7. http://www.jameschingmusicnotes.co.uk/html/xian_xinghai_yellow_river_pian.html

**МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ДЭЭД
БОЛОВСРОЛЫН ОРЧНЫ /P.E.S.T.L / ХАРЬЦУУЛАЛТ**

Ц.Түвшинбаяр*

ХУРААНГУЙ

Дэлхийн ба бүс нутгийн шилдэг сургуулийн хүрээнд багтах нь сургуулийн нэр төр, хөгжлийн төвшингийн үзүүлэлт төдийгүй тухайн улсын хөгжийн төвшинг илэрхийлж байдаг. Иймд нийгэм-иргэншил-даяарчлалын шинэ эрин түрэн орж ирсэнтэй холбогдуулан, Монгол Улсын дээд боловсролын тогтолцоог олон улсын туршлагад үндэслэн өөрийн улсын онцлогт нийцүүлэн шинэчлэн сайжруулах асуудлыг судлах, тэр дундаа Монгол- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын стратегийн түншлэлийн харилцаа, Бүгд Найрамдах Хятад ард улсын Засгийн газрын тэтгэлгийн тоо 1000-аар нэмэгдүүлсэн зэрэг манай хоёр улсын эдийн засаг, улс төрийн харилцаа өргөжин тэлж байна. Иймд тус улсуудын боловсролын тогтолцоо, туршлагыг зайлшгүй судлах шаардлагатай байна.

Монгол улс, БНХАУ-ын дээд боловсролын тогтолцоо, дээд боловсролын орчны харьцуулсан судалгаа-Р.Е.С.Т.Л харьцуулалт хийж судлахыг зорьсон. Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол, БНХАУ-ын дээд боловсролын тогтолцооны онцлог;
- Монгол, БНХАУ-ын дээд боловсролын орчны харьцуулсан судалгаа- Р.Е.С.Т.Л харьцуулалт

Түлхүүр үгс: *Дээд боловсрол, Улс төр, Эдийн засаг, Нийгэм, Технологи, Хууль эрх зүй*

Үндсэн хэсэг

Монгол Улс	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<i>Улс төрийн нөхцөл байдал</i>	
Улс төрийн тогтвортой байдлын хувьд Монгол Улсын Их Хурал дөрвөн жил тутамд сонгогддог бөгөөд ерөнхийдөө улс төрийн томоохон хоёр намын дунд сонгууль өрнөдөг. Төрийн бодлогын залгамж чанар хадгалагддаг хэдий ч төрийн	Хятадад боловсролын систем босоо удирдлагатай. Тус улс “211 төсөл” гэх хөтөлбөрийг хэрэгжүүлж 100 сургуулийг сонгон анхааралдаа авчээ. Энэ 100 сургууль нь Хятадын боловсролын яаманд

* ДХИС, ЭЗНУС-ийн багш, цагдаагийн дэслэгч



THE CULTURAL WAY

албаны тогтвортой байдал муу байх хандлагатай. Энэ нь боловсролын салбарт дараах байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайлбал:

- Холбогдох яам, тамгын газар, төрийн албаны мэргэжилтэн, удирдах албан тушаалтны ажлын байр намын томилгооны улмаас тогтворгүй болох,
- Дээрхээс үүдэн аливаа ажил, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт цалгардах,
- Шийдвэр гаргалт удаашрах гэх мэт

Боловсролын салбарын зорилгыг шийдвэрлэх үүднээс тухайн үеийн нөхцөл байдал болон Засгийн газрын боловсролын салбарын бодлогоос хамаарч олон янзын үзэл баримтлал боловсруулагдсан байдаг. Үүнд:

Төрөөс боловсролын талаар

баримтлах бодлого /2014-2024 он /

Тус бодлогын баримт бичиг нь 7 бүлэгтэй.

1. Нийтлэг үндэслэл:

1.1. Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

1.2. Боловсролын салбарт үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхийг зорилгоо болгосон.

2. Боловсролын хөгжлийн талаар баримтлах зарчим

3. Боловсролын хөгжлийн стратеги, удирдлага,

харьяалагддаг бөгөөд удирдлагууд нь шийдвэр гаргахдаа бусад сургуулиудаас давуу эрх эдэлдэг байна.

Өөрөөр хэлбэл эдгээр сургуулийг улс орны хөгжлийг тодорхойлно гэж үзэж хөгжүүлж иржээ. “211 төсөл” нь Хятадын дээд боловсролын 100 институтийг бэхжүүлж, 21 дүгээр зууны үндэсний тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр юм. Төслийн хүрээнд 112 их сургууль байдаг.¹

“211 төсөл”-ийг хэрэгжүүлснээр Хятадын засгийн газраас нийгэм, эдийн засгийн хөгжилд ахиц дэвшил гаргахын тулд дээд боловсролын хөгжилд дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчнийг сургахад чиглэсэн уг төсөл нь дээд боловсролыг сайжруулах, үндэсний эдийн засгийн өсөлтийг хурдасгах, шинжлэх ухаан, технологи, соёлыг хөгжүүлэх, Хятад улсын ерөнхий чадамжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Таван жилийн төлөвлөгөөний хугацаанд Засгийн газар их, дээд сургуулиудын тоо болон голлох салбар сургуулиудын үйл

¹ <https://www.chinaeducenter.com>



THE CULTURAL WAY

зохион байгуулалт 3.6-д дээд болон мэргэжлийн боловсролын хөгжлийн стратегийг тодорхойлсон байна.

4. Боловсролын агуулга, стандарт, сургалтын технологи, чанарын үнэлгээ
Тус бүлгийн 4.11-4.13 заалтуудад дээд боловсролын агуулга, чанарын тогтолцоог боловсронгуй болгох тухай оруулж өгснөөр боловсролын салбарын бодлого боловсруулалтанд эерэг нөлөө үзүүлэх хандлагатай байна.

5. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоо

6. Боловсролын тогтвортой хөгжүүлэх эдийн засаг, санхүүжилтийн тогтолцоо

7. Боловсролын салбар дахь хамтын ажиллагаа,

бодлогын хэрэгжилт, үнэлгээ, шалгуур

“Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

Тус хөтөлбөрт дээд боловсролын салбарт хэрэгжих 9

зорилт /3.2.18-3.2.26/ батлагдсан.

Үүнд:

1. Дээд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгох
2. Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх
3. Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог

хөгжүүлэх

ажиллагааг бэхжүүлэх талаар арга хэмжээ авах болно. Үүнээс гадна эдгээр байгууллагуудын удирдлагын тогтолцоог шинэчлэх, улмаар өндөр түвшний мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, эдийн засгийн бүтээн байгуулалт, нийгмийн хөгжилд тулгарч буй томоохон асуудлуудыг шийдвэрлэхээр зорьжээ. Тэдний дийлэнх нь хүний нөөцийн сургалт, эрдэм шинжилгээний судалгааны ололт амжилтаас гадна тэдний нөхцөл байдал, ажилтнуудын чадварыг дээшлүүлэх болно. Бүс нутгийн болон салбарын хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн эдгээр байгууллагууд гол гүйцэтгэх үүрэг хүлээнэ. Мөн “985 төсөл”² нь БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлсэн 21-р зуунд дэлхийн түвшний их сургуулиудыг байгуулахад чиглэсэн төсөл юм. 1998 оны 5-р сарын 4-нд Ерөнхийлөгч Жман Зэмин “Хятад улс олон улсын шилдэг их сургуулиудын жагсаалтыг тэргүүлэх ёстой” хэмээн мэдэгдэж байсан ба улмаар “985 төсөл”-ийг эхлүүлсэн. Эхний үе шатанд 9 их сургуулийг хамруулсан. 2004 онд эхлүүлсэн 2 дахь үе шат нь 39 их сургуульд хүрэх хөтөлбөрийг өргөжүүлсэн байна.

² <https://www.chinaeducenter.com>



THE CULTURAL WAY

<p>4. Стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх</p> <p>5. Багш, оюутны хөгжил, нийгмийн баталгааг хангах зэрэг болно.</p>	
<i>Эдийн засгийн нөхцөл байдал</i>	
<p>Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2017 оны байдлаар 5.1%, ДНБ 27.2 их наяд төгрөг гэсэн үзүүлэлттэй байна.³</p> <p>Дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн гол эх үүсвэр боловсролын зээлийн сангаар олгож байсан үндэсний тэтгэлэг /2015-2016/ болон оюутны хөгжлийн зээл /2017-, 2018/, гадаад, дотоодод суралцагчдын сургалтын төлбөр, тогтмол зардлаас бүрдэж байна. Мөн төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан багш нарын чадавхжуулах, сургалт, судалгааны орчны хөрөнгө оруулалтууд, судалгааны чадавхыг бэхжүүлэх, их дээд сургууль- аж үйлдвэрлэлийн түншлэлийг дэмжих, оюутны бүтээлч санал санаачилгыг дэлгэрүүлэх санхүүжилтүүд хийж байна.</p> <p>Энд онцлон дурдвал Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд 12.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр шинээр 18 лаборатори, 1.6 тэрбум төгрөгөөр 60 судалгааны төсөл, 351 сая төгрөгөөр 117 оюутны төслийг санхүүжүүлсэн. Японы засгийн газрын буцалтгүй</p>	<p>Улсын төсвийн хуваарлалт нь Хятадын боловсролын санхүүжилтийн гол эх үүсвэр юм. Боловсролын салбарын санхүүжилтийг Хятадын төвийн болон орон нутгийн төсвийн сангаас зохицуулдаг. Энэхүү зохицуулалт нь Боловсролын тухай хуулийн 54 дүгээр зүйлд зааснаар төрөл бүрийн нөөцийг дайчлахыг хөхүүлэн дэмжих бодлоготой нийцэж байгаа юм. Ерөнхийдөө, Хятадын боловсролын салбарын нийт зарлага жилээс жилд өсөхийн хэрээр төсвийн боловсролын зардлыг хувь хэмжээ аажмаар нэмэгдэж байна. Статистикийн мэдээнээс харахад Боловсролын нийт зардал 981530.87 сая юаниас давсан байна. 2014 онд 3280646.09 сая юань болж, 2014 онд төсвийн боловсролын зардал нь 0062642058.20 сая юань, 634836.48 сая юаниас 4 дахин их байсан байна. Үүнээс гадна төсвийн зардлын хувь нь 64.678%-иас 80535% болж</p>

³ Азийн хөгжлийн банкны “Азийн хөгжлийн төсөв 2017” тайлан



THE CULTURAL WAY

<p>тусламж 174 тэрбум төгрөгөөр АШУҮИС-ийн сургалтын эмнэлэг баригдсан зэргийг нэрлэж болох юм.</p> <p><i>Татварын орчин-</i> Татварын тухай хуулиар зохицуулдаг Татварын төрлөөс хамаарч хөнгөлөлт, урамшуулал олгодог. Өөрөөр татвараа үнэнчээр тайлагнах систем давамгайлж байна.</p> <p><i>Хөдөлмөрийн зах зээл – Их,</i> дээд сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 2017-2020 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 32.2 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон гэсэн статистик тоо баримт байдаг. Энэ үзүүлэлт өмнөх жилтэй харьцуулахад 1.3 пунктээр өсжээ. Докторант төгсөгчид бараг бүхэлдээ /98.2%/, магистрантур төгсөгчдийн 74.8 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 26.9 орчим хувьтай байна. Ажил эрхэлж буй нийт 1128447 иргэд 53.1% бол 104438 ажилгүй иргэд буюу ажилгүйдлийн түвшин 4.9% байна.⁴</p>	<p>өөрчлөгдсөн бөгөөд энэ нь тус улсын засгийн газар чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг харуулж байна.</p> <p>БХНАУ 2016 онд боловсролын салбарт 3.9 их наяд юань /565.6 тэрбум ам доллар/ зарцуулсан нь 2015 оноос 7.57 хувиар өссөн гэж тус улсын Боловсролын яамнаас гаргасан урьдчилсан статистик мэдээнээс харж болно.⁵ Боловсролын 3 түвшингийн хувьд Засгийн газрууд хөдөлмөрийн өндөр чанар, технологийн дэвшлийг бий болгохын зэрэгцээ улс орны нийтлэг хөгжлийг дэмжихийн тулд дээд боловсролын салбарт илүү анхаарч байна. Ерөнхийдөө бага сургуулийн боловсрол нь боловсролын тогтолцооны үндэс суурь хэвээр байна. Бага дунд боловсрол эзэмших хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бага боловсрол дахь засгийн газрын хөрөнгө оруулалтыг давамгайлах шаардлагатай.</p>
<i>Нийгмийн хүчин зүйлс</i>	
<p>- Хэрэглэгчдийн төлөв байдал: - Монгол улс даяар их, дээд сургуульд 150 мянган оюутан суралцаж байна.⁶</p>	<p>- Хэрэглэгчийн төлөв байдал: 1970 оноос хэрэгжиж эхэлсэн “Нэг хүүхэд” бодлоготой холбоотойгоор эцэг</p>

⁴ Үндэсний Статистикийн Хороо, Ажиллах хүчний судалгааны 2022 оны 1 дүгээр улирал товч танилцуулга 13- тал

⁵ <http://www.chinadaily.com.cn/china/2017-05/04/conntent>

⁶ Боловсролын шинжлэх ухааны яам “Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн таницуулга” 2020-2021



THE CULTURAL WAY

<ul style="list-style-type: none"> - Амьдралын хэв маяг: Хэдийгээр нүүдлийн соёл иргэншил, хөдөө аж ахуйд түшиглэсэн амьдралын хэв маягтай ч нийслэл Улаанбаатар хотод залуучууд ихтэй, дунд сургуулиа төгссөн нийт төгсөгчдийн дундаас ихэнх хувь нь их сургуульд элсэн ордог бол үлдсэн хувь нь коллеж гэх мэт өөр өөр амьдралын хэв маягаас шалтгаалан янз бүр байна. - Хүн ам зүйн үзүүлэлт: - Монгол улсын нийт хүн амын 64.67% нь 35 хүртэл насны залуучууд эзэлж байгаагаас 150 мянга нь буюу 0.7% нь их дээд сургуульд суралцаж байна. 	<p>эхчүүд хүүхдээ дээд боловсролтой болгохыг эрмэлзэх болсноор боловсролын салбарын эрэлт ихсэж, салбарын шинэчлэлтэд эерэг нөлөө үзүүлэх нэгэн хүчин зүйл болсон.</p> <ul style="list-style-type: none"> - Амьдралын хэв маяг: суурин амьдралын хэв маягтай, гэр бүлийн халуун дотно харилцааг эрхэмлэдэг. - Хүн ам зүйн үзүүлэлт: хятад улс хүн амын үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх буюу тэрбум 300 сая хүнтэй. Үүнээс: 2016 оны 42.7% нь их, дээд сургуульд хамрагдсан байна.
<p><i>Технологийн хүчин зүйлс</i></p>	
<ul style="list-style-type: none"> - Технологийн хөгжил: Монгол улсын үйлдвэрлэл төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд техник технологийн ихэнх хувийг гадны улсын технологийг худалдан авч хэрэглэдэг. - Интернет, гар утас хэрэглээ- Харилцаа холбоо, Мэдээлэл технологийн газраас явуулсан судалгаагаар Монгол улсад 3 хүн тутмын 2 нь интернет хэрэглэгч бөгөөд 100 хүнд оногдох хөдөлгөөнт интернет хэрэглэгч 57.9 хувь байна. Мөн “We Are Social” компаниас гаргасан “2016 Digital 	<ul style="list-style-type: none"> - Технологийн хөгжил: Хятад улс одоо 13 дахь 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа ба энэ хугацаанд дундаж хэмжээний инновацилаг орон болж хөгжин шинжлэх ухаанаараа дэлхий 15-д / одоо 18-д байгаа/ бичигдэх томоохон зорилт дэвшүүлсэн. Төрийн бодлого, зорилт, зохицуулалтаараа хувийн хэвшлийн компаниудад шинжлэх ухаан, инновацын хөгжилд



THE CULTURAL WAY

<p>Yearbook” рапортод багтсан Монгол Улсын интернэт, Facebook, Twitter, Instagram зэрэг социал медиа, гар утасны хэрэглээний талаарх судалгаагаар идэвхтэй интернэт хэрэглэгч 1.3 сая гарсан байна. Өнөөгийн нийгэмд оюутан залуус хичээл, судалгааны ажилдаа дэвшилтэт технологи, социал медиаг түлхүү ашиглах болсон.</p>	<p>зориулан жилд зарцуулж буй 410 тэрбум ам долларын 22% орчим буюу 103 тэрбум ам долларыг нь зориулдаг юм байна.</p> <ul style="list-style-type: none"> - Интернэт, гар утас хэрэглээ: “We Are Social” компаниас гаргасан “2016 Digital Yearbook” рапортод БХНАУ-ын 688 сая иргэн буюу 49% нь интернэт ашигладаг, Facebook, Twitter, Instagram зэрэг социал медиа, гар утасны хэрэглээний талаарх судалгаагаар идэвхтэй интернэт хэрэглэгч 653 сая социал медиа хэрэглэгч 577 сая, гар утас хэрэглэгч давхардсан тоогоор 1.314 сая хэмээн гарсан байна.⁷
<p><i>Хууль эрх зүйн хүчин зүйлс</i></p>	
<p>Боловсролын байгууллагын үйл ажиллагаа нь Монгол улсын хууль, тогтоомжийн хүрээнд явагддаг. Жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"> - “Боловсролын тухай” хууль нь 2002 оны 5 дугаар сарын 03-ний өдөр батлагдсан, 7 бүлэг, 48 зүйлтэй. <p>Хуулийн зорилт:⁸ Энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга,</p>	<p>Боловсролын байгууллагын үйл ажиллагаа нь БХНАУ-ын хууль, тогтоомжийн хүрээнд явагддаг. БХНАУ-ын Боловсролын тухай хууль нь 1995 онд батлагдсан бөгөөд 10 бүлэг 84 зүйлтэй.</p> <p>Хуулийн зорилго: Боловсролыг хөгжүүлэх бүх үндэстний чанарыг сайжруулах, социалист материаллаг болон</p>

⁷ 2022 Digital Yearbook

⁸ Боловсролын тухай хууль, 1 дүгээр зүйл



THE CULTURAL WAY

удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

Боловсролын зорилго: Монгол улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино хэмээн заасан байдаг.

“Дээд боловсролын тухай” хууль мөн 2002 оны 5 дугаар сарын 03-ний өдөр батлагдсан байх бөгөөд 9 бүлэг, 20 зүйлээс бүрдэнэ.

Хуулийн зорилт ⁹: Энэ хуулийн зорилт нь иргэнд дээд боловсрол олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Дээд боловсролын зорилго: Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино хэмээн заасан байдаг.

соёл иргэншлийн бүтээн байгуулалтыг хурдасгах, БНХАУ-ын Үндсэн хуульд нийцүүлэн хөгжүүлэх.¹⁰

Боловсролын зорилго: Социалист тогтолцоог шинэчлэн хөгжүүлэх, үйлдвэрлэлийн болон хөдөлмөр эрхлэлттэй хослуулан хөгжүүлэх, социалист нийгмийн ёс зүй, ёс суртахуун, оюун ухаан, бие бялдрын бүх шатанд хөгжин хөгжүүлэгчдийн хэрэгцээг хангах.¹¹

- БНХАУ-ын Дээд боловсролын тухай хууль 1998 онд батлагдан, 1999 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 8 бүлэг, 69 зүйлээс бүрдэнэ.

Хуулийн зорилго: Дээд боловсролыг хөгжүүлэх, Үндсэн хууль, Боловсролын тухай хуулийн дагуу шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлж, социалист материаллаг болон ёс суртахууны ахиц дэвшлийг хөгжүүлэн дэмжих.¹²

Дээд боловсролын зорилго: Дээд боловсролыг төрийн боловсролын зарчимд нийцүүлэн, социалист орчин үеийн болгох хөтөч, үр бүтээлтэй хөдөлмөртэй хослуулан явуулна.¹³

⁹ Боловсролын тухай хууль, 1 дүгээр зүйл

¹⁰ БНХАУ-ын Боловсролын тухай хууль, 1 дүгээр зүйл

¹¹ БНХАУ-ын Боловсролын тухай хууль, 5 дугаар зүйл

¹² БНХАУ-ын Боловсролын тухай хууль, 1 дүгээр зүйл

¹³ БНХАУ-ын Боловсролын тухай хууль, 4 дүгээр зүйл



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

Дэлхий ертөнц хурдан өөрчлөгдөж, нийгэм суурь өөрчлөлтүүдтэй тулгарч байна. Өнөөдөр энэ өөрчлөлтийг соргоогоор мэдэрч, мэдлэгийн нийгмийн эрэлт хэрэгцээг хангах чадварлаг, төлөвшсөн мэргэжилтэнг бэлтгэх нь их дээд сургуулиудын үүрэг юм. Хэдийгээр энэ салбарт зуугаад их дээд сургууль, түүний дотор магадлан итгэмжлэгдсэн 64 их, дээд сургуулиуд үйл ажиллагаа явуулж байгаа боловч төгсөгчдийн дөнгөж 40% нь сурсан мэргэжилтэйгээ холбоотой ажил хөдөлмөр эрхэлж байна. Удаа дараагийн судалгааны дүнд төгсөгчдийн ажил эрхэлж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь мэргэжлийн төвшин, ур чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахгүй байгаа явдал юм. Энэ нь манай дээд боловсролын сургалтын мөн чанар, арга зүй, менежмент цаг үеийн өөрчлөлтийг мэдэрч, хурдтай шинэчлэгдэхгүй байгаатай холбоотой. Энэ асуудал зөвхөн Монголын төдийгүй дэлхийн олон улс орны асуудал болоод байна.

Хятад улсын дээд боловсролын салбарын жишээнээс харахад чанартай боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай нэг хүчин зүйл нь санхүүжилт хангалттай байх явдал байна. Судалгаанаас харьцуулахад хэдий хоёр улсын эдийн засгийн чадавх ондоо ч зарцуулалтын үр ашгийн хувьд манай улс өгөөж муутай зарцуулалт хийж байна.

Санал, зөвлөмж

Дээрх харьцуулсан судалгаандаа үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Их, дээд сургуулийн хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах. Нэг салбар тэнхимийн багш нар заах хичээлийн агуулга дээр хамтарч ажиллах, судалгаа хийдэг болсноор тус хичээлүүдийн хоорондын агуулга илүү сайжирна.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, мэдээллийн тогтолцоог бий болгох, ингэснээр аль нэг салбарт хэт их боловсон хүчин бэлтгэгдэн гарахаас зайлсхийх боломжтой.

ABSTRACT

Being included in conditions one of the best universities is the honor and indicator of the development level of the university, it also refers to the country's development. By this description relating to the new era of society-civilization-globalization, we need to study and update the framework of cooperation between Mongolia and the people's republic of China. Also, to develop and study, based on international experience, Mongolia's higher education system according to our country's characteristics. The people's republic of china has increased the number 1000 of their scholarships. As a result, the cooperation of strategic



THE CULTURAL WAY

relationships between Mongolia and China has expanded. Therefore, we need to study about higher education systems of the two nations.

This research aims to study about higher education systems of the two nations, using comparison research P.E.S.T.L on the environment of higher education systems. To reach that goal we bring out these objectives. It includes:

- *Mongolia and The People's Republic of China's higher education systems' specific characteristics,*
- *Mongolia and The People's Republic of China's comparison research P.E.S.T.L on the environment of higher education systems*

Keywords: *higher education, politics, economy, society, technology, law*

НОМ ЗҮЙ

Ном, сурах бичиг

1. Стратегийн судлагааны хүрээлэн, Стратегийн судалгаа сэтгүүл ., УБ хот., 2022 он
2. Боловсрол Үндэсний хөтөлбөр 2010-2021 он
3. Боловсролын тухай хууль
4. БНХАУ-ын Боловсролын тухай хууль
5. Азийн хөгжлийн банкны “Азийн хөгжлийн төсөв 2017” тайлан
6. Үндэсний Статистикийн Хороо, Ажиллах хүчний судалгааны 2022 оны 1 дүгээр улирал товч танилцуулга 13- тал
7. Боловсролын шинжлэх ухааны яам “Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн таницуулга” 2020-2021

Интернет эх сурвалж

1. <https://www.chinaeducenter.com>

БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛД

Л.Одзаяа*

ХУРААНГУЙ

Тус өгүүлэлд бүтээлч сэтгэлгээний онолын үндэслэл түүний ач холбогдол, бүтээлч сэтгэлгээ ба шүүмжлэлт сэтгэлгээний ялгаатай талууд, бүтээлчээр унших, бичих чадварыг судалсан болно.

Түлхүүр үгс: *Бүтээлч сэтгэлгээ, арга зам, шийдэл, зөвлөмж*

Нэг. Бүтээлч сэтгэлгээ гэж юу вэ?

Ардчилсан нийгэм хөгжихийн хэрээр залуучууд бие даан асуудлыг шийдвэрлэх, нөхцөл байдалд шүүмжлэлтэйгээр дүн шинжилгээ хийх, альтернатив саналыг тунгаан бодох, ухаалаг, өргөн цар хүрээтэй шийдвэр гаргах чадвартай байх нь улам чухал болж байна. Энэ нь бүтээлч сэтгэлгээний нийгмийн үндэс юм.¹ Бүтээлч сэтгэлгээ гэдгийг боловсрол, танин мэдэхүй, сэтгэл зүй, гүн ухаан хөгжлийн ололт, үр дүнд тулгуурлан янз бүрийн өнцгөөс тодорхойлсон байдаг. Бүтээлч сэтгэлгээ гэдэг нь ямар нэгэн асуудлыг шинэлэг байдлаар болон олон хувилбартай ухаалгаар шийдвэрлэх үйл явцын үр дүн. Өөрөөр хэлбэл бодол санаа ба сэтгэхүйн нөөцийг бүтээлч байдалтай холбон үзэх ерөнхий төсөөлөл ба мэдээллээс шинэ санаа авч ургуулан бодох сэтгэхүйн цогц үйл явц юм.

Бүтээлч чанар нь зохион бүтээх чадвар, шинэлэг байдал, аливааг өөр өнцгөөс харах чадвар болон ойлголтуудыг өвөрмөц аргаар нэгтгэх чадваруудын цогц шинж юм. Бүтээлчээр сэтгэх ур чадвар гэдэг нь асуудлыг янз бүрийн бүтээлч өнцгөөс харж, оновчтой шийдвэрийг ашиглан дүгнэж, төлөвлөгөө боловсруулахад ашигладаг арга техник юм. Бүтээлч сэтгэлгээ нь мэдээллийг шүүн тунгаах идэвхтэй үйл ажиллагаа учраас олон төрлийн мэдээллийг нэгтгэн дүгнэх, мэдээлэлд бүтээлчээр хандаж оновчтой үнэн зөв мэдээллийг сонгон авах чадвартай байх нь чухал.

Бүтээлч сэтгэлгээ нь одоо байгаа мэдээлэлд үндэслэн илүү ихийг мэдэж, шинэ шинэлэг санааг олж нээх үйл явц юм. Ихэнхдээ бүтээлч сэтгэлгээ нь сэтгэлгээний янз бүрийн хэв маягт нэвтэрч, мэдээллийг өөр өөр өнцгөөс

* ДХИС, ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, хошууч.

¹ Лавай. Эрдэм шинжилгээний бичиг. УБ.,2016. №17 т 213



THE CULTURAL WAY

судалдаг. Бүтээлч сэтгэлгээ гэдэг нь бусадтай адилхан бус өөр өнцгөөр харж чаддаг байх юм. Гэхдээ энэ нь өөр байх тухай биш өөр талаас нь <шийдэл> гаргаж чаддаг байх чадвар. Бүтээлч сэтгэлгээний талаар эргэцүүлэн бодоход нэг зүйл шиг боловч цаана нь олон чадвар ажилладаг гэдгийг л хэлмээр байна. Ингээд бүтээлч сэтгэлгээнд байх хэрэгтэй чадваруудын тухай өгүүлье. Сониуч зан, бусдын оронд өөрийгөө тавих, төсөөлөн бодох чадвар, тав тухтай орчноос гарах, олон хүмүүсийн хүчээр ажил гардаг, хоббитой байх, аналитикал чадвар, open minded- асуудалд нээлттэй ханддаг байх, коммуникаци, сахилга баттай байх, зөвхөн өөртэйгөө байх цаг гаргах явдал юм.

Бүтээлч сэтгэлгээний ач холбогдол

- Бидний амьдралд үнэ цэнийг өгдөг өдөр тутамд *хамгийн сайн шийдлийг бий* болгох чадвар.
- Хичээл сургалттай холбоотой асуудлууд төдийгүй хувийн амьдралын *асуудлыг шийдвэрлэх арга* барилыг сайжруулдаг.
- Өдөр тутмын сургалтын үйл ажиллагаа, амьдарлын хэв маягын *идэвхтэй оролцоо*.
- Таны хүрээлэлд буй хүмүүс зөөлөн ур чадвараа буюу хувийн ур чадвараа үргэлж сайжруулж хөгжүүлж байдаг тул *өөрийгөө сайжруулахад* анхаарлаа хандуулахад тусалдаг.
- Бүтээлч хүмүүс шинэ боломжуудыг эрэлхийлдэг эсвэл асуудал шийдвэрлэхдээ нэгээс илүү шийдлийг олж харах чадвартай байдаг.²

Бүтээлч байдал ба Сэтгэл санаа

Туршилтын явцад сэтгэл санаа эерэг байхын хэрээр “дивергент сэтгэлгээ”-ний даалгаварууд дээр өндөр оноо авч байжээ. Асуудлыг шийдвэрлэх явцад бэрхшээлтэй тулгарахад бид гунигтай, ууртай, бухимдсан байдалд орох нь амархан байдаг. Тиймээс “түр завсарлага” авах нь үр дүнтэй. Ийм үед сэтгэл санааг өргөх хөгжилтэй үйл ажиллагаанд оролцож яагаад болохгүй гэж. Сэргэж, хүч чадал орсоныхоо дараа асуудал шийдвэрлэх үйл явц илүү амжилттай болно.³

Бүтээлч сэтгэлгээ ба тархины уян хатан чанарын хоорондын холбоо

² Өдрийн сонин. 2021.03.12

³ Өдрийн сонин. 2021.03.12



THE CULTURAL WAY

Тархины уян хатан чанар нь тархины хамгийн онцлог шинж чанаруудын нэг бөгөөд энэ эрхтэн нь морфологи, үйл ажиллагааны хувьд шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадвартай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, хүний тархи бидний мэдэрч буй туршлагаас хамаарч байнга өөрчлөгдөж байдаг. Энэ нь бүтээлч байдалтай ямар холбоотой вэ?

Тархины уян хатан чанар өөрчлөгдөх нь бидний сэтгэлгээг шинэ асуудалд хурдан дасан зохицох боломжийг олгодог нейронууд бидний эргэн тойронд байгаа зүйл, бидний тэр үеийн дурсамж гэх мэт зүйлээс хамааран харилцан холболтын хэлбэрээ өөрчилдөг тул урьд өмнө хэзээ ч байгаагүй оюун санааны замыг сонгосон байдаг.

Бүтээлч сэтгэлгээг хэрхэн хөгжүүлэх вэ?

Зогсонги байдал нь байнгын өдөөлтийг шаарддаг тул таны бүтээлч байдал хамгийн том аюул учруулж болзошгүй юм.

Янз бүрийн контент хэрэглэх

Үүний жишээ бол та интернетийн өргөн сонголттой агуулгын төрлийг ашиглах боломжтой. Тухайлбал блог, юутүб суваг, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зочлохыг хичээгээрэй. Энэ нь таны ихэвчлэн хэрэглэдэггүй сэдвүүдтэй холбогдож өгдөг.

Чиг хандлагыг дагаж мөрдөх

Таны бүтээлч сэтгэлгээний ихэнх хэсэг нь өнөөгийн нөхцөл нөлөөлж байгаа мөн *ирээдүйд гарч ирэх чиг хандлагад* нөлөөлөх болно. Тиймээс асуудлыг шийдвэрлэх байр суурьтай байх нь бүтээлч сэтгэлгээний анхны санаа гаргахад маш чухал юм.

Өдөр бүр ямар нэгэн зүйлийг бүтээх гэж хичээх

Зорилгынхоо дагуу өдөр бүр шинэ зүйл бүтээхийг хичээгээрэй. Энэ нь том эсвэл чухал зүйл байх албагүй, зүгээр л *таны мэдэж буй бүх шинэ мэдээллүүдээс үүсэлтэй шинэ зүйл юм.* Ийм бүтээлүүд нь танд болон таны хүрээлэлд тулгардаг өдөр тутмын асуудлыг шийдэх шийдэл болж чадна.

Бүтээлч байдлын сүлжээг бий болгох

Үе тэнгийнхэнтэйгээ харилцах нь *бүтээлч чадвараа хөгжүүлэх* сайхан арга юм. *Бүтээлч сэтгэлгээний ур чадварыг ухамсарлахын тулд байнгын бэлтгэл сургуулилт хийх нь шинэ санааг бий болгох эхний алхам юм.*

Шүүмжлэлт сэтгэлгээ ба бүтээлч сэтгэлгээ

Шүүмжлэлт сэтгэлгээ	Бүтээлч сэтгэлгээ
Дүн шинжилгээ хийх	Үр бүтээлтэй хийх
Нэгтгэх	Ялгаатай байх
Үнэн байдал	Боломжит байдал



THE CULTURAL WAY

Шүүмжлэл	Түтгэлзүүлэлт
Төвлөрсөн	Дэлгэрүүлсэн
Зүүн тархи	Баруун тархи
Шалтгаантай	Баялаг шинэ зүйлтэй
Тийм “ГЭХДЭЭ”	Тийм “БАС”

Анализ

Аливаа зүйлийн талаар бүтээлчээр бодохын өмнө та эхлээд үүнийг ойлгох чадвартай байх ёстой. Энэ нь та текстийг харж байгаа эсэх, хичээлийн төлөвлөгөө эсвэл тэгшитгэлийг үзэж байгаа эсэхээ ойлгохын тулд сайтар бодох чадварыг шаарддаг.

Нээлттэй сэтгэлгээ

Бүтээлчээр сэтгэж, өөрт байгаа аливаа таамаглал, өрөөсгөл хандлагыг орхиж, аливаа зүйлийг илүү шинэлэг байдлаар хар. Асуудалд нээлттэй сэтгэлгээгээр хандсанаар өөртөө бүтээлчээр сэтгэх боломжийг бүрдүүлнэ

Асуудал шийдэх

Хэрэв танд асуудлаа өөрөө шийдвэрлэхийн оронд хэн нэгний санал хүсэлт зөвлөгөө эсвэл тусламж эрэгтэй бол тусламж хүсэхээсээ өмнө өөрөө түүнийг шийдвэрлэх арга замуудыг бодож үзэх. Асуудлаа өөрөө шийдэж сурсанаар бүтээлч сэтгэлгээг үргэлж ажиллагаатай байлгана.

Зохион байгуулалт

Энэ нь зохисгүй мэт санагдаж магадгүй, бүтээлч хүмүүс ямар нэгэн байдлаар зохион байгуулалтгүй гэдгээрээ алдартай. Иймээс зохион байгуулалт нь бүтээлч байдлын чухал хэсэг юм. Гэхдээ та шинэ санаа гаргахдаа бага зэрэг эмх замбараагүй байдалд ордог байж магадгүй тул бусад хүмүүст тухай бүрд нь ойлгуулахыг хичээ.

Харилцаа

Хүмүүс таны бүтээлч санаа эсвэл шийдэлтэй үр дүнтэй харилцаж чадваж байвал таны бүтээлч сэтгэлгээний илрэл болно. Та бичгэн болон аман харилцааны өндөр ур чадвартай байх шаардлагатай. Мөн тухайн нөхцөл байдлын талаар бүтээлчээр бодохоосоо өмнө бүрэн ойлгох чадвартай байх хэрэгтэй бөгөөд энэ нь та сайн сонсогч байх шаардлагатай гэсэн үг юм. Зөв асуулт асууж, хариултыг нь сонссоноор өвөрмөц шийдлийг гаргаж чадна гэсэн үг юм.

Хоёр. Бүтээлчээр унших чадвар



THE CULTURAL WAY

Оюутнуудад тохиолддог томоохон бэрхшээлүүдийн нэг нь шинжлэх ухааны бүтээлүүд болон эх бичвэрийг уншиж, ашиглахад бүтээлчээр хандах туршлага дутагддаг.

Бүтээлчээр унших арга зүй гэдэг нь ямар нэгэн зүйлийг уншихдаа өөрийн амьдралын туршлагыг өмнөх мэдлэгтэйгээ холбон эргэцүүлж юу нь ижил, юу нь ялгаатай байгаад дүгнэлт хийж дотоод утга санааг ухаарч ойлгох бүтээлч үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Бүтээлчээр унших нь бол жирийн нэг чадвар төдий зүйл биш, харин оюуны нарийн төвөгтэй процесс мөн. Учир нь бүтээлчээр унших чадварыг хэрхэн эзэмшсэн нь тухайн хүний оюуны хөгжилтэй шууд холбоо хамааралтай байдаг.

Бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэх ач холбогдол

Суралцагчдын бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэх нь задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, эх бичвэр дээр ажиллах чадвар гэх мэт сурах арга барилыг хөгжүүлэх ач холбогдолтой юм.

Шүүмжлэлтэй унших ба бүтээлчээр унших

Шүүмжлэлтэй уншлага нь үнэлэхэд чиглэгддэг бол бүтээлч уншлага нь бүтээх эсвэл үйлдвэрлэх үйл явцад төвлөрдөг.

<p>Шүүмжлэлтэй унших гэдэг нь бичвэрүүдээс санаагаа илэрхийлэх, дүгнэлт гаргах, зорилгыг урьдчилан таамаглах, аргументуудад дүн шинжилгээ хийх, өөр өөр үзэл санааг нэгтгэх, уг санааг үнэлэх үйл ажиллагаа юм. Шүүмжтэй унших нь зөвхөн текстийг ойлгох үйл ажиллагаа төдийгүй текст дэх мэдээлэл үнэн, худал эсэхийг тодорхойлох, текстэд агуулагдах мэдлэг, үзэл бодлыг үнэлэх үйл ажиллагаа юм. Шүүмжлэлтэй унших үйл ажиллагааны гол зорилго нь мэдээллийг логик, риторик, түүх, ёс зүй, нийгэм, хувь хүний талаас буюу янз бүрийн өнцгөөс үнэлэх явдал юм.</p>	<p>Бүтээлчээр унших нь бүтээлч сэтгэлгээний ур чадварыг агуулсан унших үйл ажиллагаа юм.</p> <p>Бүтээлчээр унших нь уран сэтгэмж, шинэлэг санаа, өвөрмөц байдал, төгс төгөлдөр байдалтай холбоотой байдаг.</p> <p>Бүтээлчээр унших нь уншсан зүйлд хариу үйлдэл үзүүлэхэд тулгуурлан бүтээлч байдлыг бий болгохын тулд уншиж байна гэж үзэж болно. Бүтээлч сэтгэлгээ нь шинэ санаа дэвшүүлэхэд ашигладаг сэтгэцийн үйл ажиллагаа гэж тодорхойлогддог тул бүтээлчээр</p>
--	---



THE CULTURAL WAY

	унших нь үр бүтээлтэй сэтгэлгээний түлхүүр юм.
--	--

Хэрхэн бүтээлчээр унших вэ?

Бүтээлчээр унших үйл ажиллагаа нь дараах алхамаас бүрдэнэ. Үүнд:

1. Уншихын өмнөх үйл ажиллагаа:

1-р алхам: унших зүйлтэйгээ урьдчилан танилцах

2-р алхам: унших зүйлээ ерөнхийд нь төлөвлөх

3-р алхам: асуулт асуух

2. Унших үеийн үйл ажиллагаа:

4-р алхам: унших

5-р алхам: гол зүйлийг ялгах

6-р алхам: хариулах

Эдгээр алхам нь танд төвөгтэй юм шиг санагдах, ялангуяа ганц хоёр хуудас материал унших үед нэг их ач холбогдолгүй зүйл мэт санагдаж магадгүй. Гэхдээ эдгээр алхмыг бүгдийг нь нэг бүрчлэн хэрэглэх үү, хослуулж хэрэглэх үү гэдэг нь таны унших зүйлийн хэмжээ, түвшнээс хамаарна.

Унших алхамууд

1. Унших зүйлтэйгээ урьдчилан танилц. Та уншиж эхлэхээсээ өмнө материалаа бүхэлд нь судла. Хэрэв та шинэ ном унших гэж байгаа бол номын гарчиг /бүлэг, зүйлийг жагсаан/ гэсэн хэсгийг сайтар ажиглаарай. Цөөн хуудастай ном унших гэж байлаа ч номын бүтэц агуулгатай ийнхүү урьдчилж танилцах нь чухал ач холбогдолтой.

2. Унших зүйлийнхээ ерөнхий төлөвлөгөөг гарга. Энэ үе шатанд хэр зэрэг хугацаа зарцуулах нь унших материалын багтаамж, уншигчийн зорилтоос хамаарах нь ойлгомжтой. Жишээ нь та богино хэмжээний өгүүлэл, шүлэг уншиж байгаа бол энэ үе шатыг алгасч ч болно. Зарим тохиолдолд 1-2 минутанд унших зүйлээ ерөнхийд нь дотроо бодон төлөвлөж болно.

3. Асуулт тавих. Уншиж эхлэхийн өмнө өөрөөсөө шинээр юу мэдэж авахыг хүсч байна вэ? гэж асуу. Унших номынхоо бүтэцтэй урьдчилан танилцах явцад танд зарим нэг асуулт төрсөн ч байж болно. Зохиогчийг өөртэйгээ хамт байна гэж төсөөл. Та түүнээс юу асуух байсан бэ? Таныг шинэ зүйл мэдэж авахад тань зохиогч хэрхэн туслах вэ? Аль болохоор зохиогчтой харилцан ярилцахыг хичээ. Ийнхүү уншиж эхлэхээс өмнө унших материал дээрээ идэвхтэй ажилла. Асуултуудаа жагсаан бич. Асуулт маш тодорхой байх хэрэгтэй. Уг номыг



THE CULTURAL WAY

худалдан авахад төлсөн мөнгөтэйгээ тэнцэхүйц зүйлийг л мэдэж авахыг зорьж байгаа гэдгээ бүү март.

Уншиж байх үеийн үйл ажиллагаа

4. Унших

Уншиж байх үедээ юу уншиж байгаагаа, яг одоо юу хийж байна гэдгээ сайтар ухамсарлан унших хэрэгтэй.

5. Гол зүйлийг нь ялган тэмдэглэ.

Номоо уншсаныхаа дараа дахин нэг хар. Хувийн ном эсвэл хувилсан материал бол захын зайд нь зарим нэг тэмдэглэл хийн өнгийн харандаа болон тодруулагчаар тэмдэглэл хийх.

Энэ нь бүтээлч тэмдэглэгээ боловч мөн бүтээлчээр уншихад чухал нөлөө үзүүлдэг.

Уншихаа больвол сэтгэхээ болино. В.И.Ленин

Тиймээс оюутан ахуй насанд ихийг уншиж мэдлэг мэдээлэл ихээр хуримтлуулах чухал. Үүнд бүтээлчээр унших чадварыг өөрийн арга барил болгон хэрэглэснээр илүү их зүйлийг үр бүтээлтэйгээр унших болно.

Багш нар бүтээлчээр унших тал дээр оюутануудад баримтлуулвал зохих арга зүй

Багш нар оюутнуудад унших даалгавар өгөхдөө уг даалгаварыг уншаад яг юуг олж бичсэн цээжилсэн зүйлийг шалгах нь тэдний зорилго биш. Харин тэр текстэн мэдээллээс юуг ойлгож авсан бэ? Түүнийгээ амьдралд яаж хэрэглэж байна вэ? Бүтээлчээр унших дадал чадварыг өөртөө суулгаж чадаж байна уу гэдэг нь л чухал байдаг. Тиймээс багшид шалгуулахын тулд биш өөрт мэдлэг олж авах мөн уншсан зүйлээ цаасан дээр буулгахдаа ашигладаг тул бүтээлчээр унших нь бидэнд мэдлэг олгохоос гадна бүтээлийн хулгай, ямар нэгэн зүйлийг санаанаасаа үндэслэлгүй зохиохоос сэргийлнэ. Шууд ажиглалтын үндсэн дээр багш нарын бидэнд заадаг арга зүйг авч үзвэл, бүтээлчээр хэрхэн унших талаар шууд нарийн зааж хэлж өгдөггүй ч даалгавар хэлж байгаа зарим үгс нь цаанаа уг чадварын арга зүйг зааж өгдөг. Үүнд багш нар ямар зөвлөгөө өгдөг вэ?

- Нэг үйл ядлын логик утгыг уншиж ойлгон өөр номтой харьцуулан унших
- Багшид зориулж биш өөрийн тархиндаа мэдлэг өгөх зорилготойгоор унш
- Учир шалтгааныг нь олж ойлгож унш
- Баримттай үнэн бодит мэдээлэл олж уншиж тархиа мэдээллээр дүүргэ



THE CULTURAL WAY

- Багшийн лекцээр өгсөн мэдлэг дээр тулгуурлан ном сурах бичгээс дэлгэрүүлж судал
- Гол санааг илэрхийлж байгаа хэсгүүд дээр анхаарлаа төвлөрүүлэн унших
- Уншихдаа тоо баримт нэршил зураг хүснэгт жижиг дитайл зүйлсийг анзаарч унших

Ном болон багшийн хэлдэг арга зүйнд үндэслэн бид өөрөөр хэрхэн унших талаар тунгааж үзэхэд:

- Уншиж байгаа зүйлээ илүү сайн ойлгохын тулд үйлд явдлыг тархиндаа төсөөлөн бодох.
- Уншиж байгаа зүйлээ зорилготойгоор унших
- Уншсанаа тунгаан бодох
- Уншсан зүйлээ хэн нэгэнд ярьж өгөх

Бүтээлчээр унших чадварыг дээшлүүлж байдаг олон хүчин зүйлийн нэг болох уншсан зүйлээ найруулан бичих, хурааж дэлгэрүүлж, хувирган бичих, дуурайж бичих, зохиож бичих зэрэг бүтээлч үйлийг оновчтой ашиглах нь чухал юм.

Гурав. Бүтээлчээр бичих гэж юу вэ?

Бүтээлчээр бичих гэдэг нь таны төсөөлөл, чадвараа ашигласан шинэ санаа, бодлоо тэмдэглэж илэрхийлэх явдал юм. Энгийнээр илэрхийлвэл эрдэм шинжилгээний болон техникийн хэлбэрийн уламжлалт хязгаараас давж, бичихдээ өөрийн гэсэн арга барилаар мэдээллээ цаасан дээр буулгах явц юм.

Бүтээлч бичиглэлээс *хамгийн чухалд тооцогдох нь:*

- Намтар
- Уран зохиол: тууж, тууж, богино өгүүллэг гэх мэт.
- Илтгэлүүд
- Яруу найраг, аман яриа
- Жүжгийн зохиол / зохиол бичих
- Хувийн эсээ

Тухайлбал: Ажлын газрын тодорхойлт, тэтгэлэгт эсээ, хүн хүнтэй харилцах чадвар гээд ирээдүйд хэрэглэгдэх чухал чадваруудын үндэсийг бүтээлчээр бичих чадвар бий болгодог.



THE CULTURAL WAY

Ирээдүйд шилдэг боловсон хүчин болж бэлтгэгдэхэд бүтээлчээр бичих чадвар маш чухал юм.

Бүтээлчээр бичих зарчим

Өөрийн мэддэг зүйлээ бичих - Ихэнх тохиолдолд хамгийн сайн бичиглэл нь өөрийн мэдлэг дээр үндэслэн тодорхой бөгөөд амьдралын янз бүрийн элементүүдийн талаар олж авсан мэдлэг дээрээ тулгуурлан өөрийн тэмдэглэлээ бичих нь илүү бодитой үр дүнтэй байдаг.

Бүтээлч байдлын гол зүйл -Бүтээлч байдал нь бүтээлчээр бичих хамгийн чухал элементүүдийн нэг юм. Хайрцагнаас гарч сэтгэж, аливаа зүйлийг өвөрмөцөөр бичих.

Төсөөллөө буулган бичих - Бүтээлч бичих нэг сайхан зүйл бол "Хэрхэн" бичих тухай тодорхойлолт, дүрэм байдаггүй. Энэ бол илүү субъектив төрөл бөгөөд таны тайлбараас ихээхэн хамаардаг. Тиймээс эцсийн үр дүн нь юу болохыг харахын тулд та өөрийн төсөөллийг хязгаарт хүргэж бодитоор тэмдэглэх хэрэгтэй.

Бүтээлчээр бичиж эхлэх арга

- 1.Аль болох их унш
- 2.Тэмдэглэл хөтөлж эхэл
- 3.Бүтээлчээр бичих сургалтанд хамрагдах
- 4.Утга зохиолын хэрэглүүрүүдийг ашиглах дадлага хийх
- 5.Бичих, бичих, бичих!

Албаны бичиг

- Бодитой
- Их мэдээлэлтэй, зааварчилсан, ятгах чадвартай
- Ойлгомжтой бөгөөд шулуун шудрага
- Үнэн зөв
- Мэргэжлийн үг хэллэгтэй



vs. Бүтээлчээр бичих

- Уран зохиолын мөн уран сэтгэмжтэй
- Сонирхолтой, хүний анхааралт татсан
- Гоо сайхны мэдрэмжтэй, чухал утгатай
- Энгийн
- Ерөнхий үг хэллэгтэй



Оюуны зураглал:Оюун санааны зураглал хийх үйл явц нь нэгтгэж болно гэж төсөөлж байгаагүй санаагаа холбоход туслана. Ийм учраас бүтээлч сэтгэлгээний ур чадварыг ашиглан тархинд буй санааг цаасан дээр буулган тохирох шийдэлд хүрэхэд тань туслах болно. Оюун санааны зураглал бол шинэ санаагаа тусгаж, тэдгээрийг холбох арга юм. Энэ нь асуудлыг шийдвэрлэх боломжит шийдэл, түүний шууд үр дагавар,



THE CULTURAL WAY

тэдгээрийг шийдвэрлэх хамгийн сайн арга зам болдог. Тиймээс оюутан хүний бүтээлчээр бичих чадварт хамгийн чухалаар нөлөөлж байдаг.

Их сургуулийн багш нар оюутануудад бүтээлчээр бичих талаар юу зөвлөдөг вэ?

Жишээ нэг: Үйл явдал өгүүлбэрийг дэс дараалалтай, цэгцтэй бичих. энэ нь тэдэглэсний дараагаар ахин уншихад ойлгомжтой байна.

Жишээ хоёр: Тухайн багш бүтээлчээр бичихийн тулд бичиглэл бүр дээр гол өгүүлбэрийг тодруулж өгсөн байдаг. Энэ нь тухайн гол өгүүлбэрийг сайтар тэмдэглэснээр утга учрийг нь ойлгож мартаггүйгээр үр дүнтэй цэгцтэй бичих арга болдог.

Жишээ гурав: Өөр нэгэн багш тухайн судалж, уншиж буй хэсэгт ихээр гарж буй түлхүүр үгийг товч тэмдэглэгээр оруулж дэвтрийн аль нэг буланд тэмдэглэхийг зөвлөдөг. Ингэснээр гол зүйлээ түргэн шуурхай тэмдэглэж дараа нь харахад ойдгомжтой цэгцтэй байх арга барилд суралцуулдаг./ т=тодорхойлолт /

Лекц болон бусад сургалтан дээр зааж байгаа гарж мэдээллийг энгийнээр хуулан бичихийн оронд бодит байдал дээр хэрэглэгдэж байгаа багш нарын зөвлөгөөг дагаж мөн *бүтээлчээр бичих*, арга барилд суралцаж хэвшүүлэх нь *энгийн хуулан бичиг* хийхээс илүү үр дүнтэй мэдлэг хуримтлуулсан чухал тэмдэглэл болно.

ДҮГНЭЛТ

Ирээдүйн шинэ чадварлаг боловсон хүчин болохоор бэлтгэгдэж буй оюутан залуус бүтээлч сэтгэлгээгээ сайжруулж, бүтээлчээр унших болоод бичих чадварт суралцах нь сурах үйл явц, амьдралын туршлага зэрэгт нь нэн чухал ач холбогдолтой чадвар юм. Ялангуяа бүтээлч сэтгээний онолын үндэслэгээ болон практик ач холбогдлыг танин мэдэх нь сурах үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх чухал хүчин зүйлүүдийн нэг мөн болох нь олон судалгааны бүтээл болон практикаас олонтаа харагдаж, ажиглагдаж байна. Тиймээс энэхүү сэдвийг цаашид лавшруулан судлах хэрэгцээ шаардлага байгаа болно.

ABSTRACT

Students who are being trained to become new skilled workers of the future can improve their creativity and learn creative reading and writing skills, which are very important skills for their learning process and life experience. In particular, it is often seen and observed from many research works and practices that knowing the theoretical foundations and practical significance of creative thinking is one of the important factors that positively affect learning. Therefore, there is a need for further research on this topic.



ХА МИН-ий “ЖЭН ТУН-ий ҮЕИЙН МОНГОЛД ХҮРСЭН ТЭМДЭГЛЭЛ”-ийн
СУУРИНД МИН ИНЗУН ХААНЫ МОНГОЛД СУУГАА ҮЕИЙН АМЬДРАЛЫН
ТУХАЙ ШИНЖЛЭХ НЬ*

Хань Хуйлин*

ХУРААНГУЙ

Мин Инзун хаан Жу Чыжэнь-ий намтар, түүхийн судалгаанд харьцангуй бага судлагдсан нь түүний монголд суугаа нэг жилийн амьдралын төлөв байдал билээ. Мин Инзун хааны монгол дахь үйл ажиллагааг сэдэвлэн судлах нь энэ үеийн монгол ба хятадын түүхийг судлах нэгэн сүвэгч болохоор барахгүй, түүхэн үйл ажиллагааны асуудалд оновчтой хариу олоход чухал ач холбогдолтой хэмээн үздэг. Тухайн үед бичигдсэн хувь хүний тэмдэглэлд тусгагдсан мэдээ сураг нь энэхүү асуудлыг судлахад тун ач холбогдолтой билээ. Тус өгүүлэлд тухайн үеийн бодит хүний тэмдэглэл болох Ха Мин-ий “Жэн Тун-ий үед монголд хүрсэн тэмдэглэл”-д суурилан, Жу Чыжэнь-ий монголын хуаран дахь амьдралын төлөв байдлыг бусад сурвалжтай харилцан адилгүй тэмдэглэснийг анхаарч, тэдгээрийг нягтлан үзэж нэг мөр болгон монголд саатсан бүтэн нэг жилийн идэж өмсөх, явж суух, монголын язгууртад түүнд хэрхэн хандсан зэрэг амьдралын тухай асуудалд шүүмжлэлтэй хандаж өөрийн үзэл дүгнэлтээ дэвшүүлэв.

Түлхүүр үгс: *Мин Инзун хаан Жу Чыжэнь, монголд саатсан, амьдрал*

Нэг. Ха Мин-ий тухай танилцуулга ба түүний “Жэн Тун-ий үед монголд хүрсэн тэмдэгдэл” бичигдсэн нь

Мин улсын Жэн Тун-ий 14-р (1449) онд ойрадын Эсэн тайш, монгол морьт цэргээ дайчлан Хэбэй мужийн Тү мо бао-д мин улсын 50 түмэн цэргийг бут ниргэн, Инзун хаан болон түүний дагалт ноён түшмэдийг олзолсныг түүхнээ “Тү мо бао-ийн дайн” гэдэг. Мөн онд Эсэн тайш Инзун хаанаар барьцаа болгон бээжин хотыг бүсэлж, мин улсыг мөхөлд дөхүүлэв. Тү мо бао-ийн дайн нь мин улсын түүхэнд маш их нөлөө тусгал болсон тул тухайн үеийн ноёд түшмэдээс энэхүү үйл хэрэгтэй хамаатсан ноёд нэлээд хэдэн бодит хэргийн тэмдэглэлийг гардан бичсэн байна. Ха Мин-ий “Жэн Тун-ий үед монголд хүрсэн тэмдэглэл” нь бичигдсэн цагаар нэлээд эрт байж, тухайн үеийн түүхийг судлахад чухал хэрэглэгдэх сурвалж бичгийн нэг болж, нэлээд өндөр эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм.

* Тус өгүүлэл Өвөр Монголын Үндэстний зөвлөлийн орон нутгийн үндэстний үг хэл үсэг бичгийн судалгааны сэдэв “Ха Мин-ий “Жэн Тун-ий үед монголд хүрсэн тэмдэглэлийг эмхэтгэн судлах нь” хэмээх төлөвлөгөөний суурь мөнгөний дэмжлэгийг хүртэв.

* ӨМИС, МСДС-ийн Түүхийн салбарын багш, дэд профессор, доктор



THE CULTURAL WAY

Ха Мин бас Яньмин гэдэг, уйгар хүн (回回人 hui hui ren). Түүний эцэг Ха Жы, Жэн Тун-ий эхэн үед мин улсын хэлмэрч (通事 tong shi)-ийн тушаалтай. Жэн Тун-ий 14-р (1449) онд 2 сард, Ха Мин түүний эцэг Ха Жы лугаа ойрад монголд элчээр томилогдов. 5 сард мин улс хийгээд монголын хооронд арилжааны талын зөрчил гарснаас Эсэн тайшаас Ха Мин-ийг багтаасан мин улсын элч нарыг бүгдийг үлдээн хоцроов. 7 сард Тү мо бао-ийн дайн үүсэж, мин Инзун монголд олзлогдов. Хан Мин, Ха Жы хоёул мин Инзунд бараадахаар очсонд Инзун хаан Ха Мин-ийг монгол хэл мэддэг хэмээн дэргэдээ үлдээн орчуулагч болгожээ¹. Монгол газарт Инзун хаан биеийн эрх чөлөөгөө өдий төдий алдсан боловч Баянтөмөр жич түүний бүсгүй хоёрын сайтар харгалзлыг хүртжээ. Баянтөмөрөөс түүнд хонох монгол гэр нэгийг өгчээ. “Баянтөмөрийн түүнд өгсөн гэр нь тохируулан босгох ба хумиж хураахад туйлын дөхөм дөт амархан байж, мөн ч мал унаагаар тээвэрлүүлж явдаг”² ийм мэтийг ажлыг бүр Ха Мин хариуцаж байв. Эзэн түшмэлийн харьцааны ялгаанаас болж, хэдийгээр Ха Мин ба Жу Чыжэнь-ий харьцаа туйлын дотно байсан ч энгийн цагт хааны зөвшөөрлийг олохгүй бол түүний хонох өрөөнд дураар орж болдоггүй, нэн ялангуяа Жу Чыжэнь-тэй хамт хонож болохгүй. Гэвч тэр үед Хан Мин ер нь хааны онцгой зөвшөөрлийг олж, хааны өрөөнд хаан лугаа хамт унтаж, говийн арын хахир хүйтэн өвөлд Жу Чыжэнь-ий хөлийг халааж өгөх буюу уйтгарыг нь тайтгаруулж байв³.

Жин Тай-ийн анхдугаар (1450) онд 8 сард, мин Инзун хаан нийслэлдээ буцав. Түүнийг буцах үе түүний дүү нэгэнт хаан сууринд сууж, түүнийг дээд хаан хэмээн өргөмжлөв. Дүү Жин Тай хаанаас Ха Мин-ийг зэрэг дэвшүүлж, Жэнь Фу (镇抚 zhen fu) тушаал олгов. Тянь Шүнь-ий анхдугаар (1451) онд мин Инзун дахин хаан сууриа сэргээж, Ха Мин-ий монголд байхад түүнийг асран харгалзсан гавьяа зүтгэлийг мартсангүй, хэмэрлэг дээлт түшмэлийн дэд удирдах ноёны тушаал олгов.

Тянь Шүнь-ий тавдугаар (1461) оны 7 сард, мин Инзун хаанаас: “Ха Мин-ийг тэрслүү этгээд Цао Чинь зэрэг хүмүүсийг баривчлан алсан гавьяа зүтгэлтэй хэмээн хэмэрлэг дээлт түшмэлийн удирдах ноёны тушаал олгон, Ян Мин хэмээх овог нэр хайрлав”⁴. Чэн Хуа-ийн хоёрдугаар (1466) онд, хааны зарлигаар Жин Шян, Лю Чянь зэрэг хүмүүсийн бослогыг дарангуйлж, гавьяа байгуулж, ерөнхий захирагчийн зэрэг тушаалд дэвшжээ. Хун Жы-ийн дөрөвдүгээр (1491) оны 3 сард, хаанд айлтгалын бичиг дэвшүүлж зэрэг дэвших ба үе залгамжлахыг гуйв. Хаан: “Ян Мин эцэг хүү хоёул монголд элчээр томилогтун, өвөг хааныг халамжлан асарсан ач тустай, мөн ч тэрслүү этгээдийг хэдэнтээ дарангуйлан устгасан гавьяа зүтгэлтэй, иймээс бусад ноён түшмэдийн зэрэг дэвших хийгээд үе залгамжлах лугаа онцгойлон хандаж,

¹ 何乔远: 《名山藏》, 台湾成文出版社, 3569 页。

² 袁彬: 《北征事迹》, 纪录汇编本。

³ 哈铭: 《正统临戎录》, 纪录汇编本。

⁴ 何乔远: 《名山藏》, 台湾成文出版社, 3598 页。



THE CULTURAL WAY

түүний ерөнхий захирлын тушаал ба үе залгамжлах гуйлтыг зөвшөөрмүй”⁵ гэв. Энэ мэт монголд байх үе, Ха Мин-ээс монголд саатан суусныг сайтар харгалзан хамгаалснаас, улсдаа буцсаны дараа хааны өндөр дэмжлэг туслалцааг хүртсэн байна.

Тан улсын үеэс эхлэн шинэ хаан суурь залгамжилсны дараа урьд хааны нэг насны үйл ажиллагааны бодит тэмдэглэл бичиж өгөх нь тогтсон дүрэм болж бүрэлджээ. Үнэнийг хэлбэл заавал данс эмхэтгэл ба тулгуур бичиг эсвэл түүхийн түшмэлийн гардан бичсэн тэмдэглэлээр баримт болгох хэрэгтэй. Хувь хүний зохиол бүтээлийг ер үнэмшихгүй байдаг. Гэвч мин Инзун хааны байдал онцгой байв. Тэр монголд олзлогдон бүтэн нэг жил амьдарсан бөгөөд Жэн Тун-ий 14-р оны 8 сараас 15-р оны 8 сар хүртэлх хугацаанд түүний үйл ажиллагааны тухай албаны талын материал нь дутуу буюу буруу бичиж, ямар ч гэрч баримтгүй. Иймээс зарим хувь хүний зохиол бүтээлийг хэрэглэхгүй байхын аргагүй болж, үүний улмаас хаантай хамт монголд олзлогдсон түүнтэй хамт амьдарч байсан Ха Мин-ийг түр цагийн сурвалжилга хийжээ. Ха Мин-ий “Жэн Тун-ий үед монголд хүрсэн тэмдэглэл” нь даруй тэр үед бичигдэв. Түүнийг тухайн үеийн бодит хүний тэмдэглэл бас анхны түүхэн материал хэмээн хэлдэг, тэр нь даруй өөрийн үүсгэсэн хэрэг явдал лугаа шууд холбоотой түүхэн материал болно. Ямар нэгэн хэрэг явдал үүссэний дараа, тухайн үед буюу багахан хугацаанд тэмдэглэгдсэн хэрэг явдлын тус биеийнх нь үлдэгдэл нь чухам анхны түүхэн материалд тооцогдоно. Иймээс анхны түүхэн материалын хамгийн чухал нь гэвэл тэр цаг үеийн шууд ажиглалт ба шууд эргэцүүлэл болно. Мин улсын түүхэн дэх чухал хэрэг явдал болсны хувьд, мин Инзун хааны монголд байх үеийн үйл ажиллагааг бичиглэх нь маш их ач холбогдолтой. Түүхийн тушаалтны шууд оролцоо дутмаг учраас үүнтэй хамаатай хамгийн анхны тэмдэглэл нь тухайн үеийн оролцогч болон гэрчлэгчийн бичсэн ном болсны хувьд орхигдуулж болшгүй түүхэн сурвалж бичгийн үнэ цэнтэй билээ. Үүнд, Ха Мин-ий “Жэн Тун-ий үед монголд хүрсэн тэмдэглэл”-д суурилан, бусад түүхэн материалыг хавсарган, мин Инзун-ий монголд саатсан бүтэн нэг жилийн амьдралын тухай нарийн шинжилжээ.

Хоёр. Мин Инзун-ий монголд саатсан үеийн амьдралын тухай шинжлэх нь

1. Мин Инзун монголд байхад тасралтгүй нүүдэллэн малчих амьдралтай байж, мах идэж, арьсан дээл өмсөж, морь унаж, майханд сууна.

Мин Инзун монголын хуаранд 1449 оны 7 сараас 1450 оны 8 сар хүртэл бүтэн нэг жил саатсан билээ. Энэ явцад түүний монгол дахь амьдрал ямар байсан бэ?, монголын язгууртад энэхүү мин гүрний хаан эзэнд хэрхэн хандсан тухай, ерөөс хүмүүсийн сонирхлыг татаж ирсэн байна. Гэтэл үүнтэй хамаатай материалыг зөвхөн Инзун хаантай хамтдаа амьдарч байсан хүмүүс байсан тул олоод өгч чадна. Мин Инзун хааны монгол дахь амьдралын төлөв, их төлөв тухайн үеийн монголчуудын амьдрал лугаа төстэй байж, тасралтгүй

⁵ 哈铭：《正统临戎录》，纪录汇编本。



THE CULTURAL WAY

нүүдэллэн малжих амьдралтай байж, мах идэж, арьсан дээл өмсөж, морь унаж, майханд суудаг. Эдгээр нь түүний бээжингийн хааны ордон дахь жаргалант амьдрал лугаа тэнгэр газрын зөрөөтэй байдаг. Мин Инзун хаан монголд олзлогдох үе, биедээ хуяг хуягласнаас гадна, зөвхөн “алтан луу хатгамалт дэр байдаг”⁶. Инзун хаанаас тусгайлан монголд байсан мингийн элч Лян Гүй-ийг мингийн ордонд томилон очуулж, ордноос өөрийн хувцасаа авахуулахаар явуулсан билээ. Сүүлээр нь элчээс Сүн тайху-ийн илгээн өгсөн хувцас хунар, малгай зэрэг зүйлүүдийг тал нутагт хааны дэргэд авч ирэн өгсөн байна⁷. Хэрэг дээрээ Жу Чыжэнь-ий хүйтнээс хамгаалах хувцас хунарын ихэнхийг монголчууд ханган өгдөг. Жишээлбэл, 8 сарын 19-ний өдөр, Эсэн (Инзун хаанд) хөнжил дэвсгэр, арьсан дээл авч ирж өгөв. Хааны төрсөн өдөр, хаан бээжиндээ буцах үе, Эсэн тайшаас бүр арьсан дээл хүргэж өгсөн тэмдэглэл байдаг⁸.

Нарийн ажиглавал, түүний амьдралын үндсэн төрх нь: “Эсгий майханд сууж, идээ ундаа нь мах бяслаг, үхэр тэрэг нэгээр нүүн шилжих багаж болгомой” мөн тухайн үед монголд элчээр томилогдсон мингийн элч Ли Ши-ийн “Умарш элчилсэн тэмдэглэл”-д: “Хаан суугаа нь хөшөө майхан, газарт унтан, нүүн шилжих багаж нь үхэр тэрэг нэг, морь нэг. Хааны дэргэд түшмэл Юань Бинь, сул зарц Лю Фуэл, лам Сянь Фу зэрэг гурван хүн үйлчлэн явдаг билээ. Идээний зүйл нь Эсэн тайшаас 5 өдөрт үхэр хонь тус тус нэгийг дэвшүүлэн өргөн, хааны хоол болгодог, будаа ногооны зүйл ер байдаггүй”⁹ иймээс Ли Ши өөрийн биедээ авч явж байсан: “хэдэн доу тутарга будаа”-гаа хаанд дэвшүүлэн өргөсөн байна. Эсэн тайшаас бас хөнжил дэвсгэр, арьсан дээл хүргэж өгдөг. “Хоёр өдөрт 1 хонь, 7 өдөрт 1 үхэр алж идэн, 5 өдөр буюу 7 өдөр, эсвэл 10 өдөр 1 удаа найр хийдэг. Өдөр дараалан үнээний сүү, морины сүү өргөн, бас майхан 1 өргөн, монгол бүсгүйг томилон хааны өдөр тутмын амьдралыг хамаардаг”¹⁰.

Цэргийн аянд, эсвэл морь унах ба тэргэнд сууна. Ха Мин цэргийн аян дундах зарим зүйлүүдийг тоочин бичсэн байдаг. Жишээ нь, Эсэн мин Инзун хааныг шахамдуулан цэрэг дайчлан бээжинд ойртох зорилгодоо хүрч чадаагүй, дахин умарш буцах үе, хаан “Ха Мин-ээр гар доорх хавсрагч болгон, морь ногтлон хамтдаа явмой. Гуу суваг уул нуруу өнгөрөхөд Ха Мин мориноосоо бууж, хааныг түшин дэмжиж бартааг туулдаг. Тэгш газар хүрвэл Ха Мин дахин мориндоо гарч мөн л морь ногтлон хамт морилмой ... тэнгэр хүйтэн өдөр, Баянтөмөрөөс тэрэг 1, тэмээ нэгийг гуйн авч, замын явдалдаа хаан тэргэн дотор сууж, муурын арьсан олбогоор тулгалан хучдаг”.

Өмсөх талаар гэвэл, мин улсын цэрэг Тү мо бао-ийн дайнд гэнэтийн ялагдалд учирсан учраас Жу Чыжэнь-ий биедээ авч яваа зүйл нь хуяг дуулгаас

⁶ 袁彬: 《北征事迹》, 纪录汇编本。

⁷ 哈铭: 《正统临戎录》, 纪录汇编本。

⁸ 哈铭: 《正统临戎录》, 纪录汇编本。

⁹ 李实: 《北使录》, 纪录汇编本。

¹⁰ 袁彬: 《北征事迹》, 纪录汇编本。



THE CULTURAL WAY

гадна “гагц алтан луу хатгамал дэр байдаг”. 8 сарын сүүлээр боомтын гадна бээжин хотоос өмнө 1 сар эрт өвлийн хүйтэн ордог. Иймээс Инзун хаанаас Лян Гүй-ийг бээжинд томилон захидал чимээ хүргэх үес, түнд хувцас хүргэж ирээрэй гэж онцгойлон захив. Хожим нь элч хэдийгээр Сүнь тайху-ийн илгээсэн хувцас дээл, малгай зэрэг юмыг монголд хүргэж өгсөн боловч бүгд л монголын хүнд булаагдав¹¹. Үнэндээ Жу Чыжэнь-ий хувцас дээлийг ихэнхдээ бүр монголчуудаас хангана. Тэр хооронд Эсэн тайшаас тасраагүй мингийн хаанд ор дэвсгэр, хөвөн дээл хүргэж өгдөг. Ийм байлаа гэсэн ч Жу Чыжэнь боомтын гаднах өвлийн шөнийн хүйтнийг тэсвэрлэж чадахгүй, тэгээд Ха Мин-ийг тусгайлан дуудаж майхандаа оруулж өөрийн хөлөө давируулан дулаацуулдаг. Ха Мин мөн ч ээжийнхээ хийж өгсөн цагаан торгон дээлээ хаанд өмсгөв.

2. Мин Инзун хааны монгол байх үеийн асран хамжигч

Тү мо бао-ийн дайнд мингийн цэрэг ялагдаж, Инзун хаан монголд олзлогдон умарш явжээ. Байлдаан дунд бусад олзлогдсон нь бүх аймагт хуваагдан, мин Инзун биеийн гарал онцгой учраас Эсэний доорх Баянтөмөр хийгээд Сайхан вангийн нямбай халамжлалыг хүртжээ. Монголын талаас тусгай хүн томилон түүний өдөр тутмын амьдралыг хамааруулж байсан мөртөө нэг бүлэг дайнд олзлогсод хийгээд монголд үлдэж хоцорсон нэвтрэлцээний хүмүүс ба элч зэргийг томилж, харж халамжлуулж байжээ. Тэд олзлогсод боол, дайны дундаас азаар золгогсод мэтийн дүрээр Жу Чыжэнь-ий эргэн тойронд цугларч, ус зөөж, түлээ үүрч, майхан босгох, дулаацаж уйтгар бухимдлыг тайлж, монгол хятад орчуулга хийж, захидал чимээ дамжуулж, элч явах мэтийн шадар цэргийн тушаалын үйлдэл гаргаж, говийн ард олзлогдож хааныг асарч, өмнөш мин улсад буцахад тун их нөлөө үзүүлжээ.

Инзун хаан монголд олзлогдсоны анхны үеэр түүний дэргэд “ганц тайган Сы Нин асран хамжиж байв, удалгүй тэр монголд буун өгсөн”¹² бөгөөд мин улсын 9 балгас болон нийслэл хотын байдлыг Эсэнд задруулж, түүнд дотогш дайлахыг ятгахын хамт замч болж байжээ. Тайш Хаба багш (哈巴国师 ha ba guo shi)-аас Инзун хааны биеийн гарлыг тодруулан мэдсэний дараа, даруйд нь монголд хоригдож байсан мин улсын элч Лян Гүй-ийг эрж аваачиж, түүн лүгээ уулзуулав. Мин Инзун хаан тэр доор нь Лян Гүй-ийг нийслэл хотод томилж чимээ захидал дамжуулав. Тэр цагаас эхлэн Лян Гүй мин Инзун хааны монголоос мин засгийн ордонд сураг чимээ хүргэдэг чухал дамжуулагч болов. Үүний дараа Тү мо бао-ийн дайнд ойрадад олзлогдсон хэмэрлэг дээлт түшмэл Юань Бинь Лэй жянь жань өртөөнд Эсэн тайшийн дүү Сайхан ванд олзлогдоод байсан Жу Чыжэнь-тэй уулзжээ, Жу Чыжэнь түүнийг “Хятад үсэг бичигт дадамгай хэмээн хажуудаа үлдээж бичээч болгов”¹³. Түүнээс эхлэн Юань Бинь-ий бичиж найруулсан захидал чимээ нь мин улсын засгийн ордноос цаг тухайд нь Жу Чыжэнь-ий монголд байгаа үйл ажиллагаа жич үзэл

¹¹ 哈铭：《正统临戎录》，纪录汇编本。

¹² 《明英宗实录》，卷 181，台湾中央研究院历史语言研究所校印本，1962 年，3498 页。

¹³ 何乔远：《名山藏》，台湾成文出版社，3600 页。



THE CULTURAL WAY

санааны хувирлыг хайн мэдэх чухал замч болсон байна. Хожим нь мин Инзун хаан Жу Чыжэнь, Эсэн тайшийн зөвшөөрлөөр хэлмэрч Ха Мин-ийг дэргэдээ үлдээн орчуулагч болгов. Ха Мин-ээс улс хийгээд ойрадын хооронд харилцааны сайдаар ажиллаж, тийм мөртөө монголын дотоодод маш олон ажил хийж, монголын язгууртан болон Жу Чыжэнь-ий хоорондох нөхөрлөлийг буй болгов. Мөн ч мин Инзун хааны мингийн төрд буцахад маш их тус дэмжлэг болсон байна.

Жу Чыжэнь-ий шадар хамгаалагч нь лавтай дээр дурдсан Лян Гүй, Юань Бинь, Ха Мин зэрэг хоёр гурван хүнээр зогсохгүй. Тухайн цагт мин Инзун хаанаас хувь хүний хэрэгцээнээс Ха Мин зэрэг 5-7 хүнийг¹⁴ явуул ордонд цуглуулан говийн арын хахир хүйтнийг хамт туулж байв. Цаашлан 5-7 хүнээс ч илүү байдаг. Үндсэн түүхийн материалд суурилан тухайн үеийн бодит хүний тэмдэглэлд нүд хаявал, мин Инзун хааны дагагсадын ангид Юань Бинь, Ха Мин, Лян Гүй нараас гадна, Бай Чуань, Ли Чэн, Хажал, Жян Жинь, Же Синь, Ли Гуо, Сянь Фу зэрэг хүмүүс багтдаг. Тэр нар Жу Чыжэнь-ий эргэн тойронд цугларан хувь хүний үүрэг чадамжаа бадруулан, эцэстээ Жу Чыжэнь-тэй хамт мин улсдаа буцаж, хааны талархлыг хүртэн, төрийн түшгийг сайн эдэлсэн байна.

Жу Чыжэнь хэдийгээр дайны олзлогсдын хувиар монголын захиргаанд байж хувьд хүний эрх чөлөөгөө өдий төдий алдсан боловч Эсэн тайш мөн ч түүнийг харьяаны жанжин Баянтөмөрт захируулж, Баянтөмөрийн өргөмжлөл газар аваачиж асруулж байв. Түүний захаар Тү мо бао-ийн дайнд олзлогдсон тайган түшмэл Сы Нин, хэмэрлэг дээлт түшмэл (校尉 xiao wei) Юань Бинь, Шө Рэнь (舍人 she ren) Бай Чуань, зуутын дарга Ли Чэн, дуду Чянь Ши (都督 金事 du du qian shi) Жянь Синь, Лю Фуэл, Ли Гуо, Же Синь, хувраг Сянь Фу хийгээд Тү мо бао-ийн дайн эхлэхтээ ойрадад хоригдон суусан элч Лян Гүй, Ха Мин зэрэг 5-7 хүн мин Инзун-тай цуг Баянтөмөрийн цацарын доор тохируулагдсан мөртөө олзлогдогч, боол, дайнд амьд үлдэгсдийн хувиар Жу Чыжэнь-ий захад цугларч, говийн ард хаанаа асарч байв.

3. Монголын язгууртнуудтай харилцсан нь

Мин Инзун хаан хэдийгээр монголд олзлогдсон боловч, тэр ер нь бас ч мин улсын хаан байдаг. Ха Мин-ий номд өгүүлснийг үзвэл, Эсэн тайш, Баянтөмөр зэрэг монголын ахлагчид мин улсын Инзун хааныг хүндэтгэн харгалзсан тэмдэглэл цөөн бус байжээ. “17-ны өдөр, морио алж хуримын ширээ засдаг ... аяны буудалд очих буюу дулаан тэргэнд сууж, эсвэл мориндоо сууна. Зам дагуу монголчууд, монгол бүсгүйтэй уулзвас бүр морин дээрээ мөргөн, замын дагуу хээрийн үнэр амт ба сүү өргөн барьдаг, Эсэн удаа бүр морь алж тайллага базааж, (арш) архи өргөн, өөрөө хувьс чавгадаж, олон монголчууд аялгуу дууг дуулдаг байв. Дэд Жы Юань, Датун ван, Сайхан ван сөгдөж архи барив ...”. “Хоёрдугаар сарын шинийн нэгний өдөр, Эсэн тайшаас

¹⁴ 哈铭：《正统临戎录》，纪录汇编本。



THE CULTURAL WAY

хааныг майхандаа урин залж, бүгдээр архи барьж дуулцгаан, Эсэний гурван эхнэр нь бүр хаанд мөргөж, тэхийн арьс бэлэглэн өгсөн байна”.

Эдгээр тэмдэглэлд мин улсын Инзун хааныг өнгөлөн чимж магтан сайшаасан үг цөөн бус байх нь дамжиггүй, гэвч тэмдэглэсэн үндсэн түүх бодит хэргийг харин зохион бичсэн биш. Учир нь Инзун хаан хэдийгээр монголд олзлогдсон боловч тэр мөн л дээд хааны биеийн гаралтай байж, монголын талаас авч хэлбэл барьцааны хүнийг хамгаалах чухалтай мөртөө энэ нь мин улс хийгээд монголын хооронд энх тайван харьцааг сэргээх үйлдэлтэй. Иймээс Инзун хааныг бас олзлогдсон мөн ч зочин гэж хэлж болно. Энэ нь өнөөгийн сул хорихтой адил юм. Иймээс түүний амьдралын орон сууцыг батлах чухал, чухал бүхий ёс журмыг ч орхигдуулж болохгүй. Зөвхөн Ха Мин-ий бичигт тэмдэглэсэнтэй адилаар Эсэн тайш тэр чигээрээ өөрийгөө сайд түшмэдийн байцад тавьж хааныг дээдлэх явдал бас биш ээ.

Мин улсын Инзун хаан болон монголын ахлагчдын хоорондох харьцаа нэлээд эе эвтэй гэж түүхэн материалд тусгасан байна. Мин Инзун хаан монголд байхад Баянтөмөр түүнийг шууд хамаарч байжээ. Тэр ямар учир буюу шаардлагатай бол хамгийн түрүүнд Баянтөмөрт мэдүүлж, Баянтөмөр Эсэн тайшаас заавар авах буюу шууд тогтооно. Инзун хааны зүй ёсны шаардлагыг Баянтөмөр хийгээд Эсэн тайшаас бүр зөвшөөрнө. Эсэн тайш тэргүүтэй монголын язгууртад Инзун хааныг байн байн үзэхээр очиж, бага сага бэлэг хүргэж, заримдаа баяр дурсгалын ёслолд ч түүнийг урьж оролцуулдаг байжээ. Инзун хаан хэдийгээр харийн нутагт амьдарч ач хариулахын аргагүй боловч завшаан олдмогц сэтгэлээ гүйцэтгэдэг. Жишээ нь, нэг удаа И жоу-д хүрсний дараа мин Инзун Ха Мин-д “Чи жаахан жимс олж Баянтөмөрт хүргэж идүүлээрэй” гэж хэлж байв. “И жоу-ийн ард бүх зүйлийн жимс хураан хааны өмнө хүргэж Баянтөмөрт өгсөн байжээ”.

ДҮГНЭЛТ

Мин Инзун хаан монголд нэлээд сайн харгалзал хүртэж байсан нь тухайн үеийн байдалтай нягт харьцаатай юм. Инзун хаан Эсэн тайшид олзлогдсон тэр мөчөөс эхлэн, эн түрүүнд тайш олон даргатайгаа ярилцаж хүн томилон мин улсад чимээ өгч мэдүүлэн, сайд ноён түшмэд томилон хааныг авахаар ирүүлэх, монголоос хүн томилон хүргэж дахин хаан сууринд суулгах гэж хэлсэн байна. Үнэн санаа нь Инзун хаанаар барьцааны хүн болгож мин улстай хэлэлцээ хийж, найрамдаж, мин улсаас нэн их ашиг тус олохын төлөө юм. Хэрэв Инзун хаан монголоос буцан ирж дахин хаан оронд суувал, Эсэн тайш хийгээд мин улсын хоорондын харилцаа нэн дөхөм болно. Энэ бол даруй монголын талаас Инзун хаанд хал үзүүлэхгүй дотоод шалтгаан билээ. Харин сурвалж бичигт тэмдэглэсэн Эсэн тайшаас тэргүүтэй монголын язгууртад мингийн хаанд мөргөн сөгдөх түшмэлийн ёсон хийдэг явдал нь Ха Мин хийгээд дундадын түүхчдийн хааны тухайн үйл явдлыг тоочин бичих нэгэн зүйлийн цээрлэх арга барил уран мэргэжил болох нь гарцаагүй юм.



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. 何乔远：《名山藏》，台湾成文出版社。
2. 袁彬：《北征事迹》，纪录汇编本。
3. 哈铭：《正统临戎录》，纪录汇编本。
4. 李实：《北使录》，纪录汇编本。
5. 《明英宗实录》，卷 181，台湾中央研究院历史语言研究所校印本，1962 年。



“ХАРИЛЦААНЫ СОЁЛ”-ЫН ҮҮДНЭЭС ЯПОНЫ СУРГАЛТЫН СОЁЛЫГ
НЭВТРҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ТАЛААР ӨГҮҮЛЭХ НЬ

Жао Хашэнь Гаова*

ХУРААНГУЙ

Өнөөгийн дэлхийн эдийн засгийн хөгжил нь улс орнуудын соёлын солилцоог ахиулж, японы боловсролд ч анхаарал хандуулж байна. Энэхүү өгүүлэлд япон хэлний бодит байдал, соёлын солилцоо ба хэлний соёлын харилцаа, японы соёлыг хөгжүүлэх үүднээс суралцагчдад япон хэлийг хэрхэн илүү сайн эзэмшиж, ашиглах боломж олгох талаар хэлэлцэж, японы сургалтын соёлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Одоогийн байдлаар хятадын олон сургууль япон хэл заах соёл хоорондын харилцааг чухал сэдвийн жагсаалтад оруулж, маш их дадлага хийж байна. Японы боловсрол уламжлалт ярианы бүтцээс хэтэрсэн тул бид соёл хоорондын харилцаанд анхаарлаа хандуулж, суралцагчдын япон хэлээр харилцах чадварыг аажмаар сайжруулах ёстой билээ. Япон хэлийг гүнзгийрүүлэн судалснаар цаашдын практикт япончуудын харилцааны өндөр түвшин, чадварыг хөгжүүлж, хувь хүний илүү сайн хөгжлийг дэмжих боломжтой.

Түлхүүр үгс: *Япон хэл заах; соёлын харилцаа холбоо; танилцуулах стратеги*

Өгүүллийн бүтэц:

- *Хураангуй*
- *Түлхүүр үгс*
- *Оршил*
- *Соёлын солилцооны сургалтын ач холбогдол*
- *"Харилцааны соёл"-ын үүднээс Японы соёлын харилцааны өнөөгийн байдал*
- *Соёлын харилцааны чадамжийг сайжруулахын ач холбогдол*
- *Япон хэл заахдаа соёлын харилцааны чадамжийг төлөвшүүлэх стратеги*
- *Дүгнэлт*

* Чыфөн Дээд Сургуулийн багш, доктор

Судалгааны чиглэл: Хойд нутгийн ард түмний эртний түүхийн асуудал
Өвөр Монгол Чыфөн хот 024000



THE CULTURAL WAY

从“交际文化”视角谈日语教学文化导入策略

赵哈申高娃

赤峰学院，内蒙古 赤峰 024000

摘要：当今世界经济发展，促进了各国之间的文化交往，日语教育也日益受到重视。本文从日语的实际情况、文化交流与语言文化之间的关系、日语文化的培养等几个角度出发，探讨了如何使学生更好地掌握和运用日语，旨在为日语教学文化的发展提供助力。

关键词：日语教学；文化交际；导入策略

引言：随着经济、文化和社会交往的不断深入，中日文化交流的重要性越来越突出，日本对中日交往的重视程度也越来越高。21世纪，日语教材的主要目的是为了提高学生的跨文化交流和使用日语的水平。所以，日语教学的关键在于提高学生的跨文化交流水平。因此在日语课堂上，应该把跨文化交流的技能运用到课堂上，注重培养学生的跨文化交流技能，这样才能拓宽他们的视野，提高他们的文化素质，帮助他们突破自己的文化桎梏，使他们能够真切地感受、理解和感受到日本的文化。

一、文化交流培养的意义

中日两国的交往和合作日趋密切，因此跨民族交往已经一个无法逃避的现实。因此，学习日语专业的学生，如何能够更好地进行文化交流是非常必要的。《高等院校日语专业教学大纲》于2001年度颁布，提出了“21世纪日语教学的一个主要目的是提高学生的语言运用能力和跨文化交际能力。”所以，在日语教育中，要把“交际文化”作为一个重要的环节，并充分地融入到日语各个方面的教学当中。日语教学应该注重培养学生的文化交流能力，拓宽他们的眼界，拓宽他们的知识面，进而提升他们的文化修养，使他们逐渐突破自己的文化限制和层次，进而去领略、理解或接受日本的文化。



二、“交际文化”视角下日语文化交流的现状

中日两国文化差异日益显著，由此引发的问题也日益凸显。因此，在平时的教学中，要根据日本本土的风俗习惯，去了解和掌握有关的知识。但是，由于我国的日语教育一直以来都是以传统的语言和语法的形式来进行，而且大部分的课程模式都是以这种形式来进行的，课程主要是针对的是学生日语阅读能力、应试能力的提高，语言构成能力的不断完善和语言结构的理解加深，而忽略了对语言交际能力的培养。因为对日语的理解较为不足，造成了部分同学虽然会说一口流利的日语，在听到日语后可以根据自己积累的语言经验进行准确的理解和分析，但由于他们的文化交际方式往往会有偏差，从而造成很多的误会和偏差，进而产生一些不必要的麻烦。

目前来看，日语教学通常采取的是多练习句子形式，语法解析，一般采用的是传统的日语教学方式如词汇解释，而忽视了在日语教学中使用的词、句交流的问题，导致日语学习者在交流与应用中遇到了困难。另外在日语文化的教育中，老师们往往花费了很多的精力和时间在日本的人文、社会历史、诗歌等方面，而忽略了日语的语言沟通交流的学习，这就导致了学生在与日本人的交流中，往往会用本国的语言语境来评判日本语言文化，造成了不同国家文化上的分歧和矛盾。从相关机构研究结果可以发现，目前日语的语言教育问题多为注重掌握语言的字词、语句结构、语法等，而忽略了其日语交流实用的作用。因此在日常教学中，不断加强日语在具体语言环境下的沟通方式，促进学生可以更好的使用日语进行日常社交和交流。

三、提高文化交际能力的意义

一名哲学家曾经说过，人从本质角度来讲，就是一种文化交流的动物。从这一角度来看，不同文化之间的交流与沟通正是其根源，如果一个人想要把自己的情绪和思想完全地传达出来，但却不能很好地理解语言的文化和思想，就不容易让人信服他的观点想。总而言之，在这种意义上，语言文化和文化交际能力之间的关联较为密切。

（一）社会及自我价值的体现



THE CULTURAL WAY

在现实沟通交流中，人们往往会坚持自己的价值观，如果在交际中抛弃了自身的价值观，这样的沟通交流就不会有很有效的作用。此外在交往过程中，人们往往会有意识地强调自己的价值观念，从而影响到交际效果和社交关系。比如，日本人与中国人对待家庭、友谊等问题有着很大差别。中国人在与亲人、朋友、同行进行合作交流时，更多地显示出一种亲近的感情，而日本人则倾向于在沟通时，与别人维持一种适当、合理、舒适的距离感，因此日本和中国文化在表达特点上有很大的差异。另外在好友聚会，中国人往往会觉得一个人支付全部的钱是很正常的，因为那样会让人觉得亲切和友好，但是日本人不这么认为，他们更愿意平均付钱，并这是合情合理的。

(二) 思维方式上的体现

日本人的民族特色主要通过“和”来表达，即追求二者的均衡，实现心灵的和谐与统一。因此，日本人在对待事情和表达自己的情感时，都会仔细地去思考和观察，而这一细致而又严肃的态度也是日本人洞察力较高的原因。与此形成鲜明对比的是，中国人对辩论的重视程度较高，为了维持和推动事物的发展，通常需要用争论来劝说不同的人，进而达到思维方式的统一。所以在现实生活中，各国人民受到各种思考模式特征的影响和限制，文化冲突就会显现出来。

(三) 语言表达习惯上的体现

根据有关资料，造成不同国家间不同文化间的冲突的原因，主要是由于双方不了解其他国家的语言和文化习俗。比如，在日语的基本教育中，“老人”这个名字很容易被认为是老年人，在现实中，日本人最讨厌的就是“老人”这个称呼。因为在日本，老年人就意味着没有生存的力量，没有很大的价值，使用这个词语就好像是在贬低别人。在中国，我们习惯于叫老人，这表示一种尊重和理解，但是如果我们在日本试图用日语来形容老人，那就会引起误会，造成不必要的麻烦。



总而言之，语言学习者需要全面了解日本的民族特色，找出日语和本国语言之间的共同点和不同点，然后仔细地加以剖析和归纳，通过运用适当的方式来进行沟通，这样可以达到顺畅文化交流的目的。

四、文化交际能力在日语教学中的培养策略

(一) 文化差异的意识培养

“交往能力”的培养是指求知的人要有一种突破自己的个性，拥有摆脱本国的语言和文化体制的束缚的意识，积极主动去认识各个地区的文化含义。在不同国家，人们的生活习惯与思考模式都有很大差异，学习者应拓宽眼界，并力求在社会交流中提高灵活变通的能力。学校的日语课程一般是以培养学生全面应用外语为主要目的。因此，老师需要让学生对他国的政治，经济，文化，社会等制度及人际关系有更多的认识。在实践中，老师不仅要重视学生的语言学习能力，还要重视不同的文化环境差异。日语中的文化意识训练就是在现实生活中，两个人在具体语境中进行沟通交流，沟通交际能力都是在日常生活中养成的。在日语实践中，可以从不同的层次、多角度地对学生进行培养，也可以从中日两国不同的语言、语法等方面进行比较，以此来增强学生的敏锐力和理解力，并为正确运用日语进行沟通交流奠定基础。

日本的语言文化和我们国家的语言息息相关，从历史背景上来说，中日文化交流已经进行了很长一段时间，这就导致了日本语言里的许多单词，在字形和语言内容上都和汉语非常类似，但同时也有一些差异很大的地方。例如：汉语中的“祭司”，日语中“祭司”也可以译作“祭祀”，但是这个“祭”和“祭”又有区别，老师若不解释，很可能会让人误会。在日本，现代的祭典是一种全民的日常娱乐，而中国则是以求祭拜神明为主要含义。另外，“寝室”这个名词，中日两国的读音一样，但意思却完全不一样，比如中国人邀请一个日本的女生来你的寝室做客，由于文化的差异这个日本友人可能会手足无措，因为在日本语言文化里，“寝室”就是“个人寝室”的意思，在中国则是一个“集体宿舍”、“多人寝室”的意思。因此，在日语教学中要尽量减少母语的干扰，



尽量把本国语言的影响降到最低，同时要注意把汉语和日语之间进行文化对比和理解，从而提高自身的日语运用水平。

(二) 日语理论知识教学需要与文化教学同时进行

老师在讲课的时候，往往会产生很多的误解，这是因为老师将很多时间放在了地理、历史、文学等方面的知识的讲解，而忽视了国际文化差异上的讲解，所以有时候在日语交流中，往往会用本国的文化来理解其他国家的文化。而作为日语老师，需要将日语文化知识 with 日语国家习俗有机地融合在一起，同时多做一些情境性的教育，将日本的传统文化与理论实践更好的融合在一起，从而促进学生更好的进行跨国文化交流和沟通。

(三) 语言能力的培养

在不同国家的交流活动中，每个国家的文化都有不同的语言形态。没有良好的语言基本功，是很难达到良好的跨文化交流水平的。所以在日语课堂上，应重视对日语学习者的日语基本功的学习。首先，老师在教授日语单词时，要注意对日语的文化内涵的引入。在日语教学中，根据不同的文化背景需要对词语有不同的理解和反应。例如一些词语，尽管汉语与日语都具有同样的含义，但是它们之间的文化含义却不尽一致。比如，中国字典《辞海》中的“龟”字，古人经常使用“龟”来比喻长寿，《抱朴子·对俗》说：“知龟鹤之遐寿，故效其道（导）引以增年”但是，在现代汉语里，“龟”这个词在负面的情况下更多地使用，尤其是在骂人、贬低人的情景中，比如：“你是个缩头乌龟。”但在日本，不管是古代日语，或是现代日语，“龟”都是“长寿”的意思，多用来表示赞美。如果没有意识到中日文化习俗之间的不同，那么日本人送你一件乌龟形状的礼物，虽然礼物很精美，但也许会感到有些奇怪，为什么他会把乌龟作为礼物呢？因此，在日语课堂上，应注意引入日语的文化内涵的教授，避免学生仅凭词汇自身进行主观判断，造成不必要的误解和麻烦。对于一些带有一定的文化语境含义的词语，老师除了要讲明确其内涵，还需要对其所蕴含的文化背景进行阐述。以前日语的语法教学仅仅侧重于对文章句子的理解，而并没有将其与汉语的语法进行对比，从而没有发现其不同之处。由于任何一种语言都和其他语



言的一些异同，当要求同学们对比较困难的句型进行解析时，可以让他们将这些问题先转化为汉语，仔细观察汉语的结构，然后再对日语的语法进行剖析，使他们从中发现差异，进而使他们在交流的过程中避免使用大量的中式日语，造成他们降低自身语言的表达能力，同时对日语的学习会造成很大的影响。日语与汉语是两个截然不同的语系，两者之间有很大的区别。所以，在日语语法课上，教师应该进行日语和汉语的比较，发现两者的共性和差异，以提高日语学习沟通能力，不断促进学生的日语交流水平。

（四）交际能力的培养

学生掌握一门语言是为了使自己在现实生活中正确地使用该门语言，进而传达知识和表达情感。为了提高学生的跨文化交流的技能，可以采用角色的方式。该方式能够帮助学生在各种情境中进行各种角色的转换，从而提高学生的语言表达水平，进而为今后在现实生活中准确使用语言奠定了良好的基础。知名教育家何家宁指出：「角色扮演的情景可以选择集中反映学生需要的社会礼仪或那些可能导致文化误解的话题。」通过这种情境，可以让同学们更好地理解国家不同的语言，从而降低不正确地使用语言的次数。日语教科书中有很多交流文化的章节，例如：打电话、问路等；老师们可以通过角色表演来引导学生理解医生、就餐的文化差别。在做角色扮演时，老师要让同学们按照自己所扮演的人物所处的位置来进行沟通谈话，当他们所饰演的人物是友人的时候，就需要运用简单语言来进行训练。如果是陌生人，那就需要恭敬的态度。透过扮演不同的人物，使学员能够真实地运用日语进行交流，并能够真实地体会和体会日本的文化，从而逐步提高自己的跨文化交流水平。

结论

目前，国内许多学校都把日语教学中的跨文化交流列为一个重要课题，并进行了大量的实践。日语的教育已经超越了传统的语篇结构，所以应该以跨文化交流为重点，逐渐提升学生运用日语交流的能力。通过对日语的深入研究，进而使其在今后的实践中培养更高的日语交流水平和能力，促进个人更好的发展。



THE CULTURAL WAY

ABSTRACT

At present, many schools in China have listed cross-cultural communication in Japanese teaching as an important topic, and have carried out a lot of practice. Japanese education has gone beyond the traditional discourse structure, so we should focus on cross-cultural communication and gradually improve students' ability to communicate in Japanese. Through the in-depth study of Japanese, it can cultivate a higher level and ability of Japanese communication in future practice, and promote better personal development.

Key words: *Japanese teaching; cultural communication; introduction strategy*

参考文献:

- [1]刘樱.跨文化交际视域下高校日语教学中的文化导入策略[J].文化学刊,2020(05):217-219.
- [2]安伟.试析跨文化交际背景下日语教学中的文化导入——以高职院校商务日语专业为例[J].文化创新比较研究,2019,3(15):103-104.
- [3]田沙.跨文化交际背景下高校日语教学的文化导入策略分析[J].当代教育实践与教学研究,2017(01):126.DOI:10.16534/j.cnki.cn13-9000/g.2017.0096.
- [4]李易宣.大学日语教学中的文化导入方法研究[J].新校园(上旬),2015(09):39.
- [5]符方霞.跨文化交际能力的高校日语教学实践[J].集成电路应用,2021,38(06):174-175.DOI:10.19339/j.issn.1674-2583.2021.06.083.
- [6]金冰,慕婧.基于人文哲学的日语教学中跨文化交际能力培养策略研究[J].长春大学学报,2021,31(02):92-95.
- [7]刘樱.跨文化交际视域下高校日语教学中的文化导入策略[J].文化学刊,2020(05):217-219.
- [8]方媛.高校日语教学中跨文化交际能力培养策略[J].北京印刷学院学报,2019,27(12):97-99.DOI:10.19461/j.cnki.1004-8626.2019.12.026.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

NEWS



THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн тухай

Анх 2015 онд монгол судлаач залуу эрдэмтдийн судалгааны ажлыг дэмжих, харилцан туршлага солилцох зорилготойгоор “Содон Соёд” эрдэм шинжилгээний нэгдэл байгуулагдаж байв.

2020 оноос “Соёлын Жимээр” соёл судлалын төв болгон өргөтгөв. Тус төвийн үйл ажиллагааны цар хүрээ улам өргөжин, судалгаа шинжилгээний ажлыг сурталчлахын сацуу орчуулга, хөрвүүлгийн ажлыг гүйцэтгэх боллоо.

Эрдэм шинжилгээний өгүүллийг хөрвүүлж найруулан, монгол улсад хэвлэгдэх стандартад нийцүүлэх, тухайн ажлыг сэтгүүлд хэвлүүлэх ажлыг гүйцэтгэсээр ирэв. Мөн тусгай төслийн хүрээнд бичигдсэн судалгааны ажлыг хөрвүүлж, орчуулан монгол улсад хэвлүүлэх ажлыг зохион байгуулсаар байна. Үүнээс гадна бидний бас нэг онцлох үйл ажиллагаа бол монгол судлаач эрдэмтдийн судалгааны ажлыг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний сэтгүүлийг монгол улсад эрхлэн хэвлүүлэх ажлыг өрнүүлсээр байна.

2022 оны 1 дүгээр улирлаас манай сэтгүүл **ISSN** буюу олон улсын эрдэм шинжилгээний номын санд албан ёсоор бүртгэгдэн цаашид улирал тутам хэвлэхээр төсөвлөн ажиллаж байна.

РЕДАКЦ

© Тус сэтгүүлийг хэвлэх эрх хуулиар хамгаалагдсан болно.
Зөвшөөрөлгүй бүх төрлөөр хуулбарлахыг хориглоно !



THE CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES

„...אנחנו מייצגים את המרחב הזה בצורה הטובה ביותר“

לדבריו, המערכת המדעית והאקדמית בארץ היא אחת מהטובות בעולם, והיא צריכה להמשיך ולתמוך את המחקר הישראלי. הוא מציין גם את חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי.

הוא מציין גם את חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי. הוא מציין גם את חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי.

הוא מציין גם את חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי. הוא מציין גם את חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי, ואת חשיבות המחקר הישראלי והמערבי.

«...אנחנו מייצגים את המרחב הזה בצורה הטובה ביותר»

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвөөс
кирилл үсэгт хөрвүүлсэн судалгааны бүтээлээс

1400 ЖИЛИЙН ӨМНӨХ ӨВӨГ
МОНГОЛ ХЭЛ

1400 жилийн өмнөх өвөг
МОНГОЛ ХЭЛ

Солонгод Д.Хурцбат


1400 жилийн өмнөх өвөг
МОНГОЛ ХЭЛ



Elias Verlag IMoFiF e.V.
Cologne Germany 2020

1400 жилийн өмнөх өвөг
МОНГОЛ ХЭЛ

Сурвалж ба үндэстэн, үндэстэн ба үндэстэн



© 2021 by Elias Verlag IMoFiF e.V. - Cologne, Germany

© 2021 by Elias Verlag IMoFiF e.V. - Cologne, Germany

Өвөг монгол хэл - Монгол брахми бичиг

1450 онд бичигдсэн
Монгол брахми бичиг —
Түүний үндэс

© 2021 by Elias Verlag IMoFiF e.V.



Elias Verlag IMoFiF e.V.
Cologne Germany 2021




КИРИЛЛ ҮСЭГТ ХӨРВҮҮЛЖ, ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛСЭН СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ

2021 онд анх удаа хийгдсэн "Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл"

2021 онд анх удаа хийгдсэн
 "Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл"

Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл
 Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл



Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл
 Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠤᠨ ᠠᠶᠢᠷᠢᠭᠢᠨ ᠨᠠᠶᠢᠷᠢᠭᠢᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠤᠨ ᠠᠶᠢᠷᠢᠭᠢᠨ ᠨᠠᠶᠢᠷᠢᠭᠢᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠤᠨ ᠠᠶᠢᠷᠢᠭᠢᠨ ᠨᠠᠶᠢᠷᠢᠭᠢᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ



“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд

ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

Техник шаардлага:

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-15

Судалгааны ажлын бүтэц:

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (abstract)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

Өгүүлэл хэвлэгдэх явц:

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

8-15 – גיליון 15 – 2000

10) המערכת

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

12) המערכת

B5) המערכת

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA

המערכת לשימוש ב-APA מיושמת על ידי המערכת לשימוש ב-APA

-> אורגניזציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן און אורגניזאציען און פראצעדורן (און אורגניזאציען און פראצעדורן)

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן און אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן

אורגניזאציען און פראצעדורן :

-> אורגניזאציען און פראצעדורן (און אורגניזאציען און פראצעדורן)

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן (key word)

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן (abstract)

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן און אורגניזאציען און פראצעדורן • E-mail און אורגניזאציען און פראצעדורן

-> אורגניזאציען און פראצעדורן (content)

-> אורגניזאציען און פראצעדורן

אורגניזאציען און פראצעדורן :

